



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-139
<hr/>	
<i>1. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10-72
<i>2. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	72-80
<i>3. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн/</i>	80-115
<i>4. Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах</i>	115-139

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Жавхлан, Ц.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Ч.Хүрэлбаатар, Ж.Чинбүрэн, Б.Чойжилсүрэн, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Ганхуяг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн;

Хоцорсон: С.Амарсайхан -1 цаг 28 минут, Ц.Анандбазар -17 минут, С.Батболд -2 цаг 33 минут, Ж.Батсуурь -15 минут, Э.Батиугар -10 минут, Х.Болорчулуун -12 минут, Н.Ганибал -12 минут, Т.Доржханд -28 минут, М.Оюунчимэг -1 цаг 38 минут, Б.Саранчимэг -29 минут, Н.Учрал -10 минут, Д.Цогтбаатар -1 цаг 09 минут, Б.Энх-Амгалан -27 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг тус тус Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:14/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга О.Машбат, референт Г.Сувдаа, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Н.Учрал, Д.Тогтохсүрэн, Ц.Даваасүрэн, Х.Болорчулуун, Х.Баделхан, С.Одонтуяа, С.Чинзориг, С.Ганбаатар, Ц.Туваан, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, О.Цогтгэрэл, Ж.Батжаргал, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач Д.Энхцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Үдийн завсарлагааны цаг болсон тул хуралдаан 13 цаг 07 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа, Н.Ганибал, Б.Саранчимэг, П.Анужин, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 зүйлийн 18.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаад сануулга өгөв./14:39/

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Т.Доржханд нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 12

Бүгд: 46

73.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мөнхбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 09 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Н.Учрал, Б.Бейсен нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 28
Бүгд: 47
40.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 21
Бүгд: 47
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47

57.4 хувийн саналаар санал дэмжигдсэн тул тогтоолын төсөл буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:40/

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Х.Мөнхжаргал, мөн компанийн Өмнөговь аймаг дахь уурхайн салбарын захирал Л.Доржсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн бодлогын Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Т.Аубакир, Э.Батшугар, С.Ганбаатар, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Т.Доржханд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 17 цаг 38 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3-т заасны дагуу Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцүүлэгт буцаах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дахин хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Түр хорооны хянан шалгагч И.Уянга, Л.Эрдэнэчулуун, Түр хорооны шинжээч О.Оргилмаа, О.Лхагвадорж, Б.Эрдэнэбат, Б.Хишигтогтох, О.Мөнхбат, Ч.Амарбаясгалан, Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батаа, мөн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батырбек, Захиргаа удирдлагын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мөрөн, Төслийн санхүүжилтийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сайнзаяа, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн захирал М.Мандухай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг Түр хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах асуудлыг хойшлуулж, маргаашийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 24
Бүгд: 41
41.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 18 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Тайлан, санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Н.Ганибал, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Ц.Идэрбат, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад

Түр хорооны дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Түр хорооны хянан шалгагч И.Уянга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 19 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эчнээ ангийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 29 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Бүгд Найрамдах Халимаг Улсын төрийн байгууллагын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн “Багшийн хөгжлийн гарц” ТББ-ын төлөөлөл, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн 12Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Зүүнбаян сумын ахмадууд, Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын “Төгс дэлгэрэх” сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид, Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 53 дугаар сургуулийн 12А, 12Б, 12В, 12Г ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 30 минут үргэлжилж, 73 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 72.6 хувийн ирцтэйгээр 19 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 11 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. 3-д Онцгой дэглэмийг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Дөрөвдүгээрт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал. Тавдугаарт, Органик бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Зургаадугаарт, Монгол Улсын хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий Түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23-ын 20.3-д заасны дагуу хууль тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах тухай үндэслэл бүхий саналаа Улсын Их Хурлын даргад

ирүүлж, Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасан. Энэ заалтын дагуу Засгийн газраас 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай ЗГ 1/60 тоот, мөн хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/61 тоот албан бичиг тус тус ирүүлсэн байна. Ингээд энэ хуулийн төслүүдийг татан авсанд тооцохын тулд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 19 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр мэдүүлсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг татан авч байна. 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргасан байна. Мөн 22 оны 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргасан байна. Эдгээр хуулийн төслүүдийг уншиж танилцууллаа. Ингээд татан авах тухай бичгийг танилцууллаа. Ингээд эдгээр хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад 17 цагаас өмнө өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа саналаа ирүүлсэн байна. Энэ дээр уул нь Дэгийн тухай хуульд заасан шаардлага асуудал нэмэх болон үгүй ээ, асуудлын тов дараалал хойшлуулах тухай санал гэж бичээгүй. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх гэсэн юм байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж бол үг

хэлэхгүй. Асуудал нэмэх юу асуудлын тов, дараалал, өнөөдрийн хэлэлцэх асуудалтай тов дараалал өөрчлөх талаар бол санал хэлнэ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудалд энэ микрофон яачих юм, яах вэ?

Г.Занданшатар: Микрофон чинь зүгээр явж байна. Өөрөө унтраагаад байна.

Ш.Адьяа: Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд 1 хуулийн төслийг оруулъя гэсэн ийм саналыг оруулж байна. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийтийн болон нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж ХЗБХ-гоор хэлэлцсэн. Би 14 хоногийн өмнө Улсын Их Хурлын чуулган дээр энэ хуулийн төслийг энэ хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгөөч гэдэг саналыг ярьж ирэх долоо хоногийн чуулганаар хэлэлцэнэ гэж Улсын Их Хурлын дарга энэ чуулган дээр ярьж байсан юм. Би бас ийм хуулийн төслийг өргөн бариад 90 хонож байна. ХЗБХ, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцээд тодорхой дэмжлэгийг авсан. Энэ хуулийн төслийг яагаад оруулж ирэхгүй байна вэ?

Энэ авлигатай тэмцэнэ, төрийн алба албыг ёс зүйтэй болгоно гэж Улсын Их Хурлын дарга маань удаа дараа хэлж байгаа. Засгийн газраас энэ төрийн албыг ёс зүйтэй болгоё, энэ авлигал албан тушаалын гэмт хэрэгтэй энэ төрийн өмч хөрөнгийг хулгай луйвраар ашигладаг, тендерээр завшдаг, төрийн албыг төрлийн алба болгодог энэ тогтолцоогоо бас засъя залруулъя гэж ингэж удаа дараа хэлж байна. Энэ асуудал яагаад Улсын Их Хурал орж ирэхгүй байна вэ? Улсын Их Хурал, Засгийн газар 2 зөрчилдөөд байгаа юм уу? Ер нь ямар ойлголт байна. Засгийн

газрынхаа өргөн мэдүүлсэн хуулийн төслийг ингээд 30 хоног дарчихлаа. Миний ч юм яах вэ дээ тэгээд л нэг 90 хоночлоод байгаа юм. Тэгэхдээ энэ өдөр нийгмийн захиалга болсон асуудал байна шүү дээ. Энэ авлигал, албан тушаал, энэ олон том дарга нарын эрх ашиг энд хөндөгдөж байгаа, ойлгож байгаа.

Гэхдээ та нар өнөөдөр нийгмийн захиалга болсон энэ асуудлаа оруулж ирэхгүй. Тэр Сонгуулийн хууль, Улс төрийн намын хууль гээд энэ асуудлыг хэлэлцэх нь зөв байх л даа. Энэ авлигатай тэмцэх, сахилга хариуцлага, төрийн албаны ёс зүйгийн асуудлыг хэлэлцэх асуудал чинь хамгийн нэгд байгаа байгаа асуудал л гэж ойлгож байгаа. Олонхын бүлгийн Засгийн газар эрх баригчдын өнөөдөр ярьж байгаа юм нь ингээд яг ажил хэрэг болоод ирэхээр ингээд алд дэлэм зөрж байна. Энэ асуудлаа яг хэзээ оруулж ирэх юм бэ? Улсын Их Хурлын Байнгын хороогоор хэлэлцсэн асуудал тэр долоо хоногийн чуулганаар ордог, нэгдсэн чуулганаар хэлэлцдэг. Гэтэл танай Засгийн газрын өргөн барьсан хууль чинь өнөөдөр сар гацаж байна. Олон хүний эрх ашиг энд хөндөгдөж байгаа, ойлгож байгаа. Тэгэхдээ нийт улсынхаа эрх ашиг, шударга ёсны төлөө, нийгмийн хариуцлагын төлөө энэ ард иргэдээс нийгмээс хүсэн хүлээж байгаа асуудлын төлөө энэ хуулийг яаралтай оруулж ирэх нь шударга ёсонд нийцнэ. Хэрэв Засгийн газрынхаа өргөн барьсан энэ хуулийн төслийг оруулж ирж хэлэлцдэггүй юм бол, миний өргөн бариад ХЗБХ, нэгдсэн чуулганаар хэлэлцээд олонхын дэмжлэг авсан тэр хуулийн төслийг энэ өнөөдрийн чуулганд хэлэлцэж өгөхийг би Улсын Их Хурлын даргаар шаардаж байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Д.Адьяа гишүүн дэгээ сайн унших хэрэгтэй. Байнгын хорооноор хороогоор хэлэлцээгүй асуудал бол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэггүй гэдгийг. Байнгын хороон дээрээ тэр санаачилсан хуулиа хэлэлц. Хоёрдугаарт дэгийн тухай хуульд заасны

дагуу хууль санаачлагч байхгүй бол тухай хуулийн төслийг хэлэлцдэггүй. Хууль санаачлагч хэдний өдөр хэлэлцүүлэх саналаа ирүүлдэг. Ажлын ачаалал болон холбогдох бусад асуудлаас холбогдуулаад энэ асуудал ингэж зохицуулагддаг. р нь бол Хууль тогтоомжийн хуулиа ягштал баримталж ажилла гэдэг шаардлагыг тавьж байгаа. Хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төслөө хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авчихсан байх ёстой. Тэгээд энэ дэгээ л баримталж ажиллая. Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй. Байнгын хороогоороо хэлэлц, Байнгын хороогоор хэлэлцээгүй асуудал чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхгүй хуулиа унш. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгуугийн Содбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Монгол Улсын Үндсэн хуулийн 19¹.1-д нам үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж, 3-д намын дотоод зохион байгуулалт ардчилсан системд нийцсэн хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт

төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж нэмэлт оруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралт 1.4-д Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах. Намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх. Намын дотоодод шийдвэр гаргах хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах, намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох, улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиудыг санаачилна гэж заасан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн нэгэн гол хэлбэр болох улс төрийн намын эрх зүйн шинэтгэлд анхаарал хандуулж, парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 22 оны 6

дугаар захирамжаар байгуулан ажилласан болно.

Уг ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллийг хангасан олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг уулзалт ярилцлагыг 10 гаруй удаа зохион байгуулж, хуулийн төсөлд Улсын Их Хуралд суудал бүхий намуудаас болон бусад төрийн бусад улс төрийн намуудаас санал авсан болно. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар хуулийн төсөл түүний дагалдах хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэн холбогдох саналыг авч төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 46 зүйлтэй бөгөөд энэхүү хуулийн төсөл нь батлагдсанаар улс төрийн намын эрх зүйн орчин сайжирч энэ хүрээнд дараах эерэг үр дүнгүүд авчирна гэж үзэж байна.

1. Улс төрийн намын хариуцлага дээшилж, намын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, ардчилсан зарчимд нийцэж, түүний санхүүжилт ил тод болох, намын гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, санхүү болон үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар сонгуулийн төв байгууллагад тайлан гаргаж өгөх замаар олон нийтийн хяналтыг сайжруулах эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

2. Улс төрийн нам нь бодлогын институт болон төлөвших бөгөөд нам улсын хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах үйл ажиллагаа, сонгуулийн мөрийн хөтөлбөр нь улс орны хөгжлийн бодлогод үндэслэх, төрийн өндөр ёс, зүйтэй төрийн албан хаагчдыг бэлтгэх, төрийн ард түмний гүүр болж иргэдэд улс төрийн боловсрол олгох институт болон төлөвших үндэс бүрдэнэ.

3. Улс төрийн намын санхүүжилт ил тод хяналт сайжирна гэж үзэж байгаа. Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг механизмыг боловсронгуй болгож, төрийн түүний хяналтыг олон нийтэд ил тод, нээлттэй ишлэн болгох чиглэлд эрх зүйн шинэтгэл хийгдэж байна. Намын санхүүжилт дан ганц сонгуулийн үед бус өдөр тутмын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй болох эрх зүйн үндэс бас бүрдэнэ. Түүнчлэн намд өгөх иргэд, ААН-ийн хандив, түүний захиран зарцуулалт нь сонгуулийн төв байгууллагад хяналт тавих замаар намын үйл ажиллагаа хариуцлагатай болгох үндэс бүрдэх юм.

4. Улс төрийн намуудын гишүүдийн оролцоог тэгш оролцоог хангах чиглэлд хуулийн төсөл чиглэж байна. Намын бодлогын институт болон төлөвших хүрээнд намын гишүүнчлэлийн статусыг тодорхой болгох чиглэлд намын гишүүний нам гишүүнийг намын эжинхэнэ гишүүн, намын дэмжигч гишүүн, намын сонгуульт гишүүн хэмээн ангилах эрх зүйн үндсийг бүрдүүлээ. Түүнчлэн гишүүдийн тэгш оролцоог хангах, улс төрд төлөөлөл нь бага хангагдаж буй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд жендерийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын өөрчлөлтүүдийг баталгаажих тодорхой заалтууд орлоо.

5. Намын дотоод ардчиллыг хөгжүүлэх чиглэлд хөгжүүлэх төлөвшүүлэх чиглэлд тодорхой заалтуудыг нэмж орууллаа. Намын дотоод ардчиллыг хөгжүүлэх хүрээнд иргэдийн сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийг баталгааг хангах, намын бүтэц зохион байгуулалт, дотоод сонгууль, гишүүдийн оролцоог хангах механизмыг хуульд тусгах замаар улс төрийн намын дотоод ардчиллыг дэмжих =эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлд онцгой анхаарлаа.

Дээрх цогц улс төрийн шинэтгэлийг хэрэгжүүлснээр Монголын

Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын үндэс болсон иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө баталгаажиж, намд итгэх иргэдийн итгэл дээшилж, төрийн бодлого шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоо нэмэгдэж, улс төрийн намуудад өрсөлдөөний болон хяналт сайжирна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл энэхүү хуулийг дагалдах хуулийн тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д нам Үндсэн хуулийн 16-дугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж, 3-д намын дотоод зохион байгуулалт, ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн

дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж заасан.

Хууль санаачлагч Үндсэн хуулиар бий болгосон төрийн байгуулал, түүний тогтолцоо, институтийн чадавх, ардчиллын бэхжилтэд сөргөөр нөлөөлж байгаа тул улс төрийн намуудын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг ардчилсан зарчимд нийцүүлж, нийт үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг ил тод, нээлттэй болгох хэрэгцээ шаардлага үүссэн гэж үзэж, хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын үндэс болсон иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө баталгаажиж, төрийн бодлого шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоо нэмэгдэж, нийгмийн өргөн давхаргын төлөөлөл бүхий бодлогын нам болох, улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийн хувь хэмжээ, зарцуулалтыг нарийн тогтоож, ил тод болгосноор намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болох зэрэг эерэг үр дүн гарна гэж үзжээ. Дээрх хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын Д-парламент.мн цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг улс төрийн намд хяналт тавих СЕХ-ны эрх, үүргийн талаар, жендерийн эрх тэгш байдлыг хэрхэн хангах, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн Улс төрийн намын дотоод ардчиллыг хэрхэн хөгжүүлэх, намыг үүсгэн байгуулах гишүүдийн тооны босго, намын анхан шатын байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохицуулсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Адъяасүрэн намын дэргэд болон намын дэргэд бодлогоо бодлогын судалгааны байгууллага заавал байх шаардлагатай эсэх, тус байгууллага нь сангийн

хэлбэртэй байх эсэх түүний санхүүжилтийн талаар, Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 2 удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй тохиолдолд сонгуулийн төв байгууллага намыг идэвхгүйд тооцох шийдвэр гаргах зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан намыг идэвхгүйд тооцох шийдвэрийг хэрхэн гаргах, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуулийн ямар шаардлага хангасан улс төрийн намд олгох түүний хувь хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганболд Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй намыг энэ хуульд нийцүүлэн дахин бүртгэх эсэх, улсын төсвөөс намуудад олгох санхүүжилтийн хувь хэмжээ үйл ажиллагаанд хүрэлцэхгүйц байхаар тооцсон эсэх, санхүүжилтийн үр дүнг хэрхэн үнэлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь улс төрийн намын болон сонгуульд гишүүний татварын хэмжээ, түүний бүрдүүлэлт, хүний нөөц, цалингийн систем, улс төрийн намд бүртгэлтэй хөрөнгө, түүнээс олох орлогыг хэрхэн тооцох талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил улс төрийн намын дотоод ардчиллын асуудлыг хэрхэн зохицуулсан, намын хандив, сонгуулийн үед олгох санхүүжилтийн хувь хэмжээ, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтын талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар улс төрийн намын дотоод ардчиллыг хөгжүүлэх хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгахад анхаарч ажиллах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 90.9 хувь нь үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуух асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Тилеуханы Аубакир гишүүнээр тасаллаа. Нэр нэмэхгүй. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улс төрийн намуудын тухай хуулийг санаачилж өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна. Ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд энэ Улс төрийн намын тухай хуулийг санаачилж, Монголд ардчилсан тогтолцоо олон намын систем үйлчилж эхэлсний гуч гаруй жилийн үйл явц түүхтэй холбогдуулж энэ Улс төрийн намын хуулийг бас санаачилж зохион байгуулсан

байх гэж ойлгож байгаа. Энэ Улс төрийн намын хууль бол өнөөдөр Монголын ардчилал, парламентын засаглалын ирээдүй ямар байх вэ гэдэг дээр шийдвэр гаргах ийм түүхэн чухал бичиг баримт гэж ойлгож байгаа.

Улс төрийн намуудын тухай хуулийг Ерөнхийлөгч олон талаас нь бас үзэж дүгнэж бас зүйтэй саналууд оруулсан байгаа. Энэ Улс төрийн намуудын тухай хуулийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ 2, 3 зүйлийг бас тодруулах зайлшгүй шаардлага байна. 90 онд бид намын нам бол төрийн дээр гарсан байна, нам төртэй төр гэж байхгүй гэж бид ардчилсан хувьсгал хийж олон намын тогтолцоог сонгож авч, энэ гуч жилийн улс төрийн намуудын сорилтыг давж туулсан. Бид нарт алдаа ч байгаа, оноо ч байгаа. Тэгэхээр энд 1 зүйлийг би тодруулъя.

Энэ улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэх тухай асуудалд дэмжлэг үзүүлнэ гэсэн заалт орсон байна. Улс төрийн нам бол ТББ гэж ойлгож байгаа юу аль эсхүл төрийн бүтцийн байгууллага гэж ойлгож байгаа юу гэдэг 1 хариулт авъя.

Дээр нь энэ 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр намын гишүүний гишүүдийн гишүүнчлэлийн асуудлыг Үндсэн хуулиар тодорхой болгож өгсөн. Энд зориулж ямар бодлогын бичиг баримтыг оруулж ирсэн бэ гэдэг асуудал байна. Түүнчлэн улс төрийн намуудын бүртгэлийн асуудал. Энэ бүртгэлийн асуудал чинь ингээд маш их маргаан дагуулдаг олон асуудал үүсгэдэг. АН-ын сүүлийн 3 жилийн түүхийг бид мартаж ёсгүй. Шүүх оролцдог, Засгийн газар оролцдог, бүртгэлийн байгууллага оролцдог, цагдаа оролцдог. Энийг хуулиар яаж зохицуулсан бэ? Энэ бол тодорхой харагдахгүй байгаа. Энэ хуулийн төсөл дээр. Энэ 1 асуудлыг хариулт авъя.

Дээр нь намын дотоод зохион байгуулалтын асуудал. Өнөөдөр 801 хүн

гарын үсэг зураад нам байгуулдаг энэ тогтолцоо бол үеэ өнгөрөөсөн. Энэ бол зүгээр тоглоом болж байгаа. Эхнэр, нөхрийн нь нам байдаг. Тэгээд нам нь хурлаа хийдэггүй. Тэгээд эхнэр нь намын дарга, нөхөр нь дэд дарга байдаг энэ юм чинь цаашаа ингээд явах юм уу? Энэ дээр зоригтой шийдвэр гарга. Та нар хүнд, одоо ингээд сүүлд нь тэр Үндсэн хууль дээр бүүр Засгийн газраас намуудыг тэр Үндсэн хуулийнхаа 19 оны хийсэн өөрчлөлт ухарчихсан байна лээ шүү дээ. Олон хүн бид нар хүний эрх гэж ярина гэж. Монгол Улс ингээд жижиж болж хуваагдах тусмаа сүйрэлд орж байгаа. Энэ дээр ер нь ямар дүгнэлт байна? Энэ талаар хариултаа авъя.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эчнээ ангийн оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Гишүүдийн нэрийн өмнөөс. Хэн хариулах уу? Содбаатар дарга хариулна 80.

Я.Содбаатар: Гишүүдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлбэ. Адьшаа гишүүний асуултад хариулъя. Бид нар энэ удаа хуулийн төсөл боловсруулахдаа улс төрийн намыг Үндсэн хуульд заасны дагуу авч үзэж байгаа. Үндсэн хуульд бол нам олон нийтийн байгууллага гэж тусад нь салгаж 1 ёсны төрийн бус байгууллагуудаас салгаж авч үзсэн. Нам гээд таслал олон нийтийн байгууллага гэж явж байгаа. Нэг ёсны бид нар намыг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьд авч үзэж энэ хуулийн төсөлд тусгаж явсан авч явсан гэдгийг танд тодотгож хэлье. Бүртгэлтэй холбоотой асуудлыг Мөнхсайхан хариулна биз.

Намын дотоод ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр намын энэ удаагийн хуулийн төсөлд олон заалтууд орж өгсөн. 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн хүрээнд намын дотоод зохион байгуулалт ардчилсан системд нийцсэн

байх, хөрөнгө орлогын эх үүсвэр зарцуулалт нь нийтэд ил тод байх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг хуульчлахаар зааж өгсөн. Энэ 19 онд орсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлыг ардчилсан зарчимд нийцүүлж явах заалтууд энэ удаагийн хуульд бол нэлээн нарийн тусаж өгсөн.

Таны түрүүний дурдаж байгаа аливаа улс төрийн хүчин улс төрийн нам, төлөөллийн төв байгууллагатай, удирдах дээд байгууллагатай, төлөөллийн төв байгууллагатай, гүйцэтгэх төв байгууллагатай, хяналтын байгууллагатай байгууллагыг хуульчилж өгч байгаа юм. Тэгээд энэ байгууллагуудын хугацааг бас хурлаа хийх хугацаануудыг бас нарийн хуульчилж өгч байгаа юм. Хэрэв тэр хуульд заасан хугацаандаа тэр хурал зөвлөгөөнүүд нь хийгдэхгүй байх юм бол улс төрийн намыг идэвхгүй хэлбэрт оруулах, цаашид татан буугдах хүртэл арга хэмжээ авахаар зааж өгч байгаа юм. Нэг ёсны энэ удаагийн хуулийн төсөл дотор улс төрийн намыг хариуцлагатай байлгах, хариуцлагажуулах асуудлуудыг маш олон заалтуудыг оруулж өгсөн. Энэний 1 бол намуудын дотоод ардчилалтай холбоотой. Энийг нэлээн нарийн зааж өгсөн.

Үнэхээр энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд манай улс төрийн намууд өнөөдөр Улсын дээд шүүхэд бүртгэлтэй байгаа 36 улс төрийн намыг аваад үзэх юм бол энэ намуудын нэлээн олон нь хурлаа хийдэггүй хугацаандаа. Нэлээн олон намын зохион байгуулалттай энэ олон нийтэд үйлчлэх нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьд ажиллах боломжгүй, гэр бүлийн, компанийн, зарим нь байгуулагдсанаасаа хойш 20, 30 жил хурлаа хийгээгүй байж улс төрийн хүчин гээд нам байж байх жишээний. Тийм учраас энэ бүгдийг бас нэлээн нарийвчилж зааж өгч авах арга

хэмжээний санкц хариуцлагын тогтолцоог бас хуульчилж нарийн зааж өгсөн гэдгийг бас тодотгож хэлье. Бүртгэлтэй холбоотой асуудлаар Мөнхсайхан доктор.

Г.Занданшатар: 88 гэсэн үү? 81 доктор Мөнхсайхан.

О.Мөнхсайхан: Энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгэхээр ер нь улс төрийн намыг юу гэж ойлгох вэ гэдэг ийм асуулт байдаг. Тэгэхээр тэрэнтэй холбоотой энэ бүртгэлийн асуудал бас гарч ирж байгаа. Яагаад вэ гэхээр улс төрийн нам бол 1 талаасаа иргэдийн эвлэлдэн нэгдсэн нэгдэл, ТББ-тай төстэй харьцангуй чөлөөтэй сайн дураараа нэгддэг. Нөгөө талаас улс төрийн нам бол өөрөө иргэдийн дэмжлэг авах юм бол сонгуульд ялах юм бол төрийн шийдвэр гаргахад оролцдог ийм онцгой эрх мэдэл хэрэгжүүлэх ийм субъект байгаа юм. Тэгэхээр энэ үүднээсээ бол дэлхий нийтийн чиг хандлага мөн 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бол улс төрийн намыг энэ ардчилсан нийгмийн институт болохынх нь хувьд 2 дахь хувилбараар нь буюу түрүүн Содбаатар даргын хэлсэн нийтийн эрх зүйн этгээдийн зарим шинжтэй гэдгээр нь дотоод ардчилалтай байх, санхүүжилт нь ил тод байх зэрэг нэлээн тийм зохицуулалтууд оруулж өгч байгаа. Тэгэхдээ нөгөө талаасаа автономн байдлыг нь хангасан балансыг хангаж өгсөн ийм төсөл байгаа.

Энэтэй уялдуулаад энэ бүртгэлийн асуудлыг бол бас онцгойлж авч үзсэн. Энэ дотор бол өмнө нь гарч байсан асуудлуудыг судалсан, гаднын туршилага судалсан. Тэгээд энэ дээр зарчмын хувьд бол нэгдүгээрт намыг яг яаж үүсгэн байгуулж бүртгэх юм бэ гэдэг тэр процедурыг нэлээн тодорхой болгосон, хугацаатай болгосон. Давхардлуудыг арилгаж, хэн хариуцахыг нь тодруулж зааж өгч байгаа. Өөрөөр хэлэх юм бол СЕХ бол намыг бүртгэхтэй холбоотой материалыг бүрдүүлбэрийг

хангах, тэр хангагдаагүй байх юм бол гуч хоногийн дотор тэрийгээ бүрдүүлж өгөх гэсэн ийм захиргааны шинжтэй ажлыг нь хийгээд, Улсын Дээд шүүх бүртгэх. Одоогийн манай зохицуулалт бол хэвээрээ байгаа. Энэ нь өөрөө гуч гаруй жил хэрэгжсэн, улс төрийн болон бусад янз бүрийн нөлөөнөөс ангид ийм хараат бус бие даасан шүүхийн дээд байгууллага бол бүртгэх ийм зохицуулалт болж, давхардлыг нь арилгаж орсон. Энэ дотроо бүртгэхдээ яг ямар баримт бүрдүүлэх юм, ямар шалгуурыг хангасан байх юм гэдгийг нэлээн тодорхой зааж өгсөн учраас янз бүрээр үзэмжээрээ бүртгэхээс татгалзах ийм орон зайг бол нэлээн хумьж өгч байгаа.

Тухайлбал хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 4-д заасан 4 үндэслэлийн аль 1 нь хангагдаагүй байвал бүртгэхээс татгалзана гэдгийг маш тодорхой зааж өгч байгаа. Өөрөөр хэлэх юм бол нэгдүгээрт намын дүрэм хөтөлбөр Үндсэн хууль, бусад хуульд харшилсан, эсвэл намд хориглосон үйл ажиллагаанууд тухайлбал цэрэгжсэн, хүчирхийлсэн шинжтэй гэдэг ийм хориглосон ноцтой үйл ажиллагаануудыг явуулсан бол эсвэл гишүүдийн тоо нь бол 801-д хүрээгүй эсвэл давхардуулан өөр намын гишүүдийг бүртгэсэн, нэрийн хувьд зөрчилтэй ч гэдэг юм уу ийм тодорхой объектив шалгууруудыг тавьж өгснөөрөө ирээдүйд маргаан гарахаас урьдчилан сэргийлэх энэ нөхцөлийг бол төсөл хангаж өгч байгаа гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулъя 1 минут.

Ш.Адьшаа: Нэг энэ улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой асуудал дээр нэмэлт тодруулга авмаар байна. Энэ олон нийтийн байгууллага нам гэдэг статус дээр гэж ярьж байна. Гэтэл энэ намын байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийг төрийн байгууллагад ажилласантай дүйцүүлэх ийм асуудал энэ хуулийн төсөлд байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ чинь цаашид энэ

Төрийн албаны тухай хуультай чинь яаж холбогдох юм бэ? Төрийн алба энэ намын алба гэдэг 2 чинь 1 байх юм уу, энэ их ойлгомжгүй байна. Ингээд нөгөө олон нийтийн байгууллага гэдэг статус чинь энэ намын байгууллагатайгаа ТББ-аас ондоо ч юм ишг ийм ойлгомжгүй асуудлуудыг бас цаашидаа анхаарч энэ хэлэлцүүлгийн явцад тодорхой болгох шаардлагатай байгаа шүү. Өнөөдөр бид нар энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя 80.

Я.Содбаатар: Адьшаа гишүүн энэ таны хэлээд байгаа Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг энэ хуульд байхгүй. Улсын Их Хурал өөрөө Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар улс төрийн намд ажилласан Улсын Их Хуралд суудалтай намд ажилласан ажилтнуудыг төрийн албанд ажилласан жилээр тооцохоор оруулсан юм байна лээ. Энэ заалт бол өнөөдөр хэрэгжиж явж байгаа. Энэ заалт энэ Улс төрийн намын хуулийн төсөлтэй холбогдолгүй. Зүгээр ер нь энэ Улс төрийн намын хуулийг хэлэлцэх явцад улс төрийн намд ажилласан энэ юунуудын цалингийн юу гээд өчигдөр Батсуурь гишүүн нэлээн олон саналууд гаргасан юм. Энийг бол хэлэлцүүлгийн явцад анхаараад үзчихэж болох байх гэж ингэж бодож байна. Тийм учраас яг улс төрийн намын таны түрүүний хэлдгээр Улс төрийн намын хуульд тэр намд ажилласан хүмүүсийг төрийн албан албатай тооцно гэсэн үг, өгүүлбэр бол байхгүй. Энэ төрийн албанд байгаа тэр Их Хурлын баталсан Төрийн албаны хуульд байгаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя. Энэ Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Алтангэрэлийн Бямбажаргал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Очирсүхийн Машбат, Ерөнхийлөгчийн Тамгын газрын

Хуулийн бодлогын газрын ахлах референт Гончигдашийн Сувдаа, Монгол Улсын Үндсэн МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор Одонгийн Мөнхсайхан, МУБИС-ийн багш, судлаач, доктор Эрдэнэбилэгийн Гэрэлт-Од Гэрэлт-Од байхгүй юу? МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор Дагва-Очирын Бумдарь, судлаач Дагвын Энхцэцэг. Ням-Осорын Учрал гишүүн асуулт асууна.

Н.Учрал: Энэ Ерөнхийлөгчийн санаачилсан Улс төрийн намын хууль дээр энэ ил тод байдлыг хангах чиглэлээр бас сайн зохицуулалтууд орсон. Түүнийг дэмжиж байгаа. Авлигын төсөөллийн индексээр манай улс дэлхийд 117-д явж байна. Мэдээлэл хариуцаж байгаа байгууллагуудад зайлиггүй хамаардаг энэ улс төрийн намуудын үйл ажиллагаа нь өөрөө ил тод биш байгаа. Тэр авлигын төсөөллийн индексээ гаргадаг 18 шалгуур үзүүлэлт дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудын транспэрэнси байдлыг үнэлдэг. Ер нь бол манай улс бол олон хууль гаргасан ч гэсэн хууль нь өөрөө хэрэгжихгүй байгаатай холбоотой.

Өмнөх Улс төрийн намын хууль дээр данс нь ил ил тод байна, шилэн байна. Шилэн дансны хууль дээр хүртэл заачихсан л байгаа шүү дээ. Өнгөрсөн 2021 онд бид 12 дугаар сард Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг гаргасан. Энэ хууль дээр төрийн байгууллагууд нууц гэж тамга дараад олон мэдээлэл нуудгийг ил болго гэдэг үүргийг мэдээлэл хариуцагч нарт хүлээлгэсэн. Мэдээлэл хариуцагч нар энэ хуулиар 5000 гаруй байгаа. Энэ 5000 гаруй мэдээлэл хариуцагч дотор улс төрийн нам ордог. Тэгвэл улс төрийн нам 68 төрлийн мэдээллийг хууль нэгэнт гарчихсан бол олон нийтэд мэдээлэх үүрэгтэй хуулиараа. Гэтэл өнөөдөр улс төрийн намууд бид Засгийн газраас ил ажиллагааг явуулаад 12 сарын 15-наас хойш бичиг явуулаад нэхээж шаардаад

байж байгаа. Гэтэл өнөөдөр улс төрийн намууд энэ 68 мэдээллийг илгээхгүй байгаа. Бүр 0 хувь үнэлгээтэй байгаа шүү дээ.

Жишээ нь энэ хуулиар чинь 68 мэдээлэл дотор энэ чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл, хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв санхүү, тэр байтугай улс төрийн намуудын худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, өөрийн эрхлэх асуудлын хүрээний мэдээллүүд, улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандив, тэр байтугай мэдээлэл хариуцагчийн зардлаар гадаадад ямар хүн сурсан хүртэл мэдээллийг ил болгох нь улс төрийн намын үүрэг шүү дээ. Гэтэл Засгийн газраас ил ажиллагааны хүрээнд долоо хоног болгон мэдээлэл шаардахад улс төрийн намууд явуулдаггүй. Харин долоо хоног болгон мэдээлэл явуулаад эхэлсний ард бол Засгийн газрын тусгай сангууд эхнээсээ мэдээллээ ил болгож байна. Тусгай хамгаалалттай газрууд ил болж байна. Бусад төрлийн мэдээллүүд долоо хоног болгон ил болж байгаа.

Гэхдээ энэ бол машинд унших байдлаар илгээснийг иргэдэд нээж байгаа. Тэрнээс биш өнөөдрийн ил болгосон гэдэг 1 ийм дүр эсгэсэн байдлаар биш байхгүй юу 1 excel дээр 1 хэдэн файл тавьсныгаа ил болгосон гэж хэлээд, хүн хараад ч ойлгохооргүй 1 мэдээллийг тавьж байгаа шүү дээ. Төрийн байгууллагууд мэдээлэл хариуцагч нар. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар авлигатай тэмцэх жил болгож зарласны хүрээнд энэ ил ажиллагааны үр дүнд энэ олон мэдээллийг ил тод болгоод алган дээр нь тавьсан юм ишг тавьчих юм бол энд чинь нөгөө сургаар асуудалд ханддаг биш, судалгаатай ханддаг, харддаг биш харж асуудалд ханддаг, тоймоор биш илүү дата дээр дун шинжилгээ хийдэг ийм зөв нийгмийг бүтээн байгуулах гээд байна шүү дээ.

Тэгэхээр Улс төрийн намын хууль дээр энэ шилэн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр орсон заалтууд байгаа хэдий ч энэ заалтуудыг нарийвчлан зааж өгөхгүй бол үр дүнд хүрэхгүй. Наад улс төрийн намын хууль дээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг эшлээд 68 төрлийн мэдээллийг машинд уншигдах байдлаар ил болгохыг нь үүрэгжүүлээд, тэгээд хариуцлагыг тавьж өгөх хэрэгтэй. Тэр наад нам татан буугдана. Ямар, ямар тохиолдолд гэнэ үү идэвхгүй үйл ажиллагаа явуулж байгаа гээд байгаа шиг намын үйл ажиллагааг шилэн байдлаар ил тод болгохгүй бол дараах мэдээллийг нь нээхгүй бол хариуцлага хүлээнэ гэдгийг тавих ёстой. Ямар хариуцлага.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя 80.

Я.Содбаатар: Улс төрийн намын тухай хуулийн 1 гол зүйл бол улс төрийн намын үйл ажиллагааг олон түмэнд нээлттэй, ил тод болгох, ялангуяа үйл ажиллагаа, санхүүгийн холбогдолтой мэдээ, мэдээллүүдийг нээлттэй болгох талын олон заалтууд орсон. Улс төрийн намууд Шилэн дансны хуулийн хүрээнд санхүүгийн тайлан тооцоогоо гаргадаг байх. Улс төрийн намууд үйл ажиллагааны тайлан, санхүүгийнхээ тайланд аудит оруулдаг байх. Улс төрийн намууд сонгуулийн төв байгууллагад жил бүр намуудын орлого зарлага, хөрөнгийн байдлын талаар мэдээллүүд, үйл ажиллагааныхаа мэдээллүүдийг хүргэж нэгтгээд Улсын Их Хуралд Сонгуулийн төв байгууллага мэдээлдэг байх. Улс төрийн намууд үйл ажиллагаа юмнуудаа цахим хуудсанд байршуулж, зөвхөн гишүүддээ төдийгүй ард иргэдэд нээлттэй байх гээд маш олон заалтууд орсон.

Энэ улс төрийн намуудад авч байгаа энэ улс төрийн намуудыг нээлттэй ил тод болгох энэ хийгдэж байгаа хуулийн заалтуудыг зөрчвөл улс төрийн намуудыг идэвхгүй хэлбэр рүү

шилжүүлэх, цаашилбал татан буулгах хүртэл арга хэмжээ авах ийм зүйлүүдийг оруулж өгсөн. Улс төрийн намууд ер нь юу, өнөөдрийн байдлаар бол улс төрийн намууд нэлээн хаалттай ийм байдаг. Санхүүжилт нь яаж явж байгаа нь тодорхойгүй, хандив мөнгө нь яаж явж байгаа нь тодорхойгүй, улс төрийн намуудын дотоод юмнууд нэлээн хаалттай ийм байсан. Энийг дагуулаад улс төрийн намуудад үүсэж байгаа энэ нөхцөл байдлууд бол өөрөө манай улсын авлигын индексээс эхлүүлээд олон индекс, олон юманд бол сөргөөр нөлөөлж байсан. Тийм учраас бид нар энэ тайланг нийтэд мэдээлэх, улс төрийн намын үйл ажиллагаа ил тод нээлттэй байлгах чиглэлийн олон заалтуудыг тусгайлан зааж өгч байгаа.

Зөвхөн энэ нээлттэй энэ юу болох чиглэлээр 4 ч томоохон бүлэг байгаа. Түүний 1 нь бол жишээ нь 9 дүгээр зүйлийг бид нар намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах гээд ингээд тусгай бүлэг орж ирж байгаа юм. Тайлангуудаа олон түмэнд нээлттэй болгох чиглэлээр 43 дугаар бүлэг гээд бас ингээд тусгайлан зааж өгч байгаа. Тэгэхээр улс төрийн намууд энэ хууль гарснаар бол улс төрийн намуудын үйл ажиллагаанаас эхлүүлээд санхүү хөрөнгө, хандив маш тодорхой нээлттэй болж, нөгөө талаасаа сонгуулийн төв байгууллага энэ улс төрийн намуудыг өдөр тутмын үйл ажиллагааг нь хянах, энэ талаар мэдээ мэдээллийг олон түмэнд хүргэх ийм нээлттэй болгох чиглэл рүү бас олон заалтууд орж өгч байгаа. Хэлэлцүүлгийн явцад Учрал гишүүний хэлээд байгаагаар зарим 1 хариуцлагын тогтолцоог илүү чангатгах ийм шаардлага байна гэж үзвэл хэлэлцүүлгийн явцад бас авч үзье.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн тодруулж асууя 1 минут.

Н.Учрал: Тэгээд энэ удаагийн Улс төрийн намын хуулийн хамгийн том дэвшил бол энэ Шилэн ил тод байдал юм байна гэж би харж байгаа. Тэгээд олон

хууль гардаг. Тэгээд эргээд хэрэгжих дээрээ гацаад байгаа юм. Жишээ нь 21 оны бидний баталсан 5 хуулийг дагалдуулаад 38 журам гарах ёстой. Одоо нэг 21 журам л гаргачхаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хууль дээрээ машинд унших байдлаар тэр 68 төрлийн мэдээллийг ил болгох нь мэдээлэл хариуцагч буюу улс төрийн намын үүрэг. Хэрэв ил болгохгүй байгаа тохиолдолд дараах хариуцлага хүлээнэ гээд тодорхой зааж өгөхгүй бол болохгүй байна. Тэгэхээр ажлын хэсэг дээр бас анхаараач. Тэр машинд унших байдлаар гэж тавьж өгөхгүй бол хэн ч хараад ойлгомжгүй мэдээллийг ил болгосноо мэдээллийг ил болгосон гэж хэлээд, нэг ийм өнгөцхөн байдлаар асуудалд ханддаг юм байна. Тэгээд үүн дээр нарийвчилсан зохицуулалт хийх хэрэгтэй байх.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн БЗД-ийн 29 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье. Сая санал хэлсэн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намуудыг хариуцлагатай болгох, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод нээлттэй болгох чиглэлд томоохон өөрчлөлт орсон. Энэ бол 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтийг Улс төрийн намын хуульд тусгах, сүүлийн 10 гаруй жил Улс төрийн намын хуулийн өөрчлөлт хийгдээгүй учраас хийлгэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улс төрийн намын тухай хуулийг санаачилж Их Хуралд оруулж ирж байна гэж бодож байна.

Хуулийн төслийг бол ерөнхийд нь дэмжиж байна. Тэгээд би хуулийн төсөл санаачлагчаас 3, 4 асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ хуулийн төслийг боловсруулахдаа Монголд үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудаас хэрхэн санал авав, иргэдээс хэрхэн санал авав, түүнийг яаж тусгав гэдэг зүйлийг нэгдүгээрт нь тодруулъя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь манайд байгаа энэ улс төрийн намуудын хувьд хурлаа хийдэггүй, төлөөллийн болон гүйцэтгэх байгууллагаа сонгодоггүй, намын дарга нь сая ч бас яригдаж байна. Бусад гишүүд нь намын дарга нь бараг насаараа шахуу сонгогдохсон 1 ийм дотоод ардчилалгүй намууд бий болчихоод байгаа юм. Энэ дотоод ардчиллыг сайжруулах, хариуцлагажуулах чиглэлээр хуулийн төсөлд хэрхэн тусгав гэдгийг нэгдүгээрт нь асууя гэж бодож байгаа юм. Хоёрдугаарт нь.

Гуравдугаарт нь намыг улс төрийн намыг үүсгэн байгуулахад энэ тооны асуудал байгаа юм 801 гэдэг. Тэгээд энэ бол арай л бага байгаа юм. Бид нар 19 оны сонгуулийн юу 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ 28 оноос эхэлж сонгогчдын 1 хувь буюу өнөөдрийн байдлаар 21000 гишүүнээс дээш гишүүнтэй байх ийм заалтыг оруулж өгсөн. Энэ нь бол улс төрийн намыг хариуцлагажуулах, илүү үндэсний хэмжээнд байлгах, үндэсний хэмжээнд бодлогоо явуулдаг явуулдаг болгоход чиглэсэн ийм 1 том өөрчлөлт гэж бодож байгаа юм. Тэгэхээр энд бол 801 гээд ороод ирчихсэн байгаа. Уул нь бол би жаахан ахиулж явах ёстой юм биш үү гэдэг 1 ийм бодол байгаагаа хэлье.

Дөрөвдүгээрт нь нам дээр хамгийн чухал юм бол намын шат шатны байгууллагуудын асуудал байгаа юм. Анхан, дунд шатын байгууллага. Анхан, дунд шатын байгууллагын зохицуулалтыг хуулиар хийх болов уу гэсэн. Энэ хийхгүй оруулаад ирчихсэн байгаа юм. Бодвол дүрмээрээ зохицуул гэдэг байдлаар хийгээгүй юм болов уу?

Энийг яаж авч үзсэн юм бол гэдэг ийм асуудал байгаа юм.

Төгсгөлд нь энэ хуулийг хэдийнээс эхэлж хэрэгжихээр ер нь тооцож байгаа вэ? Мэдээж одоо ингээд ирэх жил сонгууль болно. Намыг хариуцлагажуулах, улс төрийн сонгуульд санал авсан байх асуудлууд нь 1 хэсэг заалт нь одоо хэрэгжээд, 1 хэсэг заалт нь сонгуулийн дараа хэрэгжих үү? Ер нь хэрэгжихтэй холбоотой асуудлыг ер нь юу гэж ажлын хэсэг авч үзэж байгаа вэ гэдэг ийм хэдэн зүйлийг тодруулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга.

Я.Содбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Улс төрийн намын хуулийг боловсруулах явцад улс төрийн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудтай нэлээн хамтарч ажиллаж, парламентад суудалтай, суудалгүй намуудтай болон эрдэмтэн судлаачидтай нэлээн олон талаар хамтарч ажилласан гэж хэлж болно. Монгол Улсын Ерөнхийлөгч 21 онд тангаргаа өргөсний дараа улс төрийн намын удирдлагуудыг хүлээж авч уулзаж, ер нь Улс төрийн намын хуулийн буюу улс төрийн энэ намын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр улс төрийн намууд хамтарч ажиллаач. Зарчмын гэж болох саналын зөрүүтэй байдаг томоохон асуудлуудаараа санал нэгдэх юм бол энэ асуудлыг чинь хууль санаачлагчийн хувьд нөгөө талаасаа улс төрийн намаас хараат бус байдаг институтийн хувьд Ерөнхийлөгч санаачлаад ингээд өргөн барихад бэлэн байна гэдэг агуулгаа хэлсэн.

Энэний дараа Тамгын даргаар ахлуулсан парламентад суудалтай намуудын төлөөлөл, парламентад суудалгүй намуудын төлөөлөл орсон, МУИС, Багшийн их сургуулийн энэ Улс төр судлалын танхимын судлаач эрдэмтэд орсон томоохон бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарсан. Энэ

ажлын хэсгээс хуулийн төслийг анх боловсруулж өнгөрсөн оны 5 сарын 04-ний өдөр Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 35 улс төрийн нам руу санал авахаар явуулсан. Энэний дараа улс төрийн намууд манай Тамгын газартай хамтраад бие даагаад олон улсын байгууллагуудтай хамтраад нээрээ 10 гаруй удаагийн хэлэлцүүлгүүд зохион байгуулж бас саналуудаа ирүүлсэн. Энэний дагуу энэ Хууль тогтоомжийн хуулийн дагуу энэ санал авах процессууд явагдсан гэж хэлж болно.

Ер нь бол энэ Улс төрийн намын хууль өнгөрсөн жилүүдэд парламентаар орж ирээд бас дэмжлэг аваагүй юм байна лээ. Бид нар анх 1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиа баталж, Улс төрийн намуудын тухай хуультай болсон. Дараа нь энэ 2005 онд Улс төрийн намын өнөөдрийн хүчин төгөлдөр байгаа хуулийг баталсан. Үүнээс хойш Улс төрийн намын хуульд томоохон өөрчлөлт оруулах ёстой гээд Элбэгдорж Ерөнхийлөгчийг байх үед хуулийн төсөл орж ирээд Их Хурал дээр бас босго даваагүй, парламентын босго даваагүй. Дараа нь энэ Баярцогт гишүүн бас ажлын хэсэг ахлаад хуулийн төсөл боловсруулсан байдаг. Бямбацогт гишүүн ахлаад бас хуулийн төсөл боловсруулсан байдаг. Тэгээд өнгөрсөн 18 жилийн хугацаанд бол энэ хуулийн төсөлд томоохон өөрчлөлт орж чадаагүй явж байгаад 18 жилийн дараа парламентад орж ирж байгаа нь энэ. Тэгэхээр санал авалтын хувьд бол нэлээн олон талаас саналыг нь авч тусгасан гэж хэлж болно. Олон улсын НҮБ, хүний эрхийн факт, улс төрийн эрхийн фактын гэж яадаг олон улсын индекс гаргадаг олон улсын байгууллагуудаас ч гэсэн санал зөвлөмж авч хамтарч ажилласан гэдгийг тодотгож хэлье.

Хоёрт энэ хурлаа хийхгүй байгаа дотоод ардчилалгүй улс төрийн намууд олон байгаа. Өнөөдөр энэ хугацаанд хуулийн дагуу хурлаа хийж байсан нам бол 1 л байгаа. Бусад улс төрийн хүчнүүд бол 8, 10 жилээр хурлаа хийдэггүй ийм

тохиолдлууд бүх улс төрийн намд нийтлэг байсан. Тийм учраас энэ улс төрийн намыг хариуцлагажуулах, ялангуяа гүйцэтгэх төв байгууллага, төлөөллийн төв байгууллага, удирдах дээд байгууллагуудын хурлуудыг цаг хугацаанд нь хийх, хэрэв цаг хугацаандаа хийхгүй бол тэр юунуудыг идэвхгүй хэлбэрт шилжүүлэх, цаашилаад тэр намыг татан буулгах хүртэл арга хэмжээ авах зөрчлөө арилгахгүй бол ийм заалтуудыг хуульд тусгаж өгсөн гэдгийг бас тодотгож хэлье.

Гуравд бол өнөөдөр хүчин төгөлдөр байгаа Үндсэн хуулийн заалтаар одоо яаж байгаагаар бол энэ 19 онд Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намын гишүүнчлэлтэй холбоотой тодорхой заалтыг оруулсан. Тэр заалт бол 18, 19, 28 оны 1 сарын 1-нээс хэрэгжих ёстой юм. Тэгээд тэр заалттай холбоотойгоор гишүүдийн тооны асуудал яригдаж байгаа. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн 1-ээс доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гэсэн энэ заалт бол 28 оны 1 сарын 1-нээс хэрэгжих юм. Тийм учраас бид дээр байгаа 801-ээр нь авсан. Ер нь бол бид нар илүү энэ намуудыг байгуулагдсаных нь дараа хариуцлагатай болгох чиглэлийнх нь заалтууд илүү орж өгсөн гэж ингэж хэлж болно. Одоо байгаа энэ 36, 7 нам бол энэ хууль гарсны дараа бол маш цөөхөн болж үлдэх юм байна лээ. Яг хариуцлагыг нь шахаад, төрийн байгууллага, сонгуулийн төв байгууллагаас, тэгээд тэр тайлан тооцоог нь аваад аудит хийгээд үйл.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга гүйцээгээд хариулчихъя.

Я.Содбаатар: Тийм. Хуулийг бол 24 оны 1 сарын 1-нээс хэрэгжихээр өргөн барьсан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хууль хуулийг баталсантай холбогдуулан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хавсарган хамтад нь

дагалдуулан өргөн барьсан байгаа. Энэ хуулийн төслөөр бол энэ хууль гарсны дараа Улсын дээд шүүхэд бүртгэлтэй байгаа намууд энэ энэ баталсан хуульд нийцүүлэн өөрсдийгөө дахиж дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтуудаа улс төрийн намд нийцүүлэх арга хэмжээ авах хугацаанууд өгч байгаа. Энэ бол Дагаж мөрдөх журмын тухай хууль дотор нь тодорхой зааж өгсөн байгаа.

Намын анхан, дунд шатын байгууллагатай холбоотой заалт дээр бол дүрмээр зохицуулахаар зааж өгсөн. Зарим манай улс төрийн намууд бол энэ анхан, дунд шатын байгууллагуудыг татан буулгах, 10000-аас дээш хүн амтай газар зөвхөн анхан шатын байгууллага байгуулдаг байя гэсэн саналууд ирж байсан. Тэгэхдээ энэ нь бол Үндсэн хуультай буюу иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй явж байгаа учраас намуудад энийг дүрмээр зохицуулахаар зааж өгсөн.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Тэгээд энэ ер нь бол маш чухал хууль орж ирж байна л даа. Зүгээр хуулийг зарчмын хувьд бол дэмжээд ингээд л хэлэлцээд явах нь зөв. Ер нь энэ улс орон төр сайн байхын гол үндэслэл бол намууд л зарчимтай хариуцлагатай байх ёстой асуудал байхгүй юу. Тэр талаас нь л ер нь бид энэ улс төрийн намуудыг төлөвшүүлэх чиглэлд анхаарах ийм шаардлага байх шиг байгаа юм. Улс төрийн намуудын 1 ялангуяа том намуудын маань 1 бардамнаад ингээд нийгмийн хариуцлагаа нэг үл ойшоогоод яваа юм бол намын гишүүнчлэл байгаад байгаа юм. Хатуу гишүүнчлэл. Яаж ч байсан 1 санал өгчихдөг, 20-30 хувьтай. Тэгээд саналаа авчихдаг. Одоо бүр тэрийгээ ашиглах гээд намын жагсаалтаар сонгууль хийдэг болгох гээд байгаа шүү дээ.

Хэдийгээр тэр намын жагсаалтын хүн дугуйллаа ч гэлээ гэсэн тэр хүний хувийг намын хувьд тооцно. Тэгээд намын дээгүүр жагссан байгаа бүх хүн Их Хурлын гишүүн болдог. Тэгэхээр энэ төрийн чинь энэ төрийн байгууллагуудын чинь ер нь сулруулаад байгаа юм энэ намын хатуу гишүүнчлэл. Тэгэхээр энэ чиглэл дээр алхам хийсэн зүйл энэ хуулийн төсөл дээр байна уу?

Өнгөрсөн хугацаанд бол ингээд яаж энэ улс орныг зөв байлгах ёстой юм, энэ төрийг зөв байлгах ёстой юм гэж ингээд бодоод явж байхад бол хамгийн гол учир шалтгаан бол би хатуу гишүүнчлэл юм байна л гэж бодсон. Яагаад гэвэл энэ төрд орж ирж байгаа улсуудыг, энэ Улсын Их Хуралд орж ирж байгаа улсуудыг намын гишүүн чинь намын гишүүд бол ерөөсөө үндсэндээ хэн ч байсан чирээд оруулчхаж байна шүү дээ. Нөгөө бор халзан хонь байсан ч чирээд оруулчхаж байна шүү дээ. Ямар нэг гэмт хэрэгт холбогдсон ч бай чирээд л оруулчхаж байна шүү дээ. Намын гишүүд чинь саналаа өгөөд л. Ялангуяа сонгуулийн ирц бага байх юм бол бүр нөгөө намуудын чинь хувь бараг нийт сонгуулийн ирцийн 50 хувь болчхож байгаа байхгүй юу. Сонгуулийн ирц 51 хувьтай байлаа гэхэд 2 намын нийлсэн намын гишүүдийн хувь бол нийт сонгуулийн 50 хувь нь болчхож байгаа байхгүй юу.

Тийм учраас тэр төр рүү чинь тэр нэр хүндгүй болчихсон, аль эсвэл авлигал албан тушаалын гэмт хэрэгт холбогдчихсон улсуудыг чинь чирээд оруулчхаад байна шүү дээ. Одоо бүр үүнийгээ баталгаажуулахын тулд намын жагсаалтын ард нуугдаж ордог сонгуулийн тогтолцоог оруулж ирчхээд хэлэлцэх гээд сууж байна шүү дээ. Тийм учраас энэ хатуу гишүүнчлэл байгаа цагт бол лав төр цэвэршихгүй. Тэр намын гишүүн чинь гишүүнээрээ дамжуулаад л ингээд л төрөө бохирдуулсан хэвээрээ л байна.

Өөр нэг асуудал бол төрийн албыг сулруулж байгаа юм. Энэ намын гишүүнчлэлээс болж. Намын гишүүн, намын гишүүн гэж чихсээр байгаад энэ төрийн алба чинь суларчихлаа шүү дээ. Хуучин бол яах вэ нэг намын тогтолцоотой байхад бол үнэхээр шилдгүүдээ тэр 90-ээд оноос өмнө бол төрийн албанд тавьдаг байсан. Одоо бол үгүй. Одоо бол тэгээд л намын гишүүнээр нэлээн сайн нялдаганаж гүйсэн нь бол тэгээд албан тушаалд очдог. Намд хийж байсан ажлынхаа төлөө заавал албан тушаалд очих гэдэг. Тэгээд төрийн байгууллагуудаа одоо болохоо больчихсон. Тэгээд харин сая Засгийн газраас бол шүүр ажиллагаа явуулъя. Энэ үнэхээр төрд ажил хийгээд явж байгаа улсуудын дургүйцлийг төрүүлж байна гэдэг агуулгаар энэ шүүр ажиллагаа яваад байна.

Үгүй ээ аргагүй шүү дээ. Үгүй ээ би яг төрд бүх шат дамжлагаар нь явсан хүний хувьд бол тэрийг маш сайн мэдэрч байна. Үгүй ээ, энэ чинь бүх шат дамжлагаар нь яваад л 1 карьерт хүрье гээд л хүн бүр л бодож байгаа шүү дээ юу гэдэг юм газрын дарга больё. Төрийн нарийн бичгийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ?
80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Улс төрийн намын хатуу гишүүнчлэлийн асуудлыг бид нар бас олон жил ярьж байгаа. Ялангуяа орон нутагт анхан, дунд шатан дээр улс төржиж байгаа байдал бол иргэдийн бухимдлыг бас нэлээн өндөрт байдаг. Иргэдийн уулзалт дээр ч гэсэн хамгийн их ярьдаг зүйл бол энэ хатуу гишүүнчлэлийг багасгаж өгөөч, хэтэрхий улс төржилтийг зогсоож өгөөч гэдэг ийм шаардлагууд явдаг. Энэ агуулгаараа бол Улс төрийн намын хуулийг боловсруулах явцад энийг нэлээн анхаарч үзсэн. Энэ удаагийн хуулиар бид нар улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзаж байгаа.

Тэгэхдээ улс төрийн намын гишүүнчлэлийг дотор нь 3 хувааж байгаа. Улс төрийн намын гишүүн, намын гишүүн, улс төрийн намын дэмжигч гишүүн, сонгуульт гишүүн гээд. Тэгээд энэ 3 юун дээрээ бас тодорхой чиг үүргүүдийг нь хуваарилж өгсөн. Тухайлбал улс төрийн намын тэр жинхэнэ гишүүн болж байгаа тэр хүн бол татвараа төлдөг заавал үүрэгтэй. Дээрээс нь улс төрийн намын дотоод сонгуульд саналыг өгөх эрхтэйгээр оролцдог ийм албан ийм хүн иргэнийг бол хэлж байгаа юм. Намын үйл ажиллагаанд оролцдог, намын бодлого, үйл ажиллагааг дэмждэг, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гэхдээ заавал татвар төлөхгүйгээр ийм юунуудыг бол дэмжигч хүн гэж бас салгаж өгье гэж бодож байгаа. Ингэх юм бол одоо байгаа энэ хатуу гишүүнчлэлийн хүрээнд байж байгаа зүйл бол I алхам бас алхам болж байгаа гэж ингэж харж байгаа.

Ер нь бол бид нар энэ Намын хуулийг хийх явцад бол эвлэлдэн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй холбоотой, тэр иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд хөндлөнгөөс нөлөөлж байгаа нөлөөллийг багасгах чиглэлээр бас тодорхой, тодорхой заалтуудыг тусгаж өгсөн. Намын зүгээс, төрийн байгууллагын зүгээс, албан тушаалтны зүгээс иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд янз бүрийн шахалт үзүүлдэг ийм зүйлүүдийг хязгаарлах чиглэлээр тусгайлсан бас бүлэг оруулж ингэж өгсөн гэдгийг бас тодотгож хэлье.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууна I минут.

Ц.Даваасүрэн: Тийм. Төрийн албан хаагч нар яагаад дургүйцээд байгаа вэ гэхээр насаараа мөрөөдөөд I очъё гэж бодож байгаа албан тушаал дээр нь энэ сонгуулийн үр дүнгээр I өдөр I хүн хүрээд ирж байгаа байхгүй юу. Ямар ч төрийн албаны туршилагагүй хүн. Тэгээд л дургүйцээд байгаа юм. Тийм учраас энэ

төрийн албыг цэвэр байлгая гэх юм бол бид нар энэ намын харьяаллаар 4 жилийн сонгуулийн үр дүнгээр энэ очдог юмыг л болиулахгүй бол өнөөдөр төрийн алба бүр чадахгүй болчихсон юм байна лээ. Нөгөө уламжлалт тэр карьерын систем нь байхгүй болчихсон. Сайдаар ажиллуулъя гэхээр хүнгүй болчихсон. Тийм учраас сая тэр дан дээлтэй явж чадсангүй шүү дээ.

Хуучин бол Энхбаярын Засгийн газрын үед байсан сайд нарыг бид нар 2000 оны үед бүгдийг нь л хүлээн зөвшөөрдөг байсан шүү дээ. Тэр тухайн үеийн сайд нарыг. Гэтэл өнөөдөр ингээд дан дээлтэй сайд тавихаар нийгэм ч зөвшөөрөхгүй, салбарынхан ч зөвшөөрөхгүй болчихсон. Энэ чинь өөрөө энэ 4, 4 жилээр юм уу, 2 жилээр ч юм уу төрийн албыг сонгуулийн үр дүнгээр намын гишүүнчлэлээр аваачиж ингэж томилдгоос л болсон хэрэг л дээ. Тэгээд төр бол чадавхгүй болж байгаагийн I шалтгаан энэ. Цаашидаа бид нар энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ, Бямбажаргал уу? Санал уу. Хаянгаагийн Болорчулуун гишүүн асуулт асууна.

Х.Болорчулуун: Баярлалаа. Монгол Улс парламентын засаглалтай. Тийм учраас намаар дамжиж намууд төрийн эрхээ барьж байгаа. Намын нэр хүнд энэ сүүлийн гучаад жилд үнэхээр навс уналаа. Энэ улс орны байдлын эдийн засаг, нийгмийн байж байгаа байдал, ард түмний амьдрал энэ бол намын намуудын бодлого, мөрийн хөтөлбөр буруу, бүтэц зохион байгуулалт ер нь бурууг бас харуулж байгаа юм гэж хэлэх байна.

Би бодлого гэж хэлэхэд нь, намууд сонгуульд өрсөлдөхдөө амлалт үүрэг авдаг. Тооцоогүй, судалгаагүй, амлалтуудыг өгдөг, хэзээ ч биелэхгүй, хэзээ ч биелэхгүй. Жишээлбэл та бүхэн мэдэж байгаа I нь сая төгрөг өгнө гэхэд нөгөө нам нь 1,5 сая өгнө гээд л өрсөлдөж л байсан. Ийм тооцоогүй судалгаагүй үл биелэх амлалтуудыг

намын энэ хууль дээр бол бүр хатуу чанга байлгаж хасах хэрэгтэй гэж бодож байна. Байж болохгүй ийм. Бүр тооцоотой, энэ мөрийн хөтөлбөрийг биелүүлэхэд ийм эдийн засаг санхүүжилтээс энэ мөнгийг босгоно гээд бүр нарийн тооцоотойг зааж өгч баймаар байна. Тэгэхгүй бол худлаа амлалтаар хуурсаар байгаад ард иргэд ч итгэхээ болилоо ний нуугүй хэлэхэд. Энэ манай танай нам гээд ч байх юм байхгүй энэ дээр бол.

Хоёрдугаарт тэр намын хатуу гишүүнчлэл бол үнэхээр улс орныг түйвээсэн. Нээрээ зарим ард иргэд бол тэгээд л худалч байсан, хулгайч байсан манай нам юм даа гээд буруу харж байгаад л өгчихдөг. Одоо тэгээд өгөхөө ч болих тийшээ хандаж байгаа шүү. Тэгэхээр хэтэрхий бага ард түмнээ жижиж Монгол Улсаа бас дунд нь намын гишүүнчлэлээр хуваагдаж хаямаар хувааж хаямааргүй байна. Ялангуяа сум дээр бол намын салбар үүр байх ямар ч шаардлагагүй. Энийг ард иргэд өөрсдөө хүсэж байна шүү дээ сумынхан. 10000-аас дээш хүн хүнтэй хот, тосгон, аймгийн төвд намын үүр байдаг ч юм уу тийм заалт оруулах хэрэгтэй байна. Суман дээр бол хамаатан садан, ах дүү нар, найз нөхөд үнэхээр хуваагдаж энэ юунаас чинь болж аргаа барлаа. Энэ хатуу гишүүн тэр дотор суман дээр намын үр байх эсэх талаар ер нь яаж энэ хуулийн төсөл дээр оруулсан бэ гэдгийг бас асууя.

Хамгийн гол нь үнэн зөв мөрийн хөтөлбөр гаргадаг, хэрэгжүүлдэг байх хэрэгтэй. Бид нар 1 хэсэг гишүүд Америкт очоод бид нар Америкаас их туршилага их ардчиллын их Америкаас туршилага судалдаг л даа. 1 өвгөн, 70 настай өвгөн би 4 намаас сонгогдсон. Бүгд найрамдах нам, Ардчилсан нам 2 том нам, бие даагч, өөр 1 жижиж намаас сонгогдсон. Үгүй ээ яаж болдог юм бэ гэсэн чинь үгүй ээ би мөрийн хөтөлбөрийг нь яаж аль нь зөв, үнэн зөв хэрэгжих мөрийн хөтөлбөр гаргаж байна тэндээс нэр дэвшдэг. Тийм эрх

чөлөө эдэлж байна. Манайд бол өөр нам руу орвол тэгээд л урвагчаар нь дуудаад л тэр хүнийг байхгүй болгоно л доо.

Нам өөрчлөх яах вэ, эх орноосоо харин урваж байгаа шүү. Бас намын нэрээр. Том эрх ашгийн төлөө байж чадахгүй. Улс орныхоо байгалийн баялаг эрх ашгийг ард түмнийхээ нийтийн төлөө байлгаж чадахгүй байдгийг бүгд мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр саяын миний асуусан асуултуудад хариулахыг хүсэж байна, тийм.

Г.Занданшатар: 80 Болорчулуун гишүүний асуултад Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Болорчулуун гишүүнтэй олон зүйлээр бас санал нэгдэж байгаа. Ялангуяа энэ улс төрийн намуудтай холбоотой, хэтэрхий улс төржиж байгаа байдлуудтай холбоотой, манай ард иргэдийн дунд байгаа энэ хатуу гишүүнчлэлээс улбаалсан энэ зүйлүүд бол энэ 30 жилд бид нарын бас нэлээн шүдний өвчин болж ирсэн асуудлууд. Зарим нэг ярьж байгаа зүйлүүд бол Сонгуулийн хууль руу илүү орох байх л даа. Яагаад гэхээр энэ Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль эд нар бол хүйн холбоотой хоорондоо ийм хуулиуд. Тийм учраас зарим зохицуулалтууд тийшээ орох байх гэж бодож байна.

Зүгээр ер нь бол энд бол бид нар бас нэлээн олон заалтууд хийж өгсөн. Энэ удаагийн Улс төрийн намын хуулийн 1 амин сүнс бол улс төрийн намуудыг бодлогын институт болгох чиглэл рүү нь төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бодлогын институт болгох чиглэл рүү нь шахсан олон заалтууд орж ирж байгаа юм. Тэр нь юу хэлж байгаа вэ гэхээр улс төрийн намууд өөрийнхөө жилийн санхүүжилтийн тодорхой хувийг хөгжлийн бодлого боловсруулахад, судалгаа хийхэд, хөгжлийн бодлогоо төлөвлөхөд зарцуулдаг байхаар зааж өгч байгаа. Хэрэв тэр жилийн 15 хувиа тэрэнд зарцуулаагүй байх юм бол нөгөө

аудитын шалгалт, нөгөө тайлан Сонгуулийн төв хороонд сонгуулийн төв байгууллагад өгч байгаа тайлан дээрээ зөрөх юм бол улсын орлого болгох болгодог хүртэл ийм арга хэмжээ авах юм. Нэг ёсны таны түрүүний хэлдэг амлалт, үүрэг авах гэж байгаа бол тэр амлалт, үүрэг нь улсын хөгжлийн бодлоготой нийцэж байх ёстой. Улс орны гаргасан урт хугацааны, дунд хугацааны хөгжлийн бодлогуудтай нийцдэггүй. Өглөө босож ирээд гэнэт санаанд орсон тоогоо тавьдаг. Сонгууль ойртохоор хорвоо дэлхий хамгийн сайхан болгочих юм шиг худлаа амлалтууд өгдөг. Амьдралд нийцэхгүй, Монголын хөрсөнд буухгүй энэ зүйлүүдийг бол хааж өгсөн заалтуудыг оруулж өгсөн. Улс төрийн нам бол намын мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа улс орны хөгжлийн хөтөлбөртэй уялдаж л тэр асуудлуудаа тавихаар зааж өгсөн гэдгийг бас тодотгож хэлье.

Ер нь бол Монголчууд бид нар цөөхөн ард түмэн, хагалж бутрахгүй байх ёстой. Өнөөдөр 36 нам гэдэг бол улс төрийн намын тооны хувьд ч гэсэн хэтэрхий олон байгаа гэж үзэж байгаа. Монголчууд бид нар эвлэлдэж нэгдэх, нийлэх, нэгдэл рүүгээ явах цаг болсон. Тийм учраас энэ агуулгаараа бол энэ удаагийн хуулиар бол бид нар энэ чиглэл рүү агуулгын концепцын өөрчлөлтүүд орж байгаа. Улс төрийн нам мэдээж иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөө байлгүй яах вэ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө байлгүй яах вэ. Гэхдээ энэ эрх чөлөөнүүдийг хангахын хүрээнд нэрэн доор энэ цөөхөн ард түмнийг хэт хувааж, олон намд хувааж ингэж болохгүй гэж ингэж үзэж байгаа юм. Тэр агуулгаараа хэрэв иргэд эвлэлдэн нэгдээд, үзэл бодлоороо нэгдээд улс төрийн нам байгуулж байгаа бол хариуцлагатай явах ёстой. Тийм учраас улс төрийн намыг хариуцлагажуулах заалтуудыг нэлээн хийж өгсөн гэдгийг хэлье.

Яг тэр анхан, дунд шатын бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор

ялангуяа 10000-аас дээш хүн амтай суурин газар л улс төрийн нам байгуулна гэх юм бол Үндсэн хуулийн зөрчил рүү орж байгаа учраас бид нар энийг 1 ёсны тэр 10000 хүн амтай сууринд амьдарсныхаа төлөө эвлэлдэн нэгдэж болохгүй, улс төрийн намд гишүүн байж болохгүй гэсэн агуулга цаана нь явж байгаа учраас энэ дээр одоо бид намуудын дүрмээр зохицуулахаар оруулсан. Манай ХҮН намаас энийг тусгайлан бүр заалт болгож өгөөч гээд ингээд одоо ирсэн саналуудын 1 нь. Тэгээд бол яах вэ хуулийн төсөл боловсруулах хууль санаачлагчийн хувьд бол үзэж байгаад энийг бол энэ удаагийн хуулийн төсөлд ороогүй. Мэдээж хэлэлцүүлгийн явцад бид нар энэ улс төрийн намуудын зарим 1 зүйлүүдийг бол хязгаарлах ийм зүйлүүд явах байх гэж.

Жишээ нь сумын иргэдийн Хурал орон нутгийн сонгуульд улс төрийн намыг оролцуулдаггүй, улс төрийн намаар нэр дэвшүүлдэггүй байгаач гэдэг саналууд олон намаас ирсэн. Гэтэл энэ бол Сонгуулийн хуулиар зохицуулах болохоос Улс төрийн намын хуулиар зохицуулах ёсгүй юм байна гээд ингээд орхисон байж байх жишээний. Миний түрүүний хэлдэг сая Болорчулуун сайдын хэлж байгаа олон асуудлууд бол зарим 1 зүйлүүд нь Сонгуулийн хууль дээрээ хамтад нь авч үзэж, аль нь Улс төрийн намын хууль руу орох ёстой юм зохицуулалт юм, аль нь Сонгуулийн хуулийн хүрээнд зохицуулах зохицуулалт юм бэ гэдгийг явах байх. Тийм ч учраас өнөөдөр Улсын Их Хурал.../минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн асуулт асууна.

Х.Болорчулуун: Намын үүр салбар байгуулахдаа үнэхээр 2, 3 мянган хүнтэй сум дээр намын үүр салбар байгуулаад тэнд нь бол хэд хэдэн нам байгуулагдаад энэ ингэж жижигхэн ард түмнээ талцуулж, эв нэгдлийг нь бутаргамааргүй байна. Энэ Ерөнхийлөгчөөс санаачилж байгаа Ерөнхийлөгч бүх ард түмний эв нэгдлийн

бэлгэдэл байх ёстой. Энийг сумынхан хүсэж байгаа шүү. Би өөрөө насаараа Их Хурлын гишүүн болтлоо орон нутагт амьдарсан хүн. Үгүй ээ, яагаад тэр аймгийн төв дээр, тэр нийслэлд нь намын үүрүүд нь байг л даа. Заавал тэр 10000-ыг нь заахгүй гэхэд. Суман дээр заавал намын үүр байлгахыг хуулиар энэ Намын хуулиар ч гэсэн заамааргүй байна гэж хэлэхээр байна.

Хоёрдугаарт намын хатуу гишүүнчлэлээс болино гэж зөндөө л ярьсан, ажил хэрэг болгомоор байна. Ингэхийн тулд яах ёстой вэ гэвэл намын.../минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн 1 минут.

Х.Болорчулуун: Намын гишүүнчлэлийн татвар цахим ил тод байх ёстой. Манайх Цахим яамтай болчихлоо шүү дээ. Татвараа төлөхгүй б сар болдог ч юм уу, улирал болдог ч юм уу тэгвэл автоматаар намын гишүүнчлэлээр хасагдах ч юм уу ийм юуг оруулмаар байна. Тэрнээс татвар төлөхгүй мөртөө хэдэн сар, жилээр явчхаад намын гишүүн гээд л ингээд бүртгүүлэлтээ хэвээр байдаг энэ байдлыг л халъя. Татвар төлөхгүй нь яах вэ дэмжигч гишүүн гэнэ үү, дэмжигч л байдаг юм байгаа биз. Яг гишүүнчлэлийн тэр татвар төлөлтийг хүртэл ил тод бол болгоё. Энэ дээр наад хуулийн бас зохицуулалт чиглэл бас яваасай гэдгийг бас хүсэх байна. Энийг анхаарч ажлын хэсэг ажиллаасай.

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: 2005 оны хуульд бол намын засаг захиргааны нэгж аймгуудад намын байгууллага байгуулах ийм заалт байсан юм. Тэгээд сүүлд бол хүчингүй болсон санагдаж байна. Одоо байгаа хүчин төгөлдөр хуульд. Энэ хуульд бол бид нар намууд зохицуулаад заавал сумандаа байгуулах юм уу, аймаг орон нутагт байгуулъя гэсэн заалт байхгүй.

Тэр бол улс төрийн намууд өөрсдийн зохицуулалтаар дүрмээрээ зохицуулах асуудал болж байгаа юм. Нээлттэй болгож байгаа гэсэн үг. Нээлттэй болгож байгаа гэсэн үг. Тийм учраас хэрвээ зарим намууд илүү цахимжаад, илүү яагаад заавал аймаг орон нутагт байгуулахгүй бол чи заавал тэр сумд байгуул, аймгуудад байгуул гэдэг заалт байхгүй шүү. Энийг бас тодотгож хэлэхгүй бол буруу ойлголт явах гээд байх шиг байна.

Хоёр дахь нь болохоор бол тантай яг санал 1 байгаа. Хатуу гишүүнчлэлээсээ татгалзаад. Дэлхийд намын гишүүнгүй улс төрийн нам гэж байхгүй. Улс төрийн нам хатуу гишүүнтэй юу, сул гишүүнтэй юу л гэж байгаа юм. Бид нар тэр сул гишүүнтэй буюу намын хатуу гишүүн буюу тэр намын жинхэнэ гишүүнийг намынхаа дотоод саналдаа саналаа өгдөг, дотоод сонгуульдаа саналаа өгдөг, татвараа төлдгийг нь байя. Бусад нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна.

Х.Баделхан: Баярлалаа. Манай улс олон намын тогтолцоонд шилжээд гуч гаруй жил болсон. Өмнөх нийгэмд бол нам хамт намын хамт олноороо хэлэлцээд хүмүүсийг төлөвшүүлдэг, хүмүүжүүлдэг байсан, асуудал шийддэг байсан. Одоо бидний нам бол зүгээр л сонгуулийн төлөөлөл засгийн эрхийн төлөөлөл ажиллаж байгаа нам болоод хувирч байгаа шүү дээ. Яг амьдрал дээр сая би гишүүд ярьж байна нэг хамгийн гол дутагдал бол хэт их намчирхдаг. Хүмүүсийг бол намаар нь ялгаварладаг. Чи мөнхийн цагаан, чи мөнхийн улаан нам гэсэн. Тэгээд сонгууль болгоны дараа нөгөө ажлын төлөө тэгээд тэмцэл явагддаг. Солино, хална, сэлгэнэ. Тэгээд энэ л бидний хамгийн гол дутагдал болж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ тэр хатуу гишүүнчлэл гэдгийг нь бас жаахан ялгаж

зааглахгүй бол болохгүй юм байна. Одоо бодлогын нам болгоно гэж энэ зөв. Нам бодлогоороо улс төрийн сонгуульд ороод, аль ялсан нам тэгээд Засгийн эрх бариад хөтөлбөрөө хэрэгжүүлдэг. Америк бол ерөөсөө сонгууль болгон дээр 2 нам л бодлогоороо өрсөлдөөд байгаа шүү дээ. Тэгээд аль нь ялна тэр намаа байгуулаад тэгээд ажилладаг. Бид нар бас ер нь цаашидаа тийм зам руу явах нь зөв байгаа.

Хамгийн гол нь хөдөө хэт их улс төрждөг. Хэт их улс төржинө, тэгээд ялангуяа сонгуулийн үед бол тэр сонгуульд бол бараг бүх хүмүүс ажилтай болохын төлөө, нэг амьдралтай болохын төлөө л сонгуульд яваад, тэгээд сонгуульд ялалт байгуулсны дараа би тийм ажил авна, тийм юм хийнэ гэсэн ийм тогтолцоотой болсон шүү дээ бид нар. Бид нар энийгээ засмаар байна. Тийм учраас ер нь хатуу гишүүнчлэл гэдгээсээ ер нь тодорхой хэмжээгээр бид нар энэ удаад татгалзах нь зөв гэсэн саналтай байгаа. Тодорхой бодлогын нам болъё гэж.

Тэгээд өнөөдөр бол 36 нам Улсын дээд шүүхэд бүртгэлтэй гэж байгаа. Тэгээд энэ 36 нам ер нь 1 ганц 2 намаас бусдыг нь бол бид нар мэдэхгүй шүү дээ. Арай ч ийм байж болохгүй л дээ. Тэгээд энэ хуулийн төсөл дээр бас 1 ийм зүйл байгаа юм байна 27.3 дээр бол нийт сонгогчдын 2-оос дээш хувийн санал авсан намыг төрөөс санхүүжнэ гэж. Энэ ямар юу гэсэн үг юм бэ? Сая бид нар сонгуулийн хууль ярихдаа бол 3 хувиас дээш ялсан нам бол парламентад суудал авдаг гэсэн. Тэгээд энэ 2 хувийг нь санхүүжүүлнэ гэж энэ төрөөс санхүүжнэ гэж заасан байна. Энэ ямар учиртай юм бэ гэж асуумаар байна? Баярлалаа.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна. 80.

Я.Содбаатар: Тийм. Бид нар энэ удаагийн хуулиар энэ төрөөс улс төрийн намуудад өгч байгаа хөрөнгө мөнгөний

хэмжээ, зарцуулалт, зориулалт, тайлан, энд тавих хяналт гээд цогцоор нь авч үзэж байгаа юм. Өнөөдөр улс төрийн намуудын хууль өнөөдөр байгаа. Өнөөдөр бол улс төрийн намууд суудлын авсан суудлын тоогоор суудлын мөнгө гэж авч байгаа юм. Парламентад суудалтай намууд. Аймаг орон нутгуудын иргэдийн Хурал өөрсдөө журам гаргаад аймгийн иргэдийн хурал, сумын иргэдийн хурлын бас суудлын мөнгө, төлөөлөгчийн мөнгө гээд бас тодорхой мөнгө баталдаг. Улсын төсвөөс өнгөрсөн 4 жилийг аваад үзэх юм бол бас багагүй хэмжээний хорь гаран тэрбум төгрөгийн зарцуулсан байгаа юм.

Тэгэхээр бид бүхэн бол энэ удаагийн хуульдаа бол энэ төрийн санхүүжилт гэдэг юмыг маш тодорхой болгоё. Нэг ёсны сонгогчдын саналтай уялдуулж энийг өгдөг, сонгогчдын парламентад өгсөн саналтай нь уялдаж энэ хөрөнгө мөнгийг өгдөг болъё гэж ийм санал оруулж байгаа. Тэгэхээр сонгогчдоос санал авч чадахгүй, ард түмний дэмжлэггүй бол тэр нам дэмжлэг авахгүй гэсэн үг. Тэгээд ингэж үзэж байгаад ер нь улс төрийн намуудыг төлөвшүүлэх, улс төрийн намуудаа дэмжих гэдэг агуулгаараа бол бид бүхэн нийт сонгогчдын 2-оос дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно гэдэг ийм заалт оруулж байгаа юм.

Сүүлийн 4 сонгуулийн дүнг аваад үзэх юм бол 4 сонгуулийн дүнг аваад үзэх юм бол энэ босгыг давсан улс төрийн намууд маш цөөхөн байгаа. Маш цөөхөн байгаа. 36 нам мөнгө төгрөг авах гээд байгаа юм биш. Юу гэсэн үг вэ гэхээр сүүлийн энэ ийм шийдвэр яасан болохоор би сүүлийн сонгуулийн дүнгүүдийг ерөнхий ингээд та бүхэнд хэлээд өгье. 12 онд бол 4 нам л сонгогчдын 1 хувийн саналыг давсан байгаа. Улсын Их Хурлын сонгуулиар МАН, АН, МАХН Шударга Ёс Эвсэл, Иргэний Зориг Нам л энэ сонгогчдын ийм саналыг авсан, дөрөвхөн субъект. 16 оны сонгуулиар Улсын Их Хурлын сонгуулиар МАН, АН, МАХН, Тусгаар тогтнол эв нэгдлийн эвсэл, Бүгд

найрамдах нам л 1 хувийн босго давсан байгаа. Хамгийн сүүлд Бүгд найрамдах нам 1.66-аар жишээ нь энэ босгыг давж байгаа, 1 хувийн босгыг нь. 2 хувийн босго гэх юм бол 4, 5-хан нам.

2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр аваад үзэх юм бол МАН, АН, Та бидний эвсэл, Зөв хүн электорат эвсэл, Шинэ эвсэл 2 хувийн босго давсан, 1 хувийн босго давсан хүн гэх юм бол Сахигтун 19 эвсэл 1.04-өөр давж байгаа юм. Нэг ёсны улс төрийн нам гэж хэлээд байгаа энэ 36 субъектийн чинь яг сонгуульд ороод ард иргэдийнхээ дэмжлэгийг авсныг авах юм бол 1 хувийн босго давж байгаа нь ерөөсөө л 4-5 нам л даваад байгаа юм. Тийм учраас бид бүхэн энэ ард иргэдийн дэмжлэгийг авч байгаа энэ улс төрийн юунуудад энэ төрийн санхүүжилт олгох энэ зүйлийг оруулж ирж байгаа.

Сонгуульд оролцдоггүй намууд бас байна. Нөгөө гол зорилгоо биелүүлдэггүй. Тийм учраас ингэх юм бол бид нар ээлжит сонгуульд оролцохгүй бол намыг идэвхгүйд тооцох, цааш нь татан буулгах арга хэмжээ авахаар бас хариуцлагын тогтолцоо оруулж өгч байгаа.

Төрийн санхүүжилтийн хэлбэр бол өнөөдрийн тооцож байгаагаар бол улсаас өнгөрсөн 4 жилд гарсан сүүлийн жилүүдэд гарсан хөрөнгө мөнгөнөөс төсөв дээр ирэх ачаалал бол илүү нэмэгдэхгүй байгаа гэдгийг бас тодотгож хэлэх нь зүйтэй байх. Хэлбэрийн хувьд бол бид нар 1 хувийн босго давсан намуудад шууд бус дэмжлэг гээд бодлого үйл ажиллагаагаа, мөрийн хөтөлбөрөө олон түмэнд сурталчлах чиглэлээр Олон нийтийн радио, телевизээр тодорхой үнэ төлбөргүй нэвтрүүлэг явуулах, төрийн болон төрийн өмчит заал танхимыг 1 жил жилд 1 удаа үнэгүй ашиглах эрх олгох гэх мэтчилэн ийм дэмжлэгүүд үзүүлж байгаа. 2 хувийн босго давсан намуудад бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж.../минут дуусав/

Г.Занданшатар: Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна, тодруулна 1 минут.

Х.Баделхан: Тийм. Энэ зүгээр тэр Сонгуулийн тухай хуулийн дагуу яг тэрүүнтэй уялдаатай тэгээд парламентад суудал авсан байвал тэр санхүүжилт авдаг бол ер нь зөв юм биш үү. Нэг нь бол 2 хувьтай, нэг нь 3 хувьтай гэж хэлсэн. Сая Казахстан улсад 3 сонгууль явагдсан, 6 нам орсон. Энэ манайх ч гэсэн цаашидаа бол 4, 5 л нам гарчих байх л даа. Тийм учраас 3 хувь гэж тэр Сонгуулийн хуультай уялдуулсан нь дээр байх гэсэн саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан Саньяазын Хавдислам, Ташкени Жибек нарын 3 дахь хүүхэд болж 4 дүгээр сарын 17-ны өдөр эхээс мэндэлжээ. Ингээд танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Манай Улсын Их Хурлын хамгийн ахмад гишүүн танд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөж байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ Улс төрийн намын хууль бол үнэхээр яах аргагүй маш чухал олон хөгжлийн суурь асуудлуудыг шийдэх ийм шинэ хууль гэж үзэж байна. Тэгээд зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Нөгөөтээгүүр бас урьдчилаад өргөн барихаасаа өмнө манай намаас нэлээдгүй саналуудыг авч оруулсанд талархаж байна. Ороогүй бас саналууд байх шиг байна. Энийг хэлэлцүүлгийн явцад бас ярьж хэлэлцээд оруулахаар ажиллана гэж бодож байна.

Сая Транспэрэнси интернэйшнел байгууллагаас судалгаа хийхэд ерөөсөө Монгол Улсад байгаа энэ авлигын гол үүсгээд байгаа хэсэг чинь ерөөсөө улс төрийн намууд нь өөрсдөө юм байна. Энэ сонгууль нь юм байна. Улс төрийн нам нь асар их мөнгө шаарддаг, үзэл бодлогоороо өрсөлдөхөөсөө илүү ерөөсөө маш их санхүүжилт авдаг ААН шиг, ашигт, ашигтай үйл ажиллагаа явуулдаг энэ бизнесийн ч байгууллага юм шиг иймэрхүү чиглэлээр маш буруу явж байна гэдэг ийм дүгнэлтүүд бол ер нь гарч байгаа. Тэгэхээр дэлхийн улс орнуудын одоо энэ улс төрийн намын жишигийг харахад ерөөсөө бүгд л улам хялбархан цомхон ийм чиглэл рүүгээ орж байна.

Яагаад гэхээр тэгэхлээр өөрөө цахим бий болчихсон. Өнөөдөр завал тэр хуучны 21 он, 90 он шиг сум болгонд 1 салбар үүсгээд, тэнд өөрсдийн үзэл бодлоо түгээх гишүүдийг бий болгох биш ерөөсөө хүн гар утсаар өнөөдөр цахимаар бүх л үзэл бодлыг ингээд мэдэж авах ийм боломжтой болж байгаа юм. Тэгэхээр энэ дээр эмэгтэйчүүдийг дэмжсэн маш олон асуудлууд орсонд баяртай байгаа. Энийг бас цаашидаа бид нэлээд нарийвчлаад хэлэлцэнэ.

Нэг чухал асуудал юу вэ гэхээр энэ орон нутагт хэт улс төрждөг байдлыг бид нар болиулах ёстой юм. Цөөхөн Монголчууд чинь зүгээр ёстой орон нутагт маш их өрсөлддөг. Би бол Улсын Их Хурал дээр мэдээж намууд өөрсдийн хөгжлийн бодлогоороо өрсөлдөх нь зөв, мэтгэлцэх нь зөв, хөгжлийн бодлого манай намын үзэл баримтлал ийм байна гэхээс илүү гэдэг болохоос биш яг орон нутагт очихоор зүгээр аж ахуйн ажлууд байдаг. Энд цэцэрлэг хэрэгтэй юу, сургууль хэрэгтэй юу, замыг нь хаана барих вэ гэдэг аж ахуйн ажил дээр бол улс төржилт нь илүү садаа болдог. Эсвэл улс төржилт нь тэнд маш буруу зүйлийг хааж хаах ийм юу болж байдаг. Тийм учраас бид энэ орон нутагт улс төржилтийг багасгах дээр том дэвшил гарах ёстой.

Хоёр дахь чухал асуудал түрүүн Даваасүрэн гишүүн хэлээд байна лээ. Энэ төрийн албыг ерөөсөө энэ улс төрийн намууд бид нар өөрсдөө самраад байна байна. Төрийн албаны нөгөө мерит зарчим, төрийн албаны чадавхтай байх асуудал чинь ерөөсөө сүүлийн олон жил бүр байхгүй болчихлоо. Тэгээд л нэг хэдэн цүнх баригчид л очоод л, тэр төрийн албуудыг эзэлж байдаг. Ямар ч мэргэжлийн бус ийм зүйлийг бол хориглох ёстой. Тэгэхээр энэ дээр бүр надад тодорхой санал байгаа. Энийг би хэлэлцүүлгийн явцад хийнэ. Бид нар нэг тодорхой он зааж өгөөд, хүмүүс сонголтоо хий. Чи улс төрийн мэргэжсэн улс төрч болох юм уу эсвэл чи төрийн албаар явах юм уу. Залуучууд сонголтоо хий. Хооронд нь ингэж ерөөсөө сүлжиж байдаг энэ замыг бол хаах хэрэгтэй. Мэдээж яах вэ сонгуулийн дараа улс төрийн албан тушаалууд байна.

Гэхдээ улс төрөөс гадна тэр төрийн байгууллага руу ордог энэ зүйлийг бол ерөөсөө зогсоохгүйгээр энэ Улс төрийн намын хууль бол би ач холбогдлоо өгөхгүй гэж харж байгаа. Нөгөөтээгүүр энэ Сонгуулийн хуульд энэ Доржханд гишүүн бид нар нэг зүйл оруулаад байгаа. Ер нь энэ 1 бүгдээрээ 1 юм тараадгаа больё гэж. Одоо ард иргэд бол бүр тэрийг хүсэхээ байчхаж. Бид нарын тэтгэврийг нэмээд өгөөч, бид нарыг ажилтай болгоод өгөөч, наад гурил будаагаа битгий тараа гэж иргэд бүр тэгж хэлж байна шүү дээ. Тэгэхээр улс төрийн нам яг өөрсдийнхөө үзэл бодлыг үзэл баримтлалыг хийсэн ийм ном товхимол тараахаас биш улс төрийн нам нь нэр дэвшигчид нь одоо энэ нэг бараа таваар тарааж ард түмнээ доромжилдгоо.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Одонтуяа даргын асуултад Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Одонтуяа гишүүнтэй бас санал 1 байна. Ер нь энэ улс төрийг мөнгөний нөлөөллийг холтгох, багасгах, улс төрийн зардлыг багасгах л

чиглэл рүү л бид нар бүгдээрээ явах ёстой. Би харин парламентын гишүүд үг хэлсэн гишүүн болгон энэ хэт улс төржилтийг багасгая, улс төрийн зардлыг багасгая гэдэг талаар үг хэлж байгаад их баяртай байгаа юм. Яг энэ чиглэл рүү энэ Улс төрийн намын тухай хуулийг батлан гаргахдаа, Сонгуулийн хуулийг батлан гаргахдаа ажиллаасай гэж бас хүсэж байгаа юм. Тэр агуулгаар нь аваад үзэх юм бол энэ удаагийн юун дотор бид нар энэ улс төрийн зардлыг багасгах, улс төрд орж ирж байгаа энэ хандив нэрээр орж ирж байгаа хөрөнгө мөнгийг тодорхой болгох, ойлгомжтой болгох чиглэл рүү бол олон заалтууд орсон.

Тухайлбал 1 хуулийн этгээд эцсийн өмчлөгчөөрөө жилд 1 удаа 1 улс төрийн намд одоогийн ханшаар бол 27000000 төгрөг л хандивлах боломжтой болж байгаа юм. Нэг ёсны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин үргэлжлүүлсэн, тэр нь ойролцоогоор 27000000 төгрөг. 1 хувь иргэн жилд улс төрийн 1 намд нийлбэр дүнгээрээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин үржүүлсэн буюу ойролцоогоор 6 сая төгрөг л хандивлах боломжтой болж байгаа юм. Өнөөдөр бол энийг ингэж нарийн зааж өгөөгүйгээсээ болоод тодорхой улс төрийн намуудад улс төрд хөрөнгө мөнгө зарцуулдаг, хандив нэрээр мөнгөний захиалга өгдөг, энэ нь эргээд өөрөө улс төрийг өөрөө бохирдуулдаг, эргээд түрүүний хэлдэг тэр авлигал хээл хахууль олон юмны үндэс суурь болоод байгаа учраас ялангуяа энэ одоо хуулийн этгээдээс ирж байгаа, хувь хүнээс ярьж байгаа энэ хандивын асуудал дээр бол нэлээн хязгаар тавьж өгч, эргээд зарцуулалтыг нь бас их тодорхой болгох чиглэлээр заалтууд орж өгсөн.

Яг орж ирж байгаа мөнгөний 15 хувийг нь бол чи судалгаандаа зарцуулна шүү. Хөгжлийн бодлого боловсруулахдаа зарцуулна шүү. 15 хувийг нь иргэдийг соён гэгээрүүлэх улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна шүү. 20 хувийг тэр улс төрд төлөөлөл нь бага байгаад

байгаа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд гээд энд нийгмийн бүлгүүдийг дэмжихэд зарцуулна шүү гээд ингээд тодорхой зааж өгөөд, эргээд энийгээ тайланг нь авдаг, энэ дээр аудит оруулдаг, энийгээ парламент дээр авчирч олон түмний өмнө нээлттэй хэлэлцдэг болгож өгч байгаа юм.

Тийм учраас энэ улс төр дэх зардлыг багасгах, тэгээд улс төр аяндаа зардал нь багасаад ирэхээр ёс зүйтэй, харууцлагатай, мэдлэг боловсролтой хүмүүс энэ төр барих тийм ээ улс төр рүү орж ирэх энэ үүд хаалга илүү нээгдэнэ. Тийм учраас бид бүхэн бүгдээрээ энэ чиглэл рүү яваасай гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бол зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Би бол гишүүдийн яриад байгаатай санал бол нэг бол байна. Ер нь энэ төр тунгалаг байх, нийгэмд шударга ёсыг тогтоох, авлигал хээл хахуулиас ангид байх энэ бүхний бас үндэс нь бол энэ улс төрийн намын үйл ажиллагаа, улс төрийн намын үйл ажиллагаа харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь нэлээн боловсронгуй тодорхой байхтай шууд хамааралтай гэж би бол тэгж ойлгоод байгаа юм. Тэгээд нэг үеэ бодвол энэ Улс төрийн намын хуулийн тухай хуулийн төслийг харахаар бол нэлээн дотоод ардчиллыг хөгжүүлэхтэй холбоотой, санхүү тайлан нь ил тод байх аудит бас хийлгэдэг байх эд нар гээд нэлээн ийм асуудлууд бол тодорхой орж ирж байгаа юм байна.

Тэгээд хэд хэдэн тодруулах зүйл бол байна. Улс төрийн намуудад улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм байна. Энэ санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудал чинь ер нь тэгээд энэ парламентад суудалтай намуудад байх юм уу? Тэр 2 хувийн санал авсан бол

санхүүжилт олгоно гээд байгаа юм. Энэ чинь парламентад суудалтай намуудад санхүүжилт олгох асуудал яриад байна уу? Ерөөсөө сонгогчдын 2 хувиас дээш хувийн санал авсан нам нь санхүүжилт авах асуудал яриад байгаа юм уу? Энхийг нэг тодорхой заагийг нь гаргаж хэлмээр байх юм. Би бол парламентад суудалтай намд нам нь л санхүүжилт авдаг байх нь зүйтэй юм болов уу гэсэн ийм бодолтой бол байгаа юм. Энхийг та та бүхэнд юу гэж үзэж байна вэ?

2 дахь асуудал нь энэ дотор чинь хэд хэдэн тоо бас зөрчилтэй юмнууд харагдаад байх юм. Нам намын тэр квоттой холбоотой асуудал. Намын нэрээр сонгуульт албан тушаалд сонгогдох, томилуулах албан тушаалтнууд аль нэг хүйсийн төлөөлөл нь 30 хувь 30 хувиас доошгүй байна гээд 8.2.3 дээр байгаа юм. Гэтэл 17.6 дээр чинь намын төв болоод удирдах хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль 1 хүйсийн төлөөлөл 40 хувь гээд байх юм. Энэ яагаад ингээд 1-д нэг болохоор 30 хувь гээд, нэг болохоор 40 хувь гээд ингээд 2 янзын тоо яваад байх юм бэ? Аль нэг тоогоор нь авч үзэж болохгүй ингээд яг энэ ялгамжтай юм шиг ийм юм яваад байдаг юм.

2 дахь асуудал нь энэ намын бусад байгууллага гээд байна. Одоо бол зөвхөн тэр судалгаа шинжилгээний л байгууллагатай л байх л юм байна л даа. Одоогоор бол намууд чинь бол иргэдийн дүрмээрээ эмэгтэйчүүдийн, ахмадын, залуучуудын эд нар гээд ингээд ТББ-ын бас хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ийм бүтцүүд бол байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль батлагдах юм бол энэ ахмадын, залуучуудын, эмэгтэйчүүдийн эд нар чиглэлээр ажилладаг ийм бас намын бүтцийн намын дэргэдэх ийм байгууллагууд бол үйл ажиллагаа байхгүй болчхож байгаа юм уу? Би тэгж л ойлгоод байх юм. Би бол энэ байх ёстой гэж бол би ойлгоод байх юм. Залуучууд, ахмадууд, эмэгтэйчүүдийн төлөөллийн намын

дэргэдэх бүтцийн байгууллага нь уг нь бол байх ёстой юм болов уу гэж.

3 дахь асуудал энэ намыг бас хариуцлагажуулахтай холбоотой юм бол байна. Иргэдийн ярьж байгаа бол бас л энэ намын манайд бол намууд бол олон байна. Гуравхан сая хүн амтай, 36, 7 намтай байна энэ олон байна, намуудыг жоохон хариуцлагажуулж, жоохон цөөлөөч гэсэн юм ярьдаг л даа иргэд. Тэгээд энэтэй хариуцлагатай орж ирж байгаа юм чинь бас жаахан ойлгомжгүй л байна л даа. Улсын Их Хурлын сонгуульд 2 дараалан парламентын сонгуульд нэр дэвшүүлээгүй бол идэвхгүй намд ингээд тооцно гээд. Тэгээд тэр нь буцаагаад бол амархан тайлбараа өгөх юм бол буцаад сэргээж болохоор юм шиг. Энэ бол нэг хариуцлагын тогтолцоо гэж би бол ойлгохгүй л бол байна.

Арай хатуудгах тухайлбал ер нь болдог бол улс төрийн 2 дараалан сонгуульд нэр дэвшүүлээгүй биш, 2 дараалан сонгогчдын 2 юм уу, 3 хувийн санал аваагүй бол энэ улс төрийн намд хариуцлага тооцдог байх ийм чиглэлээр хариуцлагад асуудлууд бүр тодорхой.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Улсын төсвийн дэмжлэгийн босготой холбоотой улсын төсвийн дэмжлэгтэй холбоотой асуудлаар Мөнхсайхан доктор бас нэмж хариулаарай. Ер нь бол бид бүхэн өнөөдөр ч гэсэн улсын төсвөөс тодорхой дэмжлэгийг улс төрийн намуудад өгч ирсэн. Би түрүүн хэлсэн суудлын мөнгө, аймаг орон нутгуудад, аймгийн иргэдийн Хурал, сумын иргэдийн Хурлын бас мөнгө, төлөөлөгчдийн мөнгө нэрээр. Тэгээд эд нарыг бол 1 ойлгомжтой тодорхой сонгогчдын саналтай уялдуулж л тодорхой болгож байгаа. Эргээд зарцуулалт, зориулалт, тайлан эд нарыг нь нэлээн тодорхой болгож өгч байгаа. Тэгэхгүйгээр энд шинээр одоо улсын төсвөөс юм өгчих гээд байгаа юм уу,

намуудыг дэмжээд байгаа зүйл хараахан биш гэдгийг бас нэгдүгээрт хэлчихье.

2 дахь асуултын хувьд бол энэ 2 янзын хувь явж байгаа нь үнэн. 1 нь бол намын дотоод сонгууль, намын удирдах байгууллагуудад эмэгтэйчүүдийн буюу жендертэй холбоотой 1 хүйсийн юуг 40 хувь гэж авсан байгаа босгыг. Улс төрийн намаас төрд сонгож томилогддог албан тушаал руу явж байгаа хувийг 30 гэж авсан байгаа. Нам доторх нь бол 40. Сонгуулийн хуультайгаа уялдуулаад сонгуульд нэр дэвшүүлээ гэхэд 1 хүйсийнх нь байдал 30 хувиас доошгүй байна гэж ингэж энэ Сонгуулийн хуультай уялдуулж 2 хувь явж байгаа юм. Нэг нь намын доторх хувь, нэг нь юуны хувь.

3-д судалгаа шинжилгээний байгууллагатай байх тэр нь хүрээлэнгийн хэлбэртэй, сангийн хэлбэртэй байх зүйлүүдийг нарийвчилж зааж өгсөн. Бид нар ер нь энэ бол хуулийн нэг амин сүнс нь бол ер нь улс төрийн намууд нь өөрөө бодлогын институт болж л төлөвших ёстой юм байгаа юм. Тулга тойрсон хэрүүл хийдэг биш, бүлэглэл юм, янз бүрийн энэ үзэл баримтлал үнэт зүйлгүй бүлэглэл биш, бодлогоороо уралддаг, хөгжлийн бодлого ярьдаг ийм талбар байгаасай гэж хүсэж байгаа. Тэр утгаараа бол санхүүжилтийн тодорхой хувийг зарцуулах хувийг ч зааж өгч байгаа. Ийм байгууллагуудтай байх чиглэлийг ч зааж өгч байгаа гэдгийг бас тодотгож хэлье.

Намуудын дэргэдэх байгууллагын асуудал бол хуулийн төсөл боловсруулах явцад хамгийн их яригдсан асуудлуудын нэг. Бид нар бас олон улсын жишиг юуг нэлээн судалсан. Олон улсад бол коммунист ч нам нь байна уу, АН нь ч байна уу, барууны зүүний үзэлтэй ч байна уу бүгд л улс төрийн намууд иргэдээ нийгмийн бүлгийн ийм байгууллагуудтай байгаа. Тэр битгий хэл энэ байгууллагууд нь олон улсад Либерал залуучуудын холбоо, Социал демократ залуучуудын холбоо нэрээр олон улсад

зуун хэд, зуун хэдэн гишүүнчлэлтэй улс орнуудын гишүүнчлэлтэй ийм нэгдсэн олон улсын байгууллагууд нь ч байж байгаа. Тийм учраас Монгол Улс ч гэсэн энэ олон улсын жишигээр бид нар энэ улс төрийн намууд дэргэдээ энэ нийгмийн бүлгүүдийн байгууллагатай байхыг хуулиар хориглох бол боломж муутай юм гэж ингэж харж байгаа юм.

Зүгээр тэр байгууллагууд нь хуулийн этгээдийн эрхтэй байх юм уу, намын бүтцийн байгууллагын клубийн зарчимтай байх юм уу гэдэг бол хэлэлцүүлгийн явцад нэлээн нарийн тодруулах байх. Бид нар одоогоор бол хуулийн этгээдийн гэсэн агуулгатайгаар явж байгаа. Тийм учраас сая Чинзориг сайдын хэлээд байгаатай санал нэг байгаа. Ер нь бол улс төрийн намуудад энийг хатуу зарим зүйлүүдийг хориглох бол өөрөө бид нар энэ эвлэлдэн нэгдэж орчихсон байж байгаа хүний эрхийн, улс төрийн эрхийн факт, хүний эрхийн конвенцууд, олон улсын юунуудтай бас зарим зүйл дээр зөрчилдчих гээд байгаа учраас энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хэдүүлээ бас зарим зүйлүүдийг бол сайжруулах нь зүйтэй байх гэж ингэж бодож байна. 2 хувийн босготой юугаар нэмж Мөнхсайхан 81 дүгээр микрофон.

Г.Занданшатар: 81 Мөнхсайхан доктор хариулъя. Одонгийн Мөнхсайхан.

О.Мөнхсайхан: Чинзориг гишүүний асуултад нэмэлт тайлбар хэлье. Түүрүүн бас Баделхан гишүүн бас асуусан. Тэгэхээр ер нь бол манай Монгол Улсын хувьд бол уламжлал бол парламентад суудал авсан намуудад суудлаар нь тэрэн дээр нь үндэслэж бол санхүүжилт өгч ирсэн. Тэгэхээр одоогийн хуулийн төсөл бол энэ үндсэн зарчмаа бол хадгалж байгаа. Тухайлбал төслийн 27.5 дээр суудлаар нь тооцож мөнгө хуваарилдаг одоогийн зарчмыг хадгалсан. Нэмээд санал дээр нь бол 2 хувиас хувиас дээш сонгогчдын саналыг авсан намд суудлын мөнгө бол өгөхгүй. Тэр саналыг нь хувилаад тодорхой тооны

багахан хэмжээний санхүүжилт өгөх ийм зохицуулалт нэмэгдэж орж ирж байгаа юм.

Энэний цаад шалтгаан бол бүхэл бүтэн иргэдийн нийт сонгогчдын 2 хувиас дээш гээд иргэдийнхээ дэмжлэгийг авчихсан энэ намуудыг бас орхигдуулахгүй байх ийм зорилготой. Хамгийн гол нь энэ санхүүжилтийг өгснөөрөө хариуцлагажуулж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийн 19¹.1 дээр намын зохион байгуулалт дотроо ардчилсан зарчимд нийцсэн байна, санхүүжилт нь ил тод байна, хандивын хүрээ хязгаар таарах, хэтрүүлэхгүйгээр хандив авна гэх мэтчилэн маш нарийн зохицуулалтууд зөвхөн парламентад суудалтай намуудад үйлчлэхгүй, бүх намуудад үйлчилдэг болгохын тулд тэр саналаар нь тодорхой хувиар санхүүжилт өгч байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол хуульд заасан энэ нарийн шаардлагуудыг хангахгүй, дотоод ардчилалгүй байх, санхүүжилт нь ил тод бус тайлангаа гаргаж өгөхгүй байх энэ мэтчилэн дараа нь тэр төрийн санхүүжилтийг нь зогсоох үндэслэл болоод явчихна. Цаашилаад тэр намыг идэвхгүйд тооцох үндэслэл болчхож байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө эргээд парламентад суудалтай төдийгүй суудалгүй намуудыг илүү хариуцлагатай болгоход чиглэсэн маш чухал ийм хөшүүргийн механизм байж байгаа. Энэ бол олон улсуудад бол жишээлбэл Герман эд нарт пропорциональ санал хураалт дээр 5-аас дээш хувийн санал авч байж парламентдаа ордог. Гэтэл 1 хувийн санал авчих юм бол зөвхөн саналаар нь хувилаад өгчихдөг юм байна лээ. Манайх шиг суудлын мөнгө гэж байхгүй. Манайх бол өөрийн онцлогоо харгалзаад Сонгуулийн хуулийн төсөл дээр 3 хувийн босго авах юм бол Их Хуралд орно гэж байгаатай уялдуулаад зөвхөн 2 хувиас дээш гэхэд маш өндөр ийм босго тавьчихсан.

Түүрүүн Содбаатар даргын тайлбарласнаар энэ дээр бол 4, 5-хан нам эвсэл байгаа юм. Тэгэхээр яг намаараа бол 2, 3 нам 2 хувиас дээшээ аваад бусад нь дандаа эвсэл буюу дотроо маш олон намуудыг багтаасан. Тэгэхээр энэ маань цаанаа бол тэр эвслийн цаана байгаа бүх намуудыг бүгдэнг нь хариуцлагажуулах, ил тод болгох, дотоод ардчилалтай болгох. Түүрүүн гишүүдийн санаа зовж хэлээд байгаа нөгөө эрх барих дээд байгууллагын хурлаа хийдэггүй, намын дарга нь 10, 20 жил ингээд явдаг. Хариуцлага байхгүй, хаанаас ямар мөнгө зарцуулаад байгаа нь мэдэгдэхгүй, эргээд энэ бол зөвхөн тэр нам биш бүх намуудын нэр хүндийг унагаад, цаашаа ардчилалд итгэх итгэлийг унагаад байгаатай холбоотой энэ бол маш олон улсууд ганцхан Европ биш, Азийн улсуудад түгээмэл байдаг энэ зарчмыг бол бид нар тусгаж байгаа. Энэ маань өөрөө 2019 онд Үндсэн хуульд оруулсан 19¹.1 дүгээр зүйлд заасан тэр зарчмуудыг амилуулах нарийн ийм хөшүүрэг механизм байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулъя.

С.Чинзориг: Намыг энэ хариуцлагажуулах, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах энэ асуудлыг жаахан тодорхой болгомоор л байгаа юм л даа. Улсын Их Хурлын сонгуульд 2 удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй бол идэвхгүйд тооцно гээд байгаа юм. Энэ 36 нам чинь тэгээд яаж ийж байгаад л 1 хүн ч юм уу, ядаж л холимог болох юм бол жагсаалтад 1 хүн ч юм уу бичнэ л дээ. Тэгэхээр энэ чинь бол хариуцлага болж чадахгүй байна л гээд байгаа юм. Тийм.

Тэр дараагийн юунд нь харахаар тэр намыг өөрчлөн байгуулах, зогсоох, татан буулгах чинь бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой, тусгаар тогтнолын асуудалд аюул занал учруулсан л бол намыг татан буулгахаас биш тэгээд бусад нөхцөлд бол намууд бол тэгээд байгаа л байх л юм байна шүү дээ.

Иргэдийн яриад байгаа шиг энэ олон нам дэндүү олон байна. Дэндүү улс төржүүлж байна, хариуцлага тооцооч гээд. 2 дараалан сонгуульд нэр дэвшүүлээгүй бол биш 2 дараалан тэр босго давж чадаагүй бол намыг үйл ажиллагаагаа зогсоодог тийм юм руу л явах нь.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Би Чинзориг сайдтай санал нэгдээд байгаа зүйл нь бол ер нь улс төрийн намуудаа бид нар хариуцлагажуулж байж авах тал руу байгаа юм. Тэгээд энэ идэвхгүйд тооцох гэж энэ шинэ заалт орж ирсэн юм. Тэгээд энэ дотор бол 3 заалт байгаа юм. Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 2 дараалан нэр дэвшүүлээгүй бол, энэ хуулийн 37.2-т заасан үүргээ биелүүлээгүй буюу санхүүгийн тайлангаа хугацаанд нь гаргаж өгөөгүй бол, энэ хуулийн 21.3 дахь заалт нь болохоор намын удирдах дээд байгууллага эсвэл төлөөллийн төв байгууллага хугацаанд нь хуралдуулаагүй бол сануулаад, тэгээд идэвхгүй хэлбэрт шилжүүлээд хэрэв зөрчил арилагдахгүй бол явж байгаа юм. Тийм учраас улс төрийн намуудад одоо байгаа улс төрийн намууд бол яг энэ хуулиар явахад бол маш тоо нь цөөрнө, багасна.

Нөгөө талдаа бол саяын таны хэлдэг 2 хувийн босго бол дахиад намуудыг нэгтгэх, нягтрах, эвсэл болгох энэ рүү шахаж байгаа юм. Бид нар сүүлийн 10 сонгуулийн юуг ингээд хараад тэрэн дотроо сүүлийн 3 сонгуулийг харах юм бол энэ парламентад суудалгүй намууд нэгдэж орж байж л энэ босго руу очиж байгаа юм. Дангаараа, дангаараа ерөөсөө босго.../минут дуусав/

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байна, орж ирж байгааг. Яагаад гэвэл одоо байгаа хууль нь бол

зүгээр мафийн хууль шүү дээ. Намын тухай хууль гээд нам үндсэндээ төрийг сандайлаад суучихсан. Уг нь нам төрд үйлчлэх ёстой. Нам үндсэндээ төрийн өмч Эрдэнэс тавантолгой, Оюутолгой, ГОК, төмөр зам мэтийн томоохон төрийн өмч рүү идэж уух том хэрэгсэл болчихсон. Ард түмнийг сайхан амьдруулах боломжийг нь нам гэдэг нэрээр хэдэн нөхөд өөртөө болон өөрийг нь дарга болгосон хүмүүст хувааж өгдөг хэрэгсэл болчихсон.

Өнгөрсөн 30 жил энэ бол хэдэн улс төрчдийн дур зоргын асуудал биш шүү дээ. Монголын бие даасан эрдэмтэн шинжээчдийн дүгнэлт байхгүй байсан байна л гэсэн үг. Өнөөдөр харин ингээд энэ бол судлагдахуун юм байгаа юм шүү дээ. Энэ зүгээр улс төрийн 1 асуудал биш. Тэгэхээр энэ дээр ач холбогдолтой хандах ёстой. Зүгээр би олон бөөс хуурс түүгээд яах вэ зүгээр жишээ нь 10.1.5-д хуулийн 35.6-д хориглосон этгээдээс хандив тусламж гээд 1 үг байна. 35.6 нь жишээ нь энэ хууль дотор байхгүй. Надад хамгийн сүүлийн хувилбар ирсэн гэж би бодож байгаа. Би энэ олон юмыг ярихаас илүү би асуулт руугаа орё. Ажлын хэсэг дээр энийг бичгээр би өгнө.

1 дүгээр асуулт. Намыг идэвхгүйд тооцох 21, намыг татан буулгах 22, намыг өөрчлөн байгуулах 23, намын үйл ажиллагааг зогсоох 24, намыг тараах 25 зохицуулалтуудад төрийн оролцоо давамгайл хязгаар их байгааг анхаарсан уу? Ер нь бол Намын тухай хууль баруунд бол Германы хуулиудыг л би харж байхад гишүүдийг нь хүчтэй болгох, гишүүдийг нь бяр оруулах л ганцхан арга зам байдаг болохоос биш буцаагаад та нар энэ чинь энэ би Сонгуулийн сонгуулийн төв байгууллага гэдэг юм дандаа улс төржсөн. Их Хурал, Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхээс дандаа тавьдаг улсууд. Хамгийн улс төржсөн байгууллагаас энэ намыг бас хараат болгочихсон. Энэ дээр та нар дүгнэлт хийсэн үү 1 дүгээр асуулт. Нөгөө улс төржилтөөс ангид болгоё гэж яриад байгаа улсууд шүү дээ бид нар чинь.

2 дугаар асуулт. Намын дэмжигч гишүүн гэсэн 3.1.2-ыг ярьж байна шүү. Статус бий болгожээ. Үүрэг, эрхийг нь намын дүрэм болон төслийн 20.3-д тодорхойлсон байна. Дэмжигч гишүүний бүртгэл бий болгох аргаар сонгуульд нөлөөлж болох, нөгөө ухуулан ятгах, мөнгө тараах, нөгөө халамж өгөх гэх мэт иргэдийг хүрээлэл үүсгэж болох нөгөө нэг улигт аймшигт сүлжээгээ энүүгээр байгуулах боломж бүрдэх үү? Энийг та нар хууль, эрх зүйн талаас нь бодож үзсэн юм бий юу, дүгнэлт хийсэн үү?

3 дугаар асуулт. Төслийн 3.1.14-д үгүй ээ, 3.1.14 тийм. Намын харьяа байгууллагыг тодорхойлсон. Нөгөө л холбоо, ТББ хэвээр хадгалагдаж байна. Нөгөө ахмадын, эмэгтэй, залуучууд, оюутан. Мөнгө дагасан энэ бол аюултай л даа. Мөн Дагаж журмын тухай хууль байна. Дагаж мөрдөх журмын тухай хуульд тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн байгаа энийгээ. Оюутны холбоо гээд бүх оюутнуудыг энэ эрх баригч нарт хамж авчирч өгсний төлөө Эрдэнэс тавантолгойг шанд нь аваад Монголыг сүйрүүлж байгаа энэ процесс бас яг энд явж байгаа юм биш үү? Энийг бодсон уу? Энэ гадаадад байгаа учраас ингэж байгаа юм уу та нар.

3 дугаар асуулт. Төслийн 9.3-д Сонгуулийн төв байгууллагаас баталсан программ хангамжийг ашиглах, 9.5-д нам цахим хаягаа Харилцаа холбооны зохицуулах хороо, СЕХ-нд бүртгүүлэхийн учир яг юу вэ? Энэ чинь нөгөө хамгийн улс төржсөн байгууллага нь энэ дүгнэлтийг гаргана шүү дээ. Энэ программыг нь хангамжийг нь гаргана. Тэгэхээр миний 4 асуулт. Одоо би ажлын хэсэгт нь орж ажиллах л хүсэлт тавья даа. Асуулт нь олдож олдоод байх юм.

Тэгээд нэг юм эцэст нь та нар төслийн 6.6-д нам татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол товчилсон, нэр бэлгэ тэмдгийг 24 жил дахин хэрэглэхгүй байхаар төсөлд тусгасан.

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Энэ удаагийн Улс төрийн намын хуульд зарчмын гэмээр 1 томоохон өөрчлөлт орж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр бид нар өмнө нь бол улс төрийн нам байгуулах процесст нэлээн шаардлага тавиад, тэгээд Дээд шүүх дээр Улсын бүртгэлийн газраас нэг нэр авдаг, тэгээд Дээд шүүх дээр бүртгүүлдэг. Тэгээд тэндээ нэлээн шалгуур тавьчихдаг. Яг бүртгээд Дээд шүүхээр энийг улс төрийн нам гээд бүртгэснээс хойш орхичихдог. Төр ч тэртэй харьцдаггүй, тэр байгууллагууд нь 1 хувь хүний анх үүсгэн байгуулсан хүнийх нь эсвэл 1 компани тэр улс төрийн нам ер нь юу хийж явах нь бол хэнд ч хамаагүй болгоод хаячихдаг. Эргээд нөгөө улс төрийнхөө намаар дамжиж төр нь байгуулагддаг учраас нөгөө намууд нь хариуцлагагүй болчихсон.

Тийм учраас улс төрийн намуудын өдөр тутмын үйл ажиллагааг хянан зохицуулж байх ёстой ийм төрийн институт байх ёстой юм гэж үзээд сонгуулийн төв байгууллагыг энэ удаа оруулж ирж байгаа юм. Яах вэ олон улсын жишигээр харах юм бол сонгуулийн төв байгууллага дээрээ байгаа орнууд байна. Дээд шүүх дээрээ байгаа орнууд байна. Бие даасан байгууллага хариуцаад явж байгаа, энэ Хууль зүйн байнгын Хууль зүйн яаман дээрээ хариуцаад явж байна. Тэгээд бид нар үзэж, үзэж Засгийн газар бол илүү улс төржсөн, ялангуяа эрх баригч улс төрийн хүчнээс шууд хамааралтай институт шүү дээ. Тэр утгаараа бол энэ нь болохгүй юм байна.

Шүүх байгууллага өдөр тутмын аж ахуйн ажил, энэ тайлан тооцоо авч аудит хийх энэ юманд оролцоод байх нь шүүх байгууллага шүүх институтийн хувьд бол бас зохимжгүй юм. Ингэж үзэж, үзэж парламентаас байгуулагдаж байгаа энэ сонгуулийн төв байгууллага

дээр байх нь зүйтэй гээд, ингээд Сонгуулийн төв байгууллагын хуулийг нэмэлт, өөрчлөлттэй дагах хуульдаа бол нэмэлт, өөрчлөлт оруулж ирээд энэний хүчин чадал чадавхыг нэмэгдүүлэх чиглэлийн заалтууд ингэж орж ирсэн юм. Тэгэхээр сая тэрэнтэй холбоотой 2 ч асуулт асуучих шиг боллоо.

Сонгуулийн төв байгууллага одоо шинээр энэ хойд талд бол 9 гишүүнтэй байхаар түүний 5 нь орон тооны, 4 нь орон тооны бус гишүүд байхаар. Тэгээд төрийн жинхэнэ албан хаагчдыг Ерөнхийлөгчийн институт, Дээд шүүх, Улсын Их Хурал санал болгохоор ингэж бас нарийвчилж зааж өгсөн. Тэгэхээр энэ нь бол өөрөө бас арай хараат бус байх юм болов уу гэсэн ийм зүйлээр байгаа. Зүгээр өөр байгууллага байлгая гэсэн хэн нэгэн л хариуцах ёстой. Хэн нэгэн энийг шийдэж, энийг хариуцаж энэ улс төрийн намуудын тайлан тооцоог нь авдаг, хариуцлага тооцдог ийм байгууллага хэрэгтэй. Тэгэхээр энийг яг өөр санал алтернатив санал байвал бас хэлэлцүүлгийн явцад гаргаж ирнэ биз дээ л гэж ингэж бодож байна. Яг өнөөдөр байгаа Монголын буюу энэ бүтцийн хувьд бол энэ их хүндрэлтэй юм байна лээ.

2 дэмжигч гишүүнийг бид нар тодорхой яаж өгсөн бас тодорхой дэмжигч гишүүн бол намын зорилго, үзэл баримтлал, сайн дурын үндсэн дээр нэгдэж намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ийм байгууллага. Тэгэхдээ энэ намын гишүүний чиг үүрэг дээр намын гишүүний хөндлөнгөөс нөлөөлөх, намын гишүүдэд янз бүрийн шахалт дарамт үзүүлэх энэ заалтууд болон намаас гарах орох заалтууд дээр бол нэлээн либерал нээлттэй болгож өгсөн байж байгаа. Хязгаарлалтуудыг бас нэлээн сайн хийж өгсөн. Урд хуулиа бодвол.

Намын харьяа байгууллагуудын асуудал байгаа юм. Би түрүүн хэлсэн. Намын харьяа байгууллагуудыг нэг гаднадаа ч ингээд байгаа юм биш. Манай явж ирсэн улс төрийн намуудын

төлөвшил, улс төрийн системийн төлөвшилийг аваад үзсэн ч гэсэн ийм байгууллагууд байгаа. Гэхдээ энэ байгууллагуудыг харин хэрхэн цаашид зөв төлөвшүүлэх вэ, клубийн хэлбэрээр явах уу гээд энэ байгууллагуудын тайлан тооцоог авдаг, санхүү хөрөнгийнх нь юуг бас нэмж энэ намын юунд нэгтгэж үздэг энийг нь бол нарийвчилж зааж өгсөн. Зүгээр энэ байгууллагуудтай холбоотой явж ирсэн 30 жилийн түүхэнд алдаа оноо бол байгаа байх. Тэрнийг нь бол яг энэ хуулиар зохицуулалтад орох хэрэгтэй юу бас нэмж заалтууд орох хэрэгтэй юу гэдгийг хэлэлцүүлгийн явцад орно биз дээ л гэж ингэж бодож байна.

Татан буугдахтай холбоотой намын энэ нарийвчилсан энэ заалтууд, сонгуулийн төв байгууллагын хариуцаж байгаа асуудалтай холбоотой заалтууд дээр улс төрийн намуудаас нэлээн санал ирсэн юм. Би түрүүн хэлсэн энэ хуулийг өргөн барихад өнөөдөр Улсын дээд шүүхэд бүртгэлтэй байгаа улс төрийн намууд.../минут дуусав/

Г.Занданшатар: Бусад асуултад хэн хариулах уу? Содбаатар дарга гүйцээгээд хариулчихъя.

Я.Содбаатар: Харьяа байгууллагуудын асуудлыг би түрүүн хэлчихсэн. Харьяа байгууллагуудын асуудлыг бол ер нь бол яг намын харьяа байгууллага шиг дэргэдэх байгууллага болгоод тэгээд хуулийн этгээдийн эрхгүй нэг явдаг хэлбэр байна. Хуулийн этгээдийн эрхтэй явдаг нэг хэлбэр байна. Тэгээд бид нар бол энэ удаа хуулийн этгээдийн эрхтэй явахаар ингэж оруулж ирсэн. Тэгэхдээ би түрүүн хэлсэн. Олон улсын жишигт ч гэсэн энэ харьяа энэ оюутан, залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагууд байна. Өнөөдөр манай явж ирсэн улс төрийн намын энэ 30 жилийн төлөвшилийг харах ч гэсэн ийм байгууллагууд байгаа. Зүгээр энийг ямар хэлбэртэй байлгах вэ, далд байлгах уу, ил байлгах уу л гэдэг асуудал байгаа болохоос тэнд хүн байгаа болохоор энэ байгууллагууд бол ямар нэгэн хэлбэрээр

бол олон улсад ч байдаг юм байна, манайд ч байна. Зүгээр хэлбэрийг нь яаж явах вэ гэдэг дээр бол хэлэлцүүлгийн явцад санал гаргана биз.

Сонгуулийн төв байгууллагын тэр программ хангамж гэдэг асуудлыг бол жишээ нь АН-аас орж ирсэн санал. АН-ын сүүлийн 3, 2 жил гарангийн юунууд бол янз бүрийн программ ашиглаад, цахим хурал гэдэг нэрээр тийм ээ намын дотоод үйл ажиллагааг самраад байсан, үймүүлээд байсан учраас энийг нэг ийм баталгаажсан программ хангамжийг нэгдсэн юугаар явах нь зүйтэй гэсэн ийм томъёоллоор орсон. Би түрүүн хэлсэн энэ бол Улс төрийн намуудын хуулийг яахад бид нар улс төрүүдийнхээ намуудын саналуудыг нэлээн бас авч тусгасан. Бас нэгдэж зөвшилцөлд хүрсэн саналуудыг бас нэлээд тусгасан. Тэрний зүйлүүдийг бол зарим зүйлүүдийг манай Ганбаатар гишүүн хөндөж сая хэлж байх шиг байна. Тэрний нэг бол саяын энэ жишээ нь программ хангамжтай холбоотой заалт.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна, 1 минут.

С.Ганбаатар: Энэ бол ач холбогдлоороо их өндөр хууль. Бидний толгой дээр сандайлаад суучихсан энэ мафийн бүтцийг л задлах гэж оролдож байгаа оролдлого шүү дээ. Тэгэхээр миний гол хэлэх гээд байгаа зүйл гэвэл намын гишүүдийг бяр болгох, гишүүдийг бяртай болгох гэдэг дээр л анхаараарай. Тэр гишүүдийг яаж бяржуулах вэ гэвэл тэд шийдвэр гаргадаг. Тэгэхгүй тэр өмчилчихсөн хэдэн дарга нар шийдвэр гаргадаг биш, тэрийг нь 1 хэдэн гишүүн нэрт тоглоом болоод байгаа шүү дээ. Гишүүдийг шийдвэрт оролцуулдаг, шийдвэрийн хэрэгжилт дээр нь хяналт тавьдаг, хариуцлага тооцдог энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж л бид өнөөдөр энд байгаа. Гишүүд эзэн шүү. Намын эзэн. Өнөөдөр намыг нь ингээд хууль дээр тоглоод, Дээд шүүхээр дарамтлаад тоглож байхад гишүүд нь хөдлөхгүй

байна гэдэг чинь тэр нам аль хэзээний гишүүдээсээ салчихсан байна гэсэн үг. Тэгэхээр асуултууд.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя.

Я.Содбаатар: Энэ хуулийн ерөөсөө концепц нь яг Ганбаатар гишүүний хэлээд байгаа байхгүй юу. Олон нийтийн хяналтад авчиръя. Энэ улс төрийн нам гээд байгаа юмнуудыг. Тэр тайлан тооцоог нь, тэр үйл ажиллагааных нь, тэр санхүүгийнх нь тэр зүйлүүдийг нь.

Хоёрдугаарт гишүүдийнх нь оролцоог л хангая. Нэг ёсны гишүүдийнх нь хяналтад дахиад авчиръя. Гишүүдийнхээ юу яадаггүй 1 сандайлаад 1 дээр гараад ирэнгүүтээ хурлаа хийдэггүй хэдэн жил болдог. Ерөөсөө энэ 30 жилийн хугацаанд хугацаандаа хурлаа хийсэн ганцхан улс төрийн хүчин байна лээ шүү дээ. АН хүртэл 10 жил Их хурлаа хийгээгүй л явсан юм байна лээ. Тэгэхээр энэ хурлаа хугацаанд нь хийдэг, тэр дотоод ардчиллынхаа хүрээнд сонгуульт албууд нь томилогдоод явдаг өөрчлөгддөг. Тэгэхгүй бол 30 жил 1 намын дарга хийгээд байж болохгүй. Хурлаа хийдэггүй, ганцхан хүний эсвэл 1 ААН-ийн ийм намууд байж болохгүй л гэж үзэж байгаа юм. Тэр утгаараа олон нийтийн хяналтад, гишүүдийнх нь хяналтад авчрах чиглэлийн заалтууд нэлээн орсон. Гишүүнд тодорхой санал байвал бас.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Улс төрийн намын тухай хууль орж ирж байна. Тэгэхээр ард түмний дунд улс төрийн намуудын нэр хүнд бол маш муу байгаа. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр бид нар Монголд байтугай дэлхийд хүртэл энэ намгүй систем, намгүйгээр төр бүрдэх гэдэг энэ систем одоогоор зохиогдоогүй байгаа учраас яг энэ цаг хугацаанд Улс төрийн намын тухай хууль

орж ирж энэ байдал нөхцөл байдлыг бас сайжруулсан тал руу нь шийдэхгүй бол бас хэцүү байгаа.

Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хууль маань нэлээн тийм сайн үр дүн гаргана гэж ингэж харж байгаа. Одоо манайд яваад байгаа энэ нэр хүндгүй байгаа чинь Монгол Улс шиг ийм баялаг ихтэй, газар нутаг ихтэй, хүн ам цөөтэй улсын хөгжиж чадахгүй байгаа хөгжилд чөдөр тушаа болж байгаа асуудал чинь энэ намуудтай холбоотой байгаа. Тэгэхээр энэ ерөнхийдөө энэ ардчилсан хувьсгал ялснаас хойш энэ гуч орчим жил ингээд бид нар анхдугаар ардчилсан Үндсэн хуулийнхаа хүрээнд ингээд явлаа. Одоо бид нар энэ Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, магадгүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд энэ дээр бид нар маш том зөв эерэг тогтолцооны өөрчлөлтийг хийхгүй бол бид нарт ахиц гарахгүй нь. Яг энэ тогтолцоогоороо явах юм бол бид нар нэг шавар дээр хий эргэчихсэн халзан дугуйтай машин шиг ингээд байран дээрээ зогсоод, заримдаа ухралт ухраад байна.

Тэгэхээр энэ хууль дээр бол бүгдээрээ тал талаасаа маш хариуцлагатай хандах ёстой гэж ингэж бодож байгаа. Бид нар нэг хаврын хачиг хувалздаа баригдчихсан 1 таталдчихсан хурга, ишиг шиг л ийм болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энийг задалж эрүүлжүүлэх ёстой энэ хууль нь бол энэ Улс төрийн намын тухай хууль гэж ингэж харж байгаа юм. Орон нутаг дээр энэ явж байхад энэ хэт улс төржиж байгаа гэж яриад байгаа. Гишүүдийн ярьж байгаа бол энэ үнэн. Энэнээс болоод энэ шийдвэрүүд ерөөсөө дээр гарч байгаа шийдвэрүүд чинь дунд, анхан шатан дээрээ очиж ажил болдоггүй. Нэгнийхээ ажилд садаа болж чөдөр тушаа болоод байгаа юм. Татаж унагааж байна. Ажлыг нь явуулахгүй гацаагаад байгаа юм.

Орон нутагт 1800 төрийн албан хаагч дутагдалтай байхад нөгөө талд нь

нөгөө талыг нь дэмждэг үзэл баримтлалтай хүмүүс байхад тэд нарыг ажилд авдаггүй байх жишээтэй. Ах дүү, хамаатан садан бүр гэр бүл дотроо хүртэл улс төржиж байгаа энэ асуудал байгаа. Тэгэхээр хэт улс төржилт гэж энийг хэлээд байгаа болов уу. Хатуу гишүүнчлэлийн асуудлыг сая Зөвлөлдөх санал асуулгын зөвлөмж дээр батлаад гаргаад явуулсан. Дэмжинэ гээд, хатуу гишүүнчлэлээс татгалзахыг дэмжинэ гээд. Энэ асуудал яг энэ Улс төрийн намын тухай хуульд яаж аль зүйл, заалт дээр яаж орж байгаа вэ? Зөвлөлдөх санал асуулгын энэ зөвлөмжийг дагах уу?

Дээрээс нь улс төрийн намын бүртгэлийн асуудал энэ хууль дээр яг яаж орж байгаа вэ? Улсын дээд шүүх дээр өгөөд ингээд нэг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталдаг байсан, сүүлд хуульд өөрчлөлт оруулаад бүх гишүүдийн хурал болгоод тавьсан. Одоо дахиад бүр дахиад хаашаа очих гэж байгаа юм СЕХ руу очих гэж байна уу тийм ээ, энийг 1 тодруулаад өг.

Тэгээд энэ улс төрийн намын тамга тэмдгийн асуудал дээр холбоотой заалт байна уу? 1 бүлэглэл бас 1 аливаа нэгэн сонгуульд орох гээд нөгөө хүчнээ хүчийг нь сулруулах байдлаар энэ тамга тэмдэг улсын байгууллагуудыг ашигладаг ийм асуудал гарахыг үгүйсгэхгүй. Тэгэхээр энэ дээр яг энэ энэ хууль дээр ямар зүйл заалт байна вэ?

Сүүлд нь хэлэхэд энэ сонгуулийн холимог тогтолцоог 2 нам оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ намуудын жагсаалт үйлдэхтэй холбоотой, жагсаалт гаргахтай холбоотой тэр 1 филтер дээр нь заалт энэ Улс төрийн намын тухай хуульд байна уу гэсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Энэ сонгуулийн хуультай одоо Улсын Их Хуралд орж ирж байгаа Сонгуулийн хуультай бол энэ

хууль хүйн холбоотой. Ингээж олон зүйлүүд дээр бид нар энэнд холбогдох ёстой. Тэгэхдээ таны яг асууж байгаа тэр холимог тогтолцооны нэрс юу гаргах юмнуудыг бол энд орж ирээгүй гэдгийг хэлье. Тэр бол Сонгуулийн хууль бол янз бүрээр гарч ирж байгаа учраас зарим үед мажоритар тогтолцоо, зарим үед пропорциональ, зарим үед холимгоор гарч ирж байгаа учраас энэ Улс төрийн намын хууль Сонгуулийн хуулиа дагаад 4, 4 жилээр өөрчлөгдөхгүй учраас тэр нарийн тэгж ингэнэ гэсэн зүйлийг бол энэ хуульд оруулахад бол жоохон учир дутагдалтай байх гэж бодож байна.

Хатуу гишүүнчлэлийг би түрүүн хэлсэн. Хатуу гишүүнчлэлээс бид нар татгалзаж, олон улсад байдаг сул гишүүнчлэл буюу яг тэр намын дүрэм юуг зөвшөөрөөд намын татвараа төлдөг, дотоод сонгуульдаа санал өгөх эрхтэй оролцдог энийг нь бол намын гишүүн жинхэнэ гишүүн гээд ингээд явж байгаа. Намын үйл ажиллагааг дэмждэг, намын үйл ажиллагаа, үзэл бодлыг дэмждэг, намын эвлэлдэн нэгдсэн энэ юунууд бол дэмжигч гишүүн гээд энэ дэмжигч гишүүний чиг үүргээрээ бол дэмжигч гишүүн бол харьцангуй сул байх ийм хэлбэр болж байгаа. Тийм учраас одоогийн байгаа энэ улс төрийн намуудын хатуу гишүүнчлэл нэлээн сулрах байх гэж ингээж бодож байна.

Хоёрдугаарт энэ гишүүнчлэлээр нь ялгагдаж, аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэнийх нь төлөө, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө янз бүрийн ялгаварлал үзүүлдэг зүйлүүдийг хуулиар хуульд нэлээн хатуу зааж өгсөн. Ингээж болохгүй гэж хориглосон заалтууд. Ардаа ер нь бол энэ удаагийн хуулиар бол улс төрийн нам улс төрийн юунд бол Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар хариуцлага тооцдог механизмуудыг бас нэлээн хийж өгсөн байгаа. Тийм учраас энэ дээр нэлээн зааж, энэ иргэдийг яасан зүйлүүдийг оруулж өгсөн гэдгийг хэлье. Бүртгэлийн асуудлыг Бямбажаргал зөвлөх нэмээд хариулчих.

Г.Занданшатар: Бямбажаргал 83, 82 доктор Бямбажаргал 82.

А.Бямбажаргал: Туваан гишүүний асуултад хариулъя. Сая та нөгөө асуултдаа бас 1 тодруулж хэлж байсан. Гуравхан гишүүн Улсын дээд шүүхийн бүртгэж ирсэн гэж. Тийм ээ 2021 оныг хүртэл 1990 оноос хойш л гэж ойлгож болно доо. 2021 оныг хүртэл бол Иргэний танхим бол Улсын Дээд шүүх дээр бол бүртгэж ирсэн байдаг. Өөрөөр хэлэх юм бол Иргэний танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар өөрөө бүртгэдэг. Захиргааны гэхээс илүү. Тэгээд энэ маань өөрөө ямар асуудлыг дагуулж ирсэн бэ гэхээр 3 шүүгч л санал нэгдэхэд бүртгэх үү, бүртгэхгүй юү, нэмэлт, өөрчлөлтийг тооцох уу, тооцохгүй юү, намын даргыг сонгох уу, сонгохгүй юү, бүр яваад энэ маань юү болсон бэ гэхээр намын нэрийг өгөх үү, өгөхгүй юү гэдэг асуудлыг шийдэж ирсэн түүх байна.

Тэгэхээр энэ хуулийн төслөөр яаж байгаа вэ гэхээр намын бүртгэлийн асуудлыг бол 1 мөр цэгцэлье гэж байгаа юм. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд гарсан олон түүхүүд байна. Олон намуудын муу, сайн жишээнүүд их байна. Тэгээд энэнээс үүдтэйгээр сонгуулийн төв байгууллага бол өөрөө захиргааны шинжтэй ажлуудыг нь бол хийнэ. Өргөдлөө бол сонгуулийн төв байгууллагад гаргах нь байна. Энэ маягтынх нь дагуу өргөдлүүдийг нь хянаж үзээд, тодорхой шаардлага шалгуурыг нь хэлбэрийн хувьд нь хангасан гэж үзвэл Улсын дээд шүүхэд уг өргөдлийг сонгуулийн төв байгууллага бол шилжүүлж байгаа юм.

Сонгуулийн төв байгууллагаас хүлээж авсан энэ өргөдлийн дагуу Улсын дээд шүүх уг асуудлыг өмнө нь яаж байсан шиг нөгөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа биш нийт шүүгчийн хуралдаанаараа шийдээд, хууль зүйн хувьд нь өөрөө энэ хяналтыг хэрэгжүүлж байгаа. Энэ хяналтыг хэрэгжүүлж байгаа өөрөө бас учиртай.

Юу вэ гэхээр улс төрийн нам гэдэг бол өөрөө I талаараа нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг агуулсан ийм институт. Цаашлаад төрийн эрх барих дээд байгууллагад орж ажилладаг, төрийг бүрдүүлдэг төрийн институт болдог. Тэгээд энэ үүднээсээ бол энэ манай туршлага, дээр нь бусад улсуудын ч гэсэн туршлага байгаа. Шүүхийн дээд байгууллага өөрөө энэ Үндсэн хуульд нийцэж байна уу, үгүй юу, цаашид энэ Үндсэн хуулийн суурь зарчмуудаа өөрчилчих үү, үгүй юу гэдэг энэ хяналтыг бас давхар хэрэгжүүлж байгаа гэдгийг би энд онцлон тэмдэглэе.

Мөн АН-ын маань бас сүүлд гарсан ийм жишээнүүдээс үүдэлтэйгээр тодорхой зохицуулалтуудыг оруулж өгсөн. Улсын Дээд шүүхийн шийдвэр гарснаас хойш бол Сонгуулийн төв байгууллага тав хоногийн дотор бол гэрчилгээг шууд гаргаж өгөх ёстой гэдэг ийм заалт. Дагаад нөгөө тамга маань энүүгээрээ шийдэгдчихнэ. Өөрөөр хэлбэл хугацаа нь тодорхой болчхож байна, хэн гаргаж өгөх нь тодорхой болчхож байна. Улмаар өнгөрсөн хугацаанд байсан улсын бүртгэлийн байгууллагын энэ оролцоо энд бол байхгүй болчхож байгаа. Энэ байдлаар шийдэгдэж байгаа гэж хэлье.

Г.Занданшатар: Болчихсон уу? Болжээ. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Сонгуулийн тухай хууль орж ирж байна. Бас чухал юу Улс төрийн намуудын тухай хууль орж ирж байна чухал хууль орж байна. Ер нь бол сонгуультай Сонгуулийн тухай хууль, Үндсэн хуулийг бид нар өөрчлөлт оруулъя гэж байгаа. Үндсэн хуульд оруулах өөрчлөлт энэтэй уялдуулаад бас Сонгуулийн тухай хууль, энэ Улс төрийн намуудын тухай хууль эд нар чинь хамтдаа орж ирж байж, ер нь бол бид нар нэлээн үндэс сууриар нь үзэх ийм зарчимтай болж байгаа гэж бодож байгаа.

Тэгэхээр нам бүртгэх асуудлаа дөнгөж сая нэг тайлбар хэлэх шиг боллоо. Энэ урьд өмнө бол Улсын Дээд шүүх дээр бүх өргөдлүүдээ өгөөд ингээд гардаг байсан санагдаад байгаа юм хуульдаа. Одоо болохоор сонгуулийн төв байгууллагаар өөрөөр хэлбэл сонгуулийн энэ байгууллагаар захиргааны та сая хэллээ. Захиргааны шинжтэй асуудлуудыг нь шийдээд ингээд явдаг. Тэгээд цаашаага бол энэ материалаа бол Дээд шүүхэд өгөөд, Дээд шүүх шийдвэр гаргадаг гээд байна. Жоохон процедураа хүндрүүлээд байгаа юм биш үү гэж. Энэ дээр та нэлээн тийм хөнгөхөн шинжтэй бүр сайжруулж байгаа гэсэн юм яриад байх юм. Наадах чинь бол бас нэлээн ойлгогдохгүй л байна л даа.

Тэгэхээр нэгэнт сонгуулийн төв байгууллага гэдэг бол сонгуультай холбоотой асуудлууд, өөрөөр хэлбэл энд чинь заачихсан байна шүү дээ. 30 хоногийн дотор шийдвэрээ гаргана. Нэгдүгээрт үндсэн юуны намын Улсын дээд шүүх нь бол 30 хоногийн дотор шийдвэрээ гаргана. Шийдвэр гаргаснаас хойш бол сонгуулийн төв байгууллага нь бол өөрсдөө бүртгээд ингээд цаашаа явчихна гээд байна шүү дээ. Тэгэхээр Сонгуулийн төв байгууллага зөвхөн сонгуультай холбоотой асуудлуудаа ар дээр нь яг энэнийхээ заалтынхаа дагуу явбал яасан юм бэ? Бүх асуудлууд нь бол үндсэн юу Дээд шүүх дээрээ очоод, Дээд шүүх дээрээ шийдэгддэг энэ процедур чинь нэмэлт болчхоод байгаа юм биш үү? Арай жоохон хүндэрчхээд байгаа юм биш үү л гэж би асуух гээд байгаа юм. Тэгэхээр энэний цаад утга учир нь яг юундаа байгаад байгаа юм бэ? Урьд өмнө нь яагаад болохгүй байсан юм бэ? Яагаад заавал Сонгуулийн төв байгууллагаараа дамжуулж ийшээ орж ирж байгаа юм гэдэг дээр нэлээн тайлбар өгөөч гэж.

Хоёрдугаарт Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд өөрчлөлт ороод 2024 оноос эхлээд сум, дүүрэгт нам нэр

дэвшүүлэхгүй гэсэн ийм зүйл орсон байгаа тийм үү? Энэ хууль дээр болохоор намын эрх, үүрэг гэдэг дотор 7.11.5 дээр Монгол Улсын Их Хурлын болон аймаг, сум, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцохоо гэгчихсэн байгаа. Тэгээд наад хууль чинь хоорондоо зөрчилдөөд байгаа юм уу, аль хуулиар нь явах юм бэ? Энэ өөр тэр хуульд өөрчлөлт оруулж дагалдах хууль эд нараар орж ирсэн ийм зүйл байна уу гэсэн энэ 2 асуулт дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Содбаатар, байз, зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Бүгд Найрамдах Халимаг Улсын төрийн байгууллагын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Халимаг ахан дүүстээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Үсэрсэн цус, тасарсан мах, хальж гарсан Халимагийн ард түмэн гэж байгаа шүү дээ. Яах вэ ахан дүүс агуулгаар нь орчуулчих.

Я.Содбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт таны түрүүнд дурдаад байгаа хууль төсөл дээрээ явсан байх. Одоо хүчин төгөлдөр хуулиар орон нутгийн сонгуульд нам оролцохгүй гэсэн заалт хаана ч байхгүй. Тийм учраас энэ нөгөө төсөл дээр явж байсан зүйл болов уу гэж. Энэ парламентаар батлагдсан хуулиудад одоогоор тийм юм байхгүй. Зүгээр өнөөдрийн хуультай зөрчилтэй зүйл байхгүй гэдэг юм.

Хоёрт Улсын дээд шүүх одоо явж байгаа тогтолцоогоор яаж явсан юм бэ гэхээр Улсын бүртгэлийн газар буюу Засгийн газрын харьяа агентлагаас нэрээ авдаг. Нэрээ шүүлгүүлээд тэгээд нэрээ авдаг. Тэрийгээ дагуу Улсын дээд шүүх дээр очиж бүртгүүлээд л, тэгээд л улс төрийн нам болоо. Тэрнээс хойш улс төрийн намтай ямар ч байгууллага харьцдаггүй. Сонгуульд ороод ирэхээр сонгуулийн байгууллага харьцана. Улс

төрийн намуудын өдөр тутмын үйл ажиллагааг ямар нэгэн хянах, тайлан авах, аудит оруулах, улс төрийн намуудад нэг талаасаа хяналт тавих, нөгөө талаасаа зөвлөн туслах ийм процедурууд ерөөсөө байхгүй. Тийм учраас улс төрийн нам нэг 801 бүрдүүлж байгаад л Дээд шүүхэд 1 бүртгүүлээд авбал тэрний дараа тэр улс төрийн нам 30 жил хурлаа хийнэ үү, хийхгүй байна уу, 801 хүнтэй байна уу, 8 хүнтэй байна уу, 1 компанийн нам болж байна уу, хаанаас хандив авч байна, тэр хандив нь стандарт яг хуульд заасан хандив мөн юм уу, тэр мөнгө нь зөв юм уу, буруу мөнгө юм уу хэн ч шалгадаггүй.

Тийм учраас энэ 30 жилийн хугацаанд улс төрийн нам нэртэй 1 хүний 1 цүнхний, тэгээд сонгууль болоод гараад ирэхээр наймаацдаг, оролцдог, улс төрийн бид нарын яриад байгаа энэ буруу зүйлүүдийн үндэс болоод байгаа олон зүйлүүд дээр улс төрийн намын нэрийг ашигладаг, улс төрийн нам тийм нам байна гэж гарч ирээд хаширдаг. Өөрөө ганцаараа байж байдаг. Ард түмний нэр барьдаг. Ийм завхарсан зүйлүүд бол энэ улс төрийн системд байсан. Нэг ёсны Улс төрийн намын хууль нь улс төрийн намуудын байж ирсэн энэ 30 жилийн юу нь өөрөө улс төрийнхөө нийгмийнхээ хурдыг гүйцэхгүй байгаа юм.

Тийм учраас бид нар энэ удаа бол улс төрийн намуудыг хариуцах, улс төрийн намуудын тайлан тооцоог нь авах, хянах, энэ юу нь бол сонгуулийн төв байгууллага байг л гэж ингэж үзэж байгаа юм. Энэ агуулгаараа бүртгэл хийхдээ сонгуулийн төв байгууллагаар бүрдүүлбэрийг хангаад, тэгээд Дээд шүүх бол зөвхөн хуульд заасан тодорхой заагаар л бүртгэхгүй байх, татгалзах боломжтой болгож хязгаарлаж байгаа юм. Урьд нь бол бас нэлээн нээлттэй байсан юм. Дээд шүүх янз бүрийн шалтгаанаар хууль зөрчөөд бүртгэгчид эсвэл бүртгэдэггүй. Одоо бол Дээд шүүхийн чиг үүрэг бол маш тодорхой болж байгаа. Сонгуулийн төв байгууллагаас бүрдүүлбэрээ хангаад

өгсөн улс төрийн намыг татан буулгах эсвэл бүртгэх, өөрчлөн байгуулах энэ юун дээр эцсийн шийдвэр гаргаж л өгч байгаа. Процессын хувьд.

Өмнө нь бол энийг Дээд шүүх дээр явдаг. Тэгээд Дээд шүүх хуультай байхад л улс төрийн намын нэрийг бүртгээд л хаячих жишээний. 12 жилээр хязгаарлачихсан хуультай байсан шүү дээ. Тэгээд л хуультай байхад давхар нэр бүртгээд орхичих жишээний. Тодорхой заалттай байхад зарим намыг 2, 3 жилээр нь гацаачихдаг, тодорхой үндэслэлгүй, хуулийн үндэслэл нь тодорхой бус байсан учраас янз бүрийн үндэслэлээр зогсоочихдог ийм зүйлүүд гуравхан шүүхэд суугаад шийдчихдэг энэ эвлэлдэн иргэдийн эвлэлдэн нэгддэг энэ том институтийн асуудлыг гэх мэтчилэн зүйлүүдийг бол энэ хуулиар нэлээд цэгцэлж, тодорхой болгож хуулийн заалттай болгосон. Одоо бол бид нар улс төрийн намуудыг бүртгэснийх нь дараа тавих хяналтыг бол нэлээн сайжруулж байгаа гэж хэлж болно.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулах уу?

Ж.Бат-Эрдэнэ: Таны ярьсан яг нөгөө хяналтын асуудлууд чинь яг ямар байгууллагуудаар хийхээр заагдчихаад байгаа вэ? Жишээ нь түрүүний ярьсан шүү дээ 20, 30 жил бараг л 1 дарга яваад байдаг, хурлаа хийхгүй яваад байдаг эсвэл бол 1 хэсэг бүлэг хүмүүсийн хүрээнд асуудлаа шийдээд яваад байдаг. Тэгсэн мөртөөрөө эвлэлдэн нэгдэх эрх нь Үндсэн хуулиараа батлагдсан гэсэн мөртөөрөө яг анхан шатын байгууллагын гишүүн намын гишүүний дуу хоолой цаашаагаа хүрдэггүй. Тэгээд 1 хэдэн төлөөллийн төв байгууллага эд нар гээд, тэр төлөөллийн төв байгууллагын асуудал нь тэр хүрээндээ бол намын бодлого болоод явчихдаг. Тэр намын бодлогод жинхэнэ гишүүдийнх нь дуу хоолой хүрдэггүй.

Тэгээд энэ нь бол таны түрүүний хэлдгээр 800 гишүүнтэй байх, 8

гишүүнтэй байх хамаагүй болоод явдаг гээд байна шүү дээ. Энэ хяналтын байгууллагууд нь хаанаас байгаад байх юм бэ? Хаанаас хянах юм бэ? Одоо тэдгээр хэрэв хурлаа хийгээгүй хэдэн жил болчихсон байвал тэр хурлыг нь хийлгэх юм уу, хэн хийлгүүлэх юм, ямар шаардлага тавьж байгаад хурал нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга 80 хариулъя.

Я.Содбаатар: Одоо бол энэ хяналт тавих 2 субъект гарч ирж байна гэсэн үг. Нэг ёсны ерөөсөө сонгуулийн төв байгууллага. Яах вэ аудит байгаа. Аудиторууд ингээд тайлан юунд нь санхүүгийн юунд байж байгаа. Тэгээд ерөөсөө сонгуулийн төв байгууллага. Сонгуулийн төв байгууллага тайлангаа ирүүлнэ. Сонгуулийн төв байгууллага үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг нь аваад Улсын Их Хуралд нэгтгээд оруулна. Сонгуулийн төв байгууллагад хугацаандаа тайлангаа ирүүлэхгүй бол тэр намыг идэвхгүй хэлбэрт оруулна. Зөрчлөө арилгахгүй бол тэр намыг татан буулгадаг болно. Сонгуулийн төв байгууллагын саналаар.

Тэгэхээр энэ бол сонгуулийн төв байгууллага дээр таны түрүүний бид нар яриад байгаа энэ жишээ нь 4 жилд хурлаа хийхгүй байна шүү дээ тийм ээ. Энэ бол сонгуулийн төв байгууллага идэвхгүй хэлбэр рүү шилжүүлчхэж байгаа юм. Хугацаа өгнө. Тэр зөрчил арилахгүй бол татан буулгах саналаа Дээд шүүхэд гаргачхаж байгаа юм. Гэх мэтчилэн энэ нөгөө 1 дотоод ардчиллын, энэ санхүүгийн, энэ үйл ажиллагааны энэ олон хяналтууд юмнуудыг бол төрөөс 1 байгууллага хянах ёстой л юм байна лээ л дээ. Тэр нь сонгуулийн төв байгууллага буюу. Тэгээд сонгуулийн төв байгууллага нь өөрөө бас хараат бус байх ёстой. Тийм ээ. Тэр агуулгаараа бол дагаж мөрдөх ч дагаж дагаж орж ирж байгаа хуульдаа Сонгуулийн төв байгууллага.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Ардчилсан нийгмийн зайлшгүй 1 шалгуур бол олон намын тогтолцоо л доо. Тэгээд хуулийн төслийг харахаар 1 талаасаа олон намын тогтолцоог дэмжиж байгаа улс төрийн намуудад босго тавиад, санхүүжилт өгдөг болж байгаа асуудал харагдаж байна. Нөгөө талаараа бас үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлж байгаа юм байна. Өнгөрсөн хугацаанд тооцоо судалгаа харахад гуч гаруй жилийн хугацаанд энэ 36, 7 нам 5, 6-хан нам нь сонгогчдын босго даваад бусад үлдсэн намууд нь 1 хувийн хүртэл босго санал авахгүй байна гэж үзэж тооцоогоор харагдаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь юу ярьж байна вэ гэхээр энэ олон намууд ер нь яг энэ улс орны том түвшиндээ бодлого тодорхойлох, улс төрийн намуудын төлөвшил бэхжүүлэх үйл ажиллагаанд ер нь ямар хувь нэмэр оруулсан юм, ямар хувь нэмэртэй явж байна вэ гээд ингээд харахаар үнэхээр учир дутагдалтай байна шүү дээ. Тэгээд ийм байхад нь энийг нь өгөшүүлээд ахиад цааш нь 2 хувийн босго давчих, тэгээд санхүүжилт ав гэдэг ийм байдал руу орох юм уу? Аль эсвэл түрүүн тэр 1 гишүүнээ зарим 1 гишүүнээс гарч байсан бүр ч Монголд үнэхээр ийм олон улс төрийн нам хэрэгцээ шаардлага байна уу үгүй юу? Харин цөөхөн хариуцлагатай, бэхэжсэн, төлөвшсэн ийм улс төрийн намууд цаашидаа өрсөлддөг байх. Төрийн эрхийн төлөө өрсөлддөг байх энэ чиглэл рүү явах юм уу?

Тэгэхээр цаашилаад юу ярих гэж байна вэ гэвэл харин ч энэ олон жилийн хугацаанд 1 хувийн нийт сонгогчдынхоо 1 хувийн саналыг авахгүй байгаа энэ улс төрийн намуудыг цаашидаа ер нь бол тэр идэвхгүй байдал гэдэг юм уу, тэр рүүгээ гэж байснаасаа бүүр татан буулгадаг байх, 3 удаагийн, 4 удаагийн сонгуульд 1 хувийн санал авахгүй байгаа улс төрийн нам цаашидаа ер нь оршин тогтноно гэж

ярихад тун хэцүү байна шүү дээ. Тэгэхээр 12 жил гэдэг юм уу 3 удаагийн сонгуульд ороод 1 хувийн санал авахгүй байгаа улс төрийн намуудыг татан буулгадаг байх хүртэл ийм хатуу бодлогыг цаана нь хийж өгөх ёстой л гэж би хувьдаа үздэг. Тэгж байж энэ олон улс төрийн намуудыг, 1 хүний намуудыг, гэр бүлийн намуудыг, хурлаа хийдэггүй намуудыг үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ. Ингэж байж энэ жижиг намууд нэгдэж, энэ 2 том намтай нэгдэж өрсөлдөх, гуравдагч том намыг гаргаж ирэх бодлогын хэмжээнд өрсөлдөх ийм цаашидаа тогтолцоо руу орно гэж би бол хувьдаа үздэг.

Нөгөө талаар зарим асуудлуудыг намууд дотоод асуудлаараа шийднэ, дүрмээрээ шийднэ гээд ингээд орхиж болмооргүй байгаа юм. Тухайлбал Улс төрийн нам Сонгуулийн хуультай гарцаагүй холбогдохоос гадна нөгөө талаар Төрийн албаны хуультай гарцаагүй холбогдох ёстой юм байгаа юм. Намын ажил гэдэг бол ерөөсөө хүнтэй ажиллах ажил байгаа юм. Хүнийг олж сонгох, сонгуульд оролцож ялалт байгуулсан нам мөрийн хөтөлбөрөө боловсон хүчнүүд дээрээ дамжуулж хэрэгжүүлдэг. Гэтэл яг өнөөдөр орон нутагт улс төржилт их байгаа гэдэг чинь өөрөө 4 жил улс төржилт юун дээр сонгуулийн үеэр улс төржилгүй яах вэ.

Нөгөө талаар сонгуулийн бус үед ялалтаа авсныхаа дараа бодлогоо хэрэгжүүлэхдээ байршуулах боловсон хүчнийг байршуулах тал дээр алдаа гаргаж ирсэн юм байгаа юм. Энэ дээр ерөөсөө анхаарал хандуулахгүй. Орон нутгийн намууд боловсон хүчний томилгоо дээрээ 1 номерт намын гишүүн гэж хардаг байдлаар харж байсан. Тэгвэл цаашидаа энэ эрэмбийг ёс зүй, ур чадвар гэдэг ийм эрэмбэд оруулах ёстой юм байгаа юм. Тэгээд орон нутагт яагаад улс төржилт байна гэхээр ялсан намын гишүүн биш учраас Дондог гуайн хүүхэд АН-ын учраас ур чадвартай ч байсан хамаагүй энэ ажилд болохгүй гэдэг ийм л байдлаар явж байгаа чинь

өөрөө орон нутагт ард иргэдийг улс төржүүлэх нөхцөл байдлыг бий болгоод байна шүү дээ.

Тийм учраас энэ боловсон хүчний асуудал дээр намуудыг цаашидаа тэр ур чадвартай, ёс зүйтэй, мэдлэг боловсролтой хүмүүсийг тэр эрэмбэ дараандаа оруулж томилдог байх нь өөрөө эргээд төрийн бодлогыг сайжруулах, цаашидаа улс төржилтийг багасгах энэ ч.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя.

Я.Содбаатар: 2 дахь юу нь бол 2 дахь асуулт биш юм даа. 2 дахь нь бол санал байна гэж авч байгаа. Хэлэлцүүлгийн явцад Сандаг-Очир гишүүн ч гэсэн өөрөө бас саналаа илэрхийлээд ингээд явчих байх.

1 дүгээр асуултад нь хариулъя. Энэ 1 хувийн санал аваагүй, ер нь тар дараалаад сонгуулиудад 1 сонгогчдын 1 хувийн саналыг авахгүй байгаа улс төрийн намуудыг татан буулгадаг, энэ намууд нь улс төрийн нам гэж үзэхэд хэцүү гэдэг заалт чинь бол Үндсэн хуулийн 2019 оны заалтаар орчихсон юм шүү дээ. Тэгэхээр энэ заалт чинь өөрөө одоо энэ хууль гарсны дараа 28 оны 1 сарын 1-нээс хэрэгжинэ гээд хүчин төгөлдөр хуульд ингээд явж байгаа.

Тэгэхээр 28 оны 1 сарын 1-нээс бол сонгогчдын 1 хувийн саналыг аваагүй улс төрийн хүчин байхгүй болчихно шүү дээ. Үндсэн хуульд өөрөө заачихсан юм чинь. Тийм учраас бид нар одоо байгаа хүчин төгөлдөр байгаа Үндсэн хуулийн хүрээнд өнөөдрийн хууль нь өргөн баригдаж байгаа юм. 28 оны 1 сарын 1-нээс буюу 1 бүрэн эрхийн сонгуулийн 1 бүрэн эрхийн хугацааны дараа бол Үндсэн хуулийн тэр заалт хэрэгжээд явчихаар сонгогчдын 1 хувийн саналыг аваагүй, дэмжлэгийг аваагүй улс төрийн хүчин байх боломжгүй хуулийн зохицуулалт хаагдаад ирчихнэ.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулъя 1 минут.

Ц.Сандаг-Очир: Нөгөө талаар энэ улс төрийн намуудын өмч хөрөнгийн асуудлыг энэ шинэчилсэн найруулгад яаж тусгаж оруулж байгаа вэ? Улс төрийн намууд ер нь өмчтэй байх ёстой юу, ёсгүй юу гэдэг асуудал. Орон нутгийн намын байгууллагууд өмчтэй байх уу, байхгүй юу гэдэг асуудал. Тэр битгий хэл өнгөрсөн хугацаанд төрийн тэргүүн нь хүртэл эрх барьж байгаа улс төрийн намаа татан буулгах захирамж гаргаад явж байсан түүх байгаа шүү дээ. Өмч хөрөнгийг нь хураах асуудлыг яригдаж байсан түүх байгаа шүү дээ. Улс төрийн тавцангаас арчина гээд ярьж байсан түүх байгаа шүү дээ. Энэ өмч хөрөнгийг нь энэ хүмүүсийн нэгдэл дээр бий болсон энэ улс төрийн намыг, өмч хөрөнгийг цаашидаа ер нь хэрхэн яаж хамгаалах юм, яаж бэхжүүлэх юм, яаж төлөвшүүлэх юм бэ? Энэ тал дээр бас энэ шинэчилсэн хуульд хэрхэн яаж туссан бэ гэдгийг бас та бүхэн хариулж өгөөч.

Г.Занданшатар: 80 Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Улс төрийн намууд өмч хөрөнгөтэй байхаар хуульд орж байгаа. Хөрөнгө гэдэг дотор бол нарийвчлаад хуулийн хэллэгээр аваад үзвэл үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө гээд явах юм бол бүх л улс төрийн намууд хөрөнгөтэй. Компьютергүй улс төрийн нам байхгүй байх, сандал ширээгүй улс төрийн нам байхгүй байх. Тийм учраас улс төрийн нам болгон л өөрийн гэсэн хөрөнгөтэй байгаа. Зүгээр үл хөдлөх хөрөнгө гээд байшингийн асуудал зарим үед ялангуяа парламентад суудалгүй намуудын хэлэлцүүлгийн явцад нэлээн гаргасан. Бид нар энийг ингээд судлаад үзэхээр өнөөдөр улс төрийн намууд дээр байгаа нийгмийн харж үздэг энэ намын намын байр гэдэг юмнуудыг чинь өмчлөлийн хэлбэрийг нь аваад үзэхээр яг намын биш зарим нь ТББ дээр, зарим намынхаа гишүүдэд хувьцаа хэлбэртэй болгочихсон янз бүр байгаа юм байна лээ.

Тийм учраас бид нар бол энийг энэ удаагийн хуулиар шийдэхэд жоохон хүндрэлтэй юм байна гэж ингэж авч үзсэн. Нам бол улс төрийн нам бол ашигийн төлөө бас байх ёстой.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Улс төрийн намын тухай хуулийг Ерөнхийлөгчөөс өргөн барьж байгааг зарчмын хувьд бас их дэмжиж байгаа. Яагаад гэвэл яг энэ үед бас Сонгуулийн тухай хууль орж ирж байгаа нь өөрөө Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль гэдэг чинь өөрөө яг асуудлын 2 талд байдаг. Сонгуульд нам хэрхэн оролцох вэ, тэрүүнд оролцдог намын асуудал тэр тусмаа энэ холимог тогтолцооны үед намын дотоод ардчиллын асуудал өөрөө асар их чухал.

Гэхдээ энэ дээр нэг 2, 3 зүйл бас заавал ингээд ийм асуудал бүхий 2, 3 зүйл энэ хуулийн төсөл дээр бид нар ч бас өмнө нь саналаа өгсөн. Зарим саналууд тусгагдаагүй. Цааш цаашидаа бас илүү анхаарч ажиллах ёстой гэж бас АН-ын гишүүдийн зүгээс үзэж байгаа нэг хэд хэдэн зүйл байгаа. Нэгдүгээрт нь энэ хууль хуулийн төсөл үзэл санаа ингээд ерөнхийдөө бүтцийг нь харахаар өнөөдрийн эрх барьж байгаа Ардын намын намын дотоод дүрэм дээр бас их тэр бүтэц зохион байгуулалт талдаа их суурилчихсан харагдаад байгаа юм. Тэгээд намын төлөөллийн төв байгууллагыг хэрхэн яаж байгуулах юм. Ер нь энэ дотоод ардчиллын энэ бүтцийн талдаа бол олон зүйлд өнөөдрийн эрх баригчдын намын дүрэм дээр илүү их суурилчихсан.

Тэгэхээр энэ энэний цаана бас юу хэлэх гээд байна вэ гэвэл ер нь манайд өнгөрсөн хугацаанд явж ирсэн нэг ийм бодлогын алдаа бол бодлогын алдаанаасаа гадна 90 онд хийсэн тэр өөрчлөлт шинэчлэлтийн хувьсгалт өөрчлөлтийн бас нэг үзэл санаа бол нам төр хоёрыг зааглая гэдэг үзэл санаа явж

байсан. Тэр тусмаа нам, төрийн дээр гарчихсан, гарчихдаг байдлыг зааглая. Тэгэхээр өнөөдөр явж байгаа өнгөрсөн хугацаанд явж ирсэн ер нь энэ 30 жилийн бас 1 үр үр дүн гэх үү, сөрөг тал нь ерөөсөө нам төр хоёр эрх баригч нам нь төр болоод л хувирчихдаг. Тэгэхээр одоо жишээ нь яг өнөөдөр гэхэд МАН-ын ЕНБД ЗГХЭГ-ын дарга хийж байгаа юм. Энэ чинь яаж ч бодсон үзэл санааны хувьд энэ хэдийгээр намын дүрэм олон зүйлээр зохицуулж байгаа ч гэсэн эрх баригч намын сонгуульд удирдаж ордог бүтцийнх нь ЕНБД нь ЗГХЭГ-ын дарга. Энэ зүгээр л 1 жишээ. Энэ төрийн байгууллага бүхий л салбарт яг л ийм байдлууд ингээд байна. Тэгэхээр энэ бүхэн дээр ингээд үзэл санааны хувьд хэрхэн цааш цаашидаа яаж зааглагдах зүйлүүд яаж хийгдэх юм бэ?

Хоёрдугаарт нь тэр нэг намын санхүүжилт өгч байгаа нь одоо ч гэсэн байдаг л даа. Тэгэхдээ энийг нэлээн өргөн хэмжээнд намын санхүүжилт олгоё. Нөгөө талаасаа энэ намын санхүүжилт олгосныхоо хэрээр эргэж намыг татан буулгах үндэслэл болох гэдэг нь өөрөө бас яг хэр зэрэг тэр иргэдийн энэ эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөнд бас хэр зэрэг халдах түвшний асуудал болж байна. Энийг бас нарийн бас нягталж үзэх ёстой. Тэгэхдээ мэдээж намуудыг хариуцлага сахилгын асуудал гэдэг бол өөрөө бас их өнгөрсөн хугацаанд ингээд чухал зүйл болж бас их ирж байгаа.

Тэгээд эцэст нь хэлэхэд энэ хууль дотор бас дэвшилттэй зүйлсүүд байгаа ч гэсэн анхаарах олон зүйлсүүд бас байгаад байгаа юм. Яг өнөөдөр Хятадын коммунист нам тэрбум хүнтэй Коммунист нам хэдэн гишүүнтэй байдаг вэ? Юу энэтэй харьцуулахад яг өнөөдөр Монгол Улсын 3 сая хүнд ноогдох намын гишүүдийн тоогоор бараг 500000 намын гишүүнтэй. Яг энэ хуулиар энэ бүтэц дахиад яг хэвээрээ үргэлжилнэ. 3 сая иргэдтэй 2 сая насанд хүрсэн иргэдтэй 1500000 иргэн санал өгдөг ийм улсын 500000 иргэн нь аль нэг намын гишүүн. Бараг тэрнээс ч их байгаа байх.

Тэгэхээр энэ бүтцээр намын хатуу гишүүнчлэлийн асуудал, намын санхүүжилтийн асуудал, дахиад дээрээс нь тэр намын өмч хөрөнгийн асуудал, орон нутаг дахь улс төржилтийн асуудал гээд зарчмын ийм нэг хэд хэдэн том зүйлүүд дээр яг тодорхой цэг тавьсан, цэг хатгасан ийм зүйлүүд бас яг үнэндээ байхгүй. Дэвшилтэт зүйл байгаа ч гэсэн. Тэгээд нийгмийн эрэлт хэрэгцээтэй холбоотой олон зүйлүүд дээр тийм том, том зарчмын асуудлууд дээр бас зүйлүүд байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бүгдийг тэгээд хэлэлцүүлэг явцад зарим зүйлүүд нь бас ингээд засагдаад явна биз. Тэгэхээр тэр 1 эрх баригч нам нь төр болчихдог энэ тогтолцооны эсрэг энд ямар үзэл санаа суугдаж байгаа вэ? Энэ дээр 1 хариулт өгөөч.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Содбаатар дарга хариулья 80.

Я.Содбаатар: Энэ Цогтгэрэл гишүүний асуултад хариулахад ер нь бол хэлэлцүүлгийн явцад зарим зүйлүүдийг бид нар бас нэмээд өөрчлөөд явах боломж байгаа. Тийм учраас АН-ын бүлэг бас өмнө нь санал ирүүлсэн. АН-аас өмнө нь яг хуулийн төсөл боловсруулж байх явцад нөгөө 2 хуваагдчихсан байх үедээ тус бүрдээ ч санал ирүүлж байсан. Өмнөх бүлгийн даргыг байх үед нэлээн олон санал ирсэн. Дараа нь Цогтгэрэл дарга энэ бүлгийн бланк дээр бас саналаа ирүүлсэн. Нэг зөрчилтэй юм нь бол өмнөх бүлгийн даргын ирсэн санал, энэ санал 2 нь бараг хориод хувиар зөрүүтэй. Явдалтай юмнууд их байсан. Тэгэхдээ бүх саналуудыг бид нар аль болох авахыг тусгахыг ингээд оруулахыг яасан. Зүгээр 2, 3 зүйл дээр байгаа юм. Хатуу заалтууд хийгээд өгч болох юм.

Гэхдээ өнөөдөр Монгол Улсын парламентаар баталсан олон улсын гэрээ конвенцууд байгаа юм. Иргэний эрхийн факт, Улс төрийн эрхийн факт, Европын хамтын ажиллагаа аюулгүй байдлын байгууллагаас өгсөн ингээд

зөвлөмж, НҮБ Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хэд хэдэн зөвлөмжүүд ирсэн. Тэгээд энэ хүний эрхтэй холбоотой юмнууд дээр зарим юмнуудыг бид нар яг өөрсдийнхөөрөө ингээд хязгаарлаад хатуу яахаар бол энэ эрх зүйн хүрээнд өнөөдөр хүчин төгөлдөр байгаа манай хууль болон эрх зүйн хүрээний юмнуудтай бас зөрчил үүсээд байгаа учраас зарим зүйлүүдийг бол ерөнхий оруулаад яваад байгаа юм.

Тэгэхгүй бол намын гишүүнчлэлийн хүмүүсийн эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө хязгаарлахаас эхлүүлээд ингээд ийм тодорхой заалтууд орчихоор ийм хүндрэлүүд байгаа гэдгийг бас та бүхэн хэлэлцүүлгийн явцад анхаарна биз дээ гэж ингэж бодож байна.

Яг тодорхой зарим нэг авчихаар саналууд бас байгаа. Хэлэлцүүлгийн явцад орж ирэх байх. Сая бид нарыг өргөн барьсны дараа жишээ нь АН-ын бүлгийн хурал дээр хэлэлцэж байхад намын төлөөллийн төв байгууллага, намын гүйцэтгэх төв байгууллага, намын хяналтын байгууллагуудын бүтцэд намын анхан шатны байгууллагууд, намын гишүүд энэ шууд оролцоог хангах, төлөөллийн ардчиллаар биш, төлөөллийн зарчмаар биш шууд оролцоогоор тийм ээ оруулах энэ хэлбэрийг оруулж өгөөч гэж байсан. Энэ бол жишээ нь хэлэлцүүлгийн явцад оруулаад ирчихвэл зүгээр л санал байгаа. Гэх мэтчилэн авчихаар саналууд бас нэлээн байгаа гэдгийг бас хэлье.

Зүгээр намын санхүүжилт төрийн санхүүжилт авсныхаа төлөө намыг татан буулгадаг тийм зүйлийн заалтыг бол эцсийн төсөл дээр бол хасчихсан байж байгаа. Одоо бол санхүүжилтийг нь зогсоож байгаа. Тэгээд тухайн улс төрийн нам тухайн сонгуульд орох эрхийг нь хааж байгаа. Гэхдээ иргэдийнх нь намын гишүүнийх нь сонгуульд дэвших эрхийг нь бол нээлттэйгээр оруулж байгаа. Тэгэхгүй бол нам татан буугдаад явчхаж байгаа юуг нь бол болиулсан. Сүүлийн төсөл

дээр. Тэгэхээр та нөгөө өмнөх хэлэлцүүлгийн явцад байсан төсөл ярьж байх шиг байна.

Ер нь бол бид энэ улс төрийн намаар дамжиж төрийн эрх барих үйл явцад оролцдог нь бол хаана ч байдаг зүйл. Өнөөдөр хүн төрөлхтөн улс төрийн намаар л дамжиж төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх, парламент төр байгуулах процесст оролцож байна. Гэхдээ хэтэрхий улс төрждөг, ялсан нам төрийн албан хаагчдыг хоморголон сольдог оролцдог, тэр нь намын нэрээр янз бүрийн хүмүүс оролцдог энэ зүйлийг хаах, хязгаарлах зайлиггүй шаардлага байгаа. Энэ бол ганцхан Улс төрийн намын хуулиар ч хязгаарлах зүйл биш. Ялангуяа Төрийн албаны хууль бусад хууль тогтоомж дээр ч гэсэн бид нар хамтад нь оруулж байж энэ цогц шинэчлэлийг бид нар хийж байж энэ асуудал шиг цэгцрэх учиртай юм.

Тийм учраас энэ Улс төрийн намын хуульд бид нар хязгаарлах зүйлүүдийг нь оруулсан. Дутуу орхисон зүйл байвал хэлэлцүүлгийн явцад бас нэмээд яая. Илүүтэй Төрийн албаны хууль, илүүтэй Сонгуулийн хуулиудаар хязгаарлах ёстой зүйлүүд байгаа юм. Хуулийг боловсруулах явцад бол манай Улсын Их Хурлын гишүүдээс, зарим улс төрийн намуудаас Сонгуулийн хуульд орчих зүйлийг энэ рүү оруулаач, Төрийн албаны хуульд орох ёстой зүйлүүдийг энэ рүү оруулаач гэсэн ийм зүйлүүдийг бас нэлээн саналууд гарсан. Тэгээд бид нар хуулийн санаачлагчийн хувьд бол тэд нарыг бас зарим I зүйлүүд нь бол тусаагүй байгаа гэдгийг бас тодотгож хэлье.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Тэр энэ хуулийн бас I үзэл санаа нь нээлттэй байдлыг илүү дэмжсэн тийм заалтууд бас нэлээн хэд байсан. Тэгэхдээ энэ дотор намын тодорхой албан тушаалтнууд сонгуульт албан тушаалтнууд ч юм уу бүртгэл нь

нээлттэй байх ямарваа нэгэн зүйл заалтууд яг хаанаа байгаа билээ? Сонгуульт албан тушаалтнуудыг жишээ нь I нам дээр эрх барьж байгаа ч юм уу, томоохон нам дээр үзэхэд 6, 7 мянга, арваад мянган гишүүн бас янз бүрийн сумын иргэдийн хурлаас эхлээд, ингээд үзэхээр бол I тодорхой тоо гарах юм байна лээ. Жишээ нь энэ гишүүдийг ингээд нээлттэй ил тод байдаг, тэдээс тэдэн онд энэ намын гишүүн байсан, эндээсээ дамжиж төр рүү оржээ. Энэ бүх бүртгэлийг бас тодорхой хэмжээнд намын бүртгэлээсээ гадна, сонгуулийн хороо элдэв зүйлийн бүртгэл дээр бас ил болгох асуудлыг энэ туссан зүйл байна уу?

Төгсгөлд нь ер нь энэ хуулийн нэр дээр I асуулт байгаа юм. Улс төрийн намын тухай хууль гэдэг нь өөрөө улс төрийн бус нам гэж Монголд байхгүй байна шүү дээ. Энэ ерөөсөө Намын тухай хууль л юм биш үү? Яагаад Улс төрийн намын тухай хууль гэдэг үг энд яг яваад байгаа юм бэ? Зүгээр гадаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна 80.

Я.Содбаатар: Сүүлийнх нь бол санал байх шиг байна. Тэр сонгуулийн төв байгууллагад байгууллагын цахим хуудсанд намын цахим хуудас буюу нийгмийн сүлжээний хаяг энэ хуулийн 9.1-ийн 9.6.1-ээс 9.6.7-д заасан намын баримт бичиг, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилж, ард түмэнд нээлттэй байлгана гээд ингээд 9 дүгээр бүлгүүдэд байж байгаа. Тэрэн дотор бол намын гүйцэтгэх төв байгууллага, намын дарга, ЕНБД, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан, намын удирдах дээд байгууллага эсвэл төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, түүний гишүүн, дарга нарын юунууд нээлттэй болж байгаа юм.

Хэн гүйцэтгэх төв байгууллага буюу жишээ нь Үндэсний хорооны

Үндэсний бодлогын хорооны гишүүн байгаа юм бэ, хэдээс хэдэн онд байсан юм бэ, хэн нь гүйцэтгэх хорооны гишүүн байгаа юм бэ, хэн нь санхүүгийн асуудал хариуцаж байсан ажилтан байгаа юм бэ, хэн нь дотоод бүтцийн байгууллагуудын дарга хийж байсан юм бэ гэдэг юмнуудыг бол нээлттэй болгохоор тэр 9.6 дотор бол нам цахим хуудастаа дараах барим баримт бичиг мэдээллийг ил тод байршуулж тухай бүр.../минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барьж орж ирж байна. Үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжиж байгаа. Энэ бол яах аргагүй цаг нь болсон ийм зүйл. Энэ дээр бид нэлээн сайн тал бүрээсээ ярилцаж, чамбай хууль гаргах ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа.

Улс төрийн нам гэдгийг бид нар үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлж ажилладаг тийм улс төрийн байгууллага байхаар л ерөнхий тодорхойлолтоо хийж байгаа л даа. Тэгэхээр үүсгэн байгуулахдаа яаж энэ үндэсний хэмжээнийхээ төлөөллийг хангах юм бэ, 801 гэдэг тоо мөн үү энэ тэр гээд бодмоор юмнууд байгаад байгаа. Энэ дээр 1 тайлбар авмаар гэж.

2 дахь зүйл үнэхээрийн энэ улс төрийн байгууллага тэр тусмаа хатуу гишүүнчлэлтэй байна гэвэл засаг захиргааны нэгж дагасан салбартай гэдэг асуудлыг тодруулж оруулахгүйгээр боломгүй юм билээ л гэж би бодоод байгаа. Олонхон ажилчинтай аж ахуйн байгууллагууд дамжсан намын байгууллагууд бий болбол яах вэ? Энэ талын харилцаа зохицуулалтгүй орхигдоод байгаа юм биш биз дээ гэдэг ийм зүйл байна. Энүүнийг юу гэж ойлгож байна вэ гэж нэг ийм зүйл.

2 дахь зүйл. Энэ намын байгууллагууд энэ сонгуулийн мөрийн хөтөлбөрийн асуудлыг жоохон тодруулах шаардлагатай байх гэж би бодоод байгаа юм. Дам дамаа энэ Монгол Улсын Үндсэн хууль, Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үзэл санаанд тэр хөтөлбөр өөрөө нийцдэг байж, сая бодлогын залгамж чанар тогтвортой хөгжлийн тухай асуудал яригдах ёстой. 4, 4 жилээр гэдэг юм уу, тодорхой хугацааны циклтэй сонгуулийн үйл явцын үр дүн дээр бий болсон төр засаг төвлөрч юу төвхнөж байна. Тэгэхээр энэнээс хамаараад бодлогын залгамж чанар алдагддаг, энэнээс болоод хөгжилд ямарваа нэгэн байдлаар хойш ухардаг ийм үйл явцууд энэ 30 жилийн сургамж түүх их тодорхой харуулж байгаа. Тийм учраас энэ алдааг засах үүднээс энд тодорхой зүйл ормоор юм шиг нэг.

Хоёрдугаарт тэр хөтөлбөрт янз бүрийн эдийн засаг нийгэмд бас дааж чадахааргүй тийм амлалт элдэв бусын юмнуудыг гаргуулахгүй байх асуудлыг хиймээр байна. Зөвхөн Сонгуулийн хуульд хийгээд аудит дүгнэлт хийгээд хөтөлбөрт нь оруулахгүй гэлээ ч гэлээ гэсэн уг намын байгууллага бид хөтөлбөртөө ийм зүйл оруулсан юм. Гэтэл ийм шалгуураар энэ заалт маань хасагдсан юм гээд явахад л их сонин ойлголт болж харагдаад байгаа зүйл байхгүй юу. Тэгэхээр энүүнийг ерөөсөө энэ улс төрийн байгууллагын өөрийнх нь үйл ажиллагааг зохицуулж байгаа энэ хуульд нь суурь ухагдахууныг нь тусгаж оруулж байж эндээсээ залгаж бусад хууль хоорондын нийцлээ хангах хэлбэрээрээ задарч орох нь зөв юм биш байгаа даа гэдэг ийм зүйл харагдаад байгаа. Тийм учраас энүүнийг ер нь тодруулж оруулах талаар ер нь ямар бодол санаа юу байна гэж?

Дараагийн нэг зүйл үнэхээрийн л бодлогын нам үйл ажиллагаа явуулахад хүний нөөцийн тухай л асуудал. Тэгэхээр тэр хүний нөөц бүрдүүлэлт, шилэлт, сонголтын асуудлын ерөнхий суурь

харилцааг энэ хууль дотор хийж өгч байж, төв нам нь ч, тэр салбар байгууллагууд нь ч тэр бүгд энэ хүний нөөц бүрдүүлэлтийнхээ асуудал руу анхаарч байж, боловсон хүчний чадамж дээр тулгуурлаж хөгжлийн асуудал бий болох ийм бодлого зорилтууд хэрэгжих юм гэдэг энэ суурь ойлголтыг оруулж ирэх ёстой болов уу гэсэн ийм бодол санаа байх юм. Энэ дээр ер нь ямархуу төсөөлөл юу байна вэ? Мэдээж хэлэлцүүлгийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна 80.

Я.Содбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Нам байгуулах үед тавьж байгаа шаардлагын 1 бол нам байгуулахад заавал орон нутгийн төлөөллийг оруулах ёстой. Энэ бол улсын хэмжээний нэгдмэл нам байх ёстой гэсэн юман дотор явж байгаа. Ер нь бол өнгөрсөн 30 жилийн түүхийг аваад үзвэл их сонин, сонин бас ийм улс төрийн нам байгуулах гэсэн оролдлогууд нэлээн гарч байсан. Тодорхой шашины чиглэлийн нам байгуулъя, цэрэгжсэн нам байгуулах гэсэн оролдлого хийгдэж байсан. Тодорхой ястан үндэстнээр нь нам байгуулах гэж оролдсон оролдлого санал ирж байсан. Тэр битгий хэл хамгийн сүүлд шинэ Коммунист нам гээд тодорхой 1 орны 1 намын бодлогыг Монголд хэрэгжүүлнэ гэсэн зүйл хүртэл оруулж ирж байсан. Улс төрийн гадаадад байдаг намуудын салбар салбарыг Монголд байгуулах гэсэн оролдлого хийгдэж байсан гээд үзэх юм бол эд нарыг бол хуулиар бүгдийг нь хориглож байгаа. Тийм учраас хуулиар эд нарыг хориглож бид нар улсын хэмжээнд бодлого тодорхойлсон, үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулдаг ийм намуудыг төлөвшүүлэх ёстой. Үндсэн хуулийн заалт ч өөрөө ийм. Тэгэхээр тэр агуулгаараа бол нэлээд зүйлүүд орсон, 11.3 гээд тодорхой ийм заалтууд орсон.

Хоёрт бид нар 90 оноос өмнө бол ААН албан байгууллагууд дээр намын нэгж байдаг байсан. Энэ хуулиар энийг

хориглож байгаа. Нэг ёсны нутаг дэвсгэрийн нэгжийн юугаар л дамжуулж намын салбар нэгжүүд байгуулагдах болохоос ямар нэгэн ААН-ийн нэр дээр ААН дээр юм уу олон ажилчинтай ААН гэдэг юм уу эсвэл албан байгууллагууд дээр нам байгуулахыг хориглож байгаа. Хориглосон заалт оруулсан. Тэгэхгүй бол компанийн нам байгуулагдаад байсан түүх бий шүү дээ. Сүүлийн үед эдийн засгийн энэ улс төр рүү төрийн бодлого гаргах түвшинд улс төрийн намуудаар дамжиж янз бүрийн эдийн засгийн бүлэглэлүүдийн, янз бүрийн сонирхол ихсэж байгаа учраас энэ хязгаарлалтыг бас яаралтай хийх хэрэг байсан. Тийм учраас энэ удаагийн хуульд оруулж өгсөн гэж ингэж хэлж болно.

Гуравд бол тэр намуудын хөтөлбөрийг бид нар ер нь улс орны хөгжлийн хөтөлбөртэй уялдан явах ёстой. Нам бол бодлогын институт болж төлөвших ёстой. Нам бол тодорхой санхүүжилтийнхээ тодорхой хувийг ч гэсэн намын хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санал санаачилга гаргах, иргэдийн төрийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлүүдийг олон нийтэд таниулан сурталчлахад зарцуулж тайлан гаргадаг болж байгаа. Энэ зарцуулалтынх нь хувь хэмжээнүүдийг нэлээн нарийвчилж зааж өгсөн. Намд иргэдээ судалгааны байгууллага, бодлогын судалгааны байгууллага, намд иргэдээ бодлогын судалгааны институттэй байх, сантай байх асуудлуудыг бас нэлээн хуульчилж оруулж өгсөн.

Тэгэхдээ сая энэ гишүүдийн хэлэлцүүлгийн явцад бас өчигдрийн төрийн байгуулалт дээр өнөөдөр гарч байгаа юу гэвэл энэ намын хөтөлбөр улс орны дунд болон урт хугацааны хөтөлбөртэй уялдах асуудлыг бас нэлээн нарийвчилж дахиж тусгах өгөх шаардлага бол бас байгаа юм байна гэж харж байгаа. Хэлэлцүүлгийн явцад ороод явах байх гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна 1 минут.

Ж.Батжаргал: Мэдээж хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр нэлээн тал бүрээсээ сайн ярилцагдах байх. Зарим нэршил энэ тэр онож байгаа эсэх энэ тэр гээд зүйлүүд байгаа юм. Нам дэргэдээ сантай байх тухай ойлголт ер нь юу гэж ойлгогдох юм бэ? Зүгээр бодлогын хүрээлэн, институт тэр үйл явцууд бол байх ёстой юм шиг байгаа юм тэгээд. Яг сан гэдэг нэршилээрээ орчихоор яах вэ Их Хурал дээр 1 Сангийн тухай хуулийн төсөл орж ирээд, хэлэлцэх эсэх нь яригдчихаад ингээд хараахан эцэслэгдээгүй ингээд явж байгаа зүйл бий. Тийм учраас энэ талын асуудлыг бид нэлээн бодох ёстой зүйл юм болов уу гэсэн 1 ийм санаа байгаад байгаа юм.

Дээр нь энэ намын дарга нарын асуудлыг нэлээн бодмоор юм шиг байгаа юм. Үнэхээрийн л хамтын удирдлагатай ийм улс төрийн байгууллага байна л гэж үзэж байгаа бол тэр үйл явцаа илүүтэй.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуулт байсан л даа. Манай Батжаргал гишүүн чинь санал хэлбэрээр асуулт асуудаг юм л даа. Содбаатар дарга хариульъя 80.

Я.Содбаатар: Олон улсад бол энэ намын дэргэдэх болон улс төрийн судалгааны байгууллагууд янз бүрийн хэлбэртэй байна л даа. Зарим нь бол сангийн хэлбэртэй байна. Ялангуяа Европ тал руу. Та бүхэн мэдэж байгаа Эбертийн сан ч гэдэг юм уу Конрад Аденауэр сан ч гэдэг юм уу маш олон сангууд байдаг. Зарим нь хүрээлэн хэлбэртэй байна. Институт хэлбэртэй, бодлого, судалгааны байгууллагууд. Тэгээд бид нар бол энэ намуудыг бодлогын институт бодлого боловсруулдаг бодлогын байгууллага байлгах чиглэл рүү явуулж байгаа учраас энэ олон улсад байдаг жишигийг буюу сангийн хэлбэртэй байж болно гэсэн ийм

заалтыг бол хуульд оруулж өгч байгаа. Ер нь бол намууд дэргэдээ бодлогын судалгааны байгууллагатай л байхыг шаардаж байгаа. Тэгээд намууд санхүүжилтийнхээ тодорхой хувийг энэ бодлого судалгааныхаа байгууллагаар дамжуулдаг, энэ судалгааны байгууллагууд, улс төрийн судалгаа хийдэг төвүүд, бодлого боловсруулдаг төвүүдтэй хамтарч ажилладаг энэ хэлбэрүүдийг л бид нар хуульчилж өгч байгаа юм.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна. Энэний дараа завсарлана.

Б.Баттөмөр: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилж оруулж ирж байгаа энэ Улс төрийн намын тухай шинэчилсэн найруулгыг дэмжиж байна. Энд бас нэлээн олон асуулт асууя гэж бодож байсан юм. Хүмүүс асуучихлаа, тэгээд давхиуулахгүйгээр хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Энэ яах вэ дээ энэ Монгол чинь 46 нам юу 40 нам бүртгүүлээд 36 нам нь өнөөдөр бүртгэлтэй байна гэж байгаа юм. Тийм ээ. Яах вэ энэ ингээд үзэхээр энэ их өндөр хөгжчихсөн орнуудад бол 6, 7 нам байдаг. Баруун зүүн үзэл баримтлалаараа нэгдээд засгаа байгуулаад явдаг. Манайд 36 нам байгаа боловч тэр үзэл баримтлалаараа нэгддэг, яг ямар үзэл баримтлалтай юм гэхээр зэрэг тодорхойгүй байгаад байдаг. Тэгээд л одоо 36 гэдэг чинь бас л гажуудсан тоо л доо. Монголд чинь гажуудсан юм зөндөө их байгаа шүү дээ. 200 их дээд сургууль, 56 спиртийн үйлдвэр, 120 архины үйлдвэр, бараг 900-аад сүм хийд гэх мэтээр л одоо ингээд л энэ гажуудсан тоон гажуудсан л энэ харилцаануудын нэг энэ намын л бүртгэлтэй холбоотой л яваад байгаа юм л даа.

Тэгээд эхний асуулт бол ийм байна л даа. Ингээд энэ 36 нам байна. Мэдээж энэ хуулийг шинэчилж найруулах маш их судалгаа тооцоо хийгдсэн байгаа байх.

Энэ Монголд байгаа энэ улс төрийн намууд энэ бодлогын институт болж төлөвшихгүй байгаагийн яг үндсэн шалтгааныг та нар тооцоо судалгаа дээрээ юу гэж үзсэн бэ? Өнөөдөр гэхэд нэг 3 намын төлөөлөл энэ Их Хуралд байгаа шүү дээ. Тэгэхээр энийг та нар юу гэж үзсэн бэ гэдэг нэгд хэлэлцэх асуудал.

2 дахь асуудал бол Монгол Улсын эдийн засаг улс төржсөн. Энэ улс төржсөн эдийн засаг яагаад бий болсон гэхээр энэ намуудын энэ популист амлалт. Зарим улс төрчдийн энэ намуудын популист амлалтаас болдог. Энэ яах вэ энэ популист амлалтыг хаах чиглэлээр бас хэд хэдэн заалтууд энд явж л байна л даа. Тэгэхдээ энийг яг төгс хааж чадах юм нэг их сайн харагдахгүй л байгаад байгаа юм. Тийм учраас энэ дээр та нар юу гэж бодож байгаа вэ? Энийг яах ёстой вэ гэдэг ийм юм байгаа юм.

3 дахь асуудал бол ер нь сүүлийн үед энэ нэг яригддаг юм бол энэ нэг хүйсийн төлөөлөл гээд 1 юм л байна. 30 хувь аль нэг хүйсийн төлөөлөл. Одоо энэ мэдээж эмэгтэй л гэж байгаа байх л даа. Монголд чинь тэгээд эмэгтэй ч бай, эрэгтэй ч бай энэ хуулийн өмнө бүгд л тэгш эрхтэй л байгаа шүү дээ. Юм болгонд энэ хүйсийн төлөөлөл гээд ингээд 30 хувь, 40 хувь гээд ингээд яваад байх нь ер нь хэр зэрэг байдаг юм бэ гэсэн 3 дахь асуулт.

4 дэх асуудал бол энэ 26.8 дээр нам энэ хуулийн энэ 26.1-д заасан орлогыг цахим мөнгөн хэрэгслээр хүлээж авахыг хориглоно гэж. Цахим мөнгөн тэмдэгт гэдгийг бол крипто валютаар төсөөлж тооцоолж болохгүй шүү дээ. Дэлхийн чиг хандлага чинь энэ цахим мөнгө рүү явж байгаа шүү дээ. Энийг та нар юу гэж тооцсон бэ?

Дараагийн асуудал энэ 5 дугаар бүлэг намын санхүүжилттэй холбоотой асуудал. Монголын эдийн засаг жижигхэн. Энэ 15 тэрбум долларын эдийн засагтай шүү дээ. Бид нар 30 жилийн хугацаанд үзэж, үзэж л энэ олон

нам 36 нам байгуулагдаад л үзэж, үзэж л 15 тэрбум долларын эдийн засагтай. Монгол Улсын төсвийн орлого нэг 5 тэрбум доллар л байгаа шүү дээ. 1 хүнд ноогдох ДНБ сая нэг 5033 доллар болж байх шиг байна. Энэ санхүүжилтийн юмнуудаа эдийн засгийн тооцооллоо та нар яаж гаргасан юм бэ? Одоо ингээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлт гээд 152 гишүүн нь ингээд ороод ирэх юм бол энэ эдийн засагт энэ дааж барих талын энэ тооцоонуудыг ер нь яаж хийсэн бэ? Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Бумдарь 84, доктор Бумдарь, доктор профессор Бумдарь.

Д.Бумдарь: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр манай улс төр судлалд бол намыг бол маш олон тодорхойлолтоор хэлэхээс гадна намд бол тодорхой шинжүүд байх ёстой гэдэг зүйлийг бол зайлшгүй зааж өгдөг. Жишээлбэл таны асууж байгаа улс төр нам бол улс төрийн бодлого боловсруулна. Нам бол улс төрийн үйл ажиллагаагаа бол ардчилсан тийм ээ хэв шинжээр бол хийнэ, хэрэгжүүлнэ. Мөн ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэх ийм субъект байхын тулд мөрийн хөтөлбөр нь бол бүх нийтийн шинжтэй, хөгжилд чиглэсэн байх ёстой. Түүнийгээ бол сонгуульд өрсөлдүүлнэ гэдэг ч юм уу. Мөн улс төрийн үзэл баримтлалаараа бол өрсөлдөнө гээд маш олон ийм намд байх шинжүүдийг бол заадаг.

Дээрээс нь нам бол 3 шинжийг бол заавал бүрдүүлж байж улс төрийн нам хөгжинө гэж үзэж байгаа. 1-д улс төрийн намын тоо их чухал. Улс төрийн нам өөрөө өрсөлддөг байхуйц, дээр нь улс төр нь улс төрийн нам өөрөө үндэсний бодлого тодорхойлогч байх гэсэн энэ 3 шинж бол байж улс төрийн нам бол хөгжинө гэж бол үзэж байгаа. Гэтэл манайд яагаад улс төрийн нам бодлогын институт болж хөгжихгүй байна вэ гэхээр энэ бол улс төрийн тогтолцоотой нь бол шууд холбоотой. Нэгдүгээрт бол энэ Сонгуулийн тухай хуулийг бол

зайлишгүй бол авч үзэх ёстой. Энэ бол улс төрийн намын хөгжилд бол шууд нөлөөлдөг. Намын дотоод институт бүтэц нь бол шууд нөлөөлдөг ийм хууль байгаа. Гэтэл манайд яадаг вэ гэх юм бол Сонгуулийн тухай хуулийг бол 4 жил тутамд өөрчилдөг тийм ээ, нэмэлт, өөрчлөлтүүд оруулдаг. Тухайн улс төрийн намд хариуцлага тооцох болон ард иргэдийг улс төрийн боловсрол, сонгуулийн боловсрол олж авах энэ боломжийг бол бүрэн юу энэ боломжийг хаачихдаг гэж бол хэлмээр байна. Тэгэхээр Сонгуулийн хуулийг бол тогтвортой явуулах ёстой. Энэ аргачлалыг нь бол.

Дараагийн 1 асуудал болохоор бол улс төрийн намын бол санхүүжилтийн асуудал бол байгаа. Яалт ч үгүй улс төрийн нам санхүүжилтийн эх үүсвэрээ хаанаас олох вэ гэдэг маань бол өөрөө бүрхэг явж ирсэн учраас үүнээс шалтгаалаад бол тодорхой бүлэг гэдэг ч юм уу, тодорхой юу гэдэг юм мөнгөний хамааралтай байдал нь өөрөө улс төрийн намын бодлого, нийтийн сайн сайхны төлөө хөгжил мөрийн хөтөлбөр боловсруулахад бол саад бол учруулж бол ирсэн байгаа. Энэ бүхэн нь өөрөө улс төрийн намын хариуцлага, улс төрийн нам гэдэг ямар зүйлийг зорилгоо болгосон институт субъект вэ гэдгийг бол нэг ёсондоо алдагдуулж ирсэн ийм улс төрийн тогтолцоог хөгжүүлж чадаагүй хуулиудтай бол шууд холбоотой.

Тийм учраас Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 3 бол ерөнхийдөө бол ингээд хамтдаа тийм ээ орж ирж байгаа нь энэ хаврын чуулганаар бас орж ирж байгаа нь бол их талархууштай үзэгдэл гэж бол хувьдаа үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя 80.

Я.Содбаатар: Энэ удаагийн хуулийн 1 гол зүйл бол энэ санхүүжилтийн асуудлыг ил тод,

нээлттэй, шилэн болгох, тайлан тооцоог нь тодорхой болгохоос гадна ойлгомжтой тодорхой болгож байгаа нэг хязгаарлалтууд нэлээд тавьж байгаагийн нэг зүйл бол танд хэллээ тэр цахим мөнгөн хэрэгслийг. Ер нь бол бид нар энэ бэлэн бусаар явж байгаа хандивын асуудлыг бүрэн хязгаарлаж байгаа. Бүгд ялангуяа төрийн санхүүжилттэй холбоотой бол 1 дансаар өмч хөрөнгийг нь төв намын 1 бүртгэлээр гэх мэтчилэн нэгдсэн ийм ойлголтод оруулсан нэлээд заалтуудын хүрээнд явж байгаа зүйл.

2 дахь нь төрийн санхүүжилтийн хэлбэр дээр тэр намыг урьд нь бол суудлын тоогоор байсан учраас хэрэв гишүүдийн тоо нэмэгдээд явбал тэгээд л суудлын тоогоороо төсвөөс авах мөнгө нэмэгдээд явчих байх л даа. Энэ удаа бол сонгогчдод авсан саналаар байгаа. Тэгэхээр сонгогчдын тоо сонгогчдоос авсан санал бол суудлын тоо гишүүдийн тоо 170 болно уу, 200 болно уу, 20 болно уу хамаарахгүйгээр сонгогчдын тоон дээрээ үндэслэж байгаа учраас 1,7 сая дээрээ л үндсэндээ гол суурь тооцоолол нь тэрэн дээрээ явж байгаа юм. Тийм учраас харьцангуй яах вэ.

Хоёрдугаарт аймаг орон нутгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн тоо бас янз бүрээр хөдлөөд ингээд яадаг учраас энийг бол бид нар өгдөг тэр суудлын юуг нь бас болиулчихаж байгаа юм. Тийм учраас нэгдсэн зөвхөн парламентад авсан сонгогчдын санал дээр нь илүү түшиглэсэн. Мэдээж парламентад авсан суудлынх нь тоо дээр нь нэмсэн ийм томъёоллоор энэ төсвийн юу гарч ирж байгаа юм. Ер нь бол улсын төсөв дээр ирж байгаа ачаалал бол яг өнөөдрийн байдлаар 76 гишүүнээрээ тооцоод өнөөдрийн байдлаар энэ 1.7 сая санал өгч байгаа сонгогчдын тоотойгоо харьцуулаад үзэх юм бол төсөв дээр нэмэлт ачаалал үндсэндээ ирэхээргүй байгаа. Сүүлийн 4 жилд бол бид нар янз бүрийн улс төрийн намуудад орон нутгийн түвшин, орон нутгийн сонгуулийн дүнгээр, Улсын Их Хурлын

сонгуулийн дүнгээр суудлын мөнгө, төлөөлөгчдийн мөнгөний нэрээр 20 гаруй тэрбум төгрөг зарцуулж байгаа. Энэ удаа ч гэсэн энэ тоогоор аваад үзэх юм бол энэ хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулагдахаар байгаа.

Г.Занданшатар: Үдээс өмнөх Ундрам гишүүн. Ундрам гишүүн алга байна. Хүмүүсийн төлөөлөл сая бас Бумдарь докторт хариуллаа. Улс төрийн намын олон тодорхойлолт байгаа. Манай эрэн үеийн нэр төр, нандин чанар, оюун ухаан, уураг тархи, бодлого тодорхойлогч, ардчилсан институт, сонгуульд нэр дэвшүүлдэг хүний нөөцийг бэлтгэдэг институт гээд ингээд олон тодорхойлолтууд. Сая өнөөдөр энэ Сант Марал сангийн гаргасан судалгаагаар улс төрийн намууд ард иргэдийн хүсэл зориг, санал бодлыг илэрхийлж чадаж байна уу гэсэн асуулт 87 хувь нь чадахгүй байна гэж хариулсан байна. 41.5, 46.5 хувь нь байсан уу улс төрийн намууд хэрэггүй 46.5 хувь нь улс төрийн намууд хэрэггүй 1 хүчтэй Ерөнхийлөгч байх хэрэгтэй болжээ гэж ард иргэд хариулсан байна.

Тэгэхээр энэ улс төрийн намуудад итгэх итгэл ингэж суларч ард иргэдийн хүсэл эцсийн дүндээ л ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлж, их ашиг сонирхол, үзэл бодлыг илэрхийлэх ёстой, нэгтгэж илэрхийлэх ёстой улс төрийн намуудын ийм нэр хүнд муу байгаа нь ардчиллын нэр хүндэд нөлөөлж байна. Тэгээд энэ талаар яг хуулийн төсөлд яаж тусгасан бэ? Энэ улс төрийн намд итгэх итгэлийг сэргээж, улс төрийн нам ард түмний төлөөллийг ард түмний үзэл бодлын илэрхийллийг илэрхийлж чаддаг тийм улс төрийн институт болох энэ суурь концепцын ойлголтыг энэ хуульд тусгасан уу? Ард иргэдийн 41.5 хувь нь Монгол Улс дарангуйлал руу шилжиж байна гэж хариулсан байна. Энийг энэ улс төрийн намын тогтолцоотой холбож үзэхээс аргагүй. Тэгээд сая та бүхэн хариуллаа. Бас Улс төрийн нам, Сонгуулийн хууль 2 бол хүйн холбоотой. Энэ өргөн баригдсан Сонгуулийн

хуультай хүйн холбоотой энэ хэрэгжиж чадах уу?

Монголын ардчиллыг төлөвшүүлэх хөгжүүлэхэд нийт ард иргэдийн хүсэл эрмэлзэл дуу хоолойг илэрхийлэх институт болгож өөрчилж чадах уу? Аль эсвэл зөвхөн ингээд нөгөө сонгуульд оролцох, татан буулгах тэр механик харилцаануудыг зохицуулахад илүү чиглэгдсэн үү? Энэ асуултуудад хариулж өгөөч? Нийгмийн 93.1 хувь нь шударга бус байна. Нийгэм шударга бус байна. Энэ авлигатай тэмцэх ажилд ахиц дэвшил гарахад улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдал, улс төрийн сонгуулийн санхүүжилтээс их шалтгаалж байна. Улс төрийн намын санхүүжилт, улс төрийн сонгуулийн санхүүжилт байгаа энэ авлигыг энэ сонгуулийн тогтолцооноосоо авхуулаад бүх шатанд энэ улс төрийн нам чинь өөрөө авлигыг өдөөх хүчин зүйл болсон байна гэж үзсэн байна, иргэд хариулж байна. Энэ санхүүжилтийн ил тод байдлыг ийм учраас бий болгож, дотоод ардчиллыг бэхжүүлэхэд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чиглэгдсэн.

2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт бол энэ Монголын онцлогт нийцүүлж их захгүй энэ олон улс төрийн намуудыг жинхэнэ ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийллийг улс төрийн институт болгохын тулд тодорхой шаардлагууд тавьсан. Дотоод ардчилалтай байх, ардчилсан зарчимд нийцсэн байх, улс төрийн намын санхүүжилт орлого, зарлага ил тод нээлттэй байх. Ингэж байж энэ ардчиллыг бэхжүүлэхэд тэр үед чиглүүлсэн энэ өөрчлөлтийг хийсэн. Яагаад гэхээр ерөөсөө энэ бүх болж бүтэхгүй байгаа авлигал, хээл хахууль, хөгжил хоцрогдол, доройтол, ядуурал олон юмны шалтгаан чинь улс төрийн намын энэ бодлогоос, санхүүжилтээс, улс төрийн сонгуулиас болж байна гэж ард иргэд үзээд байна. Энэ ардчиллын төлөвшил чинь. Тэгээд энэ асуудалдаа гол ач холбогдол өгч энэ намын энэ хуулийн үзэл баримтлал, философи чиглэгдэх

ёстой. Тэгээд энийг яаж шийдэж байгаа юм бэ гэдгийг өнөөдөр бас гишүүдийн асуултад тодорхой хариулах шаардлагатай байна л даа. Энэ талаар хэн хариулах вэ? Содбаатар дарга хариулъя 80.

Я.Содбаатар: Улс төрийн намын хууль парламентын босго давж 18 жилийн дараа орж ирж байгаа юм. 2005 онд Улс төрийн намын хууль батлагдсанаас хойш. Тэгээд энэ удаагийн Улс төрийн намын хууль бол бас 2019 оны Үндсэн хуульд улс төрийн намын талаар 3 томоохон заалт орсны дараа орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ удаагийн үндсэн энэ удаагийн Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барихдаа ялангуяа Үндсэн хуульд заасан намын дотоод ардчилал, ардчилсан зарчимд үндэслэсэн байх, санхүүжилт нь ил тод нээлттэй байх, төрийн санхүүжилтийн хэлбэрийг тодорхой хуулиар тогтоож өгөхтэй холбоотой ер нь энэ намыг дагасан нийгэмд байгаа энэ томоохон шүүмжлэлүүдийг энэ иргэдээс ирж байгаа итгэхгүй байгаа, энэ намуудад байгаа энэ болохгүй байгаа энэ 30 жилд явсан алдаа оноог засах чиглэл рүү бол хуулийн төсөл боловсруулахад нэлээн гол анхаарал хандуулж ажилласан.

Тийм учраас хэд хэдэн зарчмын томоохон концепцыг энэ хуулиараа хийхэд барьсан. Нэгдүгээрт бол улс төрийн нам бол бодлогын институт болох ёстой. Хөгжлийн бодлогоороо уралддаг байх ёстой. Улс төрийн нам бол 1 хэсэг бүлэг юм уу, 1 хэсэг хүмүүсийн эсвэл 1 ААН-ийн нам байж болохгүй, бүлэглэл байж болохгүй. Энэ бол улс төрийн нам, үзэл санаа, үнэт зүйл, үзэл баримтлалтай нь нэгдсэн иргэдийн эвлэлдэн нэгдсэн энэ байгууллагынхаа хувьд энэ улс орны хөгжил, энэ улс орны хэмжээний бодлого дэвшүүлэн оролцдог ийм институт болж бодлогын институт болж төлөвшүүлэх чиглэлийнх нь асуудлууд явж байгаа юм.

Хоёрт улс төрийн намын санхүүжилтийг нээлттэй ил тод болгох чиглэлээр их тодорхой зааж өгсөн? Нэг ёсны төсвөөс өгч байгаа өнөөдрийн хөрөнгө мөнгийг маш тодорхой ойлгомжтой, тэгээд зөвхөн улсын төсвөөс өгч байгаа мөнгөний зарцуулалтын зориулалтыг нь хүртэл нарийвчилж зааж өгсөн. Эргээд хяналт тайланг нь авах хэлбэрүүдийг нь маш хуулийн нарийн заалтууд оруулж өгсөн. Үүний зэрэгцээ хандив нэрээр орж ирээд байгаа тэр энэ асуудлыг нь хязгаарлаж өгсөн. Жилд өгч байгаа хандивын хэмжээ эцсийн өмчлөгчөөрөө авч байгаа жилийн нийлбэр дүнгээр бас авч үзэж байгаа. Тийм учраас бол энэ улс төрийн намуудыг дагасан энэ авлигал, хээл хахууль, улс төрийн намуудыг дагаж байгаа хүмүүсийн хардалт сэрдэлт байгаа энэ санхүүжилтийн юмнууд бол маш энэ ил тод, нээлттэй болно. Энийг Шилэн дансны хуулиар Улсын Их Хурлын парламент дээрээ хүртэл авчирч хэлэлцдэг, жилд тайлангийн сонсдог хэлбэрүүдийг хүртэл нарийвчилж хийж өгсөн.

3-д бол улс төрийн намын дотоод ардчиллын, улс төрийн нам гээд нэрлэхдэг. Тэгээд нэг хэд цөөхөн хэдэн хүмүүс дараад суучихдаг. 20, 30 жилээр нь хурлыг нь хийдэггүй эсвэл 20, 30 жилээр нь дээр нь гараад суучихдаг. Залуу үе, шинэ үе нь орж ирдэггүй, шинэ дуу хоолой орж ирдэггүй энэ зүйлүүдийг нь хязгаарласан хязгаарлалтуудыг авч байж улс төрийн намыг Ардчилсан институт байх институт чиглэлээр нь, иргэдийн оролцоотой байх чиглэл рүү нь бас нэлээн нарийвчилж зааж өгсөн. Улс төрийн намуудын хариуцлагыг дээшлүүлэх, улс төрийн намуудыг олон нийтийн хяналтад гишүүдийнх нь хяналтад авчирч өгөх олон заалтууд бас орсон гэдгийг бас тодотгож хэлье.

Улс төрийн намын энэ хууль гарснаар бол улс төрийн намуудын иргэдийн улс төрийн намд итгэх итгэл, дагаад Монголын төрд итгэх итгэл сэрэх учиртай. Тийм учраас улс төрийн

намуудын одоо байгаа энэ нийгмийн зүгээс олж байгаа энэ олон шүүмж юунуудыг энд бас нэлээн олон заалт нарийвчилж зааж өгсөн. Парламентын түвшинд ч гэсэн бас хэлэлцэх явцдаа анхаарч үзэх байх гэж ингэж бодож байна. Нэмээд Энхцэцэг судлаач нэмэх үү?

Г.Занданшатар: Судлаач Энхцэцэг 86, битгий дар, цаанаасаа асна.

Д.Энхцэцэг: Энэ дээр ер нь бол Содбаатар дарга дээр нэлээн тодорхой хариулчихсан учраас маш товчхон зүгээр өөрийнхөө саналыг хэлчихье. Энэ нөгөө өмнө нь бол бид нар ерөнхийдөө нөгөө нэг суудлын тоонд үндэслэсэн тийм ээ, төрийн санхүүжилтийг олгож байсан. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд бид нар тэр 2 хувь гээд түрүүн нэлээн олон гишүүн бас дурдсан. Тэгэхээр юу сонгогчдынхоо 2 хувийн саналыг авахын тулд намууд ажиллах хэрэгтэй болж байгаа. Энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр иргэдийнхээ дэмжлэгийг олж авахын тулд тэр нам иргэдтэйгээ бол илүү ойрхон ажиллах ийм хөшүүргийг энэ хуулиар бид нар бол оруулж ирж байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр энэ хууль маань батлагдах юм бол ийм заалт хэрэгжиж эхэлснээр нөгөө олон намын системийг төлөвшүүлэхэд бас дэмжлэг үзүүлнэ. Дээш нь дээр нь бол тэгш өрсөлдөөний боломжийг бас жоохон ахиулж өгч байгаа. Тэгэхээр ямар ч байсан бол энэ өмнө нь бид нарын авч ирсэн системээс нэлээн ахиц гарна гэж бол судлаачдын зүгээс харж байгаа. Тийм учраас энэ 2 хувийн саналыг, дэмжлэгийг олж авах энэ заалт бол бас их маш чухал заалт юм гэдгийг бол онцолж хэлэх нь зөв байх.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн алга байна. 13 цаг болсон тул өнөөдрийн үдээс өмнөх хуралдаан завсарласныг мэдэгдье. 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ.

13.07 цаг

2023 оны 04 дүгээр сарын 20, Пүрэв гараг,

Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 04 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: 4 дүгээр сарын 20-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улс төрийн намын тухай хуулийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Улс төрийн намын тухай хуулийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж байгаа. Гишүүд асуулт, асуулт, хариулт явж байгаа. Одоо ингээд Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Ажлын хэсгийг оруулъя, ажлын хэсгийг оруулъя. Бат-Эрдэнэ гишүүнийг түр авчих, ажлын хэсэг орж ирэхээр асууна. Асуух уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Улс төрийн намын тухай хуулийн төслийг улсын Ерөнхийлөгч оруулж ирж байгаа явдалд бол энэ зөв байна. Одоо хуулийн төслийг бол ерөнхийд нь зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгээ хэлье. Яах вэ ер нь Монгол Улсын төрөөс энэ нийгэмд шударга ёс тогтоох, нийгэмд шударга ёс тогтоох, авлигал хээл хахууль, энэ хүнд суртлыг арилгах ийм чиглэлээр бол нэлээн одоо бас бодлогын ахиц дэвшил бол гарч байгаа. Бид удаа дараагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд энэ асуудлыг тууштай шаардаж тавьж ирсэн ийм хүмүүс.

Ялангуяа одоо төсвийн зарцуулалт, Төрийн хэмнэлтийн хууль цаашилах юм бол энэ төрийн албыг төрлийн алба болгодог, төрийн өндөр албан тушаалд байгаа улсууд улс төрийн нөлөө үзүүлж, төр ард түмний нэр барьж авсан бонд зээл авдаг, төсөл, концесс, тендер юу байдаг юм ийм юманд одоо оролцдог байдлыг бол арилгах ёстой. Хариуцлагатай байх

ёстой, өндөр ёс суртахуунтай иргэд олон түмнийхээ өмнө одоо өргөсөн тангарагтаа үнэнч ингээж ажиллах ёстой гэж ингээж шаарддаг. Энэний дагуу бол хууль, эрх зүйн тодорхой шийдвэрүүд гараад явж байна. Энэ хүрээнд одоо бид бас олон жил ярьсан асуудал бол энэ улс төрийн намын тухай асуудал байгаа юм. Улс төрийн намаар дамжиж одоо төрийн эрх мэдлийг авдаг. Тийм учраас энэ улс төрийн намын үйл ажиллагаа, улс төрийн намын төлөвшилтэй холбоотой асуудал бол маш чухал ийм зүйл.

Тэгэхээр надад нэг 2, 3 асуулт байгаа юм. Нэгдүгээрт бол энэ хуулийн төсөл дээр 2 сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд дараалан Улсын Их Хуралд нэр дэвшүүлээгүй ийм улс төрийн намыг идэвхгүй хэлбэрт одоо шилжүүлнэ гэсэн ийм заалт байгаа юм. Тэгэхээр миний санахад энэ Улсын Их Хурлын сонгуульд 2 удаа дараалан суудал аваагүй намыг идэвхгүй байдалд оруулах юм уу эсвэл одоо татан буулгах тухай асуудлыг ярьж болоогүй юм уу? Энэ талаар одоо тодорхой хариулт өгч болох уу гэж.

Нөгөө талынхны бол энэ хатуу гишүүнчлэлтэй холбоотой асуудал байж байдаг. Энэ асуудлыг яаж зохицуулж байна вэ? Түрүүн хариултаас харах юм бол энэ улс төрийн намын үйл ажиллагааг ил тод байлгах, улс төрийн намын одоо гишүүдийн оролцоо гишүүдийн хяналтад байлгах чиглэлээр нэлээн тодорхой саналууд оруулж байгаа юм болов уу гэж би ингээж бодож байна. Энэний хүрээндээ бодлогын нам байх, дүрмийн хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрийг боловсруулах судалгаа бодлогын судалгааны чиглэлийн юман дээр онцгой анхаарч, одоо бол нөгөө дүлийдээ найдаад гэдэг шиг олон гишүүд элсүүлчихсэн ийм улс төрийн намууд чинь энэ дээрээ хайхарч өгөхгүй байна шүү дээ. Мөрийн хөтөлбөр дээрээ ч хайхарч өгөхгүй, бодлогын асуудал дээрээ ч одоо бас эргэлзээтэй. Судалгааны байгууллагууд. Цаашлах юм бол боловсон хүчний хүний нөөцийнхөө асуудал дээр

бас анхаарал тавих ийм шаардлага байна. Энэ талаас нь зохицуулалт ямар зүйлүүд орж байна вэ гэж?

Хамгийн сүүлд асуух гээд байгаа юм бол энэ намын санхүүжилттэй холбоотой асуудлыг яаж зохицуулж байгаа вэ? Энэ чинь намын санхүүжилтээс дагасан тодорхой бус байдлууд их гараад байгаа. Манайхтай ижил төстэй ийм улс төрийн намууд тухайлбал ХБНГУ-ын хувьд бол Конрад Аденауэрийн сан ч гэдэг юм уу, Фридрих Эбертийн сан гээд улс төрийн намуудаа санхүүжүүлэх төдийгүй тодорхой.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Намууд энэ удаагийн Улс төрийн намын тухай хуулийн бас нэг гол онцлог бол энэ намуудад хариуцлага тооцох, намуудыг хариуцлагажуулах энэ асуудал байгаа юм. Тийм учраас бид нар энэ намыг идэвхгүйд тооцох гэсэн ийм шинэ функцийг оруулж ирж байгаа. Энэ бол яах вэ намуудыг шууд иргэдийн эвлэлдэн нэгдэж байгаа эрх, эрх чөлөөг шууд хаан боогдуулах биш бас 1 тодорхой, тодорхой тохиолдолд тухайлбал Улсын Их Хурлын ээлжит сонгууль, санхүүгийн тайлангаа хугацаанд нь гаргаж өгөөгүй, намын удирдах дээд байгууллагууд, төлөөллийн төв байгууллагуудыг хугацаанд нь хуралдуулаагүй ийм тохиолдлуудад бол намыг идэвхгүй хэлбэр рүү шилжүүлээд тэгээд зөрчлөө арилгах шаардлага тавиад, зөрчил нь арилгахгүй бол харин тэр намыг цааш нь яах вэ гэдэг асуудал босож байгаа юм.

Яг тэгэхээр энэ дээр зүгээр яг парламентад суудал авсан, аваагүйгээр нь бол бас улс төрийн намыг ингээж хязгаарладаг ийм юунууд бол харьцангуй бага байна. Тийм учраас зүгээр хэлэлцүүлгийн явцад ийм хатуу заалт оруулж өгч, парламентад тодорхой босго даваагүй бол тэр намуудыг татан буулгадаг ийм хэлбэр оруулбал

парламентын түвшинд явах байх. Зүгээр бид нар бол одоогийн юугаар бол ийм байдалтай явсан байж байгаа.

2 дахь нь хатуу гишүүнчлэл дээр та сая бас хэллээ. Ер нь бол хатуу гишүүнчлэлийг бид нар татгалзъя. Тийм учраас намын гишүүн, намын дэмжигч гишүүн, сонгуульт гишүүн гээд ингээд энэ гишүүдээ ангилъя. Тэр хүрээндээ намын тэр жинхэнэ гишүүн гэж байгаа, намын гишүүн гэж байгаа тэр хүмүүст л татвараа төлөх тэр намын дотоод сонгуульд саналын эрхтэй оролцох, намаас сонгож томилогддог албан тушаалдаа очих энэ эрх нь байж байг. Намын дэмжигч гишүүд бол намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоод явдаг энэ хэлбэрийг нь авсан гэдгийг бас тодотгож хэлье.

3 дугаар асуултын хувьд бол ерөөсөө энэ удаагийн хуулийн өөрийнх нь гол үзэл санаа бол улс төрийн намууддаа бодлогын институт болгоё, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод нээлттэй шилэн болгоё гэдэг рүү гол чиглэж байгаа. Энэ агуулгаараа бол улс төрийн намын дэргэд бол бодлогын хүрээлэн, бодлогын сан, бодлогын байгууллагууд ажилладаг байя. Тэгээд энэ бодлогын байгууллагуудын санхүүжилт нь бол намын санхүүжилтийн 30 хувь хүртэл хувь нь байхаар үндсэндээ зааж байгаа. Тийм учраас энэ бодлогын байгууллагуудад бол яг ийм, ийм чиглэлээр төсвөөс өгч байгаа санхүүжилтийн хувийг ингэж зарцуулна, нам өөрийнхөө санхүүжилтийн юунд бол энэ бодлогын байгууллагуудаараа дамжуулан, дэргэдэх хүрээлэнгүүдээр бодлогын судалгааны бодлогын байгууллагаараа дамжуулж хэрэгжүүлнэ гэсэн ийм агуулгатай заалтууд бас нэлээн хэдэн орсон байгаа.

Ер нь бол улс төрийн намууд дэргэдээ сантай байдаг энэ олон улсын жишиг байна. Та сая Германы жишээг хэллээ. Германд ч гэсэн хэрэв парламентад суудал аваад явал улс төрийн намууд бол дэргэдээ сангуудтай

байдаг. Сангуудаараа дамжуулж санхүүжилт, төсвийн санхүүжилтийн дэмжлэг авдаг. Тэрүүгээрээ иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн энэ ардчилал үнэт зүйлийн талаарх соён гэгээрүүлэх ажлыг хийдэг, эргээд тэр сангуудаараа дамжуулаад ардчилал, зах зээл, энэ нийгмийн үнэт зүйлүүдийг сурталчилдаг, энэ хөгжлийн бодлого тодорхойлоход оролцдог энэ хэлбэрүүдийг бас Монголд нэвтрүүлж гэдэг үүднээс энэ хуульд ийм шинэ заалтууд нэмэгдээд нэмэгдлээр орж ирж байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс өөрийн бүрэн эрхийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барьж байгаад бас талархлаа илэрхийлье. Үнэхээр Монгол дахь улс төрийн нөхцөл байдал ямар хэмжээнд байгаа юм, тэр дундаа намын төлөвшил нь ямар хэмжээнд байгаа вэ гэдгийг бас олон нийт маань өнөөдрийн нөхцөл байдлаас бас шууд харж мэдэж байдаг. Тэр ч үүднээсээ бас зайлигүй энэ хуульд шинэчлэл хийх шаардлагатай байна гэдгийг бас олон нийт хүлээн зөвшөөрч байгаа байх.

Ер нь бол нийтдээ Монгол Улс өнөөдрийн байдлаар 3457548 хүн амтай гэсэн ийм тоо гарч байна. Ийм хүн амтай улсын хувьд 36 нам Дээд шүүхэд бүртгэлтэй байна гэдэг бол маш өндөр тоо байх гэж би харж байна. Зүгээр ингэснээрээ олон улс төрийн нам байснаараа улс төржилт, талцалт хуваагдал өнөөдөр бол Монгол Улсын хэмжээнд бас дээд цэгтээ хүрсэн. Өнөөдрийн оруулж ирж байгаа хуулийн төслөөр бас намын босгыг бас өндөрсгөж байгаа нь өөрөөр хэлэх юм бол нам хүчирхэг байх, чадавхтай байх, ардчилалтай байх тэр зарчмыг бий болгох ийм боломжийг бас нээж өгч байгаа болов уу гэж би харж байна.

Эхний асуулт 2019 онд батлагдсан Үндсэн хуулийн өөрчлөлттэйгөө энэ хууль маань ер нь хэр нийцэж байгаа бол? Ямарваа нэгэн зөрчил үүсэх ийм тооцоолол ер нь хэр байгаа бол гээд. Би яагаад ингэж асууж байна вэ гэвэл 801 гишүүнтэй гэсэн ийм тоо орж ирж байна тийм ээ амын гишүүн. Үндсэн хуулийн өөрчлөлтөөр болохоороо 21150 иргэний гарын үсгийг цуглуулж байж нам үүсэх боломжийг бүрдүүлнэ гэж энэ заалт байгаа. Тэгэхээр энэ мэтчилэн Үндсэн хуулийнхаа нэмэлт? өөрчлөлттэй зөрчилдөх зөрчлүүд ер нь хэр байгаа юм бол гэдэг 1 ийм асуулт.

Хоёрдугаарт ийнхүү улс төрийн нам шинэчлэгдсэнээрээ намын шинэчлэл батлагдсанаараа улс төрийн намуудын чиг хандлага маань ер нь хаашаа явах гэж байгаа юм бол? Бид ер нь хаа хүрвэл улсын маань хөгжил гэдэг юм уу, улсын хөгжлийн бодлого тийм ээ зөв чигтээ харах байх бол. Энэ дээр би бас 1 улс төр судлаачдынхаа бас тайлбарыг авъя гэж бодож байна

МАН бол цахим нам. Бид цахим нам гэдгээ хэдийнээ зарлачихсан. Яг Улс төрийн намын тухай хууль дээр цахимжих заалт ер нь хэр байна гэж та бүхэн хэлэх вэ? Аливаа бүртгэл мэдээлэл, татвар бүгд нээлттэй байх ёстой. Ер нь бол энэ бол намын дүрэмд намын хуульдаа хэр орсон бэ гэдгийг бас асуух гэсэн юм?

Нөгөөтээгүүр 1 гишүүнчлэлийн татварын тухай 1 зүйл заалт бол байгаа юм. Сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сарын хураамж нь 5 хувиас хэтрэхгүй байх. 1 бас судлаач бичсэн байна тийм ээ 1 хүн бичсэн байна. Энэ болохоор арай өндөр биш үү, зүгээр мөнгөтэй хүн намд элсдэг болчих юм биш биз дээ гэсэн ийм бас болгоомжлолыг ирүүлсэн байна. Тэгэхээр энэ дээр бас 1 тайлбарыг авъя. Өнөөдөр бас түрүүн тэр Их Хурлын дарга хэлсэн. Сант Марал судалгааны төвийн судалгаа дээр

улс төр сонирхдог уу гэсэн асуулт дээр бага зэрэг сонирхдог, огт сонирхдоггүй 26.1 хувь гэсэн ийм судалгаа гарсан байна. Зүгээр улс төрийн сонирхол гэдэг бол 1 өөр байх. Гэхдээ улс төрийн идэвх гэдэг бол сонгогчдын сонголт сонгуульд саналаа өгөх энэ идэвхээс бас шалтгаалдаг байх гэж би бодож байна. Тэгвэл сонгогчдынхоо боловсролд чиглэсэн санхүүжилтийг бас тодорхой хэмжээгээр төрийн нөгөөдөх төрөөс авах санхүүжилтийн дэмжлэгээсээ бас 15 хувь гэсэн ийм заалт байна л даа.

Бид сонгогчдынхоо боловсролыг нэмэгдүүлэх тал дээр ер нь хэр анхаарах ёстой вэ? Сонгуулийн тухай хууль дээр квот яриад эхлэхээр зэрэг зөвхөн энэ парламентад байгаа эмэгтэйчүүд өөрсдөө дахиж сонгогдох гээд байгаа мэтээр олон нийт бас нэг ойлгосон ийм зөрөө ойлголт байна. Тэгвэл улс төрийн тийм ээ намын тухай ойлголт мэдлэг мэдээллээ нам өөрөө тодорхой хэмжээнд сонгогчдоо өгдөг байх тэр үүрэг хариуцлагыг ер нь хэр зүйл заалтаар оруулсан бэ гэж би тодруулах гэсэн юм. Бид сонгогчдоосоо үүргийг нь нэхдэг. Харин тэд эрх.../минут дуусав/

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна 80.

Я.Содбаатар: Тэгэхээр энэ удаагийн хуульд 2019 оны Үндсэн хуультай хэр нэмэлт, өөрчлөлттэй хэр нийцэж байгаа талаар Бямбажаргал зөвлөх нэмэлтээр хэлчхээрэй. Ер нь бол таны сая хариулсан асуусан тэр намын гишүүний намын жинхэнэ гишүүний татварын асуудал бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувь гэдэг бол дээд хязгаар нь юм байгаа юм. Тэрнээс хэтрэхгүй гэж. Нэг ёсны намууд энэнээс илүү мөнгө хүнээс авч болохгүй. Тэрэн дотор гэхээр авахгүй ч байж гишүүний татвараа тэрнээс доошоогоо авч болно гэсэн үг. Тэгээд ойролцоогоор өнөөдрийн ханшаар бол 25000 төгрөгөөс сарын хураамж хэтрэхгүй л гэсэн агуулга явж байгаа цаана нь. Тэгэхээр 1000 төгрөгөөр тогтоох уу, 500 төгрөгөөр

тогтоох уу, 5000 төгрөгөөр тогтоох уу гэдэг нь 25-саа л хэтрэхгүй гэсэн агуулга явж байгаа.

Тийм учраас дээд хязгааруудыг нь хязгаарлалт тавьж байгаа. Яагаад гэхээр энэ зарим намууд бол энэ бүр ингээд сонгуульд дэвших хүмүүстээ хүртэл дэнчин тавьж байсан шүү дээ тийм ээ 100 сая төгрөг өгвөл сонгуульд нэр дэвшүүлнэ ч гэдэг юм уу. Тэгээд энэ эд нарыг бол хуулиар хориглож өгсөн. Энэ улс төрд бол олон түмний оролцоо нэмэгдэх ёстой. Улс төрд зөвхөн хөрөнгө мөнгөтэй хүмүүс биш мэдлэг боловсролтой, ёс зүйтэй, сэтгэлтэй хүмүүс энэ улс төрд оролцож, энэ идэвхтэй байр сууриас хандаж энэ намуудаар дамжиж төрийн хэрэгт оролцдог байх ёстой гэсэн ийм агуулгууд цаана нь явж байгаа учраас бид нар аль болох иргэдэд нээлттэй, иргэдийн хяналтад энэ улс төрийн намуудыг оруулах чиглэл рүү заалтууд оруулж өгсөн гэж хэлж болно.

Дараагийн нэг томоохон асуудал бол энэ улс төрийн иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх асуудал бол их чухал байгаа. Тэгэхээр улс төрийн намуудад энэ хуулиар, тэгээд энэ намуудын гаргаж байгаа санхүүжилтийнх нь зориулалтыг энэ рүү нэлээн чиглүүлж байгаа. Тийм учраас одоо өмнө нь бол ийм улс төрийн намуудад ийм чиглэл, үүрэгт нь улс төрийн намын санхүүжилтийн зориулалтад нь ийм заалтууд бол байгаагүй. Энэ орж ирж байгаагаараа бол иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн энэ ардчилал үнэт зүйл энэ мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэл рүү иргэний боловсролыг дээшлүүлэх чиглэл рүү тодорхой заалтууд бас энэ удаагийн хуульд тусаж өгснөөрөө онцлог болов уу гэж бодож байгаа.

Бид бүхэн энэ иргэдээ боловсруулж, иргэдээ мэдээлэлжүүлж байж иргэдийн энэ мэдэх эрхийг, иргэдийн оролцоог хангаж байж энэ

ардчилал өөрөө зөв зүйтэй явах ийм боломжтой гэж үзэж байгаа. Энэ хууль гарснаар улс төрийн намууд олон улсад байдаг энэ манай судлаачид нэмж хэлэх байх. Олон улсад байдаг энэ жишиг рүү нь л бид нар явуулж байгаа юм. Нэг ёсны өнөөдөр бол улс төрийн намуудын илүү бодлогын институт болж төлөвшүүлэх чиглэл рүүгээ явж байна олон улсад.

Хоёрт бол улс төрийн намуудын санхүүжилт илүү нээлттэй, нэг эх үүсвэрээс биш олон эх үүсвэрээс санхүүждэг. Тэгэхдээ бага, бага. Ямар нэгэн улс төрд мөнгөний хамаарлыг багасгах 1 том хандивлагч ч гэдэг юм уу, 1 намын 1 компанийн нам ч байж болохгүй гэдгүүдийг хязгаарлаж өгөөд, харин олон эх үүсвэрээс тэр олон түмний дэмжлэгээр, олон түмэн дэмжиж байгаа бол олон эх үүсвэрээс санхүүжилтээ босгодог авдаг. Тэгээд тэр авсан санхүүжилт нь юунд зарцуулагдаж байгаа, хэнээс хэдэн төгрөг орж ирсэн, тэрийг юунд зарцуулж байгаа гэдэг нь ил тод нээлттэй байдаг тэр нь Шилэн дансны хууль намуудад үйлчилдэг болж байх жишээний ийм заалтуудыг бол нарийвчилж зааж өгч байгаа.

Гуравт бол намуудыг нөгөө төр барих институтийнх нь хувьд, төр барилцаж байгаа оролцож байгаа институтийнх нь хувьд ардчиллын эд эсийнх нь хувьд хариуцлагажуулах шаардлагатай юм байна. Тэгээд улс төрийн нам нэр барьсан, ард түмний нэр барьсан ийм асуудал их байгаа учраас энэ улс төрийн намуудыг хариуцлагажуулах чиглэл рүү бас их олон заалтууд орж өгч байгаа. Тийм учраас энэний дараа улс төрийн намууд бол энэ хуулийн хүрээнд бол нэлээн олон зүйлүүд нь ялангуяа дотоод ардчилалтай холбоотой, дотоод асуудлынх нь асуудал бол нэлээн цэгцрэх болов уу гэж ингэж харж байгаа.

Дөрөвд бол энэ улс төрд эмэгтэйчүүдээ бас эхлүүлээд төлөөлөл нь бага байгаа энэ нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах асуудал бол

манайд их чухлаар тавигддаг. Тийм учраас энэ энийг асуудлыг бол бас нэлээн тодорхой тусгаж өгсөн гэж ингэж хэлж болно. Бямбажаргал дарга.

Г.Занданшатар: *Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна. Товч тодорхой хариулъя. Бямбажаргал хариулах юм уу? Ганибал гишүүнийг болилоо. 82 Бямбажаргал Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх.*

А.Бямбажаргал: *Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Мэдээж хэрэг хууль тогтоомж бол хамгийн түрүүнд нийцэх ёстой зүйл өөрөө Үндсэн хууль. Та түрүүн хэллээ. 2019 онд оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 71 дэх заалт болж орж ирсэн зүйл бол өөрөө энэ 19¹ гэдэг ийм зүйл заалт байгаа. Энэ дотор бол 3 зүйл, 20 заалт бий. Мэдээж хэрэг хамгийн гол энэ хуулийг санаачилж Үндсэн хуульд магадгүй энэ хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд өөрөө хийгдэх ёстой хамгийн гол ажил бол Үндсэн хуулийн энэ суурь зарчим Үндсэн хуульд нэгэнт нэмэгдсэн байгаад байгаа энэ утга агуулгыг өөрөө энэ хуульчлах явдал юм байгаа юм.*

Энэний дагуу бол энэ хууль бол Үндсэн хуультай нэгдүгээрт зөрчилдсөн зүйл бол байхгүй. Та сая тодотгож хэллээ. 1 хувь гэдэг ийм тоо. Энэ бол 19^{1.2} гэдэг заалт байгаа. Намыг Монгол Улсын эрх бүхий иргэдийн 1 хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гэдэг ийм заалт. 2019 оны 11 сарын 14-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад 2 зүйлийг бас нэмж баталсан байдаг. Тэрний нэг нь бол өөрөө Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих тухай хууль гэдэг энэ хууль байгаа. Энэ хууль өөрөө хүчин төгөлдөр. Хуулийн маань 4 дүгээр зүйл бол өөрөө энэ нэмэлт, өөрчлөлттэй бол адил нэг хүчин чадалтай гэдэг ийм заалт байгаа.

Энэ дотор ямар зүйл оруулсан юм бэ гэхээр 19^{1.2} дахь хэсгийн, саяын миний таны бас дурдаад байгаа энэ заалт бол өөрөө 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заачихсан байгаа. Тэгэхээр энэ харилцаагаар өөрөө нэгэнт зохицуулагдаж байгаа учраас одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа буюу дагаж мөрдөж байгаа Үндсэн хуулийнхаа хүрээнд бол энэ ямар нэгэн зөрчил бас байхгүй.

Хоёрдугаарт мөн хууль тогтоомжийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх гэдэг агуулгаар 2020 оны 02 дугаар Улсын Их Хурлын тогтоол гарсан байдаг. Энэ тогтоолын маань бол 1.4-д Улс төрийн намын тухай хуультай холбогдох чиглэлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн ерөнхий концепц нь юу байх юм бэ гэдэг утга агуулгыг бол зохицуулсан. Хуулийн маань үзэл баримтлалын агуулгад эдгээрийг бол бас дурдсан байгааг та анзаарсан байх. Тэгээд энэнээс үүдээд би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр хууль тогтоомжийн хувьд бол харин ч асуудлыг бол өөрөө Үндсэн хуульд нийцүүлэх гэдэг утга агуулгаар. Өөрөөр хэлбэл 2005 оны хууль маань бол өнөөг хүртэл бол Үндсэн хуулийн энэ утга агуулгыг одоо хэр нь зохицуулж чадаагүй явж ирснийг энэ шинэчилсэн найруулгын төслөөр бол харин гүйцээж зохицуулж харилцааг нь хуульчилж байгаа юм гэж л хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: *Жаргалмаа гишүүн нэг минут.*

Б.Жаргалмаа: *Баярлалаа. Ерөнхийдөө бас хариултуудаа авчихлаа. Тэгээд түрүүн бас би хэлсэн, Намын харьяа байгууллагуудын асуудлаар бас тодруулга байсан. Тэгээд түрүүн хариулчихсан учраас. Тэгээд энэ хууль дээр бас төр намын санхүүжилтийн асуудлыг бас тодорхой заагаад өгчихсөн болохоор бас нэлээн бас нийтдээ нийтэд гэдэг юм уу, олон нийтэд бас ойлгомжтой гэдэг юм уу, хүртээмжтэй байх, хэрэгжих хууль байх гэж би харж*

байна. Санхүүжилтийн зориулалттай гэдгийг бас нарийн заагаад өгчихсөн. Бас нам намын гишүүдээрээ дамжуулаад сонгогчдоо боловсролыг нь нэмэгдүүлэх, сонгогчдод эрх, үүргийг нь танилцуулах тэр боломжийг нь бас нээж өгсөн гэж би харж байгаа.

Мөн жендерийн асуудлыг нарийн сайн тусгаж өгсөнд бас хуулийн ажлын хэсгийнхэн болон Ерөнхийлөгчдөө бас талархлаа илэрхийлье. Энэ мэтчилэн ер нь, тэгэхдээ бас энэ хуулийг яг бүхэлд нь ингээд уншихаар 1 хууль зүйн техник талаасаа ч гэдэг юм уу тийм ээ маш их алдаанууд гэдэг юм уу жижиж сажиг үг үсгийн алдаанууд маш их байна лээ шүү. Тэрийг бас харж ажиллах байх гэж бодож байна. Тэгээд ажлын хэсэгт орох саналтай байгаа шүү гэдгийг бас Их Хурлын даргадаа уламжилъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэлчихлээ. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Монгол Улсын Ерөнхийлөгч Улс төрийн намын тухай хуулийг өргөн барьж байгаад талархалтай байна. Ер нь бас аль нэгэн улс төрийн хүчнээс биш, эрх баригч талаас биш бас эв нэгдлийг барьж олон намуудын байр суурийг илэрхийлээд нэгдсэн энэ хуулийн төсөл оруулж ирж байгаад бол маш талархалтай байгаа. Гэхдээ бас хэд хэдэн асуудлууд байна. Намуудыг хариуцлагатай болгоно гэдэг асуудал чинь энэ парламентын гадна байгаа буюу цөөн гишүүдтэй намуудыг хариуцлагажуулах асуудал биш л дээ.

Энэ намуудыг хариуцлагажуулах асуудал бол мэдээж өнөөдөр эрх баригч МАН-ын төрийн бодлогод оролцож байгаа энэ асуудлууд мөн АН-ын хувьд ч гэсэн адилхан. Энэ 33 жилд энэ 2 нам бас тодорхой хэмжээнд төр барилцах үйлд оролцсоных нь хувьд бол энэ асуудлуудыг алдаа нь энэ том намуудад байгаа юм. Тэгэхээр эд нарыг засан залруулах л Улс төрийн намын тухай хууль байгаасай гэсэн ийм бодолтой байна. Энэ талаар

бас АН-ын зүгээс тодорхой саналуудыг оруулсан байгаа. Зарим нэг нь ороогүй.

Ер нь зүгээр намуудыг татан буулгах, өөрчлөх энэ асуудал бол жам ёсны жамаараа өнөөдөр байхгүй болж байгаа. Энэ дээр бол бид нарын анхаарал бол тийм юу гэдэг юм өндөр хэмжээнд тавигдахаасаа илүүтэй аль болох харин эд нарыг чөлөөтэй орж гардаг болгох нь л бидний үүрэг байх. Өнөөдөр Үндсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бол байгууллага болон эвлэлдэн нэгдэж болно гэж. Тэгэхээр тэр шинээр нам байгуулж байгаа тоо 801 гэдэг бол өндөр. Одоо ч гэсэн өндөр байдаг. Яагаад гэхээр шинээр нам байгуулагдаж байгаа, байгуулж байгаа нам болгон намаа бүртгүүлэх гээд улс төр хийдэг. Тэрийг бүгдээрээ мэддэг. 1 нам байгуулчихлаа, байгуулах гээд байна, тэгээд нэг юу бүртгүүлчихлээ ҮҮ, АА гээд. Ер нь бол МАН анхны 7 гээд 7 хүнтэй Ардын нам байгуулагдаж байсан байх. Эхлэл нь суурь нь тавигдаж байсан байх. АН бол Залуу зохиолчдын эвлэлийн хурал гээд тодорхой хэмжээнд бас 1 заал дүүрсэн хүмүүсээр намын үзэл санаа нэгдэл нь тэнд бий болж байсан.

Тэгээд энэ өөрөө ингээд цаашаа 7 байна уу, 20 байна уу тэр намыг бий болгоод өнөөдрийн түвшинд хүртэл үзэл санааны нэгдэл өрсөлдөөнийг бий болгож чадсанаараа энэ намууд өнөөдөр чадавхжиж байгаа юм. Тэгэхээр яг энэтэй адилхан үнэхээр нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөд нам цаашаа эрх баригч болох нь уу, сөрөг хүчин болох нь уу, парламентад суудалтай болох нь уу энэ асуудлуудаа өөрсдөө явж чадвал энэ жам ёсоороо цаашаа явж байгаа юм. Тэрийг ямар нэгэн байдлаар зохицуулалтаар төрийн нэн ялангуяа төрийн оролцоотойгоор зохицуулах нь өөрөө буруу болчихоод байгаа юм. Энэ дээр бол ер нь зүгээр төрийн оролцоог л энэ намын асуудлаас хөндий байлгаач гэдгийг бол өнгөрсөн АН-ын 3 жилийн түүх харуулсан.

Энэ дээр тамганы маргаан гарсан. Энэ тамганы маргаан дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг хүртэл байгуулагдаад, энэ асуудалд дүгнэлт өгсөн байгаа. Тэрэн дээр ямар дүгнэлт гарсан бэ гэхээрээ улс төрийн намд тамга гэж байх шаардлагагүй юм байна гэж. Хэрэв та Дээд шүүх дээр бүртгэлтэй нам төлөөлөх эрхтэй болсон бол гарын үсгээрээ баталгаажуулаад үйл ажиллагаандаа оролцож болно. Эргээд нэг төрийн байгууллага тэнд тамга гэдэг юмыг бас эрхийг нь авчихдаг. Тэгээд одоогийн энэ хуулийн төсөл дээр бол зүгээр оруулаад ирсэн нь арай л жоохон хүндэрчихсэн байна. Сонгуулийн төв байгууллага аваад, тэрийг Дээд шүүхэд өгөөд, Дээд шүүх тэрийг. Ямар нэгэн байгууллагаар дамжих болгонд тэнд ямар нэгэн хүлээлт, тэрний гацаа үүсдэг. Тэгээд энийг яаж өөрчлөх боломжтой вэ?

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Содбаатар дарга хариулна. 80.

Я.Содбаатар: Тийм. Энэ Улс төрийн намын хууль бол өнөөдрийн энэ парламент дээр хэлэлцэж байгааг нь харахад ч гэсэн иргэд харж байгаа байх. Ер нь бол энэ бол улс төрийн л бүх улс төрд улс төрийн үйл ажиллагаанд оролцож байгаа парламент өөрөө улс төрийн төв хамгийн том байгууллага учраас бүгдээрээ л байр сууриа илэрхийлсэн. Олон гишүүд ч гэсэн санал асууж байх шиг байна. Энэ 30 жилийн хугацаанд Ардын намаас эхлүүлээд АН гээд энэ парламентад суудалтай суудалгүй бүгд л намууд энэ бас эрх зүйн орчны жаргал зовлон дундуур явсан. Тийм учраас энэ хуулийг гаргахад манай намууд улс төрийн намууд, улс төр судлаачид нэлээн олон саналууд өгч, ер нь энийг чамбайруулах талд бол нэлээн чамбай зүйлүүд орсон.

Гэхдээ 1 зүйл бол бүгд ер нь бол хэлэлцүүлгийн явцад хамгийн их санал нэгдэж байсан зүйл бол улс төрийн намуудыг энэ хариуцлагажуулах асуудал

бол нэн чухал юм гэдэг дээр бол санал нэгдэж байсан. Тэгэхгүй бол ингээд 30 жил болчихсон 1 ч хурлаа хийгээгүй, 30 жил болох хугацаанд төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллагууд гэж байхгүй. Тэгээд маш олон зүйлүүд байна. Тэгээд бид нар ер нь концепцын хувьд бол ер нь яах вэ нам байгуулах тэр процессыг нь бол аль болох хялбаршуулъя. Мэдээж яах вэ хүмүүс бол нөгөө 1 техникийн талаасаа сонгуулийн төв байгууллага бүрдлийг нь хангаад хариуцаж байгаа байгууллагын хувьд сонгуулийн Дээд шүүх рүү хандаж байгаа нь нэмчихсэн юм шиг харагдаад байж магадгүй. Гэхдээ хугацаануудыг нь маш тодорхой, хариу өгөх хугацаанууд, эргээд намыг татан буулгах, намтай харьцах нам дээр тавих шаардлагуудыг нь бол бид нар бас нэлээн сулруулж ингээд тавиад өгчихсөн байж байгаа.

Гэхдээ байгуулагдаа гарсных нь дараа байгуулагдсаных нь дараа бол улс төрийн намыг тодорхой хэмжээгээр хариуцлагатай болгож, шаардлага тавьдаг, хянадаг ийм зохицуулалтуудыг хийж өгөхгүй бол болохгүй байгаа. Гэхдээ 1 зүйлийг бол яг Ганибал гишүүнтэй санал 1 байгаа. Ер нь бол зүгээр энэ хууль хэрэгжээд явах хугацаанд эрх баригч улс төрийн хүчнүүдээс гэдэг юм уу эсвэл төрийн байгууллагаас шалтгаалж улс төрийн намуудын үйл ажиллагаа доголдох, субъектив янз бүрийн хүчин зүйл орж ирэхийг бид нар хязгаарлах ёстой. Улс төрийн зорилготой хүчин зүйлүүд орж ирэхийг хязгаарлах ёстой. Тийм заалтууд ч гэсэн бас нэлээн энд тэнд нь хийж өгсөн. Зүгээр нөгөө зовлон үзсэн гэгчээр энэ яг бүртгэлтэй холбоотой асуудлууд дээр би бол жишээ нь АН-аас энийг саналуудыг нэлээн тусгаж авъя. Та нар энийг дахиж нарийвчилж үзээч. Яг процессын амьдрал дээр хэрэгжих процессын хууль хэрэгжих процессын явцад алдаа оноо байна уу гэдэг дээр нэлээн саналыг нь авч тусгасан гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Ер нь бол бид бүхэн энэ улс төрийн намууд бол өөрсдөө I талаасаа иргэдийн эвлэлдэн нэгдэж байгаа үзэл бодлоо илэрхийлж байгаа индэр боловч нөгөө талдаа бол бас төрийг байгуулахад оролцож байгаа субъектийн хувьд ардчиллын эд эсийн хувьд энэ иргэдийн төлөөллийн байгууллага болж байгаагийн хувьд иргэдийн I том үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх субъект болж байгаагийн хувьд бол бид нар нэлээн хариуцлагатай байх ёстой л гэсэн байр суурин дээр энэ намуудад тавьж байгаа шаардлага, босго эд нарыг нь нэлээн тавьсан юм гэж ингэж хэлж болно.

Г.Занданшатар: Ганибал гишүүн I минут.

Н.Ганибал: Тийм ер нь тэгэхээр улс төрийн намын хариуцлагын асуудал гэдэг бол мэдээж түрүүний яриад байгаа 2 талтай л даа. Жижиг намууд дээрээс нь өнөөдрийн эрх баригч нар, улс төрд парламентад суудалтай намууд гээд. Тэгэхээр энэ намуудын бас хариуцлагын асуудал бол зайлигүй шаардлагатай байгаа юм. Ер нь зүгээр энэ хууль дээр байгаа тэр санхүүжилтийн асуудал дээр бол мэдээж санхүүжилт авах нь хэдхэн нам байхгүй юу. Тийм тодорхой та бүхэн бас хэлээд байна лээ тийм ээ. Тэгэхээр өнөөдөр эрх баригч нарт бол мэдээж намын тэр том байшингаа халаагаад, үйл ажиллагаа явуулахад бол их мөнгө хэрэгтэй. Тэгээд түүнийхээ дагуу л их мөнгө авах ийм томъёо ороод ирчихсэн байна.

Магадгүй бусад намуудад тэр боломж нь хаалттай ийм томъёо орж ирчхээд байгаа юм. Тэгэхээр нөгөө I тоогоор санал авсан тоогоор үржүүлэх гээд ингээд томъёонуудын мөн зорилго нь цаад талдаа өнөөдрийн бас МАН-ын санхүүжилтийн бодлогыг дэмжчихсэн ийм асуудал харагдаад байна гэдгийг бас анхааралдаа аваарай.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулъя 80.

Я.Содбаатар: Ганибал гишүүн ингэж гуйвуулж болохгүй. Яагаад гэхээр энэ бол Ерөнхийлөгчийн институтээс оруулж ирж байна. Энд Ардын намын, АН-ын саналууд харин ч АН-ыг бүр хагарчихсан байхад нь 2 талд нь очиж хүртэл санал авсан. Яагаад гэхээр энэ том намын хууль хэлэлцэж байхад АН-ын санал хэрэгтэй гэж ингэж бодоод авсан. Саналууд нэлээн өгөгдсөн. Энд ямар нэгэн ялангуяа эрх баригч намын ямар нэгэн сонирхол юмнууд бол тэднийхээс санал ирсэн. Гэхдээ тэндээс авсан зүйлүүд бий. Маш олон зүйлүүд нь бол бас аваагүй.

Ялангуяа энэ санхүүжилттэй холбоотой асуудлаар бол улс төрийн намуудыг сонгогчдоос саналаа авдаг бай гэж байгаа юм. Та хэрэв сонгогчдод таалагдаад, сонгогчид таныг дэмжээд саналаа л өгч байгаа бол танд санхүүжилт өгье. Тийм учраас энд бол аль нэгэн нам сонгогчдын санал авчихсан байна уу, тэр нь Ардын нам байна уу, АН байна уу, парламент суудал бусад улс төрийн хүчин байна уу, та сонгогчдын л саналыг л авч чадаж байвал санхүүжилт авдаг хэлбэр рүү оръё гэдэг энэ концепцын өөрчлөлт хийгдээд ингээд явсан. Улс төрийн намуудын хувьд бол ялангуяа 2 нам бол нэг.../минут дуусав/

Г.Занданшатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн алга байна. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн, Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн энэ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь бол бас энэ улс төрийн намтай холбоотой зохицуулалтыг илүү өргөн хүрээнд харж, зарчмын шинжтэй шинэчлэлийг оруулж ирснийг бол дэмжиж байгаа юм. Ер нь бол энэ өргөн мэдүүлсэн байгаа Сонгуулийн тухай хуулийн төсөл мөн орж ирж байгаа энэ хуулийн төсөлд жсендерийн тэгш байдлыг хангах зорилгоор энэ намын

дотоод бүтцийн байгууллагад хийсэн хүйсийн төлөөллийг зааж өгсөн, нэр дэвших энэ квотыг бас нэмсэн зэрэг нь бол эмэгтэйчүүдийг урьд өмнө нь бас дэмжиж байгаагүй шинэ дэвшилтэт заалтууд орсон гэж бас сайшаан дэмжиж байна.

Ялангуяа энэ хуулийн төсөлд намд хориглох үйл ажиллагааны 10.1.6-д сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн дэмжигчээсээ барьцаа дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө үйлчилгээ өгөхийг шаардах авах заалт оруулснаар бас эмэгтэйчүүдийн энэ нэр дэвших эрхийг илүү нээлттэй бодитой заалт болгож байна гэж би харж байна. Тэгэхээр миний асуух асуулт бол энэ намд хориглох үйл ажиллагааны энэ 10 дугаар зүйлийн хяналтыг ямар байгууллага хэрэгжүүлэх вэ? Төслийн 10.1.6-г зөрчвөл ноогдуулах торгуулийн хэмжээг хамт өргөн мэдүүлсэн энэ Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах төсөлд бол тусгасан байгаа. Тэгэхээр энэ харин энэ 10 дугаар зүйлийн заалтыг хэн хянах вэ? Энэ дээр 1 хариулт авах гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Тийм. Энэ намын үйл ажиллагаанд хориглох зүйлүүд гээд бид нар нэлээд тодорхой зааж өгсөн. Яах вэ энэ бас л энэ 30 жилд гарч ирж байгаа ялангуяа сүүлийн 10 хэдэн жилд гарч ирж байгаа л зүйлүүд. Энэ Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах гэж оролддог, зэвсэглэх, цэрэгжих, цэрэгжсэн бүтэцтэй болох, хүчирхийллийн зорилгоо хүчирхийллийн замаар гүйцэтгүүлэх, үндэс угсаа, яс үндэс, нас хүйс, арьсны өнгө, нийгмийн гарлаар ялгаварлах гээд. Тэгээд энэ дотор бид нар 1 том оруулж байгаа зүйл бол тодорхой хуулийн этгээдүүдээс, тодорхой иргэнээс этгээдүүдээс энэ хандив тусламж санхүүжилт шууд болон шууд бусаар авахыг шууд хориглож байгаа. Жишээ нь, гадаадын

иргэн, олон улсын байгууллагууд, гаднын хөрөнгө оруулалттай компани, төрийн болон ТӨК-уд гээд маш олон заалтуудаар хандив авахыг хязгаарлачхаж байгаа 34.6-гаар.

10.1.6 дээр сонгуульд нэр дэвшигч эрх олгохдоо намын гишүүн дэмжигчээсээ барьцаа дэнчин бусад аливаа хэлбэрээр мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө үйлчилгээ өгөхийг шаардах, авахыг намуудад хориглож байгаа. Энэ бол бас сүүлдээ цадигаа алдсан шүү дээ. Зарим намууд бол сонгуульд нэр дэвшихийн тулд 100 сая төгрөг өг, тэгээд маш олон хүмүүсээс авчихдаг. Дараа нь нэр дэвшихээ чадахгүй мөртөө тэр нөгөө мөнгөө олж авч чаддаггүй, хувь хүний данс руу орчихдог. Үгүй ээ энийг дагасан маш олон юмнууд болж байсан. Тийм учраас энэ бас л манай парламентад суудалтай 1 намаас л ирсэн санал шүү дээ. Тэгээд энийг бид нар бол ингээд тусгаад ингээд яваад яасан.

Ер нь бол бид нар энэ намуудын тавьдаг энэ иргэдийн оролцоог хязгаарласан зүйлүүдийг бол аль болох л намуудад нээлттэй чөлөөтэй болж байгаа юм. Намд ороод өөрөө үзэл бодлоо илэрхийлдэг, сонгох сонгогдох юманд нь оролцдог, намын нэрээр намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, намын бүх шатны байгууллагуудад сонгогдох энэ л боломжуудыг нь нээж өгөх ийм заалтуудыг нэлээн хийж нарийвчилж өгсөн.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна, асууцхсан. Аубакир гишүүн сая энд явж байсан яачихсан юм бэ? Цагаанхүүгийн Идэрбат гишүүн сая энд сууж байсан. Анужин гишүүн Пүрэв-Очирын Анужин гишүүн сая байгаад гарч орж гүйгээд байсан. Хүн сууж байгаа юм биш үү? Адьшаа гишүүнд цалингийн 20 хувиар хасах сануулга өглөө. Хурал, хурал үймүүлэхгүй шүү.

П.Анужин: Уучлаарай. Намын санхүүжилттэй холбоотой 1 тодруулах зүйл байна. Энэ Улс төрийн намын тухай хуулиа Сонгуулийн тухай хуультайгаа хэр уялдаатай боловсруулсан бэ? Намын санхүүжүүлэлт дээр энэ төрийн санхүүжилтийг 0.5 хувиар үржүүлж гаргана гэсэн 1 ийм тооцоолол бичсэн байна л даа. Тэгээд энэ нь өөрөө хэр нийт хэдэн төгрөг гэж харагдаж байгаа юм, төсөв нь хэд гэж та нар ийм тооцоолол хийсэн юм, энэ нь тэгээд хангалттай юм уу? Нөгөө л нэг нэр дэвшигчид нь сонгуулийн үе болохоор нөгөө мөнгөний сонгууль хийдэг энэ зүйлээсээ гарч чадах юм уу?

Сонгуулийн хуультайгаа уялдах шаардлагатай гэж ингэж харж байна. Энэ дээрээ бол яах вэ бид нар тодорхой санхүүжилтүүдийг бол их тодорхой болгож, энэ хууль дээрээ оруулж ирсэн байгаа хэдий ч Сонгуулийн хууль дээр бол ерөөсөө энэ санхүүгийн зохицуулалтууд чинь хангалттай орж ирээгүй харагдсан л даа. Тэгэхээр энэ чинь 1 юмны 2 тал өөрөө. Тэгэхээр энэний уялдааг хэрхэн хангасан бэ гэдэг ийм асуулт байна. Тэгээд тэр 0.5 хувь гэдэг дээр ямар тооцоолол хийсэн юм бэ энэ тооцооллыг бас тодорхой хэлж өгнө үү гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна 80. Содбаатар дарга хариулахын өмнө энэ асуулт хариултын дараа санал хураалттай учраас гишүүд чуулганы танхимд цуглана уу. Асуулт хариултын цаг удахгүй дуусна.

Я.Содбаатар: Энэ хуулиар бид нар энэ намуудын санхүүжилтийг ил тод нээлттэй болгох, шилэн болгох намуудын санхүүгийн тайлан тооцоо гаргадаг байх, намын жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийдэг байх, тэрнийгээ жилийн 1 дүгээр улиралдаа багтааж цахим хуудсандаа байршуулдаг байх, намууд энэ санхүүжилтийнхээ тайланг олон нийт, гишүүд дэмжигчдэдээ нээлттэй танилцуулдаг байх, улсын хэмжээнд улс төрийн намуудын

санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайланг СЕХ жилд нэгтгэж, Улсын Их Хурлын парламентад танилцуулдаг байх ийм зохицуулалтуудыг нэлээн оруулсан.

Намууд энэ санхүүтэй холбоотой асуудлуудыг нээлттэй, ил тод болгох санхүүгийн тайлан энэ юмнуудыг ил тод болгох заалтуудыг тэрэндээ хэрэв тэгэхгүй бол Зөрчлийн болон бусад хуулиудаар хариуцлага тооцох асуудлуудыг ч нэлээн нарийвчилж зааж өгсөн. Ингээд санхүүжилтийн хэлбэр гэхээр 2 хэлбэрээр л санхүүжилт намуудад ирж байгаа. Нэг нь бол төрийн санхүүжилтийн хэлбэр. Тэгээд төрийн санхүүжилтийн хэлбэр бол өмнө нь бас нэлээн тодорхойгүй явж ирсэн юм. Суудлын мөнгөөр өгдөг. Тэгээд энэ хэрэв парламент суудал авбал суудлын мөнгө өгдөг. Дараа сонгуулийн санал өгсний дараа жилийн дээр нь авсан саналынх нь тоогоор 1 удаагийн мөнгөн тэтгэлэг өгдөг. Тэгээд намуудын аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд авсан юунууд дээр нь бас янз бүрийн хэмжээтэйгээр суудлын мөнгө гэж өгнө. Төлөөлөгчдийн мөнгө гэж өгнө. Тэгээд энэ нь дүнгээр аваад үзэх юм бол улсын төсвөөс 4 жилийн хугацаагаар нь аваад үзэх юм бол 20 гаруй тэрбум төгрөг гараад явчхаж байгаа байхгүй юу.

Гэхдээ энэ нөгөө нарийвчилсан хуулийн заалтгүй тодорхойгүй явж ирсэн учраас энэ нь алдаг оног. Эргээд энэ төсвөөс орж ирж байгаа мөнгөний зарцуулалт юунд байсан юм бэ, зориулалт нь ямар байсан юм бэ, хэрхэн тайлагнах юм бэ гэдэг асуудал нь бас тодорхойгүй явж ирсэн. Тийм учраас шинэ хуульд энэ төсвөөс хэрэв санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа бол тэр нь тун ойлгомжтой, зөвхөн парламентад авсан суудлынх нь тоо, парламент авсан сонгогчдынх нь тоотой уялдуулаад өгч байгаа. Дээрээс нь нэмээд энэ авсан мөнгөө төсвөөс авч байгаа татвар төлөгчдийн мөнгийг авч байгаад зарцуулж байгаа бол түүнийгээ тайлагнадаг. Зориулалт нь тодорхой

ийм заалтуудыг бол шинэ хуулийн төсөлд тусгаж өгсөн.

Жилдээ яг энүүгээр таны түрүүний хэлсэн томъёо буюу сонгогчдын авсан саналыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 05 хувиар үржүүлж өгч байгаа юм. Энэ нь өнөөдрийн ханшаар бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 550000 гээд үзэх юм бол тэрний 05 хувиар гэдэг бол 2750 төгрөг гэсэн үг. Тэгээд 2750 төгрөгөөр сонгогчийн 1 өгсөн санал сонгогчийн санал болгоныг үржүүлнэ гэсэн үг. Ингээд нийтдээ бол энэ чинь өнөөдөр 1 сая 700 зуугаад мянган сонгогч ингээд үзэх юм бол 5.9 тэрбум шахам төгрөгийг энэ саяын томъёоллоор бол гарч ирж байгаа юм. Энийг парламентад суудал 2 хувийн босго авсан сонгогчдын 2 хувийг авсан дээш санал авсан улс төрийн намууд энэ хэмжээний санхүүжилтийг хувааж авна л гэсэн үг. Нийт дүнгээрээ.

Тэгэхээр ийм хэмжээ. Нэг ёсны бид нар улсын төсөв дээр ирэх 4 жилээр нь аваад үзэх юм бол ирэх 4 жилээр энэ хууль гарснаар бол одоогийн гаргаж байгаа мөнгөнөөс их хэмжээний мөнгө гарахааргүй зохицуулагдаж харагдаж байгаа. Нөгөө талдаа өмнө нь бол зүгээр суудлын мөнгөө өгчихдөг байсан бол одоо зориулалтыг нь зааж өгөөд, хувийг нь зааж өгөөд, тайланг нь зааж өгөөд ил тод байх, нээлттэй байх. Тэгээд бүх намууд 1 дансаар, бүх намууд биш шүү нам болгон 1 данстай байхаар. Тэгээд нам авсан тэр хөрөнгө мөнгөнийхөө тайланг цахимаар Шилэн дансны хуулиар тайлагнаж байх энэ нарийвчилсан.../минут дуусав/

Г.Занданшатар: Болсон уу? Анужин гишүүн тодруулъя 1 минут.

П.Анужин: Миний асуугаад байгаа нь би бас түрүүн ойлгуулж чадаагүй байж магадгүй. Энэ 5.9 тэрбум төгрөг гэж байгаа чинь тэгээд энэ шинэ хуульдаа зааж байгаа нөгөө сонгуульд оролцох эрх бүхий этгээд, нэр дэвшигчдэдээ ингээд дэмжлэг туслалцаа

үзүүлэх гэсэн гол концепт нь бол ийм зүйл яваад байгаа шүү дээ. Тэгээд энэ энэндээ хүрэлцээтэй гэх нь юу юм. Энийгээ бид нар үндсээр нь өөрчилж чадаж байгаа юм уу? Яах вэ 0.5 хувь гэдэг тоог тавьж байгаа нь дэвшилттэй хэдий ч бид нар тэр цаанаа нөгөө нэр дэвшиж байгаа хүмүүс чинь мөнгөний сонгуулиас ангид байна энэ тэрээ гээд байгаа, тэр нь тэрэнд нь үнэхээр ийм бодит дэмжлэг үзүүлэхүйц ийм өөрчлөлт болж чадаж байгаа юм уу л гэж байгаа байхгүй юу. Харахад бол энэ чинь 5.9 тэрбум гээд том дүн сонсогдоод байдаг. Гэтэл бид нарын нөгөө хүсээд байгаа өөрчлөлтөд чинь нөлөөлөхүйц ийм алхам болж чадаж байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг л асуугаад байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна.

Я.Содбаатар: Монголд энэ улс төрийн юунд явж байгаа шинэтгэлийн юманд бол энэ улс төрийг мөнгөний оролцоог нь багасгах, мөнгөний факторыг багасгах, улс төрийн зардлыг бууруулах ийм зарчмуудыг барих ёстой. Манай сонгууль, манай улс төрийн намууд, улс төрийн үйл ажиллагаа бол асар өндөр зардалтай явж байгаа. Тэгээд энэ нь өөрөө эргээд улс төрд мэдлэг боловсролтой залуу хүмүүс эсвэл улс төрд ёс зүйтэй ийм хүмүүс орж ирэхэд бас тодорхой хаалт болчихоод байгаа. Зөвхөн л мөнгөтэй хүн ордог ийм орчин болчих гээд байгаа юм. Тийм учраас бид нар энэ улс төрийн намууд энэ хууль гарсны дараа бол энүүгээр бол улс төрийн намууддаа энэ зарцуулж байгаа хөрөнгө мөнгө бол нээлттэй, ил тод болохын зэрэгцээ багасна.

Нөгөө талдаа таны түрүүний хэлдгээр бол сонгуулийн үеийн зардал, сонгуулийн бус үеийн зардал гэж 2 байгаа. Сонгуулийн үеийн зардал бол Сонгуулийн хуулиар зохицуулагдана. Сонгуулийн бус үеийн зардал буюу түрүүн миний хэлээд байгаа хандивыг хязгаарлалчихсан. Жилд эцсийн өмчлөгчөөрөө 1 хуулийн этгээд 1 намд 27

сая төгрөг хавьцааны л төгрөг хандив өгч байгаа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Үндсэн хуулийн 30.1-д бол Монгол Улсын төрийн тэргүүн Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гээд ингээд тусгачихсан байдаг. Үнэхээр өнөөдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ өнгөрсөн хугацаанд хагарсан салсан, нийгэмд баахан талцал үүсгэсэн, хэрүүл үүсгэсэн энэ олон холбоо ТББ энэ болгоныг бас нэлээн сайн цэгцэлж байх шиг байна. Энэ Сагсан бөмбөгийн холбоо гэж юу байлаа. Тоглох заалаа олохгүй болтлоо хэрэлдчихсэн, талцчихсан. Үндэсний бөхийн холбоо гэж юу байлаа. Үндэсний бөхийнхөө өргөөг буулгах шахсан л. Ахмадын холбоо гэж бас 2, 3 хуваагдсан. Ингээд Монголд ер нь хуваагдаагүй юм байхгүй байжээ. 1 холбоо дандаа хажуудаа 1 дагуултай, бөөн хэрүүлтэй. Эхнээсээ ингээд цэгцэрч байна л даа.

Тэгээд хамгийн сүүлийн жишээ бол энэ Сагсан бөмбөгийн үндэсний лигийн энэ тэмцээн уралдаан ямар сайхан болов, сагсан бөмбөгчид нэгдэв. Хагарах тусмаа л бас нийгэмд асар их хор хохирол учруулдаг юм байна л даа. Сагсан бөмбөгийн холбоо хагарснаараа залуучууд хагараад л явчхаж байгаа. Ахмадын холбоо 2 болсноороо ахмадууд 2 хэсэг болоод л. Бөхчүүд, уяачид бас ингээд л нэгдэж нийлэх юм яригдаад. Энэ цаг үед харин энэ Монголчуудын бас дотроо 3300000-уулаа байж бас хагардаг, нэг нэгнийгээ хүлээн зөвшөөрдөггүй энэ зүйл бол энэ улс төрийн намтай бас нэлээн холбоотой байдаг.

Ялангуяа анхан шатад ажиллаж байх үед ч тэр. Энэ олон улс төрийн сонгуулиуд болох үед, тэр битгий хэл багийн даргаа сонгох хүртэл гээд л энэ болгон бол нэлээн тийм улс төрийн их

тэмцэл дундуур явж байдаг. Энэ тэмцэл нь өөрөө их хагарал бутралыг дагуулж байдаг их зовлонтой юм байдаг л даа. Тэгээд энэ бараг хориод жил яригдсан энэ улс төрийн нам ингээд шинэчилж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ингэж дэвшүүлж орж ирж байгаад бол зарчмын хувьд дэмжиж байгаа.

Энэ дээр харин 2 асуулт байгаад байгаа юм. Нэгдүгээрт энэ олон гишүүд бас үдээс өмнө ч гэсэн хэлж байна. Энэ намын гишүүнчлэлийн асуудлыг ер нь яаж шийдэж байгаа юм бэ? Хариулт дээр бол 3 хувааж байгаа. Эндээс энэ Улс төрийн намыг хуулийг боловсруулахдаа 3 хувааснаараа ямархуу үр дүн гарна гэж бодож байгаа юм, өнөөдрийн энэ орон нутагт байгаа энэ улс төржилт, талцал маргаан бас яаж бас нэг жоохон илаарьшина гэж ингэж харж байгаа вэ, ямар үр дүн хүлээж байгаа вэ гэж нэгдүгээрт асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт энэ тэгээд дэлхий дээр байгаа ер нь төрийн эрх барих оролцох үйл ажиллагаа бол улс төрийн намаар л дамжина. Улс төрийн намыг тунгалаг цэвэр болгох гэдэг нь бол туйлын зөв. Энэ дотор бас орон нутагт ялангуяа улс төрийн намын дамжиж гүйцэтгэх засаглал нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дарга нар ч сонгогдоод л ингээд л үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ дээр нэг хуулийн 8.2 дээр энэ улс төрийн намын төв байгууллагыг сонгох, улс төрийн албан тушаалд тавих 2 дээр нэг тодруулах 2 дээр гуравхан зүйл тавьчихсан байгаа нь миний хувьд бол ойлгохдоо энэ улс төрийн нам өөрөө 4 жилдээ хуралддаг, бүтцийн байгууллагаа бүрдүүлэх нь нэг өөр хэрэг. Тухайн шатын сонгуульд ялсны ар дээр тэр намаас улс төрийн албан тушаалтнуудыг сонгоход бас нэг өөр процесс явах байхгүй юу. Тэгэхээр энэ хоёрыг ингээд нийлүүлээд гуравхан зүйл заалтаар зохицуулна гээд ингээд тусгаад өгч байгаа нь нөгөө намын дотоод ардчилал ил тод байх энэ зарчимтайгаа хэр нийлж байгаа вэ?

Миний ойлгож байгаагаар бол энэ Улс төрийн намын хууль гарснаараа тухайн улс төрийн нам, тэр дотоод ардчилал, тэр төлөөний байгууллагаасаа улс төрийн албан тушаалтнуудыг сонгох процессыг хүртэл маш нарийн зааж өгөх ийм оролдлого байна гэж ингэж харж байгаа байхгүй юу. Гэтэл тэрийг гуравхан заалтаар зохицуулаад зохицуулахдаа дээр 8.2 дээрээ болохоор төлөөний байгууллагаа сонгох, улс төрийн албан тушаалтан 2-ыг нэр дэвшүүлэх 2-ыг ингээд хооронд нь холбоод оруулаад ирчихсэн байгаа нь хууль зүйн хувьд маргаан үүсэхгүй юу? Ойлгомжгүй байдал үүсэхгүй юу гэж би ийм 2 асуулт асууя.

Г.Занданшатар: Содбаатар дарга хариулна 80.

Я.Содбаатар: Гишүүнтэй санал нэг байгаа. Ер нь бол Монголын нийгэмд энэ нэгдэл рүүгээ явах цаг болсон. Монголчууд бид нар 3.5 сая цөөхүүлээ ард түмэн. Энэ олон улсын нөхцөл байдал, энэ бүс нутгийн нөхцөл байдал энэ геостратегийн энэ үед бол Монголчууд бид нар эвтэй найртай, эв нэгдэлтэй байж, Монголчууд бид нар нэг цонхоор асуудалд хандаж байж, Монголчууд бид нар хамтдаа байж энэ хүнд цаг үеүдийг даван туулна. Тийм учраас Монголчууд бид нар нэгдэл рүүгээ явах энэ зүйл бол энэ хуулийн бас нэг барьж байгаа зарчим.

Монгол Улсын Ерөнхийлөгч ч гэсэн Монголд энэ төрийн бус байгууллагуудаас эхлүүлээд, мэргэжлийн холбоодоос эхлүүлээд энэ иргэдийн эвлэлдэн нэгдэх нэгдэл рүүгээ явах нягтрах энэ чиглэл рүү хамтарч ажиллах энэ зүйлүүдийг аль болох дэмжиж, энэ чиглэлийн зүйлүүдийг ивээл доороо авч эсвэл нэгдэж нийлэхэд нь санал санаачилга гаргаж ингэж явж байгаа. Манай спортын холбоод маш одоо Ерөнхийлөгчийн чиглэл юуны дагуу нэгдээд нийлээд, олон улсад сайхан нэр хүндтэй улс орныхоо нэр хүндийг гаргаж байна. Манай мэргэжлийн байгууллагууд Зохиолчдын холбоо хүртэл нэгдсэн хороо

хүртэл нэгдсэн шүү дээ. 90 оноос хойш 2 хуваагдчихсан байсан. Тэгэхээр ингээд нэгдэл нийлбэр рүүгээ явж байгаа.

Тэрүүн шиг энэ өнөөдөр улс төрийн нам гээд 30 хэд хуваагдчихсан байгаа энэ улс төрийн намууд ч гэсэн нэгдэж нийлээд яваасай гэж бодож байгаа юм. Энэ агуулгаараа тэр санхүү, төрийн олгож байгаа санхүүжилтийн хэлбэр дээр ч, энэ хуулийн олон зүйлээр юу гэдэг юм бол нэгдэл рүү явахад нь нэлээн шахаж байгаа ийм заалтууд ийм зүйлүүд нэлээн орж ирж байгаа. Нөгөө талаасаа иргэдийн оролцоог хангах асуудал бол их чухал байгаа юм. Тийм учраас энэ иргэдийн оролцоог хангах, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх зүйлүүд. Тэгэхгүй нэг нам байгуулдаг, нэг хэдэн дарга дээр нь суучихдаг. Тэгээд нам нэрээр яваад байдаг. Тэр намын нэрийг бариад, ард түмний нэр бариад, гишүүдийнхээ нэрийг бариад давхиад байдаг, хурлаа хийдэггүй, өөрчлөгддөггүй, тэр хүмүүсийгээ юманд оролцуулдаггүй. Энэ зүйлүүдийг бол хуулиар нэлээн хязгаарлаж ингэж өгсөн.

Таны түрүүний хэлдэг ер нь бол дэлхийн бүх л орнууд улс төрийн намаараа дамжиж төр барих юунд оролцож байгаагийн хувьд бид нар ч гэсэн энэ төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгож, томилогдох албан тушаалуудад тавьдаг criteria шаардлага энэ юмнуудыг нэлээд. Зүгээр яах вэ ерөнхий тунхаглалын чанартай бол 2, 3 заалт бид оруулсан юм. Зүгээр одоо ингээд хэлэлцүүлгийн явцад бас манай гишүүд Байнгын хороон дээр, чуулган дээр ингээд 2 бүлэг дээр орж би танилцуулсан. Тэгэхэд бол олон саналууд гарч байна лээ сайн. Эд нарыг хэлэлцүүлгийн явцад бас заримыг нь авах нь зүйтэй гэж бодож байгаа юм.

Бид нар улс төрийн намын үүрэг дотор бол тухайлбал төр улс төрийн улс төрийн алба хаах хариуцлагатай иргэнийг бэлтгэх үүрэг гэж намын үүрэг болгож өгсөн байж байгаа. Ёс зүйтэй иргэдийг дэвшүүлэх энэ юунуудыг нарийн

заалтуудыг оруулж өгсөн байж байгаа. Гэхдээ дахиж сая Идэрбат гишүүний хэлдэг шиг нарийвчилж зарим зүйлүүдийг оруулж өгөх шаардлагатай юм байна гэж ингэж харж байгаа. Хэлэлцүүлгийн явцад нэмж оруулах зүйлүүд байгаа.

Нөгөө талдаа яах вэ бид нарын эвлэлдэн нэгдсэн иргэний эрхийн факт, улс төрийн эрхийн факт гээд олон конвенц актуудаар бол бид нар бас зарим зүйлүүдийг хатуу зааж өгөхөөр бас жоохон явдалтай зүйлүүд байсан учраас төслийн хүрээнд бол хязгаарласан зүйлүүд бас байгаа гэдгийг тодотгоё.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүд байна уу? Доржханд гишүүнээр тасаллаа. Би нэг үг хэлье. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Их чухал хууль орж ирж байгаа. Хэлэлцэх ёстой. Тэгээд Ерөнхийлөгчийн зүгээс оруулж ирж байгаа зүйл дээр Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурлын шийдвэрүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой. Энэ дээр би нэг 3 зүйл хэлмээр байна.

Нэгдүгээрт, Цэц дүгнэлтээ шийдвэрээ гаргачихсан байгаа шүү дээ. Төслийн 6.6-д заасан нам татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол товчилсон нэр бэлгэ тэмдгийг 24 жил дахин хэрэглэхгүй байхаар төсөлд тусгасан. Энэ бол ҮХЦ-ээр шийдвэр гарчихсан. Энэ дээр би хариулт аваагүй. Энийгээ ажилдаа тусгаж ажиллана биз. Ажлын хэсэг дээрээ ярих байх.

2 дугаар зүйл Улсын Их Хурлын ТББХ-ны 2023 оны 3 сарын 15-ны 2 дугаар тогтоолоор Зөвлөлдөж шийдье, зөвлөлдье гэсэн нэг зөвлөмжийн 2.6-д улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзаж, бодлогын нам болох эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж заасан байна. Энэ бол нөгөө төслийн 3.1.1, 3.1.2, 12.3.6-д заасан нөгөө 801 гишүүний бүртгэл, 20 дугаар зүйлд заасан намын гишүүнчлэлийн тухайд энэнээс зөрчсөн

байна гэж би ойлгож байна. Энийгээ ажлын хэсгийнхэн анхаарч ажилдаа тусгана гэж би бодож байна.

3 дугаар зүйл 2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх тухай Улсын Их Хурлын 20 оны 2 дугаар тогтоолын 1.4-д Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн 1 хувиас доошгүй тооны дэмжлэг авсан үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн нэг ийм шийдвэр байгаа шүү дээ энэ чинь Улсын Их Хурлын шийдвэрүүд ярьж байгаа байхгүй юу. Цэцийн шийдвэр ярьж байгаа. Энийг хуульд оруулж ирэхдээ хүндэтгэлтэй хандаж, энэ бол төслийн 12.3.6 та нар хар даа. Нам бүртгүүлэхэд намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл байна гээд энийг зөрчиж байна гэж би ойлгож байна.

Эцэст нь хэлэхэд ер нь нам тэр олон улсын тодорхойлолтыг нь харсан. Үзэл бодлоороо нэгдсэн нам өөрөө өөрийгөө засагладаг гэж үг байгаа юм шүү. Өөрөө өөрийгөө засагладаг. Өөрийн гишүүд болон олон нийтэд үйлчилдэг байгууллага гэж байгаа юм. Төр бол үүнийг хажуугаас нь зохицуулалт хийдэг болохоос биш, төрөөс тэр түрүүн ярьсан сонгуулийн төв байгууллага гэдгээр засаглана гэсэн санаа байхгүй. Яг түрүүн тэр асуултад би уг нь хариулт авахдаа Германы хуульд бол олон нийтийн байгууллага гэж байна шүү. ТББ биш, төрийн байгууллага биш, олон нийтийн байгууллага гэдэг статус дээр нийгэмд танигдсан мэргэшсэн эрдэмтдээр нэлээн хүчтэй байр суурийг нь илэрхийлдэг юм билээ. Иймэрхүү зүйлүүдээ эргэж харна гэж найдаж байна.

Тэгээд 4-д нь хэлэхэд түрүүн би уг нь асуулт дээрээ асуусан юм байгаа юм. Гишүүдийг эрх хэмжээг нь нэмэгдүүлээч. Гишүүдийг л гэж яриад байгаа юм. Та нар Монгол Улсын Үндсэн хуулийг ярих юм бол иргэд Улсын Их Хурлыг, Засгийн газрыг, Ерөнхийлөгчийг яаж сонгох вэ,

яаж үйлчлүүлэх вэ, яаж хариуцлага тооцох вэ л гэдэг 4 сэдэв байгаа. Үүнтэй адилхан намын тухай хууль бол гишүүд нь яаж шийдвэр гаргах юм, яаж гомдол гаргах юм, яаж даргаа сонгох юм, гарсан даргыг яаж хариуцлагажуулах юм, яаж хазаарлах юм гэдэг тухай байх ёстой болохоос биш өмнөөс нь өөр байгууллагаар дарга нарыг нь хазаарлах тухай бас хэтэрхий их орчихсон байна уу даа.

Тэгэхээр Монгол оронд та нар бодоод үз дээ. Нам төрийн өмчийн компаниудын дарга болдог гишүүр болоод удаж байна шүү дээ. Намд зүтгэсэн. Тэгэхээр намчнуудыг төрийн өмчийн компанийн энэ Эрдэнэс тавантолгой байна уу, өөр юу ч билээ энэ баахан баян, баян ТУЗ-ийн гишүүнээр томилдоггүй байх тал дээр энэ дээр оруулмаар байгаа юм. Нам мөнгө 2-ыг салгая л гээд байгаа шүү дээ.

Төрийн мөнгөнд шунахайрсан, төрийн өмчийн компанид албан тушаал эзэмшихийг хүссэн хүмүүсийн гишүүр нь намд хандив өгөх болчихсон. Тэгэхээр энэ төрийн өмчийн компани энэ намчин байдлыг яаж мөнгөтэй холихгүй байх вэ гэдэг энэ заалт дээр гишүүдийг хүчтэй болгоё, гишүүдийг бяр оруулъя. Англи үгийг нь хэлээд яах вэ зүгээр гишүүд бол намын эзэн юм, өмчлөгч юм гэж заасан байна лээ шүү дээ. Тэрнээс намын дарга манайх болчихсон. Нам өөрөө дарга нар нь өөрийгөө нам гээд итгэчихсэн ийм аймшигтай байдлыг таслан зогсоох саяын үзэл баримтлалууд орно гэж би итгэж байна.

Г.Занданшатар: Асуулт хариултын цаг дууссан. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж байгаа. Тэгээд Доржханд гишүүн үг хэлсний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цугларна уу. Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Багшийн хөгжлийн гарц төрийн бус байгууллагын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой

танилцаж байна. Хүндэт багш сурган хүмүүжүүлэгчид та бүгдийг соён гэгээрүүлэх их ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе гишүүдийн өмнөөс. Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхлээр хуулийн төслийг бол маш их дэмжиж байгаа. Яагаад вэ гээд тэгэхээр энэ зөвхөн парламентын суудалтай 3 намын хүрээнд биш юм. Бүх улс төрийн намуудын хүрээнд 2 жил тойрон яригдаж байгаад, саналуудаа тусгаж байгаад, тэгээд маш олон улс төрийн үйл ажиллагаа явдаг институтүүдийн саналыг тусгаж байгаад оруулж ирсэн. Маш олон дэвшилттэй заалтууд бол байгаа.

Тэгэхдээ зарим зүйл дээр бас тусгах шаардлагатай зүйлс байна. Нэгдүгээрт юу байна гээд тэгэхээр энэ парламентын ардчиллыг бэхжүүлэх асуудлыг бид нар их ярьж байгаа. Тэгээд парламентын ардчилал гээд ярихлаар иргэд бол ингээд нам муухай, хүн сайхан. Хүнээ сонгоно гэдэг юм маш их байна хандлага. Тэгээд энийгээ бид нар өөрсдөө засаж авахгүй бол болохгүй. Тэгээд засах арга хэрэгсэл нь юу байна гээд тэгэхээр парламент гэдэг чинь бодлогын мэтгэлцээний талбар байдаг. Тэгээд намууд нь өөрсдөө үнэт зүйл дээрээ нэгдээд, сахилга баттайгаар үйл ажиллагаагаа явуулж байж, тэнд бодлого ярьдаг парламенттай, бодлогыг санхүүжүүлдэг парламенттай, бодлогыг кнопддог ийм парламенттай байж энэ маань өөрөө ингээд биеллээ олох юм байгаа юм.

Тэр агуулгаараа бид нар ардчиллаа хамгаалж чадна, тусгаар тогтнолоо хамгаалж чадна. Гэтэл энэ асуудал маань иргэдэд, олон нийтэд бол маш буруу ойлголттой байна. Маш олон намтай, намууд нь хэрэг алга. Тэгээд гарч ирэхлээрээ луйвар хулгай их хийгээд байна гээд. Тэгэхээр энийгээ зоригтой хиймээр байгаа юм. Нэг хийж байгаа бол бүр л тултал нь хиймээр байгаа юм шүү. Үүний хүрээнд бол нэгдүгээрт хатуу

гишүүнчлэлийг одоо үүгээрээ зүгээр зоригтой халчихъя. Манай намын ялдаг систем юм, манай нам олон салбартай юм, танай нам ийм юм гэсэн байдлаар хандмааргүй байна.

Монгол Улсын 21 аймгаар явлаа, 9 дүүргээр явж байна. Өнөөдөр хүртэл ингээд иргэдтэй уулзаж байна. Энэ хуваагдлаа талцлаа болиод өгөөч. Ялангуяа сум, дүүргийн түвшинд ингээж хуваагддагаа болиоч гэдэг хүсэлтийг бол маш олон иргэд өгч байна. Эрхэм гишүүдээ анхаараач, тийм анхаараач. Жижигхэн 3.4-хөн сая иргэдтэй, маш том боломжтой улс сүүлийн 10 жилд аравхан тэрбум доллар дээр гацчихлаа. Маш их улс төржилт байна. Тэгээд маш их цөхрөл гомдол байна. Үүнийг бид нар одоо л эр зоригтойгоор шийдэж, энэ төрөө цэгцлэх шаардлагатай байна. Ийм болохоор хатуу гишүүнчлэлээ больё. Бүх аймаг, орон нутаг, сумд, хороод, 330 сум, 200 хороод том, том ингээд байшингуудтай яг талбайн хажуу талд ингээд том байшинтай, тэрний орой дээр нь ингээд туг гараад байна, залраад байна. Яг хажууд нь.

Тэгээд үр дүнд нь болохоор энэ чинь ингээд маш их зардлыг бий болгоод байна. Монгол Улсад бүх орон нутаг салбарт ийм өөрийн гэсэн салбартай 1 ширхэг ч яам байхгүй шүү. Агентлаг байхгүй, 1 ширхэг ч компани байхгүй. Олон улсад ийм олон далбаа ингээд хийсгүүлчихсэн ийм нэгжүүд байхгүй шүү дээ. Ганцхан социалист оронд байгаа байх, Хойд Солонгост байгаа байх, магадгүй Монголд байна. Энийгээ больчих. Энэ системээ одоо бид нар эвдэхгүй бол энэ чинь өөрөө маш их зардлыг бий болгоод байна. Үр дүнд нь залуучууд, мэргэжилтнүүд, эмэгтэйчүүд энэ улс төрийн намын үйл ажиллагаа руу яг чөлөөтэй орж чадахгүй байгаа юм.

Яагаад вэ гэхээр маш их өндөр зардлын босготой болохоор. Тэгэхээр энийгээ хориглоё. Тийм болохоороо яг ийм хот суурин газар аймгуудынхаа түвшинд та нар салбартай байчих. Гар

утас гараад ирчихсэн шүү дээ. Дэлхий ертөнц чинь, улс төрийн үйл ажиллагаа чинь ингээд технологи руу орчихсон. Хурал хийлээ гэхэд цахимаар хийдэг болчихсон, зардал шаардлагагүй болчихсон ийм үед заавал ингээж бүх орон нутаг нэгжүүдэд намын үүр байгуулах, далбаа хийсгэх, тэнд ингээд хатуу гишүүнчлэлийг ингээд торлоод байж байдаг энэ систем чинь Монгол Улсыг ингээд барьчхаад байна. Одоо больё. Ардын намынхан, АН-ынхан. Бүх аймаг, бүх сумдад байна. Дэлхий дээр ийм юм байхгүй шүү дээ, байхгүй шүү. Ийм болохоор энэ хатуу гишүүнчлэлээ больчихъё.

Дараагийн зүйл нь юу байна гэхээр бүртгэлийн асуудал байна. ХҮН намын хувьд бол 3, 4 жил бүртгэлийн асуудал маш хэцүү байсан. Одоо АН бол бүртгэлийн асуудал маш хүнд байгаа. Тэгээд өнөөдөр 1 нэгдэж байх шиг байна. Тэгэхээр энийгээ тодорхой болгочихъё. Улсын Дээд Шүүх дээр бол бүртгэх юм байна. Тэгэхдээ бүртгэхийн тулд заавал СЕХ-гоор дамжуулж, бэлтгэл ажлыг нь хийж байгаад шүүх бүртгэнэ гээд ингээд нэг давхар дамжлага гаргаж ирээд байх шиг байна. Энийгээ шууд, Дээд шүүх рүүгээ өгчихмөөр байна. Харин явц дундын хяналтыг нь бол ҮХЦ нь хийдэг байна уу нэг тийм байдлаар цаашаагаа яг энэ бүртгэл дээрээ анхаарлаа хандуулаад цэгцлээд явчихмаар байх юм гээд.

Тэгээд эцэст нь гээд хэлэхэд энэ хууль Сонгуулийн ерөнхий хууль тэгээд Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлтийн асуудал маань цогцоороо яригдах ёстой. Энэ бүгд дээрээ л бүгдээрээ Их Хурлын гишүүд маань 1 талдаа ингээд гарах юм бол Монгол Улсын төрийн түүхэнд төвхнөх ийм том үйл явдлын өмнө байна. Энийгээ харин хамтдаа бүгдээрээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Доржханд гишүүн, Ганбаатар гишүүн нар дэмжиж үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Байнгын хорооны

саналаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалт дууслаа. 34 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлж байна.

15.07 цаг

Хоёр. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орно. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 3 дугаар сарын 23, 24-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундармаар ахлуулж, гишүүдэд Д.Батлут, Н.Ганибал, Х.Ганхуяг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Ажлын хэсгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор алслагдмал сумдын эрүүл мэндийн байгууллага болон бусад төрийн байгууллагуудад шилжүүлэх, МХЕГ-ыг татан буулгасантай холбогдуулан тухайн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэх талаар зарчмын зөрүүтэй нийт 39 санал, найруулгын 2 саналыг тогтоолын төслийн хавсралтад нэмэх саналын томъёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлэгт оруулсан болно.

Байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн

Д.Батлут улсын онцгой объект болох Орхон аймгийн иргэдийн ундны цэвэр усны дэд станцуудын харуул хамгаалалтад Дотоодын цэргийн ангийн ашиглаж байсан Эрдэнэт үйлдвэрийн эзэмшлийн автомашиныг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хураан авсныг буцаан олгох асуудлыг шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг орон нутгийн өмчид шилжүүлсэн автомашины засвар үйлчилгээний асуудалд анхаарах, эдгээр автомашинуудын хуваарилалтыг нээлттэй, ил тод болгох, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Улсын Их Хурал төрийн өмчийн бодлогын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байх. Тавилга, эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх хуваарилах асуудлыг Засгийн газар, агентлагийн түвшинд шийддэг байх гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Улсын Их Хурлаар хэлэлцэх ач холбогдол багатай, эд хөрөнгө шилжүүлэх хуваарилах талаар олон саналын томъёолол гарч байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.23 дахь хэсгийг үндэслэн тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Төрийн төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ундрам гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын дарга Болдын Цэнгэл, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Батчулууны Мөнхбаатар нар оролцож байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нэрсээ өгье. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Учрал гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Энэ талаар мэдээлэл ховор байна. Тийм учраас Цэнгэл дарга энэ дээр нийт хэчнээн төрийн байгууллагуудаас машин хурааж авсан юм. Энэ машинуудыг бас орон нутагт шаардлагатай газруудад нь өгөх гэж байгаа юм байна. Тухайн хураагдаад бараг нэлээд хугацаа өнгөрсөн. Өнгөрсөн хугацаанд энэ автомашин техник хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хэн хаана, хэзээ, яаж хариуцаж байсан юм бэ? Тэр машинуудын эд анги дугуй гээд л бүх юмнууд нь яг байснаараа байгаа юу үгүй юу гэдэг дээр ямар баталгаа байгаа юм бэ?

Нөгөө талаас орон нутагт шилжүүлэх гэж байгаа энэ шийдвэрийг хэн гаргаж байгаа юм. Хэрхэн ямар судалгаа дээр яг хэрэгцээтэй газар нь өгч чадаж байгаа юу үгүй юу, зүгээр найз дундаа явчхаж байна уу гэдгийг яаж энд орон нутагт шилжүүлж байгаа юм бэ? Ямар тооцоо судалгаа дээр шилжүүлж байгаа юм бэ? Энэ талаараа мэдээлэл өгнө үү.

Л.Мөнхбаатар: Төрийн өмчийн хорооны дарга хариулъя.

Б.Цэнгэл: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. ТӨБЗГ-ын дарга Цэнгэл. Нийт ер нь машин тэрэгний

хэрэгцээ байгаа тухай салбарын салбараас, хөдөө орон нутгаас, Улсын Их Хурлын гишүүдээс гээд одоо мянга гаруй санал бичгээр ТӨБЗГ дээр ирсэн. Мөн ЗГХЭГ дээр бас саналууд ирдэг. Тэр саналууд нь бол манайх руу ингээд шилжиж ирдэг. Хэрэгцээ шаардлага хүсэлт бол их олон байгаа. Энэ саналууд бол бас нэмэгдэж ирсээр байгааг бол хэлье гэж бодож байна.

Бид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд нийт 424, 427 машиныг татан төвлөрүүлсэн. Энэ 427 машинаас бол хөдөө орон нутагт бол 120 орчим машиныг бол ингээд шилжүүлэх үйл ажиллагааг зохих журмын дагуу ингээд хийж гүйцэтгээд байж байгаа. Энэ Улаанбаатар хотод татан төвлөрүүлж байгаа тээврийн хэрэгслүүдийг бол ихэвчлэн бид бол төр засгийн авто бааз хуучнаар одоо бол аж ахуйн тооцоон дээр бол бие дааж ажиллаж байгаа энэ авто бааз дээр бол ингээд төвлөрүүлж ажиллаж байгаа. Хөдөө орон нутагт байгаа машинуудыг бол тэнд нь зохион байгуулах ийм чиглэлийг бол өгч ажиллаж байгаа.

Энэ чиглэлээр бол Засгийн газрын 204 дүгээр тогтоол гарсан. 204 дүгээр тогтоол дээр бол энэ машиныг яаж хуваарилах талаар бол их тогтоолд их тодорхой тусаж өгсөн байж байгаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д бол тээврийн хэрэгсэл ажлын шаардлагаар хэрэглэх болно гэдэг ийм Төрийн хэмнэлтийн хуулийн 6.5-д 19 байгууллагын ийм жагсаалт гарсан энэ хуульдаа. Тэгэхээрээ, энэ байгууллагадаа эхний ээлжид бол энэ татан төвлөрүүлсэн тэргүүдээс бол хуваарилалт явуулна. Засгийн газрын авто баазыг парк шинэчлэлтийг сайжруулна. Үлдэж байгаа тээврийн хэрэгслийг бол тэр мянга гаруй санал хүсэлт ирснийг эрэмбэлж байгаад бас судалж байгаад хэрэгцээ шаардлагатай байгаа гэдэг газруудад нь бол хуваарилж өгөх ийм чиглэл гарсан.

Энэ чиглэл гараад одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжих тохиолдолд заавал Улсын Их Хурлаар ордог зохицуулалттай байгаа учраас энийг бид нар үзэл баримтлалынх нь хүрээнд нь асуудлаа боловсруулаад Засгийн газраар оруулаад, ингээд Их хурал дээр бол асуудал ингээд дэмжигдээд ингээд сая Байнгын хороогоор ингээд орсон. Яг энэ үзэл баримтлал батлагдаад явж батлагдсаны дараагаар 1 шинэ нөхцөл байдал үүссэн.

Тэр ямар шинэ нөхцөл байдал үүссэн бэ гэхээр бол улсын МХЕГ татан буугдах үйл ажиллагаа энэний дараа явагдсан. Тэгээд улсын МХЕГ энэ системийн энэ байгууллага татан буугдаж байгаатай холбогдуулаад энэ байгууллагын өмч хөрөнгө, эд хогшилыг бас хэрэгцээтэй байгаа газрууд нь хуваах шийдвэрлэх ийм шаардлага гарсан учраас ЗГХЭГ-ын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан. Энэ тухайлбал өмнө энэ үзэл баримтлал ингээд өргөн баригдсаны баригдах үед тухайлбал 29 машин Их Хурлаар шийдвэрлэгдэх 29 машин байсан бол юу мэргэжлийн хяналтын асуудал нэмж орж ирсэнтэй холбогдуулаад нэмээд 30 машин, нийт өнөөдөр бол 59 машин тээврийн хэрэгслийн тухайлбал энд Их Хурлын шийдвэрээр орж ирэхээр бол орж байгаа.

Өнөөдрийн асуудал дээр бол зөвхөн машин биш. Мөн барилга, эд хогшил гээд бусад зүйлүүд орж ирж байгаа. Ер нь Их Хурлаар ингэж шийдүүлж байсан тохиолдол бол өмнө нь бол 8 байдаг. Өнөөдөр 9 дэх удаагаа Их Хурлаар төрөөс орон нутгийн өмч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Гүйцээгээд хариулчихъя.

Б.Цэнгэл: Тэгээд өнөөдөр бол 9 дэх удаагаа энэ Улсын Их Хурлаар энэ

асуудлыг ингэж оруулж ирж байгаа. Хадгалалт хамгаалалт нь ямар байна гэж асууж байна. Хадгалалт хамгаалалтыг бол бид ер нь машиныг хүлээж авахдаа актаар хүлээлцэж байгаа. Актаар хүлээлцэж аваад ямар эд анги нь бүрэн бүтэн байна гэдгийг бол Засгийн газар авто баазын мэргэжлийн улсууд нь ороод ингэж авч байгаа.

Энэ Их хурлын энэ шийдвэр дотор бол сая Байнгын хорооноос ороод ингээд буцаж байгаа асуудал бол саналын зөрүүтэй 40 орчим саналын зөрүүтэй томъёолол байгаа учраас энийг бас буцаж байгаа. Яагаад ийм асуудал үүссэн бэ гэхээр бол яг амьдрал дээр тухайн газарт хуваарилагдаж, тухайлбал Засгийн газрын хурал дээр Эрүүл мэндийн сайд санал гаргаад нэн ялангуяа мэргэжлийн хяналтаас татан төвлөрүүлэлт нэг 100 гаруй машин дээр бол дийлэнх нь бол эмнэлгийн байгууллагуудад шилжүүлэх нь зүйтэй гэдгийг Засгийн газраас шийдсэн байсан. тэгээд энэ дээр бол хуваарилалт хийж явж байхад бол өөр төсөл хөтөлбөрийн журмаар нөгөө газар нь бол машин тэрэгтэй болсон, зарим 1 нь бол машин тэргээ голсон учраас 1 аймгаас нөгөө аймаг руу шилжүүлэх ийм зохицуулалтын юмыг бол хийх ийм зайлиггүй шаардлага гарсан учраас энэ дээр хөдөлгөөн орсон.

Мөн Их Хурлын гишүүдийн хүсэлтийг харгалзаж энэ дээр бас хөдөө орон нутагт нэн ялангуяа өвөлжилт хүндрэлтэй байгаа аймгуудад бол асуудлыг шийдэж явсан. Ингээд энэ дээр бол бас чуулган дээр бол Их Хурлын гишүүд нь горимын санал гаргаад энэ дээр бол асуудлыг нь бол ингээд дэмжиж явъя гэдэг ийм байдал гарсан. Энэ дээр бас 1 зүйлийг зайлиггүй хэлэх зүйл гэх юм бол ер нь цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан үзээд энд байж байгаа дийлэнх машинуудыг бол хөдөө орон нутагт нь ашиглалтын гэрээгээр, түр хугацаагаар гэх юм уу ашиглалтын гэрээгээр яаралтай машин тэрэгний хэрэгцээ байсан учраас бол энийг хөдөлгөөнийг нь

бол хийж байх нь зүйтэй гэдгийг Засгийн газраас чиглэл өгсний дагуу ажил ингээд бол зохион байгуулалтын арга хэмжээг бол хийсэн. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Нийслэлийн ЧД-ийн ерөнхий боловсролын 17-дугаар сургуулийн 12Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Ням-Осорын Учрал гишүүн асуултаа асууя.

Н.Учрал: Энэ Засгийн газраас энэ 2022-оос 23 оныг авлигатай тэмцэх жил болгож зарлаад, энэ 5Ш ажиллагааны хүрээнд бас үр дүнгээ өгч байгаа сайн үзүүлэлтүүд байна. Ялангуяа энэ төрийн өмчийн компаниудыг шинэчлэх менежментийн өөрчлөлтийг хийх ажил бол бас багагүй хэл ам дагуулж байгаа ч гэсэн урагшилж байгаа. Тэгээд Цэнгэл дарга бол бас зүтгэж байгаа юм. Тэгээд гол нь мэдээж саад бэрхшээл сорилтууд тулгарч байна.

Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр өнгөрсөн хугацаанд энэ шилэн ажиллагааны хүрээнд төрийн өмчийн ТУЗ-үүдийг ил болгох гэж энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд заасан үүрэг. Гэтэл мэдээлэл хариуцагч нар гээд байгаа 5000 гаруй байгууллагуудаас өнөөдөр төрийн өмчийн 71 компанийн л ТУЗ ил болчихоод байдаг. Тэгээд иргэд бол юу гээд байна вэ гэхээр нь жараахайнуудыгаа яриад, ақулуудыгаа ярьдаггүй болчихлоо, гаргаач гээд шаардаж байгаа.

Тэрнээс биш Засгийн газрын зүгээс энэ мэдээллүүдийг аль заримыг нь нуугаад, заримыг нь ил гаргаад байгаа юм огт байхгүй. Тэгэхээр Төрийн өмчийн хороонд хамаарагддаггүй энэ төрийн өмчийн компаниудын ТУЗ-ийн цалин хөлс, нэр усыг ил болгоход энэ 5000 гаруй төрийн байгууллагууд ажиллаач л гэж хэлмээр байна. Хэдэн сар бичиг өгөөд хариу өгдөггүй. Тэгээд 6 сарын 1-нээс

өмнө хэрэв энэ шилэн ажиллагаа дээр машинд уншигдах байдлаар энэ мэдээллийг оруулаагүй байх юм бол холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно, АТГ шилжүүлнэ гээд Ерөнхий сайдын албан даалгавар гарчихсан. Тэгэхээр ТӨХ-ны удирдлагуудад би хэлмээр байгаа юм. Энэ ТУЗ-аа ил болгоод, цалин хөлстэй нь тавьчихаач.

2-т өнөөдөр энэ төрийн өмчийн байруудыг бараг 10, 20 жилийн өмнөх үнээр зах зээлийн үнээр түрээслээд ийм паразит шиг амьдардаг нөхөд бий болчихож. Тэгээд ингээд ажил хариуцъя гээд ингээд орохоор янз бүрийн дарга цэрэг нар яриад зовоогоод байдаг. Энэ ажил авсан хүмүүсийг. Тэгэхээр шилэн ажиллагаа гэдэг бол бүгдийг нь л ил болго гээд байгаа юм. Хэн нэгэн буруутай, хэн нэгэн нь хууль зөрчлөө гээд байгаадаа биш. Зүгээр л ил тод болго. Тэгэх юм бол өнөөдөр ТӨХ-ны дарга хэн байгаагаас үл хамаараад ил тод л ийм л нийгмийг бүтээе гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр Цэнгэл дарга одоо нэг дэх өдөр төрийн өмчийн байруудыг 5, 6 мянгаар түрээслэж байгаа нөхдийг ил болгоё. Тэгээд нэг дэхэд би хариуцлагатай хэлмээр байна. Энэ мэдээллийг явуулж өгөөч. Өнөөдөр төрийн өмчийн байруудыг 5, 6 мянган төгрөгөөр түрээслээд, дотор нь бараг барилга барьчихдаг. Тэгээд гар гэхээр зах зээлийн үнээр түрээсэл гэхээр ямар тайлбар тавьдаг вэ гэхээр тэгвэл бид нар мөнгөө нэхэмжилнэ. Энд чинь хэдэн тэрбумаар нь бид нар засвар үйлчилгээ хийчихсэн. Бид нарт өг, үгүй бол гарахгүй. Тэгээд ингэж төрийн өмчийн байруудыг, төрийн өмчийн эзэмшилд байгаа өмч хөрөнгийг ийм паразит бүр ийм шимэгч байдлаар ашигладаг 1 ийм амьдардаг хэсэг бүлэг нөхдүүд төрөөр чинь дүүрчихлээ шүү дээ.

Тийм учраас иргэд бухимдахаас аргагүй байна. Өнөөдөр энэ шилэн ажиллагааны үр дүнд бий болж байгаа мэдээллүүдээс болоод иргэдийн урам зориг мохож байна. Тийм учраас Төрийн

хэмнэлтийн ч хуулиа хэрэгжүүлбэ, шилэн ажиллагаагаа ч явуулъя, ил тод ч болгоё. Тэгээд Цэнгэл дарга бас хариуцлагатайгаар хэлээч. Нэг дэх өдөр бид нар энийг машинд унших байдлаар мэдээллийг ил болгоно. Та ТУЗ-ийн цалин хөлс нэр усаа дуусгаж өгөөч. Тэгээд нэг дэх өдөр төрийн өмчийн ямар байрыг хэн гэдэг хуулийн этгээд, ААН 15 жилийн өмнөх зах зээлийн үнээр түрээслээд, төрд хохирол учруулаад байгааг олон нийтэд зарлахад дэмжлэг үзүүлээч. Ингээд бас 1 төр нь төр шиг байя л гэж хүсээд байна.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах юм бэ? Төрийн өмчийн хорооны дарга уу? Энэ Учрал гишүүн маань бас гишүүнээс гадна Засгийн газрын гишүүн байгаа, сайд. Та хэд бол энийгээ Засгийн газар дээрээ уул нь ярих ярианууд л энд яригдаад байна даа. Төрийн өмчийн хорооны дарга хариулъя, 85 дугаар микрофон Болдын Цэнгэл.

Б.Цэнгэл: Бид өнөөдөр төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч бол 7 субъект байна л даа. Бид сая Эрдэнэс Монгол компани нэгдлийг үүсгээд дөчөөд компанийг Эрдэс Монгол нэгдэл рүү ингээд шилжүүлэх процесс явагдаад дууссан. Эрчим хүчний системийн 31 компани байгаа. Эдгээр 31 компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч гол субъект нь бол Эрчим хүчний сайд буюу Эрчим хүчний яам байж байгаа.

ЗГХЭГ хүртэл өөрөө бол бас нэлээн хэдэн компанийн хувьцаа эзэмшигчээр явж байгаа. Тэгэхээр бид Төрийн болон орон нутгийн өмчийн шинэчилсэн найруулга дээр бол хувьцаа эзэмшигчдийн эрхийг олон хэсэгт тараах биш аль 1 нь байх ёстой гэдэг байдлаар бол энэ хуулийн төсөл маань явж байгаа. Тэгэхээр энэ асуудал эрх зүйн хувьд шийдвэрлэгдчих юм бол энэ асуудал аяндаа ингээд шийдэгдээд явна гэж бол бид харж байгаа.

Яг таны хэлж байгаа энэ ТУЗ-ийн гишүүдийн ил тод байдал, түрээсийн харилцааны ил тод байдлын талаар таны удирдаж байгаа яамтай манай ТӨБЗГ бол ер нь харьцангуй овоо нягт ажиллаж байгаа. Яг манай дээр байж байгаа компаниудын мэдээллийг бол бид бол харилцан ярилцаж байгаад Эрхэмээ дэд сайдтай бид нар бол нэлээн ойр ажиллаж байгаа. Энэ мэдээллүүдийг бол бүрэн өгсөн. Энэ ирэхгүй байгаа бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчийн дор ажиллаж байгаа компаниудыг бол хэдийгээр хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхэд чинь бол өөр субъектүүд байгаа учраас хүндрэлтэй юмнууд бол гарч байгаа хэдий ч бид бас давхар шахаж ажиллана.

Түрээсийн асуудал бол бид бол тантай бол санал 1 байгаа. Бид энийг цэгцлэх зорилгоор бол ер нь бол төр болон төрийн өмчийн энэ барилга байшин объект бол ер нь бол үнийн бас хамгийн доод үнийг бол бас журамлаж өгсөн байдаг юм. Энэ бол өнөөдрийн зах зээлийн нийгэм үнийн өсөлттэй уялдаад байгууллагууд бол янз янзын хүсэлт тавиад энийгээ өсгөж өгөөч гэдэг асуудал тавьдаг боловч бид бол энийг бол энэ хэмжээнд нь барьж байгаа. Энэ дээр бол бид ажиллаад түрээсийн мэдээллийг манайхан яг ажиллаж байна. Ирэх нэг дэх өдөр гэхэд бол би танд энэ харилцааг бол ер нь бол бүгдийг нь шилэн болгох юмыг бол хамтарч ажиллаж болох байх гэж бодож байна.

Ер нь манай мэдээлэл бол харьцангуй манай сайт дээр бол бүгд бол ил тод байж байгаа. Энэнээс дурын хүн ороод үзэхэд ТУЗ-ийн гишүүнд хэн ажиллаж байна, хэдэн төгрөгийн урамшуулал авч байна гэдэг нь бол ил тод ингээд хийчихсэн байгааг бол та бүхэнд бол хэлье. Гэхдээ бид манай Учрал сайдын хэлж байгаа асуудалтай 100 хувь саналыг байгаа. Энийг бол бүгдээрээ хамтарч хийгээд, энийг ил тод нээлттэй болгох энэ асуудлыг бол хийнэ. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан, Энхтүвшин нарын удирдлагаар Дорноговь аймгийн Зүүнбаян сумын ахмадын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгддээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. 1 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ Төрийн өмчөөс орон нутгийн өмчит эд хөрөнгө шилжүүлэх тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм байна. Энэ дээр 1 асуулт байна. Энэ Баян-Өлгий аймгийн Буянт сумын ЗДТГ-т Прадо 150 7288 номерын машин шилжүүлсэн гээд байх юм. Энэ Буянт сумын ЗДТГ-т ийм машин очоогүй. Энийг дундаас нь тэр Цагаан нуурын хил, гааль боомт хариуцсан төлөөлөгч авсан зураг байх юм. Энийг та лавласан уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ хамгийн цас зудтай даваа, хад ихтэй энэ Булган сумын тэр энэ Мицibuши Пажеро маркийн машин аваагүй. Тэр нь бүр эвдэрчихсэн явах боломжгүй юм байна энэ дээр чинь Ланд Крузер 200 маркийн машин авсан. Эндээс запаас сэлбэг янзлаад явуулсан. Энийг бас сольж оруулахгүй бол бас сүүлдээ энэ буруу орчих вий нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ аймгуудын мэргэжлийн хяналтын байгууллагууд тарсан шүү дээ. Тэрний байр гээд нүсэр 2 давхар байр байгаа. Энэ танай харьяанд байдаг уу, төрийн өмчийн харьяанд уу, энийг яаж шилжүүлэх вэ? Нөгөө талаар аймгуудын 2 Засаг даргын орлогчтой байсан бусад зарим албадын машиныг хураасан энийг яаж шийдсэн юм бол ер нь тэр талаар мэдээлэл авъя.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Болдын Цэнгэл дарга хариулъя 85 дугаар микрофон өгөөрэй.

Б.Цэнгэл: Бейсен гишүүний асуултад хариулъя. ТӨБЗГ-ын дарга Цэнгэл. Зарчмын санал гаргасны үндсэн дээр бол тэр Прадо100 маркийн 7288 УНУ маркийн машиныг бол сумд биш Баян-Өлгий аймгийн ЗДТГ руу шилжүүлсэн байгаа.

Ер нь бол бид Хилийн боомтын зөвлөл байгуулагдсан. Хилийн боомтын зөвлөл бол их олон машин хүссэн. Яг өнөөдөр бидэнд ямар зовлон байгаа гэхээр бол машин хүссэн хүсэлтүүд бол мянга даваад явчихсан, одоо ч цаашидаа нэмэгдэж байгаа. Түрүүн би хэлсэн 427 машин төвлөрүүлснээс хөдөө орон нутагт 120, 30-ийг нь өгсөн. Бусдыг нь бол 6.5-д Хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д байгаа байгууллага руу бол шилжүүлсэн.

Тэгэхлээрээ бид байгаа энэ 16, 17 оноос хойш бол төрийн төсвийн байгууллага төрийн өмчит компаниуд дээр парк шинэчлэлт бол ер нь хийгдээгүй. Тэгэхээр байгаа бидний энэ нөгөө хуваарилах гээд ингээд зовоод байгаа машинууд маань бол ер нь ихэнх нь дийлэнх нь ашиглалтын хугацаа дууссан, ашиглалтын хугацааг нь бид нар нөгөө хурлаар оруулж бас сунгадаг байхгүй юу. Сунгасан. Элэгдлээрээ анхны өртгөө нөхчихсөн. Ер нь ийм тээврийн хэрэгслүүд бол гол төлөв байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол зарим нэгэн байгууллагад очсон машин бас гологдох шилэгдэх тийм ээ ийм юмнууд, зарим нь давхардал үүссэн ийм зүйлүүд бол гарсны гарч байгаа учраас энэ дээр бол бас зарим саналын зөрүүтэй саналын томъёоллоор орж ирээд ингээд их олон саналын зөрүүтэй томъёолол болж ингэж харагдаад байгаа юм.

Тэгэхээр Бейсен гишүүний саналыг бид нар бол бас судалж үзээд бас аймагт нь бол бас тодорхой асуудлуудыг бол шийдэж өгсөн. Гэхдээ ер нь бол хөдөө орон нутгийн нөхцөл байдал бол хүнд байгаа бид ойлгож байгаа. Засаг дарга нь машингүй, ЗДТГ нь машингүй, ер нь

бол сумууд хүнд ийм нөхцөл байдал бол бид байгаа. Гэхдээ бид энийг аль болохоор бололцоотой газар нь хүргээд өгчих юм сан гэж бодож байна. Одоо нөгөө гологдсоор байгаад шилэгдсээр байгаад гологдчихсон 20-иод машин үлдчихсэн байж байгаа. Тэгээд бид нар арга ядаад улсуудад бол та нар очоод үзээдэх, бололцоотой бол бид нар шийдээд өгье гэдэг байлаар явж байгаа. Зарим нь бол бид нарт 1 засварын хэдэн цаас байна, энэ машиныг чинь аваад засаад сэлбээд авъя гэдэг хүртэл ийм л байдалтай байж байна.

Баян-Өлгийн мэргэжлийн хяналтын хувьд орон нутгийн өмч дээр байдаг асуудал. Тийм учраас энэ дээр бол бас чиглэл, гишүүний асуусан асуултад бид нар бас орон нутагтай нь бас ажиллала гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ нөгөө тарааж өгсөн төслийн юман дээр энэ буруу орчихсон байна лээ. Тэгээд бичиг баримт нь буруу гарчих болов уу гээд тэгж байна. Тэр Булган сум дээр чинь суудлын автомашин Мицубуши Пажеро гээд тавьчихсан байх юм. Тэр чинь Ланд 200 авсан, тэрийг засаад оруулахгүй бол болохгүй байх гэдгээ хэлье.

Л.Мөнхбаатар: Санал хэлчихлээ тийм ээ, асуух юм уу? Хариулт авчихъя, Цэнгэл дарга хариулъя.

Б.Цэнгэл: Тийм энэ дээр нөгөө тухайлбал Пажеро нь бол Сүхбаатар аймаг руу явсан. Тэгэхээр энэ дээр бид нар нягталж үзээд Бейсен гишүүний хэлсэн энэ асуудлыг нягталж үзээд зөрүүтэй асуудлуудыг нь байх юм бол энэ дээр бид нар зохицуулалтын арга хэмжээг авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос төслийг хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзэж үзсэн

ийм санал, дүгнэлт гаргасан байна. Уг асуудлаар санал хураалт явуулъя.

Төрийн өмч, Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Булгантуяа гишүүн горимын санал гаргая.

Х.Булгантуяа: Мөнхбаатар даргаа энэ нөгөө санал хураадаг тоног төхөөрөмж ажилласангүй, дахин санал хураалт явуулж өгөөч, саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Булгантуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт. Санал хураалт гишүүдээ анхааралтай байгаарай. 55.3 хувиар уг санал дэмжигдлээ. Өмнө нь явуулсан санал хураалт хүчингүйд тооцогдсон. Одоо яг үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 57.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул тогтоолын төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг та бүгдэд уншиж танилцуулъя. Тогтоолын төсөл буцаах тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн өмчөөс орон нутгийн өмчит эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал,

дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Нямаагийн Энхболд гишүүн юугаа дараарай. Нямаагийн Энхболд гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Баярлалаа даргаа. Ингээд санаачлагчид нь буцаачихаар асуудлыг Засгийн газар өөрөө тэрүүгээрээ шийд гэсэн шийдвэрийг Улсын Их Хурлаас Засгийн газарт эрхийг нь өгчихлөө гэсэн үг болж ойлгож байна уу? Үгүй ээ харин тийм учраас асуугаад байна л даа. Угаасаа хуультай гээд оруулаад ирсэн чинь буцаа гэгчхээр яаж ойлгох вэ? Тэр нь тэрийгээ бас хэлэхгүй бол нэг ойлгомжгүй болоод л явчихлаа даа тийм ээ.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд гишүүний энэ санал дээр бас юу яая. Тодруулж хариулъя. Байнгын хороон дарга нь хариулчихъя. Цэрэнпунцаг Эдийн засгийн байнгын хороон дарга Цэрэнпунцаг хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ Их Хурлын тогтоолын төслийг оруулж ирэхдээ ажлын хэсэг уул нь оруулж ирсэн тэр төсөл нь аягүй задгай орж ирсэн юм. Тэгээд бараг 47, 8 зарчмын болон найруулгын саналууд гарч ирсэн. Тийм ээ. Тэгээд энэ л олон санал хураалтуудын гол нь энэ Их Хурал дээр энэ ийм зарчмын саналууд гаргаад хураагдах нь бол Их Хурал, Байнгын хороон дээр хийгдэх ажил биш байна. Энэ бол 1 жагсаалттай холбоотой. Дагаад тийм ээ жижиг, жижиг нэг ер нь сандал ширээ, 1 машин тэрэгний л асуудлууд байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ бид нар нэг мөр болгоод.

Жишээлбэл сая энэ Бейсен гишүүн эд нарын асуугаад байсан асуултуудыг бол бид нар энэ төсөл санаалагч оруулж ирсэн энэ төсөл санаачлагчид маань тэрэн дээрээ цэгцэлчхээд оруулж ирээд, ийм цэгцтэй гол нь бодлогынхоо асуудлыг

бид нар ярьж байх нь зүйтэй юм гээд манай Байнгын хорооны гишүүд бол энийг буцааж, ажлын хэсэг дээрээ цэгцэлж дахиж оруулж ир л гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Эцсийн найруулга дээр гишүүд санал хэлж дууслаа. Тогтоол батлагдсанд тооцлоо. Дараагийн асуудалдаа оръё. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

15.40 цаг

Гурав. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Дараагийн асуудалдаа оръё. Онцгой дэглэмийн хугацаа сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төслийн талаарх Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын газраас Эрдэнэс тавантолгой ХК-д 22 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай саналаа Улсын Их Хуралд 23 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр ирүүлснийг Эдийн засгийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар хамтран хэлэлцлээ.

Эрдэнэс тавантолгой ХК-д онцгой дэглэм тогтоож, тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлснээр компанийн санхүүгийн нөхцөл сайжирсан, гадаад валютын орох урсгал нэмэгдсэн бөгөөд нүүрсний олборлолт, тээвэрлэлт, борлуулалтын өртөг зардлыг бууруулах ил тод байдлыг хангах, нүүрсний арилжааг боломжит түвшинд тогтвортой хадгалах,

сайжруулах, тус компанид үүссэн сөрөг асуудлуудыг арилгах үүднээс Эрдэнэс тавантолгой ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах шаардлага байгаа талаар Засгийн газрын саналд дурдсан байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр 1992 оны онд шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн үйл ажиллагаа тасралтгүй явж байгаа бөгөөд Үндсэн хууль батлагдахаас өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан зарим эрх зүйн баримт бичиг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь Үндсэн хуульд нийцэж байгаа болон онцгой дэглэм тогтоох асуудал хууль зүйн үндэслэлтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг 23 онд тээврийн компаниудын төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ нь жилийн эцсийн байдлаар төсвийн болон валютын нөөцөд хэрхэн нөлөөлөх талаарх тооцоо судалгааг хийсэн эсэх, Бүрэн эрхт төлөөлөгчийн болон онцгой дэглэмийн хугацааг сунгах шаардлага байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр төлбөрийн болон гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан, Монгол Улсын 1 хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ өссөн талаар онцлоод, хил холболт хийгдээгүй мухар төмөр замын асуудлын талаар ямар бодлого баримталж байгаа болон нийт борлуулах нүүрсний тодорхой хувийг биржээр арилжаалах боломж боломжтой эсэх, Монгол Улсын Их Хурлын гишүүн Анандбазар Монгол Улсын эдийн засгийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа байгалийн баялгийг хэрхэн зөв зарцуулах, орлогын тодорхой хувийг ажлын байр шинээр бий болгох ХАА-н салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтад чиглүүлэх нь зүйтэй талаар, мөн уул уурхай дагасан бизнесийг дэмжиж, ажлын байрыг хадгалж үлдэхэд анхаарах, Эрдэнэс тавантолгой ХК-ийн ноогдол ашгийг иргэдэд хуваарилах асуудлыг тодорхой болгох, Улсын Их Хурлын

гишүүн Батжаргал онцгой дэглэм тогтоосон хугацаанд гарсан үр дүнг тогтвортой хадгалахын тулд хугацааг 1 удаа сунгах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэн батлах, иргэдэд ноогдол ашиг хуваарилахгүйгээр бүтээн байгуулалт хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд ноогдол ашигт ноогдол ашиг хуваарилагдах хөрөнгийн дүнгээр нэгж хувьцааны үнийг нэмэгдүүлэх нэмэгдүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар онцгой дэглэм тогтоосон хугацааны ТУЗ-д өмнө нь ажиллаж байсан гишүүдээс байгаа эсэх мөн тэдгээрт хүлээлгэсэн хариуцлага болон Засгийн газраас томилогдсон бүрэн эрхт төлөөлөгчийн ажил үүргийн давхардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин нэмүү өртөг шингээж ажлын байрыг нэмэгдүүлсэн, мөн татварын бааз суурийг тэлсэн нүүрс угаах болон баяжуулах үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах, Тавантолгой цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут тус компанид хийгдэж байгаа хөрс хуулалт, бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийг нүүрсээр тооцсон хүчин төгөлдөр гэрээ байгаа эсэх, борлуулалт хийхдээ нүүрсээ сорчлохгүй байхад анхаарч экспортод гаргах нүүрсийг шинжлэн судалж дүгнэлт гаргах лабораторийн хүчин чадал, техник технологи нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганболд хил холболт хийгдээгүй мухар төмөр замуудыг холбох хугацааны талаар, нүүрсний борлуулалтын үнийг богино хугацаагаар тооцож, уян хатан тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл онцгой дэглэм тогтоосон хугацааны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар дүгнэлт

гаргуулан хэлэлцүүлэх нь зүйтэй талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газраас Эрдэнэс тавантолгой ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай саналыг Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг саналыг дэмжиж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлаа.

Л.Мөнхбаатар: Аубакир гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан, Эрдэнэс Тавантолгой ХК-ийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Жигжидийн Ганбат, ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, энэ ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Эрдэнэс тавантолгой ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Хүүгийн Мөнхжаргал, Эрдэнэс тавантолгой ХК-ийн Өмнөговь аймаг дахь уурхайн салбарын захирал Лхагвын Доржсүрэн, Эрдэнэс толгой Эрдэнэс тавантолгой ХК-ийн Хууль, эрх зүйн

газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, тус компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Цэрэнсамбуу, тус компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантулга, тус компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Анх-Од нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Ганбаатар гишүүнээр тасаллаа, хэн Учрал гишүүн яасан орохгүй байгаа юм уу? Нэрсийг ахиж авъя. Энэ хооронд би Баттөмөр, Энхтүвшин. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Юуны өмнө эдийн засгийн, гишүүдээ анхаарлаа хандуулъя. Эдийн засгийн хамтарсан Байнгын хорооны хурал дээр бас асуудлууд нэлээн нухацтай яригдаж байсан. Юуны өмнө бас Ганбат даргатай энэ баг БЭТ Эрдэнэс тавантолгой дээр тогтоосны үр дүн бол бас энэ нүүрсний экспорт 10 сая тонноор өмнөх үетэй харьцуулахад нэмэгдсэн, тэрбум долларын илүү ашиг олсон валютын нөөцөд эергээр нөлөө үзүүлж байгаа, зарим нууц гэрээ оффтейк гэрээнд ил болсон гээд 6 сарын хугацаанд бол нааштай сайн үзүүлэлтүүд гарсныг бол юуны өмнө тэмдэглэе. Тэгэхээр яг шударгаар юм уу эсвэл бас ил тод нээлттэй ажиллавал нүүрсний экспортоос бид ямар их боломж ашиг олох, орлого олох зөв юманд зарцуулбал олон асуудлыг шийдэх боломж байгааг бол харуулж байна гэдгийг юуны өмнө хэлъя.

Тэгээд 1 зүйлээс 2 зүйлд онцгой асуудалд анхаарал хандуулъя. Өчигдөр би бас асууж байсан. Нөгөө дутсан нүүрсний асуудал өөрөө олон хүний анхаарал татаж байгаа. Тэгээд энэ жижиг Тавантолгой дээр үү эсвэл бас том Тавантолгой дээр ч гэсэн энэ нүүрс дутсан асуудлууд яригдаж байгаа. Яг одоогийн байдлаар энэ нүүрстэй холбоотой маргаантай их хэмжээний

тоотой тийм асуудлууд байгаа юу, шийдэгдсэн үү гэдэг дээр нэгд хариулт авъя.

Хоёрт нь энэ оффтейк гэрээтэй холбоотой асуудал өөрөө их чухал байгаа. Одоо бид нарт ирсэн материалаас үзэхэд 1 том гэрээ бол үлдчихсэн байгаа гэсэн. Бүгд найрамдах урд Хятад Ард Улстай борлуулсан гэрээтэй холбоотой асуудлаар гэж байгаа. Үлдсэн 1 гэрээний үлдэгдэл хэмжээ 4.3 сая тонн гэж байгаа. Тэгээд хугацаа нь 24 оны 12 сарын 31-нд дуусна гэж байгаа. Энэ яг ямар гэрээ вэ? Ямар компанитай хийсэн, энэ яг нүүрсний үнэ төлбөр нь одоогийн ханшаар харьцуулахад алдаатай гэрээ юу эсвэл энэ нь бас ингээд нөгөө цаашидаа явахад боломжийн гэж үзэж байгаа ийм гэрээ байгаа юу гэдэг асуудал байна.

2 дахь зүйл нь одоо яг бид нар бас яриад байгаа онцгой дэглэмийг дахиад бараг 1 жил дахиад сунгахаар ингээд орж ирж байна. Ер нь бол 1 онцгой нөхцөл байдал 6 сарын хугацаанд БЭТ бол хангалттай сайн ажиллаад одоо Эрдэнэс Тавантолгой хэвийн горимдоо шилжээд, зах зээлийнхээ зарчмаар ингээд энэ компани маань ажиллаад явах бүрэн бололцоо байгаа юу гэдэгт 1 хариулт би авахыг хүсэж байна. Уг нь бол би байгаа гэж харж байгаа.

Гэхдээ яг хүний нөөц шууд энийг аваад явах гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, боловсон хүчин гээд бас бэлтгэл ажил шаардлагатай байгаа учраас онцгой дэглэмийг ингэж гэж дахин сунгаж орж ирж байна уу? Уг нь бол энэ бас зарим 1 хууль дүрмийг өөрчлөхгүйгээр шууд ингээд БЭТ тогтоогоод яваад байх нь хууль, эрх зүйн хувьд зөрчилтэй зүйлүүд бас байгаа юм байна лээ. Тэгэхдээ энийг бол засна гэдгийг бол өчигдөр ЗГХЭГ-ын дарга ярьж байна лээ л дээ.

Ер нь Эрдэнэс Тавантолгой хэвийн горимоор зах зээлийнхээ жамаар ажиллаад явчих бололцоо бүрдсэн байгаа

юу? Яг энэ онцгой дэглэмийг үргэлжлүүлж БЭТ-ийн энэ үйл ажиллагааг яг энэ байдлаар нь цаашид сунгаж явснаар бид ингэж олоод байгаа нүүрсний экспорт, энэ нүүрс дагасан бизнес энэ тэрийг ийм амжилтад хүргэх бололцоо байгаа учраас бид сунгаж байгаа юм гээд тооцоо судалгаа хийсэн учраас энэ асуудлыг Их Хуралд оруулж ирж байна уу? Би бол бас байнга ингээд БЭТ юм уу онцгой дэглэмийг сунгаад яваад байх нь бас тийм ч зөв биш гэж бол харж байгаа. Гэхдээ одоохондоо ийм зайлшгүй шаардлага байна гэж хэлээд байх шиг байна лээ. Тэгэхээр энэ дээр 1 анхаарал хандуулж, хариулт өгнө үү гэж хэлэхийг хүсэж байна.

3 дахь зүйл нь энэ компанийн өрийн дарамтыг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ гэсэн яг одоогийн байдлаар Эрдэнэс Тавантолгой компани бас ашигтай ажилласан гэж үзэхгүй байгаа гэж яриад байгаа. Хэрэв ашигтай ажиллаж байна гэж үзвэл 1072 ширхэг нөгөө 1 иргэдийнхээ хувьцааг тооцоод бодоод өгөх бололцоо байх ёстой. Одоо 21 оных өгөөгүй, 22 оных өгөөгүй. Тэгэхээр та бүхэн маань өнөөдрийн түвшинд иргэдийн энэ ноогдол ашгийг хуваарилаад өгөх бололцоотой гэж харж байгаа юу? Ер нь хэзээнээс өгөх бололцоо байгаа вэ гэдэгт би бас тодорхой хариулт авахыг хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулахаас өмнө зочид танилцуулъя. Нийслэлийн БЗД-ийн ерөнхий боловсролын Төгсдэлгэрэх сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Оюунчимэг гишүүний асуултад хэн хариулах вэ? Хэн хариулах вэ? Шадар сайд хариулъя. Амарсайхан сайдын микрофоныг өгөөрэй.

С.Амарсайхан: Засгийн газар Онцгой дэглэм тогтоох үед бол Эрдэнэс тавантолгой ХК-ийн санхүүгийн нөхцөл

байдал хүнд байсан, сахилга бат, хариуцлага алдагдсан байсан. Дотоод үйл ажиллагаа, эргэлтийн хөрөнгөтэй, экспортын орлоготой холбоотой эргэлзээтэй тоо баримтууд их байсан. Тийм учраас бол нэгдүгээрт дотоод зохион байгуулалтыг сайжруулах, хоёрдугаарт экспортыг нэмэгдүүлэх, гуравдугаарт валютын орлогыг нэмэгдүүлэх, нөөцийг нэмэгдүүлдэг зорилгоор 300 Засгийн газрын 385 дугаар тогтоолоор 22 оны 10 дугаар сарын 26-ны өдөр онцгой дэглэм тогтоосныг та бүхэн маань мэдэж байгаа. Түүнээс цааш авч хэрэгжүүлсэн хэд хэдэн арга хэмжээнүүд байгаа.

Нэгдүгээрт бол энэ Эрдэнэс тавантолгой компанид томилогдсон онцгой бүрэн эрхт төлөөлөгч нүүрс олборлолт, тээвэрлэлт тэдгээрийг оновчтой зохион байгуулах, шаардлагагүй орон тоо, бүтцийг цомхотгох, зардлыг багасгах, мөн нүүрсний худалдаа гэрээний асуудлыг ил тод болгох, бүр цаашилаад засаглалыг оновчтой бөгөөд ил тод нээлттэй олон нийтийн хяналт доор явуулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах ийм зорилгыг тавьж ажилласан. Энэ хүрээнд бол 2023 оны 2 дугаар сарын 09-ний өдөр анх удаа биржээр зохион байгуулсан нүүрсний худалдаа амжилттай болсон. Нийтдээ 416000 тонн нүүрсийг борлуулсан, 20.9 сая ам.долларын нэмэлт орлого олсон. 24000 тонн коксжих нүүрс, 192000 тонн эрчим хүчний нүүрсийг ингэж борлуулсан. Бас шинэ тогтолцоог бий болгосон байгаа.

Хоёрдугаарт нь Тавантолгой ХК, Эрдэнэс тавантолгой компанийн хоорондын тусгай зөвшөөрөлтэй талбайд нэвтэрч олборлолт хийсэн асуудал эцэслэгдсэн гэж ойлгож болно. Өнгөрсөн хугацаанд бол нийт 258.9 мянган тонн нүүрсний төлбөр болох 13.9 сая ам.долларыг төгрөгт шилжүүлбэл 48 тэрбум төгрөгийн өглөг авлагыг барагдуулж, энэ асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Өглөг авлагыг.

Онцгой дэглэм тогтоох үед бол Эрдэнэс тавантолгой компани нийт 178 нүүрс худалдах гэрээтэй байсан бол үүнд үнэлэлт, дүгнэлт хийж, нийтдээ 101 болгож бууруулсан. Өөрөөр хэлбэл гэрээний гүйцэтгэл мөн эрх, үүрэг ил тод байдлыг хангах хүрээнд ийм ажил хийгдсэн гэж ойлгож болно. Нийтдээ 254.9 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт хийсэн байна. Энэ мэт ингээд яриад байвал маш олон асуудлууд бий. Мөн хулгай зэлгийтэй холбоотой, хууль зөрчсөн үйлдэлтэй холбоотой, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд, мэдээ мэдээллийг ил тод болгох ажлууд бас хийгдсэн.

Ингээд цааш нь яагаад энэ онцгой дэглэмийг сунгах шаардлагатай байна гэхээр бид өнгөрсөн хугацаанд дандаа алдаа дутагдлыг засах, сахилга батыг сайжруулах, хууль бус, нуугдмал байсан асуудлуудыг ил тод болгох ажлууд хийгдсэн. Цаашидаа олон нийтийн хяналт доор энэ компанийн үйл ажиллагааг сайжруулах, засаглалыг олон улсын түвшинд хүргэх мөн шилдэг боловсон хүчнийг нэмэгдүүлэх, иргэдэд Засгийн газарт ирэх өгөөжийг сайжруулах, үйл ажиллагааг илүү үр дүнтэй явуулахад хугацаа шаардлагатай байгаа учраас энэ онцгой дэглэмийг сунгах асуудлыг оруулж ирж байгаа.

Хууль тогтоомжтой холбоотой асуудал бий. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эсвэл цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэдэг асуудал яригдаж байгаа. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т зааснаар хуулиар зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хэрэв тухайн асуудлыг хэлэлцэх шийдвэрлэх хууль шинэчлэгдээгүй бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулах уу? Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгийн гишүүд, нэр албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулья.

Ж.Ганбат: Энэ Оюунчимэг гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Яах вэ тэр дутсан нүүрстэй холбоотой асуудал юм бол яг 12 оноос эхэлж энэ асуудал яригдаад, 17, 8 оны үед нийтдээ нэг зарим хэсгийн тодорхой хэсгийг нь нүүрсээр нь төлж барагдуулсан юм байна лээ. Тэгээд сая 2022 оны 12 сарын 27-ны өдөр нийтдээ 258 нь 9000 тонн нүүрсний төлбөр болох нийт 13 оны 9 сая ам.доллар буюу 48 тэрбум төгрөгийг яг бид нар Эрдэнэс тавантолгой компанийн дансанд орон нутгийн Тавантолгойд шилжүүлснээр энэ нүүрс дутсан гэдэг асуудлыг бол эцэслэн шийдвэрлэсэн ийм асуудал бол байгаа.

Дараагийн нэмэлт нэг тодруулга өгөх нь тэр оффтейк гэрээтэй холбоотой нийтдээ яах вэ яг оффтейк гэрээ нь бол ингээд 3 юу 4 оффтейк гэрээ дотроо дэд гэрээ 38 гэрээ байсан. Үүнээс Тавантолгой, Гашиун сухайт төмөр замтай холбоотой 27 дэд гэрээ энд ийм байсан. Үүнийг бид хугацааг нь бол дуусгавар болгосон. Энийг бол сунгахгүйгээр. Энэ бол дандаа нөгөө ам нөхцөлтэй ийм гэрээнүүд байсныг бол хугацааг нь дуусгавар болгосныг нь болгоод, одоо яг хугацаа нь дуусаагүй 1 гэрээ байгаа. Энэ гэрээ нь бол 24 оны 12 сарын 31-нд дуусна. Үлдэгдэл нь 4.3 сая тонн нүүрс гээд. Энэ бол зүгээр худалдан авагч нь нөгөө БНХАУ-ын худалдан авагч ийм компанитай байгуулсан 1 гэрээ бол үлдчихээд байгаа.

Богдхаан төмөр замтай холбоотой 9 дэд гэрээ байсан. Энийг бол зогсоосон. Нүүрс баяжуулах үйлдвэр дээр нүүрсээр төлбөрийг нь барагдуулах 1 гэрээ бол ингээд хэрэгжээд явж байгаа. Газрын тосны хийн хоолой дээр мөн 1 гэрээ байгаа. Нөгөө талдаа бид уурхайн ам нөхцөлтэй яг 133 гэрээ байсныг бид нар хил нөхцөл рүү шилжүүлэхээр хэлцэл бол энэ компаниудтай хийсэн. Хугацаа нь дуусгавар болоогүй байсан. Энэ хүрээндээ нийт 133 гэрээ бид 87 гэрээг нь ганц модон нөхцөлөөр буюу хил

нөхцөлөөр энийг биржийн үнээр бол хэлцэл хийх байдлаар өөрчлөлт оруулах ийм юм хийсэн.

Яг үлдсэн нөгөө урьдчилгаа төлбөр авсан бас 4 том гэрээнүүд байгаа. Чалко компанитай байгуулсан, энэ бусад 3 худалдагчаар, нийтдээ 4 худалдан авагчийг байгуулсан өмнө нь 603 сая ам.долларыг урьдчилаад авчихсан, дараа нь нүүрс нийлүүлэх гэрээ нөхцөлтэй. Энэ гэрээнүүдийн хугацаа бол дуусах болоогүй энэ байгаа. Гэхдээ гэрээнд өөрчлөлт оруулах хил нөхцөл рүү шилжүүлэх асуудлаар худалдан авагч талд бол саналыг бол удаа дараа хүргүүлж, энэ асуудлаар хэлцэл хийж, санал солилцох байдлаар бол ингэж явж байгаа. Мэдээж нөгөө нэгэнт өмнө нь байгуулагдсан гэрээний асуудлууд гэрээний 2 талын ойлголцлын асуудал, хугацаа шаардсан ийм асуудлууд үүсэж байгаа.

Тэр 87 гэрээг бид нар хил нөхцөл рүү шилжүүлснээр яг одоогийн үнээр тооцох юм бол бид нар 300 орчим сая ам.долларыг нэмж орох ийм бол боломжтой байна гэж ингэж үзэж байгаа. Нөгөө талдаа яах вэ бид хамгийн гол юм нь Улсын Их Хурлаар батлагдсан биржийн Уул уурхайн биржийн тухай хууль 7 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилнэ. Бид 2 сарын 9-нөөс эхлээд туршилтын арилжааг бол зохион байгуулсан. Энийг бол хэвшүүлэх бол зайлшгүй шаардлага байна. Мэдээж 12, 13 жилийн хугацаатай Эрдэнэс тавантолгой компани нүүрсийг дандаа ам нөхцөлтэйгөөр зарж борлуулж ирсэн. Энийг хил нөхцөл рүү биржийн систем рүү шилжүүлэхэд мэдээж хугацаа шаардлагатай байна. Нөгөө худалдан авагч нартай бас ойлголцох, үйл ажиллагаа сурталчлах ийм ажлуудыг бол зайлшгүй хийж хэвшүүлэх шаардлагатай байгаа юм гэдгийг бас энд хэлэх нь зүйтэй болов уу.

Нөгөө талдаа өнгөрсөн 2022 онд Эрдэнэс тавантолгой компанид 1.3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан.

Эрдэнэс тавантолгой компанийн 18.4 хувийг нь 2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн 2.5 сая иргэд эзэмшиж байгаа. Энэ 2019 оны ашгийг 20 онд 1 удаа хуваарилсан юм байна лээ. Ингэхэд 1 иргэнд 96.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яасан хариулт хангалтгүй байгаа юм уу? Гүйцээгээд хариулъя. Гэхдээ 1 минутад багтаагаад хариулаарай. 80 дугаар микрофон өгье ажлын хэсгийн.

Ж.Ганбат: Энэтэй холбогдуулан бид өнгөрсөн 2 яах вэ 2019 оны ашгийг 20 онд хуваарилж байсан ийм 1 түүхтэй юм байна лээ. Түүнээс хойш бол ноогдол ашиг бол хуваарилагдаагүй. 22 оны 1.3 их наядаас ноогдол ашиг хуваарилах эсэх асуудлыг бол бид аудитаар тайлан нь ороод баталгаажсаад ингээд дуусаж байгаа. Энийг бол ТУЗ-даа танилцуулна. Мөн 4 сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан байгаа. Энэ хүрээндээ бид энэ асуудлыг бол ТУЗ болон удирдах юу хувьцаа эзэмшигчдийн хуралд бол энэ асуудлыг бол танилцуулна. Засгийн газраас болон энэ компанийн зүгээс ер нь ноогдол ашиг тараах асуудлыг компани өөрийнхөө хүрээндээ шийдвэрлээд явах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг бол баримталж байгаа. Компанийн зүгээс бол бид нүүрс угаах баяжуулах төслийг бол хэрэгжүүлж байгаа. Энэ хугацаагаар бол 24 оны 7 сард ашиглалтад орно. Энэ дээр бид нарт бас хөрөнгө санхүүгийн шаардлага байгаа. Ийм учраас бид ногдол ашиг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуултад асуултаа асууя.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Эрдэнэс тавантолгойд тогтоосон онцгой дэглэм дэглэмийг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүрэн дүүрэн дэмжиж байна. Эхлээд бол бид нар БЭТ буюу бүрэн эрхт төлөөлөгч томилж байхад бол бас шүүмжлэлтэй хандаж

байсан. Хэр зэрэг оновчтой шийдэл юм бэ гэж бас яриа хөөрөө нэлээн гарч байсан.

Тэгээд өнөөдрийн хүрсэн үр дүнг харахад бол Ганбат даргатай энд томилогдсон багийнхан бол хэрхэн сайн ажилласан нь бол их тодорхой байна л даа. Сая Шадар сайд Амарсайхан манай бүх бүгдээрэнг нь тоо баримтаар хэллээ. Компани дахь санхүүгийн нөхцөл сайжирсан байна, нүүрсний олборлолт тээвэрлэлтийн өртөг буурсан байна, Монгол Улс руу орж ирэх валютын урсгал нэмэгдсэн байна гээд үнэхээр бас энэ дэвшилттэй талууд байна.

Тэгээд мэдээж хэрэг энэ дэвшилттэй талуудыг цааш нь улам бататгах, тогтворжуулах шаардлага бий л дээ. Тийм учраас бол энэ дэглэмийг хугацааг сунгах шаардлагатай гэдэг ийм үндэслэлээр оруулж ирсэн гэж би ойлгож байгаа учраас бол дэмжиж байна.

Хоёрдугаарт миний хэлэх гэж байгаа зүйл бол манай Эрдэнэс тавантолгой ХК-ийнхан маань манай Сангийн яамны ТНБД Ганбатаар ахлуулсан бүрэн эрхт төлөөлөгчийн багийнхан маань зөвхөн энэ компанитай холбоотой, нүүрстэй холбоотой үйл ажиллагаа биш Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхны 180 сая мод тарих ТЭЗҮ батлуулсан байгууллага болж байна. Өнөөдрийн энэ цаг агаарын өөрчилж тийм ээ, энэ цөлжилт, салхи шуурга энэ бүхэн бол ер нь энэ мод тарих нь ямар тулгамдсан асуудал вэ гэдгийг бидэнд бэлхнээ харуулж байгаа юм.

Тийм учраас бол би бол та бүхэнд энэ чиглэлийн ажлыг бас давхар хийгээд явж байгаад бол талархаж байна. Тэр дундаа энэ ажлыг бас Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар 8 жил ажилласан бас төрийн ажлын туршилагатай Сауле сайд маань амжилттай удирдаад ингээд явж байгаад бол би та бүхэндээ ер нь энэ бүх

үйл ажиллагаанд чинь талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Асуултдаа орёе. Хамгийн гол нь бас та бүхнийг томилсон энэ асуудал бол компанид үүссэн сөрөг үр дагаврыг арилгахад чиглэсэн гэж. Ямар, ямар сөрөг үр дагаврууд ер нь энэ компани дээр голлон байсан бэ? Эдгээрийг одоо засаж залруулахад тулгамдаж байгаа асуудал юу байна. Улсын Их Хурлын гишүүд бид юу анхаарах вэ? Ямар асуудлыг та бүхэндээ шийдвэрлэж өгөх вэ? Энэ тал дээр 1 тодорхой хариулт өгөөч.

Түүнээс гадна хугацааг ямар хугацаагаар сунгаж байж та бүхний эхлүүлсэн энэ ажил үр дүнтэй, тогтвортой, цаашид хэвийн үйл ажиллагааг хангасан ийм нөхцөл байдал үүсэх вэ? Энийгээ та бүхэн хэрхэн үнэлж байгааг үнэлж байгаа вэ гэдэг асуудлыг та бүхнээсээ тодруулаад, тэгээд нэмж асуултаа тавья. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Хэн Ганбат дарга хариулах уу? Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

Ж.Ганбат: Засгийн газраас Эрдэнэс тавантолгой компани дээр онцгой дэглэм тогтоох үеийн асуудал бол санхүүгийн хувьд бол нийтдээ 1 урьдчилж орсон орлого нэртэй яах вэ дараа нь нүүрсний төлбөр нөхцөлтэй 582 сая ам.долларыг урьдчилаад олчихсон, урьдчилаад авчихсан. Энэ хүрээнд өр төлбөр үүсгэгчсэн. Хоёр дахь нь 450 сая ам.долларын урт хугацаат бондын өр төлбөр байсан. 2022 оны төсвөө 1.7 их наядын мөнгөн хөрөнгийн бол дутагдалтайгаар баталчихсан. Гэрээт олборлогчтой бол 123 тэрбум төгрөгийн өр үүсгэгчсэн асуудлууд бол бас амаргүй байсан.

Нөгөө талдаа бид энэ асуудлууд дээр бас 1 ноцтой хэд хэдэн юм байсан. Сонгон шалгаруулалтыг бол зарлахгүйгээр нууцын хэлбэрт оруулаад

иууд гэрээ байгуулдаг ийм асуудал бол нэлээн газар авчихсан ийм байдалтайгаар байсан. Сонгон шалгаруулалтад орсон ч гэсэн гэрээ байгуулахгүйгээр компаниудын тэр гэрээг байгуулахгүйгээр дараагийн үндсэн компаниудтайгаа гэрээг нь хадгалж үлдэх ийм бол алдаа дутагдалтай юмнууд бол байсан. Энэ асуудлыг бол бүгдийг нь ил тод болгож байгаа.

Ер нь нөгөө талдаа Эрдэнэс тавантолгой компани дээр бид ямар нэгэн байдлаар нууц гэдэг асуудал бол байхгүй. Бүх асуудлыг нь ил тод болгож байгаа. Ялангуяа гэрээт ажлууд болон сонгон шалгаруулалтын ажлуудыг бүгдийг нь ил тод нээлттэй, тендерийн зарчмаар бол ингэж явж байгаа. Тэгээд яах вэ мэдээж энэ дээр хугацаа орж ирж. Хамгийн гол асуудлууд энэ биржээр нүүрсээ ил тод арилжаалах гэдэг энэ асуудал өмнө нь бол борлуулалт нь бол далд хэлбэртэй байсан. Энэ нүүрс тойрсон асуудлууд гэдэг энэ асуудал үүсчихсэн байсан.

Тэгэхээр бид 7 сарын 1-нээс Биржийн хууль үйлчлээд эхэлнэ. Энэ дээр бид нүүрсээ энэ оны хувьд бол бид 30 хувиа биржээр арилжаалах ийм зорилт тавьж байгаа. Тэгээд дараа жилүүдэд эхлээд ер нь бүх борлуулж байгаа нүүрснүүдээ биржийн арилжаанд оруулчих. Энийг бол бид яаралтай хэвшүүлэх ийм бол шаардлага байна. Мэдээж 10 энэ компани 2011 онд анхныхаа экспортыг хийсэн. 12, 3 жилийн түүхтэй компани дандаа ам нөхцөлтэйгөөр нүүрсээ зарж ирсэн. Мэдээж ингээд хил нөхцөл рүү биржээр ил тод ингээд арилжихад манай гол худалдан авагч БНХАУ-ын худалдан авагч нар бас энэ дээр дасан зохицох асуудлууд байна. Энэ дээр ойлголцох асуудлууд байна. Ямар нэгэн саад бэрхшээлүүд байна. Ялангуяа бид нар хил нөхцөлөөр нүүрсээ арилжаатай холбоотой бид тээврээр өөрсдөө Ганц мод боомтоор хүргэж өгч байгаа.

Энэтэй холбогдуулан БНХАУ-ын худалдан авагч тал нөгөө ам нөхцөлөөр бол өөрсдөө тээврээ хариуцдаг байсан учраас тэр компаниудын бас асуудал давхар хөндөгдөж байгаа. Тэгэхээр бид энэ асуудал дээрээ хатуу байр суурьтай байж байгаад энэ биржийн арилжаагаа хэвшүүлэх нь л хамгийн чухал болчхоод байна. Биржээр бид нүүрсээ зараад хэвшчих юм бол нүүрс тойрсон далд үл ойлголцлын асуудал бүгд ил тод нээлттэй болно. Худалдан авагч нар нь бол ил болоод, ингээд ирчих. Нөгөө тал энэ талдаа бид Монгол Улсад бол бас энэ хил нөхцөлөөр зарсантай холбоотой нэмэлт орлого олох ийм шаардлага.

Хоёр дахь нь бид яг энэ компани дээр 12, 3 жилийн хугацаанд дандаа сорчилж ирж зарсан нүүрсээ. Дандаа сайн чанарын нүүрсээ зарж байсан. Бид үүнийг сорчлохгүйгээр бүх гаргаж байгаа бүтээгдэхүүнээ арилжъя гэдэг ийм бодлого бол тавьж байгаа. Энэтэй холбогдуулан нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийг бид яаралтай ашиглалтад оруулах ийм бол бодит бол шаардлага байна. Энэтэй холбогдуулан ноогдол ашигийн асуудал бас уялдаж байна. Бид энэ угаах үйлдвэрийг ашиглалтад оруулахад бол хөрөнгө мөнгөний хувьд бол бас шаардлага үүсэж байгаа. Тэгээд хугацаанд нь энийгээ оруулах юм бол жилд бид ядаж нэг арван сая тонн нүүрсээ угаагаад баяжуулаад зарах юм бол зарж байгаа үнэ дээрээсээ бид жараас ная ам.долларын орлого 1 тонноос олох ийм боломжууд бол бүрдэж байна.

Тэгэхдээ нэн яаралтай бид энд дахин хэлээд байгаа нь биржийн асуудлыг л бид маш яаралтай хэвшүүлэх, тэгээд нөгөө талдаа бид бас хил нөхцөлөөр хүргэж өгч байгаа тээврийн асуудлаа бас хэвшүүлэх бол ийм 2 асуудал дээр онцгой анхаарч ажиллах зайлиггүй шаардлага үүсэж байгаа.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Би тэр Байнгын хороон дээр 1 асууж байсан зүйлээсээ үргэлжлүүлээд зарим зүйлийг дахиад тодотгоод асууя. Эрдэнэс тавантолгой компанид аудит олон улсын аудит хийлгэх ёстой гэдэг байр суурь байнга л сонсогдож байсан. Одоогоор хийгдээгүй. Тэгэхдээ одоо 22 оны санхүүд аудит хийж байгаа Грөүд Файнэнс гэдэг компани 3 дахь жилдээ аудит хийж байгаа гэдэг мэдээлэл яригдсан. 3 дахь жилдээ.

Гэтэл тэр 20, 21 он, 19 он ер нь сүүлийн үед гарч байгаа тэр бүх хулгай зэлгий энэ том дүнтэй зүйлүүдийг чинь тэр бүгдэд аудит хийсэн компани одоо дахиад 3 дахиа хийж байгаа юм байна. Тэгээд өмнөх жилүүдийн аудитын тайлангуудад ямар зөрчил дутагдал ямар санал өгч байсан, яагаад энэ компанийг дахиад сунгаж үргэлжлүүлж ажиллах болсон бэ? Энийг хаанаас ишийдсэн бэ? Хамгийн гол нь тэр өмнөх аудитын дүгнэлтүүд дээр чинь ийм ноцтой зүйлүүд байхгүй. Бүх зүйл тайлан тооцоо, баланс асар сайхан байгаа тухай Ганхуяг захирал тайлан тавьдаг байсан. Тэгээд яагаад энэ аудит гэдэг чинь өөрөө өөрснөө сонгоод төрөө төрийн аудитаас магадгүй сонгоод ингээд үргэлжлүүлээд сонгоод яваад байхлаар нөгөө 1 булхай луйвар чинь дарагддаг, тэрийг дарагдуулж байсан компани чинь дахин хийгээд байгаа юм биш үү? Энэ дээр нэг мэдээлэл өгөөч?

Хоёрдугаарт нь бүрэн эрхт төлөөлөгч БЭТ томилно. Энэ нь онцгой нөхцөлийн үеийн гэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь онцгой нөхцөл дахиад тэрийг үргэлжлүүлнэ гэдэг чинь зарим хуулиудыг зүйл заалтуудыг хялбарчлах, тойрох, шуурхай ишийдвэр гаргахыг хүсэж байгаа байх. Тэр онцгой нөхцөл байдлын үеийн БЭТ-ийн дүрэм журмыг нь харахаар нэг ийм 7 нөхцөл байх шиг байна лээ. Бүтэц орон тоог өөрчлөх, ажлын цагийн хуваарь, цалин хөлс, худалдан авалтыг хянах, гэрээ хэлэлцээрийг шаардлагатай бол цуцлах энэ тэр гээд. Та нар яг энэ хуулийг нь аль зүйл заалт нь та нарт яг

БЭТ үргэлжлүүлэн ажиллах онцгой нөхцөл гэж үзэх. Тэгэхийн тулд энэ хуулийн аль зүйл заалт нь та нарт яг хэрэгцээ шаардлагатай болчхоод байгаа юм. Алин дээр нь яг ямар гэрээ хэлэлцээр хийхэд бизнесийн үйл ажиллагааг хэвийн явахад аль заалтад аль заалтыг нь ашиглах гэж байгаа юм бэ үргэлжлүүлэн?

Одоо байгаа хууль дүрмийн хүрээнд явах бололцоогүй болчхоод байгаа юм уу? Компанийн хууль, Төрийн өмчийн болоод худалдан авалтын тухай, Тендерийн хуулиуд бусад хуулиудтай холбоотойгоор ажил цаашаа явах боломжгүй болчхоод байна гэсэн гэж үзэж байгаа юу? Хэрвэв тийм бол аль зүйл заалтыг нь та нар ашиглах гээд байгаа юм бэ? Эдгээрт нь хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Түрүүн бас Сарангэрэл гишүүн 1 асуулт асуусан, хариултыг нь хэлээгүй өнгөрчих шиг боллоо. Ямар хугацаагаар сунгах гэж байгаа юм бэ гээд. Энэ бол Засгийн газарт эрх олгох тухай энэ хуулиар бол зайлшгүй шаардлагатай гэж үзвэл 1 удаа 6 сараар сунгана гэсэн ийм заалттай. Тийм учраас 1 л удаа сунгана. Гэхдээ 6 сарын хугацаатай гэж ойлгож болно. Цогтгэрэл гишүүний асуултад хэн хариулах вэ? Шадар сайд Амарсайхан хариулъя. Ажлын хэсгийнхэн нэмж хариулаарай дараа нь.

С.Амарсайхан: 1991 онд батлагдсан боловч өнөөдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 7, 8 хууль байгаа юм. Тэгээд тэр хуулийн 1 бол энэ Онцгой дэглэм тогтоох тухай хууль. Тэгэхээр Улсын Их Хурлаас зайлшгүй энэ хуулийг шинэчлэн баталтал энэ хууль баталсан тохиолдолд энэ хууль хүчин төгөлдөр бус болно. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бол бид бас хүчин төгөлдөр хууль мөрдөж явж байгаа Үндсэн хуульд заасны дагуу гэдгийг нэгдүгээрт тодорхойлоод хэлчихье.

Хоёрдугаарт Засгийн газар ер нь энэ олон нийтийн анхаарал татсан,

хардлага сэрдлэг дагуулсан, ялангуяа хууль зөрчсөн, авлигал хээл хахуультай холбоотой энэ экспортын үйл ажиллагаа, улсын эдийн засаг төсөв санхүү бүрдүүлэхтэй холбоотой өндөр ач холбогдол бүхий энэ төрийн өмчит ААН-үүдийн үйл ажиллагааг цаашид аудит дотоод хяналтаасаа эхлээд хөндлөнгийн, хараат бус, хэн нэгний нөлөөнд автахгүйгээр хийх ёстой гэдэг асуудал дээр онцгой ач холбогдол өгч байгаа. Тийм ч учраас олон улсын аудит оруул гэдэг үүрэг даалгаврыг өнгөрсөн хугацаанд өгсөн байгаа. Тэр өмнө нь аудит хийж байсан хяналт хийж байсан ААН ямар учраас яагаад өнөөдөр хүртэл бас үйл ажиллагаа явуулж байгаа хяналт хийж байгаа юм бэ гэдэг талаар Ганбат бүрэн эрхт төлөөлөгч тодорхой хариултыг нь өгчхөөрэй гэж.

Цаашидаа энэ хугацаа сунгах асуудал бол бид хуулийнхаа хүрээнд л ярина. 6 сар 1 удаа сунгана гэсэн энэ заалтын дагуу оруулж ирж байгаа. Энэ хугацаанд түрүүн хэлсэн олон улсын засаглал ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах, бүтэц зохион байгуулалт, тогтолцоог жигдрүүлтэл бид энэ хуулийн заалт хэрэгтэй байна. Өнгөрсөн хугацаанд бол дандаа хулгайтай, дандаа алдсан өмчтэй, хариуцлага сахилга бат алдсан асуудалтай, дотоод зохион байгуулалт, сая ярилаа үйлдвэрлэлийн олборлолтын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгох уулын ажлаасаа эхлээд олборлолт, тээвэрлэлт, тэгээд нүүрсийг дахин боловсруулж угаах, өртөг нэмсэн бүтээгдэхүүн болгох, орлого ашгийг нэмэгдүүлэх гэсэн ийм дотоод зохион байгуулалттай холбоотой асуудлууд хууль хяналтын байгууллагатай холбоотой асуудал дээр төвлөрсөн.

Одоо дахиад дараагийн 6 сар бол жинхэнэ хэний ч хардлага сэрдлэггүй, цаашид нээлттэй бөгөөд үр өгөөжтэй ийм мэргэшсэн түвшинд үйл ажиллагаа явуулах, хэвшүүлэх үйл ажиллагаа руу л орно гэсэн ийм зорилготой байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ганбат дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Асуултад нэмж хариулъя. Яах вэ Үндэсний аудитын газраас энэ аудитын компанийг сонгоод тэрнийх нь дагуу энэ аудитын компани гэрээний дагуу хийгээд явж байсан юм байна лээ. Засгийн газрын зүгээс бид нар бол 1 юмтай таны асуудалтай бол бид 100 хувь санал нэг байгаа нь ер нь энэ компани дээр бид Засгийн газрын зүгээс бол Эрдэнэс тавантолгой компанийн зүгээс бид олон улсын аудит хөндлөнгийн аудит оруулаад, яг энэ санхүүгийн үйл ажиллагаа болон ер нь бусад үйл ажиллагаанд нь аудит хийлгээд бид эхлэлийн цэгээ зөв тодорхойлчихоод ингээд цаашаа явах нь зөв юм гэдэг энэ байр сууриас бид олон улсын хөндлөнгийн аудит оруулахаар 2, 3 удаа бол нээлттэй сонгон шалгаруулалт бол зарласан.

Харамсалтай нь олон улсын аудитын компаниуд бас орохоосоо бас татгалзаж байна. Яах вэ тэр нь яг ид нөгөө нүүрсний гэх асуудал эд хурцаар яригдаж байсан үед уучлаарай 20, 21, 22 оны үйл ажиллагаанд бид бол орох бол боломжгүй байна гэдэг ийм асуудлыг бол удаа дараа илэрхийлсэн. Гэхдээ бид 1 олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 1 аудитын компанитай хэлцэл бол хийж байна. Энэ 1 үйл ажиллагаа нь 22 он дээр ядаж та нар ороод өгөөд энэ дээр нь дүгнэлт гаргаад, тэгээд үүнээсээ цаашаа бид ажлаа явуулах шаардлага байна гэдэг ийм асуудлууд бол тавьж байгаа.

Дараагийн тэр 1 үргэлжлүүлэх шаардлагын 1 шалтгаан нь уг нь энэ бирж болчихоод байгаа байхгүй юу. Бид үнэхээр яг энэ түүхэн цаг үедээ энэ Улсын Их Хурлаас батлагдсан энэ Биржийн хуулийн хүрээнд бид энэ уул уурхайн энэ бүтээгдэхүүнийг ил тод, нээлттэй арилжаалах асуудлыг зайлшгүй хэвшүүлэх шаардлагатай байгаа юм. Ингэж чадах юм бол энэ бид нүүрсийг нөгөө далд хэлбэрээр, ямар үнээр, хэн гэж хүн авна тодорхой

байгаад байхгүйгээр одоо Хөрөнгийн бирж дээр очоод харахад бол арилжааг бол бид долоо хоногт 2, 3 удаа хийж байна. Тэр бол нээлттэй. Энийгээ л хэвшүүлэх чухал болчхоод байгаа юм. Нөгөө талдаа нөгөө худалдан авагч тал маань олон жил 12, 3 жил ам нөхцөлтэй яваад ирчихсэн учраас энэ бол амаргүй байна, бэрхшээлүүд бол байнга гарч байна. Тээвэрлэлт дээр асуудал үүсэж байна. Ямар нэгэн байдлаар шалтаг шалтгаанууд хэлж байгаа учраас бид энийг бол хэвшүүлэхийн тулд бол жоохон хугацаа бол шаардлагатай байна гэдгийг ингэж бол нэмэлтээр хэлье.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургуулийн 12А, Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгддээ сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Би сая их тодорхой л асуулт асуусан л даа. Энэ аудитаар орж байгаа энэ Гроуд Файнанс гээд компани чинь саяын нүүрсний их хулгайн үеэр дүгнэлт гаргаад, зөрчилгүй гээд дүгнэлт гаргаад байсан компани байна шүү дээ. Аудитын компани. Яагаад энэ их шуугианы дараа энэ компани чинь яагаад дахин сонгогдчихоод байгаа юм бэ гэдэг л асуулт асуусан л даа. Тэрнээс бусад зүйл биш.

Дахиад хоёрдугаарт нь тэр онцгой нөхцөл БЭТ-тэй холбоотой асуудал чинь дахиад л одоо та тэр бусад зүйл заалтууд нь биш тэр онцгой нөхцөлийн, биржтэй холбоотой зүйлээр л та энийг сунгуулах гэж байгаа юм байна шүү дээ. Тэгвэл биржтэй холбоотой биржээр уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаална гэдэг чинь Их Хурлаар батлагдаад, Монгол Улсын хууль болоод гарчихсан биз дээ. Энэ хуулийг аваад ердийн ТӨК хууль хэрэгжүүлэхэд заавал онцгой нөхцөлтэй байж энэ хууль хэрэгждэг, БЭТ томилогдож байж хэрэгждэг. Тэгэхгүй бол Биржийн тухай

хууль чинь хэрэгжиж болохгүй ямар тийм хуулийн гацаа байгаа юм бэ энд? Тийм гацаа байхгүй шүү дээ энд. Энэ дээр 1 тайлбар.

Л.Мөнхбаатар: Энэ дээр нэг тодорхой хариултууд өгчих. Уул уурхайн биржийн тухай хууль чинь бол 7 сарын 1-нээс хэрэгжинэ биз дээ? Тийм ээ. Ганбат дарга хариулъя.

Ж.Ганбат: Би тэр аудитын компанитай энэ бол бид бол онцгой дэглэм 22 оны 10 сарын 26-нд тогтоогдсон, эхэлсэн хугацаа. Тэгэхэд энэ компани угаасаа аль хэдийн гэрээ байгуулчихсан. Энэ аудитын компани энэ дээр бас ажлаа эхэлчихсэн ийм байдалтай байсан. Нэгэнт сонгогдчихсон компани дээр бид тэр нь оны бараг тэр чинь 2/3-оос илүү хугацаа нь өнгөрчихсөн. Ер нь 10 сарын 26 гэдэг маань 22 оны 11, 12 сард л ер нь бид 2 сар үйл ажиллагаа явуулсан л даа. Тэгэхээр энэ утгаараа энэ компани үргэлжилсэн. Бид харин олон улсын нэр хүнд бүхий аудитын компанийг оруулах талаар Засгийн газрын шийдвэрийн дагуу оруулах гэж бол ингэж ажиллаж байгаа. Одоо энийг бол ойрын үед тэр нэг хэлцлээ хийгээд, ойлголцчих юм бол энэ олон улсын аудитын компанийг үйл ажиллагаа юу оруулах асуудлыг яаралтай шийдвэрлээд явах бүрэн бололцоотой юм гэдэг ийм л асуудал болж байна.

Би саяын тэр биржтэй холбоотой юман дээр яах вэ би бодит мэдээллийг л өгөөд байгаа нь үнэхээр 12, 3 жил аман нөхцөлөөр явчихсан БНХАУ-ын худалдан авагч нар энүүнийг бол амар хүлээн зөвшөөрөхгүй байсан. Энэ бол 7 сарын 1 туршилтын арилжаа. Бид нийтдээ сая эхний 1 дүгээр улиралд 416000 тонн нүүрс, сая өнгөрсөн 4 сарын 14-ний өдөр бид нар 3 сар 3 арилжаагаар 200 гаруй мянган тонн нүүрс бол арилжсан.

Гэхдээ энэ дээр бол нэлээн амаргүй байна. Хятадууд бол нөгөө худалдан авагч нар бол эргээд нөгөө ам

нөхцөлөө бол санагалзаж байна. Ямар нэгэн байдлаар шалтаг шалтгаан хэлж биржийн нүүрсийг гацаах ийм юмнууд бол байнга үүсэж байгаа юм. Энэ талаар бол байнга цахимаар болон биеэр худалдан авагч нартай бол байнгын уулзаж байгаа. Мэдээж энэ бол бас нөгөө бизнесийн зарчмаар нөгөө олон жил манай ам нөхцөлтэй хямд нүүрсээр бизнес хийгээд сурчихсан хүмүүс бол энийгээ тавихгүй байна л даа. Ялангуяа Баяннуур аймгийнхны хувьд бол манай яг Өмнөговийн Ганц мод боомт гээд яг тэр боомт дээр байрладаг аймаг. Энд энэ аймгийн зүгээс яг манай нүүрсээр бол олон жил бизнес хийчихсэн, дагасан тээврийн компаниуд нь хөгжчихсэн маш олон тооны машинууд байна. Угаах үйлдвэрүүд гол төвлөрөл нь тэндээ байна. Эд нарын ашиг сонирхол бас нөгөө талдаа давамгайлах байдалтай янз бүрийн байдлаар манай биржийн үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлөх ийм байдал бол яг ний нуугүй хэлэхэд бол маш хүчтэй илэрхийлж байгаа.

Өнгөрсөн долоо хоногт хүртэл биржийн нүүрсийг буцаах хүртэл ийм тохиолдлууд бол үүсгэж байна. Хил нөхцөл гэдгийг хилийн наад талд Гацуун сухайт чингэлэг терминал Цагаан хадан дээрээс нүүрсийг чинь авъя гэдэг асуудлуудыг маш хүчтэй илэрхийлж байна. Бид өөрсдөө татан авалтаа хийнэ гэдэг ийм байдлаар бол худалдан авагч нарын зүгээс бол байр суурийг бол ингээж удаа дараа илэрхийлж бас энэ бүгдэд нь бид бол аль болох л бид нар хилийн цаад талд хүргэж өгөх, улам илүү үнэ хүргэж ингээж Монгол улсад орж ирэх валютын орох урсгалыг нэмэгдүүлэхийн төлөө бол бид үнэхээр 2, 3, 4 сард бол ингээж үнэхээр яг энэ дээр бол шөнө өдөргүй бол ажилласан нь бол бодит үнэн л дээ.

Л.Мөнхбаатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Өнөөдөр энэ Эрдэнэс тавантолгойн бүрэн эрхт төлөөлөгчийг

сонгох асуудал Улсын Их Хурал дээр орж ирж хэлэлцэгдэж байна. Энэ Эрдэнэс тавантолгойтой холбоотой асуудал ер нь энэ төрийн өмчийн компани болох Эрдэнэт, Төмөр зам гээд л энэ асуудлуудын засаглалыг сайжруулах асуудал бид өнөөдөр ярих ёстой л гэж ойлгож байгаа. Өнөөдөр тэр хулгай луйвар гээд л, гэмт хэрэг л гээд л энэ зөндөө юмыг бид сүүлийн 3 жил ярьсан. Энэ асуудал амь бөхтэй оршиж байсан. Энийг таслан зогсоохын төлөө төр, хууль хүчний байгууллага, Засгийн газар ажиллаж байгаа. Энэтэй санал нэг байгаа.

Бид өнөөдөр энэ хулгай луйвар энд ажиллаж байгаа энэ бүрэн эрхт төлөөлөгч бусад хүмүүсийг шүүмжлэх амар байна. Энэ энүүн шиг амар юм байхгүй, өө эрэх шиг амар юм байхгүй. Тэгэхдээ бид ард түмнийхээ амьдрал Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн асуудал дээр бид засаглалын асуудал дээр бид энэ төрийн эрх барих дээд байгууллага дэмжлэг өгч ажиллах ёстой гэж бодож байгаа. Ковидын хүнд он жилүүдэд Эрдэнэт гэдэг газар бүх цахилгаан эрчим хүч бүх юмыг шийдэж байсан. Төмөр замын тэр 16000 ажилчид өнөөдөр Хэрлэн гээд даргыг бас их муулдаг. Тэр хүнд цаг үед өнөөдөр Монгол Улсын бүх ачаа тээврийн шийдлийг бүгдийг нь шийдэж байсан. Эрдэнэс тавантолгой гээд энэ компани Монгол Улсын тэр эдийн засгийн хүнд үе цаг үед Монгол Улсын эдийн засгийн асуудлыг шийдэж байсан. Энд буруу зүйл байсан энд бид дүгнэлт хийж байгаа.

Тэгэхээр энэ БЭТ гэдэг ч юм уу энэ Засгийн газрын төлөөлөгч гэдэг энийг цаашидаа явуулаад, энэ алдаа завхралын дараа үеийн эдийн засгийн бодлогыг бид дэмжиж, зөв шийдэл гаргаж, улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэх, экспортыг дэмжих энэ менежментийн багийг бас ажиллуулаад үр дүнг нь харах нь Монгол Улсын эрх ашиг байгаа гэж харж байгаа. Энд маш их хүнд бэрхшээл байгаа. Тэр хулгай луйварчид гээд хүмүүсийн бүлэглэл, нам дотор байгаа

бүлэглэл, гадна дотнын энэ шунахай сэдэлтэй хүмүүс, эрх ашиг нь хохирсон хүмүүс, гадна дотнын нэн ялангуяа тэр Баяннуур аймаг гээд Хятадын нүүрсний эдийн засгийн том бүлэглэл байгаа шүү дээ. Үүнийг хэдэн зуун мянган машин техник ороод ирчихсэн, олон эрх ашиг нь хөндөгдсөн энэ асуудал дээр энэ БЭТ гээд юмаа бид Засгийн газрынхаа бүрэн эрхт төлөөлөгчийг дэмжихгүйгээр бид нар хаашаа явах юм. Юм шүүмжлэх амар. Алдаа завхралыг гэдэг нэрийн дор үүнийг гацаах амархан.

Харин ч өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллага энэ хүмүүсийн энэ үйл ажиллагааг дэмжлэг үзүүлээд, хууль, эрх зүйн орчин нь бусад нөхцөлийг нь дэмжиж ажиллах нь Монгол Улсын эрх ашиг байгаа юм. Тэрнээс биш энд бид нар тэр хэдэн оны хууль байна уу, тэдэн оны БНМАУ хууль байна уу, тэдэн оны хууль байна уу гэдэг бол нэг их сонин биш. Эцсийн үр дүндээ энэ Монгол Улсын Эрдэнэс тавантолгой гэдэг Монгол Улсын эдийн засгийн бүх зүйлийг шийддэг энэ компанийн засаглал сайжирч, экспорт, зөв менежмент явахад л бид өнөөдөр дэмжлэг үзүүлэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа юм. Надад асуулт байхгүй. Ингээд энэ энэ асуудлыг цаашдаа бид 6 сарын дараа үр дүнг нь харна. Зөв юм байсан бол бид баяр хүргэнэ, муу юм байсан бол энд хариуцлага ярих л асуудал байна шүү дээ. Тэрнээс биш өнөөдөр 1 компанийн захирал тэрнийг тавина энийг тавина гэдэг тэр бүлэглэлүүдийн асуудал зодоон.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүн дэмжиж тогтоолын төслийг дэмжиж үг хэллээ. Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Өнөөдөр бүрэн эрхт төлөөлөгчийг сунгах тухай ярьж байна л даа. Ер нь зүгээр засаг эрх мэдэлтэй энэ дарга нар маань зүгээр л томилоод ажлыг нь хийлгээд хянаад явчих энэ боломжийг заавал ингээд сүржин нэртэй БЭТ, тэгээд 92 оны Үндсэн хуулиас өмнөх

хуулийг ашиглаж тэр бүрэн эрхт төлөөлөгчийг томилж ингээд 1 ийм улс төрийн шоу нь хэтрээд байгаа юм. Тэр зүгээр л ажлаа хийх ёстой л доо. Энэ Засгийн газар ажлаа хий. Үнэхээр хулгайч нараа олчихсон гээд байгаа, маш том алдагдлуудыг бий болгочихсон байна гээд, оффтейк гэрээ гээд 19 их наядаар нь гэрээ хийчихсэн байна гээд олон асуудлуудыг ингээд засаж залруулна гээд БЭТ томилчихоод байгаа юм. Тэгээд БЭТ-ийг яагаад сунгах гээд байгаа гэхээр БЭТ дараагийн засаглалын хэлбэр компанийг цааш нь яаж авч явах вэ, менежментийг нь яаж авч явах вэ, олон нийтийн хяналтыг яаж тогтоох вэ гээд энэ асуудлыг шийдтэл аягүй бол ажиллах байлгүй дээ.

Өнөөдрийн одоо явж байгаа үйл ажиллагаанд чинь өмнө нь ард түмэн итгэдэггүй байсан, өнөөдөр ч итгэхгүй байгаа. Хэрэв олон нийтийн оролцоог оруулж ирэхгүй л бол эргээд л итгэхгүй. Тийм учраас энэ хүртэл та бүхэн ажиллаж байгаа байх л даа. Тэгээд 3 асуулт асуучихъя. Нэгд нь тэр оффтейк гэрээнүүд гэрээний дагуу тэр нүүрсээ нийлүүлээд хэвийн явж байна уу, зогссон гэрээ байгаа юу нэг.

Хоёрт нь өнгөрсөн цаг хугацаанд 7 их наядын худалдан авалт хийгдсэн энэ их алдаатай мадагтай байсан гээд ярьдаг. Энэ худалдан авалтууд дотроос хамгийн алдаатай томоохон хохирол үзүүлсэн 3 гэрээг та 1 сайхан хэлээд тайлбарлаад өгөөч. Тэгээд тэр яаж засаж залруулсан талаар.

Гурав дахь нь гаалийн хяналтын талбай дээр Эрдэнэс тавантолгойн нүүрс байгаа. Тэгээд тэрэн дээрээ яг тодорхойгүй тоотой байсан. Энэ дээрээ та нар тооллого дүгнэлт хийгээд, эцэслээд гаргасан уу? Ер нь Эрдэнэс тавантолгойгоос хэдий хэмжээний тонн нүүрс хулгайд алдагдчихсан байна вэ? Олборлосон нүүрснээс чинь. Энийгээ та бүхэн гаргасан уу БЭТ-хөн. Тэвэр дээр мэдээж түрүүний ярьдаг тэр богинын тэвэр гэдэг асуудал хүртэл байна уу,

байхгүй юу? Яг тэр биржээр зарсан нөхцөлөөр чинь бүх үйл ажиллагаа хэцүү байна л гэж байна. Одоо шууд тээвэр хийдэг зарчим чинь үйлчилж эхэлсэн үү? Хэдэн тонн нүүрс өнөөдрийн байдлаар шууд тээврээр хил нөхцөлтэйгөөр өнөөдөр зарчхаад байна вэ гэсэн ийм асуудал байна.

Эцэст нь 1 асуудал байгаа юм. Тэр менежментийн асуудал олон нийтийн оролцоог хангах, нээлттэй болгох гээд энэ асуудлууд дээр ЗГ яаралтай шийдлээ гаргамаар байна. Саяхан тэр Хууль зүйн сайд чинь олон нийттэй уулзахдаа Эрдэнэс тавантолгойн асуудлыг шар толгойтой хүмүүс удирдах гэж байгаа гээд яриад явж байна лээ л дээ. Тэр шар толгойтой гэж ямар хүмүүс байна вэ? Энэ дээрээ та бүхэн асуудлаа гаргачихсан юм уу? Ийм асуудлууд байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүний асуултад Шадар сайд Амарсайхан хариулъя. Нэмээд ажлын хэсэг хариулж болно шүү. Амарсайхан Шадар сайдын микрофон өгөөрэй.

С.Амарсайхан: Жишээ нь БЭТ тогтоосноос хойш бол экспорттой холбоотой улсын төсөвт төвлөрүүлэх татвар хураамж, тэгээд бусад төлбөр тооцоонууд бол 1.6 дахин нэмэгдсэн байгаа юм. Өнөөдрийн байдлаар хэдийгээр эдийн засаг сэргэх хандлагатай байгаа ч гэсэн бүрэн тогтворжоогүй байна. Эдийн засгийн нөхцөл байдал бас сайнгүй хэвээр байгаа. Нүүрсний зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж байна. Үнэ хэдийгээр нэмэгдэж байгаа ч гэсэн бас хангалт нийлүүлэлттэй холбоотой зохион байгуулах, сайжруулах ажлууд бий. БЭТ-ын эрх мэдлийг сунгаснаар Засгийн газар ямар нэгэн давуу эрх олж эсвэл хэн нэгэнд давуу эрх олгох гээд байгаа асуудал биш. Яг Ганибал гишүүний хэлдэг энэ менежментийг сайжруулах, урт хугацаанд тогтвортой, ил тод, үр өгөөжтэй ажиллах ийм бүтэц суурийг оновчтой бий болгоход цаг хугацаа

хэрэгтэй байна гэж байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт ЭХХШТХ-ийн дагуу хэрэг үүссэн мөрдөн байцаалтын шатад байгаа, шүүхэд шилжиж байгаа олон хэргүүд бий. Тухайлбал эрүүгийн бас хэрэг 45 хэрэг байна. Үүнээс зөвхөн 4 нь шүүхэд шилжсэн байгаа. Бусад хэргүүд нь олон 10 холбогдогчтой, мянга гаруй сэжигтэн холбогдогчтой ийм хэргүүдийг хянан шалгах ажлууд өнөөдөр хүртэл хууль хяналтын байгууллагууд дээр үргэлжилж байна. Эдгээртэй холбоотой мэдээ мэдээллийг гаргаж өгөхөөс эхлээд, нягтлах, түргэн шуурхай зохион байгуулах ажлууд бас энэ Тавантолгой компани дээр хийгдэж байгаа.

Гуравдугаарт бол энэ компанийн үйл ажиллагааг илүү өгөөжтэй явуулах, цаашидаа тогтвортой явуулахад энэ онцгой дэглэмийг үргэлжлүүлж салбар хоорондын уялдааг хангах, хууль дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах, үйл ажиллагааны хяналтыг илүү чангатгах, сахилга батыг дээшлүүлэх, нэгдсэн горимд оруулах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа юм. Бусад асуудлаар Ганбат дарга өөрөө нэмээд хариулчихъя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Эхний асуудал оффтейк гэрээтэй холбоотой ерөнхийдөө 4 оффтейк гэрээ дотроо 38 дэд гэрээтэй ингээд бол байсан. Энэ бол дандаа нүүрсээр төлбөрийг барагдуулах ийм нөхцөлтэй гэрээнүүд байсан. Үүнээс энэ бол дандаа ам нөхцөлтэй гэрээнүүд шүү дээ. Үүнийг бол тэгээд, дээрээс нь үнийн хөнгөлөлтийн асуудлууд яригдаж байгаа. Энэ нэг асуудлуудыг гэрээнийх нь хугацаа дуусгавар болснуудыг нь би цаашаа сунгахгүйгээр дуусгавар болгочихсон. Тавантолгой Гашуун сухайт төмөр зам дээр яг 1 гэрээ байна. Энэ гэрээний хугацаа бол нүүрснийх нь үлдэгдэл хэмжээ нь 4.3 сая тонн, гэрээнийх нь

хугацаа 24 оны 12 сард 12 сарын 31-нд дуусна. Энэ Тавантолгой Гашиун сухайт төмөр замтай холбоотой нүүрсний энэ 1 гэрээний асуудал үргэлжлээд бол явж байгаа.

Богдхаан төмөр зам дээр 9 гэрээ байсан. 9 дэд гэрээ байсан үүнийг бол бүрэн зогсоосон. Нүүрс баяжуулах үйлдвэр дээр 1 гэрээ байгаа. Энийг бол 90 хувь нь нүүрсээр, 10 хувь нь мөнгөөр төлбөрийг нь хийх байсан үүнийг бид 90 хувийг нь бууруулах байдлаар бол хэлцэл хийгээд, энийг бол ойлголцоод, энэ дээр бол баяжуулах үйлдвэр нь явж байгаа. Газрын тосны хийн хоолой дээр мөн бас нүүрсээр бол төлбөрөө хийх гээд 1 гэрээ гээд ингээд явж байгаа. Тэгэхээр яг бол оффтейк гэрээтэй холбоотой нийтдээ яг Тавантолгой Гашиун Сухайт төмөр зам дээр 1 гэрээ, нүүрс баяжуулах үйлдвэр, газрын тосны хийн хоолой дээр 1 1 гэрээнүүд бол хэрэгжээд бол явж байгаа.

Худалдан авалттай холбоотой хамгийн ноцтой асуудал бол тендер зарлахгүйгээр нөгөө тэр төсөл арга хэмжээгээ нууцад хамруулаад шууд гэрээ хийчихдэг ийм асуудалтай байсан. Энэ дээр хамгийн эхний асуудал бол бид тэр далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой геологи хайгуул өрөмдлөгийн асуудал дээр нууцад хамааруулж байгаад, гэрээг нь шууд байгуулаад үүн дээр яг 10 сарын 26-нд онцгой дэглэм тогтоосны 2 хоногийн дараа бол 70 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын урьдчилгаа төлбөр болох 20 тэрбум төгрөгийг ямар нэгэн баталгаа аваагүйгээр авах ийм бол оролдлого гарсантай холбогдуулан энэтэй нийт 5 ажилтныг нь бол ажлаас чөлөөлөөд, АТГ шалгуулахаар ингээд өгчихсөн.

Дараагийн 1 асуудал нь тоног төхөөрөмжийг ингээд худалдан авах ийм тендер зарлаад гэрээ байгуулчихсан. Энэ дээр нийтдээ 1.2 их наядын төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийг олборлолтын үйл ажиллагаагаа өөрсдөө хийнэ гэдэг ийм байдалтайгаар тендер

зарлаад 900 гаруй тэрбум, 930 хэдэн тэрбум төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийн тендерийг 1 компанид өгсөн. Энэ нь бол гэрээ нь байгуулагдаад юм нь нийлүүлж эхлээд сая он гараад эхнийх нь техникүүд ирсэн. Бид хүлээж авах шаардлага тэр чинь бүрэн бүтэн байдал болон манай тавьсан шаардлагуудын нөхцөл байдлыг үзсэн. Энэ компанийн эхний тендер зарлахад тавьсан шаардлагуудыг хангахгүй юм байна гэдэг байдлаар энэ буцаахаар бол ингээд үүсчихсэн.

Нөгөө нөгөө талдаа энэ 900 гаруй тэрбум төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг бид ямар байдлаар ашиглахаар тооцсон юм бэ гээд тооцоог нь нягтлаад үзэхээр энэ ингээд зайлигүй шаардлагатай биш гэдэг нөхцөл байдал үүсчихсэн. Олборлолт дээр нь угаасаа хувийн хэвшлийнхэн хөрс бол олборлолт дээр нь явж байгаа. Энэ компани өөрсдөө олборлолтоо хийх шаардлага байхгүй. Яг олборлолт дээр энэ тоног төхөөрөмжөөр нь олборлолтоо хийгээд явсан тохиолдолд өртөг нь өндөр гараад эхэлчихсэн, алдагдалтай. Тэгэхээр бид үүнийг яах вэ гэдэг жишээ нь ийм асуудал байна.

Гурав дахь асуудал нь даатгалтай холбоотойгоор Эрдэнэс тавантолгой компани өөрсдөө бас үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжөө даатгуулчихсан. Даатгалын тендерт Бодь даатгал гэж компани ялчихсан. Гэтэл тэр компанитай ямар ч шалтгаангүйгээр гэрээг нь байгуулахгүй байж байгаад өмнөх компанийнх нь талд өөрөөр хэлбэл үргэлжлүүлэх нөхцөл байдлаар оруулчхаж байгаа юм. Ийм ингээд ноцтой ийм асуудлууд үүсээд байгаа учраас бид бол энэ дээр ямар нэгэн худалдан авалттай холбоотой бүх юмыг нь нээлттэй ил тод сонгон шалгаруулах ёстой гэдэг ямар нэгэн нууцын зэрэглэлд хамаарахгүйгээр явах.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах вэ нэмж хариулах уу? Гүйцээгээд хариулчихъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Энэ ер нь бол яах вэ тэр одоо нүүрс дээр ийм юм болоод байгаа. Уурхай дээр овоолго олборлоод гаргасан нүүрс дээр бол хэмжилт хийгээд баталгаажуулж байна. Энэ намайг эрдэнэ, Эрдэнэс тавантолгой компани дээр онцгой дэглэм тогтоох үед уурхай дээр 7.3 сая тонн нүүрсний овоолго байсан. Энэнээс ингээд ам нөхцөлтэй гэрээнүүд Цагаан хад руу явж байна. Цагаан хаднаас цаашаа дамжаад хил гарч байгаа. Гэтэл энэ хоорондын ингээд зөрөө үүсдэг. Гэхдээ энэ хоргодол гэдэг байдлаар яваад байна. Нүүрс өөрөө ингээд тээвэрлээд явахад бас хоргоддог юм байна. Салхинд тэнд очоод буулгахад бол хоргоддог.

Тэгэхээр бид ямар асуудлыг асуудал тавьж, Засгийн газрын болон холбогдох төрийн байгууллагуудад тавьж байгаа гэхээр энэ энэ хэвийн хорогдлын талаар норм стандартыг баталж өгөөч гэдэг юм ярьж байгаа юм. Яг энэ дээр одоо Эрдэнэс тавантолгой компанийг уурхайгаас Цагаан хад болон хил хүртэл тээвэрлэхэд ямар хэмжээний хорогдол энэ дээр гардаг юм уу, гардаггүй юм уу гэдгийг компани өөрсдөө бол тодорхойлж байна. Энийг баталгаажуулах шаардлагатай байна. Тэгэхгүй бол энэ нүүрсний зөрөө гэдэг дутах гэдэг асуудал энэ хэвийн хорогдол гэдэг асуудал дээр бол үүсээд байгаа.

Нөгөө талдаа яг таны хэлж байгаатай бид бүх юмыг тоолж байна, баталгаажуулж байгаа. Яг олборлож байгаа нүүрс нь хэд юм, цаашаа тээвэрлэхэд ингээд энэ бүгдийг баталгаажуулах. Мөн энэ дээр ямар нэгэн зөрөө үүсэхгүй байх, зөрөө үүссэн тохиолдолд тэр нь хорогдол гэдэг юмаа яаж тооцох вэ гэдгийг нь баталгаажуулдаг, хэмждэг ийм байдлаар бүх юмнуудыг нь бол зохион байгуулаад бол ажиллаж байгаа.

Нөгөө талдаа яах вэ ер нь ингээд Тавантолгойн бүлэг ордтой холбоотой овоолгын асуудлууд бас жоохон асуудалтай юм байна лээ. Жишээ нь орон нутгийн Тавантолгой нөгөө овоолсон шороогоо манайд жишээ нь нүүрстэй талбай дээр овоолго үүсгэчихсэн. Яг тэр нь газар дээр нь үүсгээд тэгэхээс өөр аргагүй. Гэхдээ одоо тэр шороог нь бид зайлуулж байж доорх нь нүүрсийг нь жишээ нь олборлох нөхцөл байдал орж байгаа учраас орон нутгийн Тавантолгой дээр энэ асуудлаа та нар бас холдуулаач гэдэг ийм асуудлыг тавьж байгаа. Ер нь энэ нэг энэ 3 компанийн бас үйл ажиллагаа нь уялдах, зохион байгуулах ийм асуудлуудыг бол бид зайлиггүй тавихаас өөр аргагүй ийм нөхцөл байдалтай юм байна лээ. Уялдааг нь сайжруулах.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургуулийн 12В, Г ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Тилеуханы Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Монгол Улсын Засгийн газар бол энэ Монгол Улсын өмч ард иргэдийн өмч энэ Эрдэнэс тавантолгой гэдэг компани дээр асуудал даамжраад гэмт хэргийн шинж чанартай ард иргэдийн авах ёстой байсан боломжийг хулгай хийсэн, Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын өмчид бүдүүлгээр хайр гамгүй хандаж байсан учраас бүрэн эрхт төлөөлөгчийг томилуулан ажиллаж байгаа. Өчигдөрхөн Эдийн засгийн байнгын хороо болоод Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаас бүрэн эрхт төлөөлөгчийг сунгаж ажиллуулъя. Монгол Улсын Засгийн газар хяналт тавих ажлаа үргэлжлүүлбэ гээд 6 сарын хугацаагаар сунгах асуудлыг оруулж ирж байгаа. Миний хувьд бол дэмжиж байгаа.

Энэ Монгол Улсын өмч хөрөнгө ард иргэдийн өмч хөрөнгөд Монгол Улсын Засгийн газар л хяналт тавьж эзэн болохгүй бол өөр хэн эзэн болох вэ. Бүрэн эрхт төлөөлөгчийг сунгалаа тавилаа гээд буруу ойлголттой байдаг юм уу, дутуу дулимаг ойлголттой шүүмжлээд байж болохгүй. Монголын ард түмэн бүгдээрээ л харсан. Эрдэнэс тавантолгой компани дээр яаж найрлаж байсныг, сүүлдээ энэ чинь тэнд ажиллаж байсан хүмүүс хэрэгт очоод л зүгээр ажилд томилогдоод очдог хэрэгт ороод л гарч байсан тохиолдол их байсан шүү дээ. Тийм учраас энэ бүрэн эрхт төлөөлөгч томилогдож байгаа дээр бол бухимдаад байх явдал бол ерөөсөө байхгүй. Монгол Улсын Засгийн газар хийх ёстой ажлаа л хийж байгаа гэж.

Эрдэнэс тавантолгой ХК дээр онцгой дэглэм тогтоосонтой зэрэгцээд үндсэндээ Монгол Улс маань түүхэндээ анх удаа уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр худалдаалах борлуулах ажлыг эхлүүлсэн, амжилттай явж байгаа. Үүний үр дүнд өнөөдөр валютын ханиш тодорхой хэмжээнд бууж байгаа. Төгрөгийн ханиш чангарч байгаа. Дээрээс нь валютын орох урсгал бол нэмэгдсэн. Тодорхой хэмжээнд ашигтай ажиллаад эхэлж болж байгаа. Энэ маань юуг харуулж байна вэ гэхээр тухайн Эрдэнэс тавантолгой буюу ганцхан Эрдэнэс тавантолгой ч биш ер нь энэ ТӨК-удын засаглалын хяналтыг сайжруулах шаардлагатай юм байна гэдгийг бол Эрдэнэс тавантолгой компанийн жишээ тов тодорхой харуулсан л даа.

Тийм учраас зөвхөн Эрдэнэс тавантолгой гэхээс илүүтэй өөр цаана нь байгаа ТӨК-удыг цэгцлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газар бол зоригтой бариад ажиллаад эхэлж байгаа. Тийм учраас эдгээр ийм зөв зүйтэй асуудлуудыг бид нар дэмжээд ажиллах ёстой гэж. Эрдэнэс тавантолгой компани дээр цэгцлэх шаардлагатай янзлах ажлууд бол маш их бий. 2, 3-хан асуулт байна. Ер нь зайлиггүй хийгдэх ёстой бүтээн

байгуулалтын ажлыг Эрдэнэс тавантолгой компанийн ашгаар цаашаа гүйцээж хийх шаардлагатай ажлууд надад бол харагдаад байгаа юм.

Нэгдүгээрт, баяжуулах үйлдвэрийг яаралтай барих хэрэгтэй. Бид нар өнөөдөр 170, 80 доллароор нүүрсээ борлуулаад байж байгаа. Цаашаа угаагаад байдаг юм уу, баяжуулаад гаргах юм бол энэнээс илүү их ашиг олох бололцоо бий. Яах вэ зарим хүмүүс бол хэлдэг. Ноогдол ашгаа өгчихвөл яасан юм бэ олсон ашгаараа гэж. Энэний эсрэг бол би байдаг юм тодорхой хувийг нь бид нар бүтээн байгуулалтаа хийх ёстой мөнгөө хийгээд, илүү ирээдүйд олох ашгаа нэмэгдүүлэх ёстой. Тийм учраас энэ хүрээнд бүтээн байгуулалтын ажлууд яг ямар, ямар ажлууд хийгдэх юм. Үүн дотроос баяжуулах үйлдвэрийн ажлуудыг нэгдүгээрт барьж авах уу? Одоо танд дахиад хагас жилийн хугацаа байна. Тодорхой хэмжээний бас цэгцлээд бас нэг голдиролд нь оруулчих хугацаа гэж харж байгаа. Тийм учраас баяжуулах үйлдвэрийнхээ ажлыг гүйцээж хийх үү?

Тэгээд цаашаа гарч байгаа та нэг дөчөөд километр зам байх ёстой засмал замын асуудал гэх зэрэг энэ бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх, олох, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг бол зайлиггүй хийх ёстой гэж бодож байгаа. Танд энийг хийх бодол бий юу? Өмнө нь бол байсан. Хувьцаа эзэмшигчдээсээ байдаг юм уу, зохих хүмүүсээсээ зөвшөөрөл авахгүй маш олон хэрэгтэй, хэрэггүй хөрөнгө оруулалтуудыг улсын хөрөнгийг хайр гамгүй ашиглаж байсан. Тийм учраас саяын миний асуусан асуулт дээр цаашидаа хийгдэх бүтээн байгуулалтуудынхаа ажлуудаар ажлынхаа талаар 1 товчхон танилцуулаач гэж ганцхан асуулт байна даа.

Л.Мөнхбаатар: Аубакир гишүүний асуултад хариулъя. Ганбат

дарга ажлын хэсгийн 80 дугаар микрофон.

Ж.Ганбат: Эрдэнэс тавантолгой компани дээр нийтдээ 11 төсөл хэрэгжиж байгаа. Нийт 4.9 тэрбум ам.долларын төсөвт өртөгтэй. Үүнээс 1.5 тэрбум ам.долларыг нь санхүүжүүлчихсэн ийм байж байгаа. Үүнээс яах вэ Богдхаант төмөр замыг бол зогсоохсон байгаа. Энэ 11 төслөөс яг Эрдэнэс тавантолгой компани дээр зайлиггүй бид ишийдвэрлэх нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл байгаа энэ бол гэрээнийхээ хугацаагаар 24 оны 7 сард ашиглалтад орох ийм шаардлага байгаа. Энэ дээр нийтдээ бид 335.4 сая ам.долларын төсөвт өртөгтэй, одоо ажил нь 30 гаруй хувьтай явж байгаа ийм байдалтай байгаа. Энийг бид зайлиггүй дуусгах ёстой байх.

Мөн энэ баяжуулах үйлдвэртэй холбоотой загийн усны хоолойн гүний ус ашиглах төсөл гээд энэ ерөнхийдөө маш амжилттай явж байгаа. Гэрээнийхээ хугацааг энэ оны 9 сард дуусна. Ингээд бид бол энэ баяжуулах үйлдвэр нь 10 сая тонн нүүрс бол угааж баяжуулах хүчин чадалтай ийм үйлдвэр байгаа. Энийг бол бид зайлиггүй одоо 1 хоногийн өмнө ч гэсэн дуусгаж байж, бид нүүрсийг илүү үнэ хүргэх бол ийм шаардлага байна. Нөгөө талдаа бид Тавантолгой Гаишуун сүхайтын энэ төмөр замыг холбох асуудал, мөн Хангийн төмөр замыг холбох энэ төмөр замуудын холболтыг нэн яаралтай бид хийж дуусгаж байж, нүүрсийг бид илүү цаашаа эцсийн хэрэглэгчид хүргэж, үнэ өргөж зарах энэ асуудалд зайлиггүй шаардлага үүсээд байна.

Мөн энэ уурхай дээр энэ баяжуулах үйлдвэрүүд нүүрсээ зөөх болон уурхай дээр бид конверын системийг яаралтай үүнийг нэвтрүүлэх ёстой. Одоо яг байгаа нөхцөлөөрөө авто тээврээр энэ нүүрсийг угаах үйлдвэр рүү зөөгөөд ингэх тохиолдолд 1 тонн нүүрсийг тээвэрлээд хүргэхэд 24.3 мянган төгрөгөөр тээвэрлэхээр болж

байгаа. Конверын систем нэвтрүүлэх юм бол ердөө энэ маань 3400 төгрөгийн өртгөөр гээд буюу энэ дээр бараг бид нарт 10 дахин бага ийм хямд зардал үүсгэж байгаа учраас энэ компани дээр хамгийн гол зардал бол уурхай дээр энэ олборлолт мөн тээвэрлэлттэй холбоотой яг ийм асуудал үүсэж бид угаах үйлдвэр, усны төслөө дээрээс нь нэмэх нь энэ өртөг зардлыг бууруулах зэрэг конверын төслийг бид зайлиггүй хэрэгжүүлж нэн яаралтай дуусгах, тэгээд дээрээс нь төмөр замын холболтын төслүүдийг бид яаралтай явуулж байж бид илүү цаашаа нүүрсээ үнэ хүргэх ийм боломжтой. Эд нар дээр бид үлдэж байгаа хугацаандаа бол энэ дээр гол саяын хэдэн дурддаг төслүүд дээр гол төвлөрч, энийг аль болох богино хугацаанд ашиглалтад оруулахын төлөө бол зорьж ажиллана.

Л.Мөнхбаатар: Энхбаярын Батиугар гишүүн асуултаа асууя.

Ж.Батиугар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Газар доор байгаа баялаг бол Монгол Улсын иргэд бүгдээрээ л жигд хүртэх ёстой. Яагаад гэвэл энийг бол хэн нэгэн бүтээгээгүй. Харин байгаль Монголчууд бүгдэд нь заяасан баялаг юм. Тэгээд хамгийн зөв хүртээх механизм бол Баялгийн сан байгуулж үүгээрээ дамжуулж төсөл хөтөлбөр болон ирээдүй хойч үедээ үлдээх. Өнөөдөр бол байдлаар эхний ээлжид нь 1072 хувьцааг амилуулмаар байна. Энэ бол үхмэл байгаад байна. Яг яах гэж авсан юм, хаана бүртгэлтэй байна тэгээд ямар ч эргэхгүй.

Тэгэхээр эхний ээлжид бол яах бололцоо байна вэ? Өөр ангиллын хувьцаа болгоод энийг өөр классын ангилал болгоод тэгээд магадгүй заавал татварын дараах ашгийн тодорхой хувьцааг нь хувийг нь энэ ноогдолд ашиг болгож олгодог. Англиар яривал A share, B share гэж ярьдаг юм. Бас хөрөнгийн бирж дээр ч гэсэн ийм юм байдаг юм.

Тэгэхээр иймэрхүү бололцоо байна уу гэж асууя.

Хоёрт нь 2022 онд Монгол Улс 32 сая тонн нүүрс экспортод гаргасан. Тэгэхээр Тавантолгой бол ойролцоогоор 6 тэрбум тонн нөөцтэй гэж ярьдаг. Тэгэхээр чинь 50 хувийг нь л олборлоход бид нарт зуун жил хэрэгтэй байна шүү дээ. Зуун жил. Тэрнээс наана ойрын ирээдүйд нүүрс хэрэгцээнээс гарчихна гэсэн тийм судалгаа байгаа. Та бүхэн бас бүгдээрээ мэдэж байгаа байх. Тэгэхээр хамгийн зөв ирээдүйн орлогоо өнөөдөр үнэлээд, тэгээд тэрийгээ үр шимд хүртэх арга бол гадаадад юм уу, дотоодод ялангуяа гадаадын бирж дээр IPO хийх арга юм. Тэгж байж IPO гэдэг чинь компаниа үнэлэхдээ ирээдүйн бүх ашиг орлогыг нь базааж үнэлж байгаа арга. Тэрүүн дээр бол D, C, F гэх мэтчилэн янз янзын тийм аргачлал байгаа. Тэгээд намайг 2011 онд JPmorgan-д ажиллаж байхад бид нар Тавантолгойг үнэлсэн юм. Тэгээд 6-9 тэрбум доллароор үнэлж байсан юм тухайн үед. Тэгээд энэнийхээ юу гэдэг юм 25 хувийг нь бирж дээр заръя гэж бодъё. Тэгвэл 1.5-аас 2 тэрбум доллар цэвэр босох боломж байгаа юм.

Тэгээд энэ мөнгөөрөө нөгөө бүтээн байгуулалтуудаа хийх бололцоотой. Тавантолгойт цахилгаан станц болон нүүрс угаах үйлдвэр гэх мэтчилэн. Тэгэхээр энэ дээр та нарт ямар нэгэн судалгаа байгаа юу? Та бүхэн өөрсдийгөө үнэлж үзсэн үү? Яг олон улсын жишигээр зарчмаар. Яг энэ дээр ч адилхан бас Peabody energy, A..., Shenhua energy бол бүгдээрээ л IPO хийчихсэн 25 хувийг нь хөрөнгийн бирж дээр арилжиж байгаа компаниуд. Тэгэхээр хөрөнгийн биржид арилжиж байгаа компаниудын 1 давуу тал нь бол хамгийн зөв топ менежерүүдийг авчрах бололцоо байдаг. Хяналт нь бол маш өндөр. Дээрээс нь нэмээд ашигт ажиллагаагаа бол идэвхжүүлэхтэй бололцоо бол олгодог л доо. Яг тийм мэргэжлийн менежер хэрэгтэй байгаа юм энэ дээр.

Тэрүүн би хэд 2 асуулт асуусан. Ахиад үүнийг дагуулаад 4 асуулт асууя. Эхний асуулт нь бол энэ нь Тавантолгой цахилгаан станцаа ямар байдлаар санхүүжүүлэх төлөвлөгөө байгаа юм бэ? Яг прожект финансаар л санхүүжүүлэх нь зөв. Тэгэхгүй бол өөрсдөө гаргаад яваад байгаа бол нөгөө Монголд орж ирж байгаа нөгөө нэг валютын нөөцөө буцаад л эргэж гаргаж байгаа гэсэн үг. Тэгэхээр яг хани дээр бол том нөлөө өгөхгүй л дээ. Харин эсрэгээр энэ прожект финансинг болон IPO хийж байгаа юм уу санхүүжилт нь хамгийн зөв энэ бол.

Хоёр дахь нь бол нөгөө 1 биржээр арилжиж байгаа нь маш зөв хэрэг. Энэний үр дүнд бол өнөөдөр Монгол Улсын төлбөрийн тэнцэл 10 хэдэн жил жилийн дараа анх удаа эерэг гарч, 160 долларын ашигтай гарсан. Үүний үр дүнд төгрөгийн хани чангарч, долларын хани буурч байна. Үүнийг дагаад богино хугацаанд импортоор орж ирж байгаа инфляц буурах нөхцөл байдал үүссэн байгаа юм. Тэгэхээр энэ жилд нийт олборлолтынхоо хэдэн хувийг биржээр арилжаалах төлөвлөгөө байгаа вэ гэж асууя.

Л.Мөнхбаатар: Батшугар гишүүний асуултад Ганбат дарга хариулъя.

Ж.Ганбат: Батшугар гишүүний асуултад хариулъя. 1072 хувьцааны асуудал бол одоо яг Эрдэнэс Тавантолгой компанийн 14.8 хувь буюу 2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн 2.5 сая иргэд Эрдэнэс тавантолгой компанийн хувьцаа эзэмшиж байгаа. 16 оны эхээр энэ хувьцаатай зарим иргэдийг сайн хувьцаанд оруулаад энэ хувьцааг нь зарах эргэлтэд оруулах гэж үзсэн. Гэхдээ энэ бол ингээд зогсчихсон байгаа. Тэгэхээр яг үүнийг эдийн засгийн эргэлтэд хэрхэн яаж оруулах вэ, мөн Монгол Улсын 2012 оны 4 сарын 11-нээс хойш төрсөн иргэдийг хэрхэн хамруулах талаар бол Засгийн газар дээр бол энэ талаар бол ажиллаж байгаа.

Ер нь 2022 онд бид Эрдэнэс тавантолгойн 1.3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. Энэ дээр ноогдол ашиг хуваарилах эсэх асуудлаа бол компани ТУЗ-даа танилцуулаад, хувьцаа эзэмшигчдийн хурал дээр бол энэ эцсийн шийдийг гаргана. Ер нь Засгийн газраас барьж байгаа чиглэл болон компани бол яг л нөгөө бизнесийн зарчмаараа ноогдол ашиг тараах эсэх асуудлаа компани ингээд өөрсдөө шийдвэрлээд энэ асуудлаа ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурлаараа шийдүүлдэг байх нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг бол баримтлан бол ажиллаж байгаа.

IPO гаргах асуудал энэ өмнө нь бол Эрдэнэс тавантолгой компани IPO гаргах асуудал, IPO гаргах гэж 1 удаа оролдлого хийж байсан. Гэхдээ энэ асуудал нь 2020 оны 4 сард бол энэ бол зогссон байгаа. Энэ асуудал бол амжилтгүй болоод. Тэгээд яах вэ яг өнөөдрийн байдлаар бол бид бол нэмэлт IPO гаргах асуудлаар бол яг бол судлаад энэ тал дээр бол бол ажиллаж байгаа юм бол одоогоор бол алга байна. Ер нь цаашдаа энэ IPO гаргах асуудлыг мөн дахин үнэлгээний асуудал энэ тэрийг бол зайлшгүй авч үзэх нь зөв зүйтэй юм гэдэг ийм байр суурийг баримталж байгаа. Мөн олон улсын аудитын нөгөө хөндлөнгийн аудитыг энэ компани дээр яаралтай оруулж бид бас үнэлэлт дүгнэлт гаргуулах бол ингээж шаардлагатай бол байгаа.

Тавантолгойн цахилгаан станцын асуудлыг бол Засгийн газрын хуралдаан дээр Эрчим хүчний яамнаас бол энэ асуудлыг бол гол төвлөрч бол ажиллаж байгаад. Эрдэнэс тавантолгой компани бол энэ дээр зөвхөн гарааны санхүүжүүлэх байдлаар бол ингээж оролцож байгаа. Ерөнхийдөө бол IPO гаргах болон олон улсын нээлттэй сонгон шалгаруулах байдлаар энэ асуудлыг бол Эрчим хүчний яам гол төвлөрөөд бол энэ дээрээ бол ажиллаж байгаа гэдэг ийм байдлаар бол ажиллаж байгаа. Засгийн газрын чинь 2 долоо хоногийн хурлаар бол

энэ асуудал яригдаад, Эрчим хүчний яам энэ талаар бол Тавантолгойтой бол хамтарч ингээж ажиллахаар бол яригдаж байгаа.

Биржээр бол бид энэ онд 30 хувиа бол биржээр бол арилжина гэдэг ийм бол төлөвлөгөөтэй бол ажиллаж байгаа. ТУЗ-өөр батлагдсан энэ оны борлуулах нүүрсний хэмжээ нь 23 сая тонн нүүрс бид борлуулна гэдэг ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Эхний 1 дүгээр улиралд 7.5 сая тонн нүүрсийг бид борлуулсан. Яах вэ энэ эрчээрээ явах юм бол бид энэ онд 30 сая тонн нүүрс борлуулах бол бүрэн бололцоотой байм байна гэдэг ингээж тооцож байгаа. Тэгэхээр бид энэ нийт борлуулах нүүрсний 30 хувийг бирж дээр бид арилжаална гэдэг ийм байдлаар бол үйл ажиллагаагаа зохион байгуулан бол ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Чинзориг, Доржханд. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ чухал асуудал. Ерөнхийдөө БЭТ томилогдоод үр дүн гарч байгаа гэдэгт би итгэлтэй байгаа. Тэрийг үгүйсгээгүй. Гэхдээ өнөөдөр Улсын Их Хурал хууль тогтоох байгууллагын хувьд хувь хүнтэй ямар ч холбоогүйгээр би хууль тогтоох байгууллагын хувьд 1 хэд хэдэн тодруулах зүйл асууя.

Энэ бүрэн онцгой байдал тогтоох гэдэг тухай ингээд анх яаж бий болсон юм бэ гэдгийг би нэг тайланг нь ингээд архиваас аваад үзлээ. Чимэд гуай тэр үед хэлж байсан байна шүү. Бид магадгүй ардчиллыг хязгаарласан хатуу чанд журам тогтоосон гэсэн хэл яриа ярианд орох байх. Ийм асуудал гарч магадгүй учраас урьдчилан харж байх ёстой гэж бүр онцгой анхааруулсан байна. Өөрөөр хэлбэл дараа нь Засгийн газрын энэ уг хууль биш тогтоолын төслийг оруулж ирээд үйлдвэрчний эвлэлийн энэ бусад үйлдвэрчнээс бусад байгууллагыг түр түдгэлзүүлэх гэсэн юм л гэсэн зорилго орж ирсэн.

Би хууль тогтоох тухай ярья л даа. Нарийн ширийн баахан юм яриад яах вэ. Тэгэхээр бид ер нь явж явж энэ тогтоолыг үзсэн чинь Улсын бага хуралд түүний хэрэгжилтийг явцыг сар бүр Улсын бага хурал олон түмэнд мэдээлж байх юм гэж байна. Энэ Улсын бага хурал юм уу, Улсын Их Хурал юм уу? Энэ дээр надад Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга хариулт өгөөч. Энэ хууль эрх зүйн зөрчил гарах уу, үгүй юу? Би бол Улсын Их Хурлын гишүүн, Бага хурлын гишүүн биш.

Хоёрдугаарт энэ нөхцөл байдал арилаагүй бол хугацааг 1 удаа, 6 сар, 6 сараар сунгана гэж байгаа юм. Хулгай хэвээрээ байгаа гэсэн үг үү? БЭТ-ээс хойш дахиад хулгай гарсан хэрэг үү? Энэ бол аймшигтай атгаалжин хар мангасыг дараад гараад ирээрэй гэсэн болохоос биш очоод мангас болчихоорой гэсэн санаа биш шүү дээ энэ чинь асар том мөнгөний тухай ярьж байгаа шүү дээ. 1.2 их наяд төгрөгийн тендер ярьсан. Үгүй ээ энэ чинь ганц тендер битгий яриач гэсэн. Хүүе бид дөнгөж та нарын өмнө 13 сая төгрөгийн өмчийн тухай ярьж байгаа шүү дээ 1 аймагт. Тэгэхээр та нар бол арай даварч байна. Миний асуулт.

2 дугаар асуулт. Хэрэг эрхлэх газрын орлогч даргаа Монгол Улсын хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга Ганбат, Эрдэнэс тавантолгой компанийн ТУЗ-ийн гишүүн Ганбат, Эрдэнэс тавантолгой компанийн гүйцэтгэх захирал Ганбат, Сангийн яамны ТНБД Ганбат гээд 4, 5 давхар дээл өмсчихсөн байгаа энэ явдал ажил үүргийн давхардал үүсэх үү? Өөрөө өөрийгөө хангалттай хянах уу? Энэ нөгөө ардчилал гэдэг чинь байгаа юу? Би та нарт бүр их сонирхолтой юм ингээд уншъя. Энэ хуулийг харсан онцгой байдал бий болсноороо нийтлэг баримталдаг хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр гэж байгаа юм шүү дээ. Хууль хэрэгжүүлэхгүйгээр хууль хэрэглэхгүйгээр 6 сар хүртэл хугацаагаар онцгой дэглэм тогтоож ажиллуулах

эрхийг БНМАУ-ын Засгийн газарт олгосугай гэсэн ийм юм л ашиглаад байгаа юм л даа та нар. Хуульгүй дор хулгай, мэдлэггүй дор боол гэж үг байдаг юм шүү. Энэ бол бүүр гаршиж байна.

Тэгээд би тэр Байнгын хороон дээр ярьсан юмаа дахиад л давтъя л даа. Моннис гэдэг компани хууль бусаар шалгарчихсан байна. Энэ гомдлыг нь ТУЗ-ийн дарга Ганбатад Төрийн өмчийн газрын дарга Ганбат энийг шийдэж байгаа юм. 126 тэрбум төгрөгийн Хөгжлийн банкнаас хугацаа хэтэрсэн төлөхгүй байгаа зээлтэй хүн тендерийн хуулийн харилцагч банкнаасаа хугацаа хэтэрсэн зээлгүй байх ёстой гэсэн тэр юмыг зөрчиж байна гэж би харж байгаа. Энэ хууль зөрчиж байна уу, үгүй юу?

Тэгэхээр тэгээд хамгийн аюултай нь тендерийн гэрээн дотор нь надад бол Монголын үйлдвэрчний Холбооны гишүүдээс ирсэн гомдол байна. 3 гомдлыг би зүгээр эхнийхийг нь ярьж байна. Тэгэхээр Тендерийн хуульдаа маш бага үнээр маш багаар авсан гэж байгаа. Та нар үнэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат хариулъя. 81 дүгээр микрофон өгөөрэй.

Б.Ганбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ хууль зүйн үндэслэлийн хувьд бол 91 оны хуулийг барьж байгаа юм. Тэгэхээр энэ 91 оны энэ БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай гэсэн энэ хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. 91 онд батлагдсан нэлээн хэд хэдэн хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Тэгэхээр энэ нэгэнт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд энэ асуудал бол орж ирж байгаа 1 дүгээр үндэслэл нь бол энэ.

2 дахь нь бол яг энэ 1991 оны хуулиар өмнөх бас төрийн өмчтэй ААН

дээр онцгой дэглэм тогтоох асуудлыг орж ирээд ингээд практик хэрэглээ гаргаад явчихсан. Тэгэхээр хууль хэрэглээний явцад бол энэ 91 оны хууль, энийг бол хэрэглээний хувьд бол практик гаргаад явчихсан. Энийг Улсын Их Хурал бас хүлээж аваад шийдээд ингээд жишиг тогтоочихсон ийм юм байж байгаа.

Хууль зүйн хувьд бол энийг ингээд хэрэглээд явахад бол энэ хууль дээр өөр дээр нь бас 1 заалт байгаа гишүүнээ. Энэ дээр 2 дугаар зүйл дээр нь юу байна гэхээр энэ онцгой журам гэдэг энэ журам маань хууль тогтоомжийн ардчилсан зарчимд нийцсэн байвал зохино гэдэг ийм бас зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ бол өнөөдрийн энэ авч байгаа ялангуяа энэ Эрдэнэс тавантолгой өмнөх практик гэж ярьж байгаа нь бол Эрдэнэт үйлдвэр дээр бол ийм кэйс гараад ингээд хууль хэрэглээний явцад бол хэрэглээд явчихсан ийм тохиолдол байгаад байгаа. Тэгэхээр энэ 2 тохиолдлууд дээр бол энэ 91 оны хуулийг хэрэглээд энэний дагуу бүх хууль зүйн үр дагаврууд санхүүгийн болон бусад үр дагавруудыг гаргаад явчихсан ийм жишиг бол байгаад байгаа. Тэгээд энэ агуулгаараа бол энэ хууль зүйн үндэслэлийн хувьд бол энэ хуулийн дагуу өнөөдрийн энэ асуудлыг оруулж ирж ингээж танилцуулж байгаа.

91 оны энэ хуулийнхаа дагуу хуульд заасан шаардлага нь байна гэж үзээд ингээд Засгийн газар бол саналаа оруулж ирж байхыг, байхыг гэсэн ийм үсэгтэй үг үсэгтэй томъёололтой явж байгаа юм. Тэгэхээр энэ хуулиараа бол ийм томъёололтой байгаа учраас өнөөдөр энэ саналаа Монгол Улсын Засгийн газар оруулж ирж, Улсын Их Хуралд хууль тогтоох байгууллагадаа танилцуулж байгаа юм гэж ингээж ойлгож болно.

Дараагийн таны асуудал асуусан асуулт дээр тэр 4 янзын юу давхар дээлтэй гэж ингээж харагдаж байна гээд. Энэ дээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хууль байгаа. Энэ хууль дээр бол төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх дэг журам бүх тавигдах шаардлага нөхцөлүүд бол бүрэн тусгагдсан байгаа. Энэ хүрээндээ төрийн жинхэнэ албан хаагч гэдэг ийм статустай этгээд нь төрийн өмчийн төлөөллийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид заасан тэр нөхцөл шаардлагын дагуу төлөөллөө хэрэгжүүлээд явах бүрэн бололцоо нь бол нээлттэй байгаа. Энэ агуулгаараа бол Сангийн яамны ТНБД төрийн өмчтэй компанийн ТУЗ-д бол томилогдоод ажиллах бүрэн бололцоо нь бүрэн нээлттэй байж байгаа. Өнөөдрийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя, гүйцээгээд хариулчих.

Б.Ганбат: Өнөөдрийн Эрдэнэс тавантолгой компанийн бүрэн эрхт төлөөлөгч гээд энэ онцгой бүрэн эрхт төлөөлөгч гээд Монгол Улсын Засгийн газраас томилогдсон. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдээд Засгийн газрын шийдвэрээр томилогддог ийм юу байгаа. Энэ албан тушаал дээр Сангийн яамны ТНБД өнөөдрийн байдлаар 3 хуулийн этгээд дээр ийм бүрэн эрхт төлөөлөгч гэдэг ийм статустай, төрийн албан хаагчийг томилсон байгаа. Энэ нь өөрөө асуудал нь Монгол Улсын Засгийн газрын хуулиар олгогдсон бүрэн эрхэд хамаарч байгаа ийм асуудал байгаад байгаа учраас Засгийн газар энийгээ хүлээн зөвшөөрч бололцоотой гэж ингээж үзсэн учраас томилгоо хийгдээд ингээд явж байгаа гэж ойлгож болно. Тэр тендерийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат яах юм нэмж хариулах юм уу?

Б.Ганбат: Тендертэй холбоотой асуудал дээр бол 1 ийм Тендерийн хууль байгаа. Тендерийн хуулийн дагуу гарсан тендерийн худалдан авах ажиллагааны дүрэм журмууд гээд зөндөө баримт бичгүүд бол байгаа. Энэ дээр тавигддаг тендерийн үйл ажиллагаанд тавигддаг 1

том шаардлага нь бол татварын болон НДШ-ийн хугацаа хэтэрсэн өртэй байх гэдэг ийм асуудал байгаа. Энэ шаардлагыг бол тухайн үед бол энэ тухайн худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудал дээр хөрөнгө нь хэн шийдэж байна тэр тухайн хуулийн этгээд нь бол ажлын хэсгээ байгуулаад үнэлгээний хороо гэдэг ийм нэгжийн хэсгийг томилоод, тэр үнэлгээний хороо бол хууль тогтоомж Засгийн газраас баталсан, мөн Сангийн сайдын эрхийн актаар баталсан тэр тендерийн үйл ажиллагаатай холбогдолтой бүх дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах ийм чиг үүрэгтэй байгаа. Тэрэн дээр бол татвар, НДШ-ийн хугацаа хэтэрсэн өртэй бол гэсэн ийм шаардлагыг тавьсан байдаг юм.

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Сүүлийн үед бол ер нь төр муу менежер, төрийн юм гэж бол байх ёсгүй, байхаараа ийм байгаад байна. Тийм учраас ер нь хувийн хэвшил рүү л явах ёстой гэсэн ийм зүйл маш их яригддаг. Энэ Их Хурлын чуулганы танхимд ч тэр гэж яригддаг. Үнэхээр ч сүүлийн үед гарч байгаа энэ зүйлүүд тэрийг баталж байгаа юм шиг л байдаг байлаа. тэгээд энэ Монголчуудын хэдэн үеэрээ идэх хөгжих энэ бололцоог олгох энэ Тавантолгой дээр бүрэн эрхт төлөөлөгч томилоод, түүний багийнхан ажиллаад, ямархуу үр дүн энэ зургаахан сарын дотор гаргав, гарчихсан бэ гэдгийг ер нь өнөөдөр тайлагнаж байна. Би бол энэ багийнханд баяр хүргэмээр байгаа юм.

Үнэхээр Монголын ард түмний энэ их баялаг хулгайн замаар явж байсан байна. Засаад төр бол бас муу менежер биш юм. Энэ дээр томилогдсон хүнээсээ л шалтгаалж байгаа болохоос тэр хүмүүсийн хамтын ажиллагаа тэр баг хамт олны үйл ажиллагаа л болохоос биш зөвхөн төрийг энэ дээр бас буруутгаад байж болохгүй юм гэж ингэж харж байгаа юм. Тэгээд одоо энэ

тодорхой хувийг нь янз бүрийн байдлаар хувийн хэвшилтэй хамтрах, гадна дотнынхонтой хамтрах, үгүй ээ энэ орж ирж байгаа ашигийнх нь нэлээдгүй хувь нь тийшээгээ явдаг эсвэл тэгээд 1 төр татвар нэрээр 1 багахан юм аваад л үлддэг, тэр нь яг одоо өнөөдөр ажил амьдрал шийдэхэд ямар ч бас тодорхой багахан хувь нэмэр оруулахаас биш дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй ийм л дүр зураг анзаарагдаад байдаг.

Тэгэхээр цаашидаа ер нь энэ Эрдэнэс тавантолгой энэ компани сая зуун жил ашиглах нөөцтэй гэж байгаа энэ их том компанийг бид гадна дотнынхонтой хамтрахгүйгээр Монголчууд яг өөрөө төр. ингээд иргэдэд байгаа тэр хувьцаагаа амь оруулаад цаашид аваад явах бүрэн дүүрэн бололцоо бас байна уу? Энэ компанийн ирээдүйг бас яаж харж байгаа вэ? Миний хувьд бодохдоо бол төр бас энэ дээр өөрийнхөө стратегийн энэ том ордыг хэн нэгэнтэй хамтрахгүйгээр төрөөс томилогдож байгаа тэр хүмүүс нь чин шударгаар ажиллаад, компанийн засаглал тэр ил тод байдал, энэ худалдан авалт, хамаг юмаа ил болгоод ингээд явах юм бол Монголын ард түмэнд ирэх өгөөж нь хадгалагдаад үлдэх юм л гэж ингэж бодож байгаа. Эрдэнэт үйлдвэр шиг. Ковидын үед Эрдэнэт үйлдвэр хүн болгонд 300000 төгрөгийн дэмжлэг үзүүлж байсан. Тэр үед бол бас орон нутагт ажиллаж байсан хүний хувьд ямар их хэрэг болов гэдгийг бас мэдрэгдэж л байсан л даа. Тийм учраас ер нь төр бол бас 1 ийм стратегийн ордуудтай хэн нэгэнтэй хамтрахгүйгээр цаашид аваад явдаг байгаасай л гэж ингэж бас бодож байгаа юм.

Нөгөө талдаа өнөөдрийн бидний энэ ярьж байгаа сэдэв энэ болж өнгөрсөн процесс энэ бүх зүйлийг аваад үзэхэд энэ ашигт малтмалын салбар дээр ер нь байгаа болгоныг ухаад байх юм уу? Байгаа нөөц сайтай ийм уурхай энэ ашигт малтмалын ордуудаа энэ мэтчилэн үр өгөөжтэй ашиглах юм уу гэдэг бас торгон ийм зааг дээр байна уу

гээж ингэж бас хараад байгаа юм. Орон нутагт явж байхад энэ уул уурхайн хэрүүл ердөө мундахгүй. Ашиг өгдөг эсэх нь мэдэгдэхгүй, орон нутгийнхныг ажлын байраар хангаж байгаа юм байхгүй, байгаль орчинд асар их хохиролтой, тэр тушаасан олборлосон ашиг малтмалаа хааш нь яаж шилжүүлдэг юм, орон нутаг, улсын төсөвт хэдэн төгрөг өгдөг нь мэдэгддэггүй ийм жижиг сажиг баахан юмнуудаар ухуулж байхаар энэ Тавантолгой ишг хэдэн сайн компани төр өөрөө зөв менежер хийгээд ингээд ер нь явбал яасан юм бэ гэсэн ийм бодолтой байдаг юм.

Тэгэхээр би танай та бүхнээс ер нь энэ Тавантолгойн ирээдүйг ер нь яаж төлөвлөж байгаа юм, яаж төсөөлж байгаа юм бэ? Одоо ингэж байгаад л баахан IPO гаргана, хувийн хэвшилтэй хамтарна, тодорхой хувийг нь зарна үрнэ гэсэн ийм төлөвлөгөө байна уу? Энэ дээр заавал гадна, дотнынхон гэхгүйгээр Монголчууд өөрсдөө энэ компанийн сайн засаглалыг хийгээд явах бүрэн дүүрэн бололцоо байгаа юу? Хүчин чадал байгаа юу? Боловсон хүчин, технологи, техник энэ тал дээр би бас тодруулъя гэж ингэж бодсон.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг Ганбаатар хариулна. 80 дугаар микрофон өгөөрэй.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой компани дээр яг би зүгээр 1 хэдэн тоонуудыг нь зориуд дурдъя гэж бодож байгаа. Хатуу коксжих нүүрс 2 тэрбум тонн нүүрсний нөөц байна, хагас коксжих нь 1.4 тэрбум тонн, эрчим хүчний нүүрс 2.9 тэрбум тонны нөөцтэй байна. Бид энэ ингээд тоонуудыг би яагаад зориуд хэлж байна гэхээр эрчим хүчний нүүрс 2.9 тэрбум тонн нөөцтэй гэхээр бид энэ хагас коксжих болон эрчим хүчний нүүрснүүдийг бид яаралтай эдийн засгийн эргэлтэд оруулж, энийг зарах шаардлага борлуулах ийм шаардлага

үүсэж байгаа юм. Тэгэхгүй бол компани 12, 3 жилийн түүхэндээ дандаа сорчилж сайн чанарын нүүрсээ зарж ирсэн. Тэгэхээр бид энэнээсээ аль болох зайлсхийж, энэ гаргаж байгаа энэ бүх бүтээгдэхүүнээ ер нь борлуулдаг энэ арга руу шилжүүлэх. Нөгөө талдаа бид угааж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ийм зайлшгүй шаардлагууд ингээд үүсэж байна.

Нөгөө талдаа ер нь энэ компанийг бол ингээд Монголчууд өөрсдөө аваад яах вэ бүрэн ингээд чадамж нь бий болжээ гэж яах вэ үзэж байгаа. Тэрийг би нэг зориуд хэлж байгаа нь хөрс хуулалт, олборлолт дээр яах вэ сая 2 багц энэ Ганбаатар гишүүний асууж байгаа тендер дээр дан дотоодын компаниуд орж ирсэн. Эхний 1 дүгээр багц дээр 3 компани, 2 дугаар багц дээр 2 компани гээд нийтдээ 5 компани. Бид бол яах вэ гаднын компаниуд бас орж ирдэг юм болов уу гэдэг ийм хүлээлтүүд бол байсан. Гэхдээ бол энэ ингээд олборлолттой бол хөрс хуулалтаа Монгол компаниуд хийгээд явах бол бүрэн боломж байна гээд ингэж харж байгаа.

Засаглалын хувьд бол Засгийн газрын түвшинд бол хэд хэдэн асуудлыг судалж үзэж байгаа. Ингээд эсвэл олон улсад нээлттэй сонгон шалгаруулах эсвэл зөвхөн дотооддоо энэ удирдлагын багийг нээлттэй сонгон шалгаруулах ийм зарчмаар. Ер нь энэ хараат бус байдлаар энэ төрийн өмчийн компаниудын засаглалын хувьд бол энэ улс төрийн болон ямар нэгэн хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус ангид байлгах энэ тогтолцоог нь ил тод нээлттэй болгох л зайлшгүй ийм шаардлага үүсчхээд байгаа шүү дээ. Бид үүнийг ямар нэгэн улс төрийн хараат бус, хөндлөнгийн нөлөөлөлгүй явуулж чадах юм бол Монголчууд энэ өөрсдөө энэ компаниа бол аваад явах бол бүрэн бололцоотой юм гэдэг ийм байдлаар.

Нөгөө талдаа 2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн 2.5 сая иргэд энэ компанийн 18.4 хувийг эзэмшиж байна.

Тийм учраас энэ дээр иргэдийн тэр хяналтыг нь тавихын тулд ТУЗ-д нь энэ төлөөллийг хэрхэн яаж оруулах вэ, энэ дээр ямар байдлаар олон нийтийн оролцоог хангах вэ гэдэг энэ асуудал дээр Засгийн газрын түвшинд яригдаад, мөн цаашидаа яг нийт 2.5 сая иргэд гэхгүй нийт Монгол Улсын иргэдийг эндээс энэ Эрдэнэс тавантолгой компаниас ашиг хувь өгөөжийг нь хүртээдэг болгох гэдэг энэ асуудлууд дээр бол яг одоо энэ Засгийн газрын түвшинд бас хэд хэдэн саналууд гараад нарийвчлан бол ингээд судалж ингэж бол ажиллаж байна.

Тэгэхээр бол энэ онцгой дэглэмд сунгагдсан 6 сарын хугацаанд энэ засаглалын асуудлыг нээлттэй ил тод болгох, үүний бас зөв шийдлээ гаргах, олон нийтийн хяналтыг тэгээд улам сайн ил болгох гэдэг ийм асуудлуудаар гол төвлөрч ажиллаж шийдлээ гаргана гэдэг ийм байдлаар бол Засгийн газрын түвшинд бол ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: 6 сараар энэ бүрэн эрхт төлөөлөгчийг томилсон, онцгой нөхцөл байдлыг сунгах энэ Засгийн газрын саналыг бол дэмжиж байгаа. Сая компанийн гүйцэтгэх захирлын яриан дээр гарч ирж байгаа тэр засаглалын асуудал дээр бас ил тод болох ийм л зүйл байгаа юм байна. Ер нь миний дахиад хэлэхэд ер нь бид төрийн өмчтэй, энэ их асар их баялагтай, асар их үр ашигтай ажиллах боломжтой энэ салбаруудыг төр өөрөө удирдах тал дээрээ, хяналт тавих тал дээрээ муу ажиллаад, тэрнээсээ болоод төр муу менежер гэдэг нэр аваад, тэрнээсээ болоод энэ улс орноороо хүртэх ёстой энэ 3300000 хүн амсах ёстой, хүртэх ёстой энэ баялгаа цөөхөн хэдэн хүний хяналтад бас оруулчих вий дээ гэсэн энэ болгоомжлол бас байдаг. Энэ бол манай Даваасүрэн гишүүн бас энэ талаар бас нэлээн ярьдаг. Ер нь улс орон гэж байгаа л бол бид нар дангаараа өөрсдөө дотооддоо аваад явах ийм бололцоо.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүн уг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэс тавантолгой компани онцгой дэглэм тогтоогоод 10.2 сая 5 тонн нүүрс олборлож, 13 сая тонн нүүрсийг борлуулж, 4 их наяд төгрөгийн борлуулалт орлоготой ажиллаж, 1 их наяд 540 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлжээ. Эндээс харвал бас богино хугацаанд сайн ажилласан байна гэж ингэж дүгнэхээр байна. Харин та бүхэн өнгөрсөн хугацааны нүүрсийг ам нөхцөлөөр хямд борлуулж байсан байна. Нүүрсний тээвэрлэлтийн хяналт сул байжээ. Бас нүүрс дутсан асуудал байгаа. Төслийн санхүүжилтийг нүүрсээр төлөх гэрээ байгуулсан гээд ингээд. Энэ болгоныг ер нь алдагдсан боломжийг мөнгөн дүнгээр тооцож үзсэн үү? Тийм тоон судалгаа байна уу? Хэрэв өнөөдрийнх шиг та бүхнийх шиг ингэж ажилласан бол ер нь ямар нөхцөл байдал бид бүхэн ямар нөөц бололцоог улсад төвлөрөх татварын орлогыг алдаж вэ гэдгийг та бүхэн гаргаж тооцож үзсэн юм байна уу гэж.

Хоёрт Ганбат даргын өмнөх удирдлагын үед ноднин бид нар энэ Багануурын нүүрсний уурхайг түшиглэж нүүрс химийн цогцолбор байгуулна гээд Эрдэнэс тавантолгойгоос төсөл хэрэгжүүлээд, уурхай дээр очиж ажиллаад, ашиглалтгүй байсан байр талбайг 9 сараас 11 сарын хугацаанд маш богино хугацаанд засвар тохижилт хийгээд, яг бэлэн болгочихсон. Бэлэн болгочихсон. Дэд бүтцийг нь татсан, ажлын байрыг нь бэлдсэн, тоноглолуудыг нь бэлдсэн. Одоо энэ төсөл хөтөлбөр цаашидаа явах юм уу, явахгүй юм уу? Яах нь тодорхойгүй ингээд хөрөнгө оруулалт гаргачихсан байгаа.

Энэ төсөл хөтөлбөрт одоогийн байдлаар тэр засвар үйлчилгээнд хэдэн төгрөг гаргаад байгаа юм бэ? Тэгээд

цаашидаа та бүхэн энэ төсөл хөтөлбөрийг явуулна гэж байгаа юм уу, явуулахгүй гэж байгаа юм уу? Энэ өөрөө зөвхөн I уурхайн асуудал биш шүү дээ. Энэ Улаанбаатар хотын төвлөрөл, утааны асуудал, Багануурын нүүрсийг сайжруулах, коксжуулах, дагалдсан, бүтээгдэхүүн гаргаж авах ийм том төсөл хөтөлбөр л юм байна лээ. Тэгээд энэ дээр та бүхэн ямар санаа оноотой байгаа юм, энэ ажил цаашидаа явах уу гэдгээ маш тодорхой хариулт өгөөч? Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ганбат дарга хариулъя.

Ж.Ганбат: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бид ийм I тооцоо зүгээр хийж үзсэн юм. Эрдэнэс тавантолгой компани анхныхаа экспортыг 2011 онд хийж байсан. Энэ 11 оноос эхлээд экспортоо хийгээд, дандаа хил ам нөхцөлтэйгөөр бол зарж байсан энэ дээр. Бид үүнийг яг одоогийн яах вэ хил нөхцөлөөр нүүрсээ борлуулж хэрэв борлуулж байсан бол гэдгийг тооцож үзсэн. Одоо нийтдээ Эрдэнэс тавантолгой компани нийт яг 11 онд экспортоо хийгээд гээд нийтдээ нэг 96.3 сая тонн нүүрсийг борлуулсан байдаг юм байна лээ. Үүнийг бид нар хил нөхцөлөөр зарсан бол гээд яг одоогийн яах вэ үнийг аваад тооцоод үзэхэд бид Монгол Улс яг эндээс орж ирэх орлогоо 4 тэрбум ам.долларын орлогыг бид алдсан юм байна гэдэг ийм бол I тооцоолол зүгээр хийж үзэж байсан. Яах вэ энэнээс бид тооцоо, улсын төсөвт 4 тэрбум доллароосоо улсын төсөвт орж ирэх татварын орлогуудыг нь тооцоод үзвэл бас тодорхой хэмжээгээр ерөөсөө орлогыг бол алдаж иржээ гэдэг ийм байдлаар бол дүгнэлтээ бид бол тоо хийж бол ингэж үзэж байсан.

Нөгөө талдаа энэ дээр би яах вэ энийг удаа дараа хэлээд байгаа нь бид дандаа сайн чанарын коксжих нүүрсээ дандаа сорчилж зарж байсан. Бид эрчим хүчний нүүрс болон сул коксыг зарж

байгаа. Дандаа овоолго байдлаар үүсгээд тэр нь өөрөөр хэлэх юм бол үргүй зардал болоод ингээд явж байсан. Бид яах вэ энэ дээр бид яаралтай одоо өмнө нь эрчим хүчний жишээ нь сул коксожсон нүүрс гэдэг энэ компани 12, 13 жилийн түүхэнд ерөөсөө л 200000 тонныг л I удаа л зарж үзэж байсан. Бид яах вэ яг энэ уулын ажлын нөхцөл байдал энэ тэрээ үзэхээр бид энэ эрчим хүчний нүүрс, сул коксожсон нүүрсийг зарж байж, бид цаашаа үйл ажиллагаа нь бас хэвийн явах ийм нөхцөл байдал руу орж байгаа учраас бид энэ дээр туршилтын арилжаануудыг бирж дээр явуулж үзсэн. Энэ бол амжилттай болсон. Бид энийг бол зараад явбал болох юм байна гэдэг ийм бол дүгнэлтийг бол гаргаж байгаа юм.

Тэр Баганууртай холбоотой химийн үйлдвэрийн гэдэг дээр энэ дээр бол яах вэ судалгаа хийгдээд, энэ нүүрс химийн үйлдвэрийн судалгааг бол хийгдчихсэн. Эхний байдлаар энэ дээр 4 орчим тэрбум төгрөг энэ тэр байрны засвар энэ тэртэй холбоотой хийгдчихсэн юм байна лээ. Нөгөө талдаа би яг энэ Эрдэнэс тавантолгой компани яг 11 төслийг санхүүжүүлээд ингээд явж байгаа. Нөгөө талдаа яг ийм шууд өөрийнх нь үндсэн үйл ажиллагаанд хамааралтай болон хамааралгүй төслүүдийг санхүүжүүлээд ирчихсэн, санхүүгийн хувьд энэ нь бол өөрийнх нь жишээ нь юу гэдэг юм дарамт болчихсон ийм байдалтай юмнууд байгаа. Тэгэхээр бид ямар зарчим барьж байгаа гэхээр яг шууд энэ компанийн үндсэн үйл ажиллагаанд жишээ нь эергээр нөлөөлөх, жишээ нь тэр баяжуулах үйлдвэр, угаах үйлдвэр, төмөр замын холболт энэ тэр гэдэг яг ийм төслүүд дээрээ нэн тэргүүний ингэж анхаараад, төслүүдээ эрэмбэлэн санхүүжүүлээд явах нь зүйтэй юм гэдэг ийм байдал дээр явж байгаа.

Тэгэхгүй бол яг өнөөдрийн нөхцөл байдалд Эрдэнэс тавантолгой компани яг энэ хэрэгжиж байсан өмнө нь саяын таны хэрэгжиж байсан төслүүдийг цаашаа санхүүжүүлээд явахад бол бид

бол санхүүгийн хувьд бас хүндрэлтэй байдал руу орж байна гэдэг ийм дүгнэлтийг хийгээд, энэ асуудал бол Засгийн газарт бол бас танилцуулсан. Тэгээд яг шууд нүүрс угаах үйлдвэр, ингээд төмөр замын төслүүд дээрээ голлон анхаараад төслүүдээ эрэмбэлээд явъя гэдэг ийм байр суурийг бол баримталж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух уу? Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Ямар ч байсан тэгвэл тодорхойгүй хугацаагаар гацаж, хойшилж байгаа юм байна л гэж шуудхан хэлэхэд ойлгож байна. Эрэмбэлбэл, одоо тэгээд 20 дугаарт эрэмбэлэгдэх байх, эсвэл 11-д нь эрэмбэлэгдэх юм байна гэж ингэж ойлголоо.

Та бүхэн валютын нөөц нэмэгдэж байгаа. Эрдэнэс тавантолгой ер нь яг нүүрсээ валютаар зарж яг валют чинь бэлнээр орж ирж байна уу, үгүй юү? Хэдэн хувь нь орж ирж байна вэ? Аль эсвэл тэнд баахан өмнөх өрнийхөө овоолго нүүрснүүдийг л гаргаад байгаа гээд байгаа. Өмнө нь түрүүлээд авчихсан идчихсэн. Тэгээд энэ нэмэгдэж байгаа валютын орлоготой ямар шууд хамааралтай байна вэ? Шууд бэлнээр валютаар нүүрс чинь орж ирж байна уу, эсвэл өмнөх өрүүдээ дарж борлуулж ингэж ажиллаж байна уу? Энэ дээр та бүхэн 1 тодорхой мэдээлэл өгөөч.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Ганбат дарга хариулах уу? Ганбат дарга хариулъя, ажлын хэсгийн 80 дугаар микрофон.

Ж.Ганбат: Нэмэлт тодруулгад хариулъя. 2022 оны 10 сарын 26-наас 2023 оны 4 сарын 1-нийг хүртэлх хугацаанд 13 сая тонн нүүрсийг бид борлуулсан. Энэний үнэлгээ нь бол 1 тэрбум 260 сая ам.доллар. Үүнээс бид нар 755.6 сая ам.долларыг яг бэлэн Монгол Улсад оруулж ирсэн. Энэ үүнээс

269.9 сая ам.долларыг бид урьдчилж олсон орлого буюу өмнө нь мөнгийг нь аваад, дараа нь нүүрсийг нийлүүлэх нөхцөлтэй өгчихсөн. Үүний өрийг нь бол дарсан.

Нөгөө талдаа бид нар оффтейк гэрээнд 280, 208 сая ам.долларыг оффтейк гэрээний төлбөрт бол нүүрсээр төлбөрийг нь барагдуулсан ийм байдалтай байгаа юм. Бид энэ урьдчилж олсон орлого гэдэг дээр 603 сая ам.доллар урьдчилаад авчихсан, дараа нь нүүрс нийлүүлэх нөхцөлтэй. Энэ дээр бид яаралтай дуусах талд нь бол яах вэ ажиллаж байна. Гэхдээ яг бодитоор 1 тэрбум 260 сая ам.долларын борлуулалт.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт болсон уу? Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Би 2, 3 асуулт асууя. Ямар ч байсан ингээд үр дүн бол гарч байгаа нь бодитой, бүгдээрээ харж байна. Тэгээд ямар ч байсан энэ БЭТ томилоод явсан нь бол зөв байсан байна гээд. Харин сунгах уу, үгүй юу гэдэг дээр бол хэрэв энэ завсрын шилжилтийн үед сунгах шаардлагатай байна гэх юм бол сунгах нь зүйтэй байх. Харин ямар хугацаагаар яаж сунгах юм бэ зохицуулалтаараа 1 удаа сунгах юм уу, аль эсвэл ингээд сунгаад яваад байх юм уу тэрэн дээр нэг тайлбар өгөөч.

Хоёрдугаарт болохоор энэ бид нарын ойлгож байснаар бол ам нөхцөлөөр, хямдхан үнээр маш их нүүрс зарсан. Бүр тэрнээсээ маш хямдхан үнээр оффтейк гэрээ байгуулсан. Тэгээд оффтейк гэрээ бол нийт 19 их наяд төгрөгийн оффтейк гэрээ байна гээд. Гэтэл өнөөдөр энд үзүүлсэн мэдээллээр болохоор 179.6 мянган доллар 179.6 доллароор 1 тонныг зарж байна 2023 оны 3 сарын 29, 2023 оны 2 сарын 9 гэхэд 179.1 ойролцоогоор 180 доллар зараад байна. Гэтэл бид нарын нөгөө оффтейк гэрээ чинь дунджаар 50, 60 доллароор л бодоод авчихсан байгаа шүү дээ. Асар их

зөрөө гарч байгаа биз дээ энэ. Тэгээд дунд нь тээврийн зардал гээд тэгэх нь 30-50 доллар юм байна гэж ойлгосон. Уг нь бол төмөр замаар тээвэрлэх юм бол 8 доллар гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ зөрөөтэй яваад байна.

Одоо асуулт нь та бүгдийн энэ мэдээлэл дээр чинь оффтейк гэрээ 208 долларын санхүүжилт өгсөн гэсэн ийм 1 тоо явж байх юм. Тэгээд өмнө нь надад өгч байсан мэдээллээр оффтейк гэрээний санхүүжилтийг бол зогсоосон. Тэгээд шаардлагатай бол хөндлөнгийн аудит хийгээд, тэгээд гэрээндээ үнэлгээ хийгээд, тэгээд үнэхээр бодитой байна гэх юм бол цаашаа үргэлжлүүлэе. Үгүй бол энийгээ бол зогсооно гэсэн ийм байр суурьтай байгаа л гэж би ойлгосон. Гэтэл энэ санхүүжилт чинь яваад байгаа юм уу Ганбат даргаа?

Өөрөөр хэлэх юм бол нөгөө 1 өмнөх тэр ам нөхцөлтэй зах зээлийн хямдхан үнэтэй нүүрсээ ингээд өгөөд л байгаа юм уу? Гэтэл бодит байдал дээр чинь энэ одоогийн зохицуулалтаар цахимаар үнэ тогтоож байна. Энэ үнэ чинь болохоороо тэрнээс чинь 3 дахин илүү өндөр үнээр бид нар борлуулж чадаад байна шүү дээ. Гэтэл өмнөх тэр оффтейк гэрээнийхээ хүрээнд ингээд нүүрсээ хямдхан өгсөн хэвээрээ байгаа юм уу? Энэ дээр 1 тодорхой хариулт өгөөрэй.

Дараагийн 1 асуулт нь энэ төмөр замын холбоосны асуудал байна. Би газар дээр нь очиж зүүчихсэн. Бүх боомт дээр Эрдэнэс тавантолгой компани тэгээд тавантолгой төмөр замын компани гүйцэтгэгч компаниудтай нь очиж уулзсан. Газар дээр нь үзсэн, шилжүүлэх байгууламжийг нь харсан. Тэгээд тэр 1 цаашаагаа Хятадын талаас ирж байгаа төмөр зам, манай төмөр зам 2 чинь 2, 3 километр зөрчихсөн. Тэгээд тэрийг холбоё гээд тэгэхээр дунд нь баахан бүтээн байгуулалт явчихсан юм байна лээ шүү дээ. Тэгээд баахан компаниуд газар авчихсан. Тэгээд энийгээ ингээд холбохын тулд нэлээн өндөр зардал

гаргах ийм нөхцөл байдал үүсчихсэн байна. Тэгэхээр эндээс чинь яг ямар хэмжээний санхүүжилтийг та нар гаргах юм бэ? Та нар гаргах юм уу аль эсвэл дахиад нүүрсээрээ санхүүжүүлэх юм уу яах юм бэ? Яг санхүүжилтийг хэн хийх юм, ЗТЯ-наас хийх юм уу яах юм, концессоор хийх юм уу яах юм бэ? Улсын төсөв дээр бол тийм хөрөнгө оруулалт бол байхгүй.

Тэгээд энэ холбоосыг чинь яаралтай хийхгүй бол тэр 1 төмөр зам хийсний чинь ямар ч үр дүн гарахгүй юм байна лээ шүү дээ. 1, 2 жилийн дотор гайхамшигтай сайхан янзын сайхан энд төмөр зам барилаа гээд байсан. Тэгээд ямар ч ашиглалт байхгүй мухар зам чинь бодитой л юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ дээр та нар яг ямар байр суурьтай байгаа юм бэ?

Тэгээд дараагийн асуулт нь энэ Сангийн яамны ТНБД үргэлжлэх юм уу, үгүй юм уу? Сангийн яам чинь манайх шиг ажилтай шүү дээ. Би Ганбат даргыг бол мэдэж байгаа, мэргэисэн тэндээ ажиллах ёстой хүн. Гэтэл давхар ингээд энд Эрдэнэс тавантолгойн ингээд БЭТ-ээр ажиллаад байх юм уу, яах юм бэ? Тэгээд энэ дээр 1 бас хариулт.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Доржханд гишүүний асуултад хариулъя. Ганбат дарга хариулах уу?

Ж.Ганбат: Доржханд гишүүний асуултад хариулъя. Тэр оффтейк гэрээтэй холбоотой төмөр замын төслүүдийн санхүүжилт яг оффтейк бол ингээд 4 гэрээ дотроо дэд 38 гэрээтэй. Тавантолгой Гашиунсухайт төмөр замын дээр 27 дэд гэрээ, Богдхаан төмөр зам дээр 9 дэд гэрээ бол байсан. Энэ гэрээнүүдийг бол бид дуусгавар болгоод одоо 1 гэрээ үлдсэн. Бид ам нөхцөлөөр сунгая гэдэг хүсэлт тэрийг нь бол бүгдийг нь зогсоосон. Энэ 1 гэрээ үлдсэн. 1 гэрээ нь бол хугацаа нь 24 оны 12 сарын 31-нд дуусахаар байгаа.

Бид энэ гэрээг мөнгөн хэлбэрээр төлбөрийг нь өгье, нүүрсний үнэлгээг нь өөрчилье гэдэг удаа дараа хэлцэл хийсэн. Хамгийн сүүлд Бодь энэ тэр, тэр Бодь компанитай уулзсан уулзалт дээр бол бид төлбөрөө төгрөгөөр, гүйцэтгэлийг нь ингээд мөнгөөр авъя гэдэг ийм байр суурь бол илэрхийлсэн байгаа. Тэгэхээр бид нүүрсээр бол энийгээ ойлголцоод гэрээндээ өөрчлөлт оруулчих юм бол нүүрсээр төлбөрийг нь хийхгүй, бид нар төлбөрийг нь нөгөө мөнгөөр төгрөгөөр ингээд хийдэг энэ юм руу шилжүүлэх бол хэлэлцээрийн үр дүн бол гарч байгаа гэж ингэж үзэж байгаа. Энэ дээр бол 2 талдаа гэрээгээ эцэслэж байгуулах ийм асуудлууд дээр бол ажиллаад бол нэг талд нь гарч байгаа гэж ингэж үзэж байгаа.

Нөгөө талдаа тэр 5 тэр Тавантолгой Гишүүнсүхайд төмөр замын холболтын асуудал тийм зөрсөн асуудал үнэхээр байгаа. Гэхдээ сая энэ хавар 2 сар сард энэ асуудлаар бол Зам, тээврийн яам дээр энэ холболтын ТЭЗҮ зураг төсвийн асуудал нь бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлачихсан байгаа. Энийгээ эхлээд дүгнээд, дараа нь мөн бас нээлттэйгээр гүйцэтгэгчээ сонгон шалгаруулж, санхүүжилтийн хувьд бол бид заавал нүүрсээр гэдэг бол асуудал бол тавихгүй байгаа Засгийн газрын түвшинд бол. Энийг бол яг санхүүжилтийг нь явдаг зарчмаар нь явуулъя гэдэг ийм байр суурийг бол илэрхийлж байгаа.

Яах вэ мэдээж нөгөө энийг гүйцэтгэгч компанийг нь сонгохдоо тендерийн нөхцөл байдал дээрээ бид энэ асуудлаа хэлнэ. Аль болох бид нүүрсээр гэдэг асуудал руу бид орохоос аль болохоос бол зайлсхийж байгаа. Ер нь бол энэ өөрөө эргээд буруу юм гэдэг ийм байдал дээр бол байр сууриа бол Тавантолгой компанийн зүгээс илэрхийлж байгаа, болчихлоо.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Ганбат дарга юу яачих тийм ээ. ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга

Ганбат сүүлийнх асуултад хариулъя. 81 дүгээр микрофон өгөөрэй.

Б.Ганбат: Доржханд гишүүний асуултад хариулъя. Хугацааны асуудал асуусан. Хуулийн 3 дугаар зүйл дээр бол 1 удаа 6 хүртэл сараар сарын хугацаагаар сунгаж болно гэсэн ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ хуулийнхаа дагуу явах байх гэж ингэж ойлгож байгаа.

Дараагийн асуудал энэ нөгөө Сангийн яамны ТНБД-аар үргэлжлээд байх уу гээд. Өнөөдрийн орж ирж байгаа асуудал бол онцгой дэглэмийн хугацааг сунгах асуудал орж ирж байгаа юм. Онцгой дэглэмийн хугацаа хууль тогтоох байгууллага сунгасан тохиолдолд Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг үргэлжлүүлэн ажиллуулах эсэх асуудлыг Засгийн газар шийдвэр гаргах ийм шаардлагатай болно. Тэгээд тэр үеэр нь тулбал энэ асуудал нь Засгийн газар дээр зохих журмын дагуу хэлэлцэгдээд ингээд шийдвэрлэгдэх байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: 1 гишүүн асуулт асууж, уг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Санал хураалтад бэлтгээрэй. Доржханд гишүүн яах юм тодруулах юм уу? Тодруулж асууя. Дэмжсэн, дэмжээгүй үг бол байхгүй.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр нөгөө Хэрэг эрхлэхийн Ганбат дарга та бас Сангийн яаманд ажиллаж байсан. Тэгээд нөгөө Сангийн яамныхаа ачаа үүрдэг л дээ. Тэгээд цаашаа бас ингээд 6 сар ингээд явна. Төсвийн үе эхэлнэ. Тэгээд наад хүн чинь бол Сангийн яамандаа хэрэгтэй хүн л дээ. Тэгэхээр нөгөө ачаа үүрдэг хүмүүсийгээ ингээд та нар дахиж, дахиж ачаалаад, тэгээд аягүй бол нөгөө нийгмийн асуудал руу, нэг улс төрийн юм руу ингээд холиод явчих юм. Төрийн алба нь төрийн албаараа байдаг бол зүгээр шүү. Би зүгээр санал хэлж байгаа шүү. Засгийн газар дотроо бас ярилцаарай.

Харин бүрэн эрхт төлөөлөгчөөс би 1 юм асуугаад тодруулаад байгаа нь энэ л дээ. Энэ төмөр замын тэр холбоосыг чинь хэн санхүүжүүлэх юм бэ, эх үүсвэр нь хаана байгаа юм бэ? Эрдэнэс тавантолгой санхүүжүүлэх юм уу эсвэл концессоор хийх юм уу? Тэгээд санхүүжүүлсэн тохиолдолд та нар ямар байдлаар санхүүжүүлэх юм бэ? Энэ дээр 1 хариу өгөөч. Тэгээд цаашидаа бол ингээж 1 компани төсвийн шинж чанартай шийдвэр гаргадаггүй баймаар байгаа байхгүй юу. Ялангуяа төрийн өмчийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Доржханд гишүүний асуултад бүрэн эрхт төлөөлөгч Ганбат хариулъя.

Ж.Ганбат: Яах ер нь бол яг тантай санал нэг байгаа юм. Энэ компани ингээд бүх юмыг нуруун дээрээ үүрээд яваад байх юм бол бид энийг бол даах ийм боломжгүй болчихоод байгаа юм. Нөгөө талдаа одоо бид өмнө нь энэ төмөр замын төслүүдийн явж байсан алдааг бас давтмааргүй байгаа юм. Нүүрсээр энийг санхүүжүүлдэг. Тэгэхээр яг зарчмаараа үүнийгээ тэр ямар зарчмаар хөрөнгө мөнгөө босгоод, тэрний эргэн төлөлт дээрээ тэр нэг төмөр зам нь холбогдоод ирэхээр аяндаа өөрсдөө орлогоо олно, олсон орлогоосоо энэ босгосон санхүүжилтээ буцаан төлдөг ийм зөв механизмыг нь бүрдүүлээч гэдэг ийм л байр суурийг бид баримталж байгаа.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя. Одоо санал хураалт эхэлнэ гишүүд.

Б.Баттөмөр: Аливаа ажлын үр дүн тоогоор илэрхийлэгддэг. Монгол Улсын 2023 оны 1 дүгээр улирлын статистик гарсан. Тэгээд ингээд үзэхээр 30 жил алдагдалтай явсан төлбөрийн тэнцэл 66.2 сая долларын ашигтай, тэгээд урсгал данс 191 сая долларын ашигтай, тэгээд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 656 тэрбум төгрөгийн ашигтай гарч байгаа байхгүй

юу. Тэгээд энийг яг юу болоод ингээж сайн үзүүлэлт гарав гэсэн чинь бол Эрдэнэс тавантолгойн л үйл ажиллагаа идэвхэжсэнтэй холбогдож л ингээж гарч байгаа юм л даа. Тэгээд 1 төсөл ингээд сайн ажиллахад ингээж байна шүү дээ.

Тэгэхээр энэ бол Монгол Улсад маш их боломж байна. Бид энэ яг энэ зөв зам руугаа сая ингээд явж байгаа. Одоо ингээд энийгээ ингээд улам лавшруулаад, улам их боломжуудыг гаргах, энэ баялаг дээр их сайн менежмент хийх боломж байна шүү гэдгийг л бидэнд харуулаад байгаа юм л даа. Тэгээд энэ ордыг бол Орос Монголчууд анх социализмын үед байгуулаад, 7.2 сая тонн юу тэрбум тонны нөөцтэй гээд ингээд гаргачихсан. Тэгээд энд 1 хэлсэн бичсэн юм байгаа юм л даа. Энэний эрсдэл бол яг технологийнх нь дагуу ашиглахгүй бол их хохирол гарна гэсэн тийм үг үсэг байдаг гэж надад 1 инженер нь ярьж байсан юм. Тэгээд ингээд аваачаад үзэхээр зэрэг энэ хулгай нүүрлэх болсон шалтгаан нь бол хамгийн нэгдүгээрт нь их олон хэсэг болгосон. Хоёрдугаарт нь ил тод биш. Гуравдугаарт нь удирдлагын менежмент засаглал муу байсан. Ийм шалтгаануудын улмаас л энэ хулгай нүүрлэсэн гэж ингээж байгаа юм л даа.

Тэгээд 7.2 сая тонныг бол нэмнэ, тэрбум тонныг нэмэгдүүлэх боломжтой. Харамсалтай нь өнөөдөр эргэн тойронд гаднын компани авчихсан ийм л байдалтай л байгаа юм л даа. Технологи зөрчвөл ямар хохирол гардгийг бол ОТ юу Эрдэнэс тавантолгой дээр харагдаж байгаа шүү дээ. Тэр нөөц дээр нь аваачаад баахан овоолго хийчихсэн байдаг юм гэсэн. Тэгээд энэ энэ тэрийг энэ овоолгуудаа маш их хэмжээний зардал гарч, зөөнө гэсэн ийм тооцоо байдаг юм байна лээ. Энийг би Ганбатаас асууж байгаа юм энэ асууя гэж бодож байна. Энэ яг ийм юм байна уу, үгүй юү?

Эрчим хүчний нүүрс шатааж байна гэж. Энийг ашиглах чиглэлээр ямар юмнууд хийх вэ гэж. Төр засгийн

зүгээс бол цаашидаа бол энэ оффтейк гэрээ урьдчилж авсан гэрээнүүдийнхээ учрыг олох шаардлагатай. Мухар төмөр замынхаа асуудлыг шийдэх ёстой, дулааны станцаа барих ёстой, баяжуулах үйлдвэрээ байлгах ёстой. Ил тод хувьцаат компаниуд болгох ёстой, биржээр худалдах ёстой гээд ингээд маш их олон асуудлууд байгаа. Энэ болгоноо дэс дараатай шийдэх ийм шаардлагатай гэж.

Монголын ард түмний өнөөдрийн байдлаар 28.7 хувь нь ядуурчихсан байгаа. Ядуурах магадлалтай улсуудыг нь тэгээд ингээд аваад үзэхээр 42.6 хувийг нь бол ядуурч болигүй гэсэн ийм тооцоо байдаг юм. Энэ бол зүгээр хувь хүмүүстэй холбогдсон ч юм биш байгаад байгаа юм. Энэ би бол голдуу энэ төрийн бодлоготой холбоотой гэж бодож байгаа. Яагаад энэ улсууд ингэж ядуурах болов. Төрийн алдаатай бодлого. Энийг энэ орд газрын тодорхой хугацаанд бэлтгэлийг нь хийсний үндсэн дээр дөч хүртэл хувийг нь энэ ядуурч байгаа энэ улсууд Монголын ард түмэнд эзэмшүүлье гэсэн ийм хуулийн төсөл Их Хурлын даргад өргөн барьчихсан байгаа. Энийг ажил болгох хэрэгтэй.

Маш том, том Эрдэнэттэй дүйх ордуудыг 1 компанид өгчихсөн нь 20 жил ингээд л хараад сууж байна шүү дээ. Оюу толгойтой дүйх тэнцүү ийм ордыг Оюу толгойтой дүйж болохуйц ийм хэмжээний ордыг хувь хүн авчихсан. Олон сая доллароор худалдана гээд л ингээд л явж байгаа шүү дээ. Яагаад ингэж ард түмнээсээ харамлаад байдаг юм бэ? Энийг би энд попорч байгаа юм биш. Ер нь бол энэ ард түмэнд энэ баялгийг нь өгөх хэрэгтэй. Энэ 19 гишүүнтэй гишүүн санаачлаад хулгайтай тэмцэх ийм лобби бүлэг байгуулсан байгаа. Өнөөдөр энэ юутай боомтын хянан шалгах ажлын хэсэгтэй хамтраад бол ажиллаж байгаа. Бид нар энэ дээр бол ажиллана. Энийг одоо хийнэ. Энийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Юу яачих хариулсны дараа тодруулж асууна. Баттөмөр гишүүний асуултад бүрэн эрхт төлөөлөгч Ганбат хариулъя.

Ж.Ганбат: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс тавантолгой компани 2011 онд экспортоо хийгээд анх үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм байна лээ. Гэтэл энэ дээр бас 1 асуудал үүсээд байгаа нь нөгөө орон нутгийн Тавантолгой 2004 оноос 2012 он хүртэл Эрдэнэс тавантолгой нөгөө нүүрстэй тусгай зөвшөөрлийн талбайд 17 сая метр куб хөрсний овоолго ингээд үүсгэчихсэн. Яах вэ тухайн үеийн яагаад үүсгэсэн гэдгийг нь судлаад, тухайн үеийн судалгаагаар бол нүүрсгүй талбай гэж тооцоод овоолгоо үүсгээд ингээд явчихсан.

Гэтэл яг өнөөдөр үзэхээр манай энэ доороос нь нүүрсээ бид нүүрстэй талбай болж таарсан. Судалгаагаа хийгээд үзэхээр. Тэгэхдээ үүнийг үе шаттайгаар ингээд шилжүүлэх талаар орон нутгийн Тавантолгойтой хамтраад бол ингээд ажиллаж байгаа юм. Ийм бол ингээд асуудал бол яг энэ овоолго үүссэнтэй холбоотой юм байна.

Нөгөө талдаа Эрдэнэс тавантолгой компани яг нөөцийг нь бол хатуу коксжих нүүрс 2 тэрбум тонн энэ нь 31 хувь эзэлж байгаа. Хагас коксжих нүүрс 1.4 тэрбум тонн буюу 21 хувийг нь эзэлж байна. Эрчим хүчний нүүрс 2.9 тэрбум тонн буюу 48 хувийг эзэлж байгаа. Яг 11 оноос эхэлж үйл ажиллагаа явуулаад өнөөдрийг хүртэлх хугацаанд Эрдэнэс тавантолгой компани дандаа нүүрсээ сорчилж ирсэн. Дандаа сайн чанарын нүүрсээ зарж эхэлсэн. Энэтэй холбогдуулан их хэмжээний эрчим хүчний нүүрс, хагас коксожсон нүүрсний овоолгууд бий болсон. Бид цаашидаа яг саяын энэ тоонуудыг би зориуд хэлээд байгаа нь бид цаашидаа эрчим хүчний нүүрс, энэ хагас коксожсон нүүрсийг бид борлуулах зайлигүй ийм шаардлага бол үүсээд байгаа юм. Энэ хүрээндээ бид сая бирж дээр 200000 тонн эрчим хүчний

нүүрсийг бид биржээр арилжиж үзсэн. Энэ дээр бол амжилттай бол зарагдсан. Мөн сул коксожсон нүүрсийг сая 4 сарын 14-нд бид туршилтын байдлаар бас зарж үзсэн. Энэ бол амжилттай зарагдсан. Тэгэхээр бид цаашидаа энэ эрчим хүчний нүүрс, хагас коксожсон нүүрсийг бид амжилттай борлуулж байж цаашаа явна гэдэг ийм байдлаар сорчлохгүй гэдгийг бол энд албан ёсоор хэлж байгаа юм.

Нөгөө талдаа Тавантолгой станцыг хэрэв ашиглалтад оруулах юм бол Эрдэнэс тавантолгой компанийн энэ эрчим хүчний нүүрсийг бол бид Тавантолгой станцад нийлүүлэх ийм бол бүрэн бололцоотой. Энэ дээр 1.4 сая тонн эрчим хүчний нүүрсийг бол Тавантолгой станц бол хэрэглэх бол ийм бол тооцоотой байгаа. Тэгэхээр бид цаашидаа энэ сорчлохгүйгээр аль болох ингээд үр ашигтай энэ бүх гаргаж байгаа бүтээгдэхүүнээ зарж борлуулах талд нь онцгой анхаарч ажиллах тэгээд ийм шаардлага бол бий болж байгаа.

Хувьцааны асуудлыг бол би Эрдэнэс тавантолгой компанийн яг 18.4 хувийг нь 2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн Монгол Улсын 2.5 сая иргэд бол эзэмшиж байгаа. Бид энэ дээр Засгийн газрын түвшинд нийт Монголын бүх хүн амдаа ер нь энэ Эрдэнэс тавантолгой компанийн өгөөжийг бас яаж хүртээх вэ гэдэг бас энэ асуудал дээр бол ажиллаж байгаа. Мөн энэ дээр 2012 оны 4 сарын 11-нээс хойш төрсөн иргэдийгээ бас яаж хамруулах вэ гэдэг энэ. Бид бол 1 зүйл дээр бол Засгийн газрын түвшинд бол Эрдэнэс тавантолгой компани Засгийн газрын түвшинд ойлголцож байгаа нь Засгийн газраас өгч байгаа чиглэл яг компанийнхаа тэр засаглалынхаа хувьд яв, ногдол ашиг хуваарилах энэ асуудлыг компани өөрсдөө шийдээд, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаараа хуулийнхаа дагуу шийдвэрлүүлдэг байя. Энэ дээр ямар нэгэн байдлаар Засгийн газрын зүгээс болон ийм улс төрийн байдлаар оролцох нь бол буруу юм гэдэг ийм байдал дээр бол чиглэлээ өгөгдөөд,

энэ чиглэл рүү бол ажиллаж байгаа. Бид аудит хийсэн тайлангаа ТУЗ-дөө бол ирэх долоо хоногт танилцуулна. 4 сарын 28-нд Эрдэнэс тавантолгой компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болно. Энэ асуудал дээр бол ногдол ашгийн асуудлыг бол танилцуулж бол шийдвэрлүүлнэ.

Г.Занданшатар: Завсарлага авахаар хүсэлт. Баттөмөр гишүүн тодруулж асууна. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Зах зээлийн эдийн засагт энэ эрэлт, нийлүүлэлтээр зохицуулагдаагүй юмыг энэ төрийн оновчтой зохицуулалтаар зохицуулдаг хуультай. Эдийн засгийн ийм онолтой. Тэгэхээр Засгийн газар энэ дээрээ тэр хувьцаа эд нар, эд нараа эзэмшүүлэх талаар зоригтой шийдвэр гаргах ёстой. 2005 оноос хойш төрсөн Монголын энэ хүүхдүүдэд бүгдэд нь хувьцаа эзэмшигч болох ёстой шүү дээ. Энэ 14 хувийг нь хүмүүс эзэмшиж байгаа юм чинь энүүгээрээ дамжаад энэ нээлттэй болгох, энэ хөрөнгийн бирж дээр. Энэ Энержи Ресурс гэж компани байгаа шүү дээ. Үнэхээр загвар байж байгаа шүү дээ. Энийг өдөр болгон энийг харах ёстой шүү дээ. Тэр Хонгконгийн хөрөнгийн бирж дээр бүх мэдээллүүд нь явж байна шүү дээ. Тэгээд ингэж байж л энэ одоо энэ амжилт гарна шүү дээ тэгээд. Тэгээд энийг хийвэл яасан юм бэ?

Би Ганбатаас асуух гэж байгаа юм энэ Засгийн газрын. Энэ Монгол Улсад энэ эрх ашгийн эрэмбэ гэж байдаг бол хамгийн түрүүнд хийгдэх ёстой ажил энэ Тавантолгойн цахилгаан станц шүү. Энийг 2024 онд энэ тэр суурийг нь тавьчхаад эхлүүлэх ёстой. Мааш их үр ашигтай ажиллах ийм станц энд байгаа шүү. Нүүрс нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганбат дарга хариулъя 81.

Б.Ганбат: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тийм энэ хувьцааны эзэмшлийн асуудал сая бас манай бүрэн

эрхт төлөөлөгч маань хариуллаа. Өнөөдөр яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Компанийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль байгаа. Хувьцаа дээр бол ямар тохиолдолд ногдол ашиг хуваарилж болох вэ гэдэг ийм асуудал хуульчлагдаж зохицуулагдсан байгаа. Тэгэхээр тэр нөхцөл байдлыг тэр тухайн хуулийн этгээдийн эрх бүхий субъект буюу Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бол ингээд зохих журмын дагуу шийдвэрээ гаргаад явна.

Ингэхэд энэ хөндлөнгийн нөгөө санхүүгийн хяналт гэдэг энэ чиглэлээрээ хөндлөнгийн аудитын байгууллагын аудитлагдсан тайлан заавал гарсан байх ийм зайлиггүй шаардлага байгаа юм. Өнөөдөр.../минут дуусав/

Г.Занданшатар: 81 гүйцээгээд хариулчихъя.

Б.Ганбат: Өнөөдрийн байдлаар бол Эрдэнэс тавантолгой компани дээр бол хуримтлагдсан өр төлбөр бол их байгаа. Тэгэхээр Баттөмөр гишүүнээ яг энэ харьцааны асуудлыг бол та маш сайн ойлгож байгаа. Ер нь бол 22 оны жилийн эцсийн үйл ажиллагаагаараа бол хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 1.3 их наядын ийм ашигтай гарах ийм магадлалтай байгаа. Аудиталсан тайлан бол хараахан гараагүй байна. Хуримтлагдсан өр төлбөр бол нэлээдгүй байгаа гэдгийг бол танд мэдээлэл болгож хэлье.

Дараагийн таны асуулт бол Тавантолгой цахилгаан станцын асуудал. Энэ цахилгаан станц Тавантолгой цахилгаан станцтай холбогдолтой асуудал дээр санхүүжилтийн эх үүсвэрийн асуудал нэлээн яригдаж байгаа. Энийг бол Засгийн газрын түвшинд бол энэ цахилгаан станцтай холбоотой эх үүсвэрийн асуудлыг ямар журмаар, яаж шийдэх вэ гэдэг хамгийн оновчтой хувилбарыг сонгоё гэдэг ийм асуудлаар нэлээн тал талаасаа олон өнцгөөс ярьж байгаа. Энэний ер нь бол

асуудлаа шийдлээ гаргалгаагаа, эх үүсвэрийнхээ бололцоогоо, гадаад дотоод бүх төрлийн эх үүсвэрийн сувгуудыг дайчлаад энэ дээр санхүүжилтийнхээ боломжийг гаргах ийм шийдэл, гарц гаргалгаа бол гарна гэж ингэж бол бодож байгаа.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглана уу. Санал хураалт явуулах бэлтгэлийг хангая. Ер нь бол Байнгын хороодоор хэлэлцэх явцад ч гэсэн тэр Эдийн засгийн байнгын хорооны даргыг дуудъя. Хэлэлцэх явц ч гэсэн, сая хэлэлцүүлгийн хувьд ч гэсэн анхааран ажиглаж байхад бол энэ БНМАУ-ын Засгийн газарт чиглэл өгөх тухай хууль бол хууль тогтоомжийг бас хэрэглэхгүйгээр шууд эрх зүйн тусгай журам тогтоох асуудлыг хуульчилсан. 91 оноос хойш нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал бол бүрэн өөрчлөгдөж, шинэчлэгдэж шинэ Үндсэн хууль гарч, шинэ эрх зүйн орчин буй болсон. Тэгээд энэ Үндсэн хуульд яг энэ шилжилтийн үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс 90-92 оны үеийн шилжилтийн үеийг зохицуулсан, тухайн үеийн протоколыг уншиж үзэхэд бол тэгээд өмч хувьчлал, хоршооллын өмч, улсын өмч эзэнгүйдэж байсан улсын үйлдвэрийн газрууд дээр бол онцгой дэглэм тогтоох зайлиггүй шаардлага гарч, хулгай зэлгий, дарханы үйлдвэрүүдээр тоног төхөөрөмжүүдийг зарсан, үрэгдүүлсэн, хоршооллын өмчид шилжүүлсэн ийм асуудал бол гарч байсан учраас төр үйлчлэх журам гарсан ийм практиктай юм байна лээ.

Мөн эрх зүйн хувьд бол Улсын Баг Хурлын бүрэн эрх бол Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар 92 онд батлагдсан хуулиар бол Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бөгөөд эрх залгамжлагчийг Улсын Их Хурал гэж үзэхгүй гэж заасан. Тэгэхээр Улсын Их Хурал бас энэ асуудлыг 19 онд Эрдэнэтэд авч хэлэлцэхдээ бол Эрдэнэтэд бол тухайн үед онцгой дэглэм

тогтоосон өмнөх практик байгаа учраас Эрдэнэт үйлдвэрийн тохиолдол дээр энэ эдийн засгийн онцлог нөхцөл байдал, тэр хуулийн нийтлэг журамтай нийцэж байна гэж тогтоогоод, энэ хуулийг бол хүчингүй болгоорой. Нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчин өөрчлөгдсөн учраас ийм дагавар протоколтойгоор 19 оны хугацаа сунгах асуудлыг хэлэлцэж тогтоол баталсан.

Тэгэхээр энэ хууль бол үндсэндээ агуулгын хувьд БНМАУ-ын Засгийн газар, Улсын Бага Хурал гэсэн институтууд байхгүй бөгөөд энэ шилжилтийн зохицуулалт үйлчлэхгүй болсныг харгалзаж үзье. Энэ хуулийг хүчингүй болгох асуудал хууль бол хэлэлцэгдээд дэмжигдчихсэн. Эрх зүйн чадамжийн хувьд бол анхны хэлэлцүүлэгт орогдоод явж байгаа гэж үзэж болно. Тэгэхээр тэр хууль хүчингүй болчихоор, хүчингүй болчихоор энэ процесс маань яаж хэрэгжих вэ? Энэ тогтоолын төслийн заалтуудыг бас энэнтэй нийцүүлж энэ хуулийг хүчингүй болгож, энэнтэй нийцсэн ер нь тэр Онцгой дэглэм тогтоох журмыг шаардлагатай бол Засгийн газрын хэмжээнд өөрөө зохицуулдаг эрх хэмжээ болгосон ийм зохицуулалт, шинэ эрх зүйн хуулийг батлах ёстой.

Ер нь бол 9 хууль байна. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан боловч одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа хүчингүй болгоогүй Эрүүгийн хууль байна 86 оны Эрүүгийн хууль. Энэ хууль хэрэглээнд байхгүй. Тэгсэн мөртөө энэ хүчингүй болгоогүй. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хууль байна 57 оны хууль, энийг хүчингүй болгоогүй. Тэгэхдээ энэ хуулийг хэрэглэхгүй байгаа. Газрын хэвлийн тухай хууль байгаа. Өршөөл үзүүлэх тухай хууль байгаа. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль байгаа. БНМАУ-ын тэтгэмжийн хууль байгаа. Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хууль байгаа. Тэгээд энэ

хуулиуд маань бол хууль хэрэглээнд байхгүй. Гэхдээ хүчингүй болоогүй байгаа. Тэгээд энэ 9 хуулийг хүчингүй болгох асуудлыг яаралтай шийдэх асуудлыг энэ тогтоолын төсөлд тусгах шаардлагатай. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль гэж байгаа юм.

Ийм учраас энэ тогтоолын төслийг хуулийн зөрчлийг нь бас арилгаад, энэ заалтыг нэмээд энэ 9 хуулийг бас цаашидаа хүчингүй болгох, эрх зүйн үр дагаврыг хүчингүй болсон тохиолдолд энэ чинь, одоо Компанийн хуулийг чинь энэ 4 сард батална гээд яриад байгаа шүү дээ. Тэгээд Төрийн өмчийн компанийн хуультай энэ хууль батлагдчихвал энэ бас нөхцөл байдал өөр болно. Ер нь бол цаашидаа энийг бас онцгой дэглэм гэж юуг хэлэх юм, онц байдал гэж юуг хэлэх юм, онцгой нөхцөл байдал гэж юуг хэлэх юм, ковидын нөхцөл байдал гэж юуг хэлэх юм энэ нөхцөл байдал уялдаж байгаа. Ийм учраас энийг нэг мөр журамлаж хэрэглэх шаардлагатай байгаа юм.

Ер нь бол төлөөлөгч томилоод, төрийн өмчийн компаниуд дээр бол хэрэглэх бололцоотой. Энэ хуулийн бас I агуулга нь бол социалист өмчийн социалист эрх зүйн үед мөрдөгдөж байсан хууль учраас өмчийн хэвшил харгалзахгүйгээр онцгой дэглэм тогтоох бололцоог олгож байгаа public компани чинь. Энэ маань гадаадын хөрөнгө оруулагчид болон энэ эдийн засгийн хөрөнгө оруулалтын орчинд бас сөрөг сигнал болж өгч болзошгүй энэ тэрийг харгалзан үзэж, тогтоолын төслийг бол дахин боловсруулах шаардлагатай гэж үзэж байгаа, үзэж байна. Ийм учраас 93.3-аар анхны хэлэлцүүлэгт нь буцаах ийм горимын санал гаргаж байна.

Эдийн засгийн байнгын хороо энийг ахиж хэлэлцээд, маргааш чуулганаар хэлэлцэж, энэ тогтоолын төсөл дээр бол 93.1-ээр явж байгаа учраас энэ хэлэлцэх эсэх байхгүй. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль өргөн, тогтоолын төсөл өргөн мэдүүлэхээр

явсан бол 3 хэлэлцүүлэгтэй яваад энэ бол амжихгүй байсан. 10 хоногийн өмнө өгөх ёстой байсан. Энэ хуулиа барья гэвэл. Сар болгон энэ онцгой дэглэмийнхээ тайланг тайлагнаж байх ёстой. Тийм учраас анхны хэлэлцүүлэгт буцаах тийм горимын саналаар санал хураалт эхлээд явуулна.

Тэгэхдээ энэ бол Эдийн засгийн байнгын хороогоор л хэлэлцэх юм байна лээ. 2 Байнгын хороогоор хэлэлцэх шаардлагагүй. Тэгээд энэ 9 хууль энэ тэрийг хүчингүй болгохгүй бол бас ийм хууль хэрэглээний ийм практик бас тогтоож болохгүй. Эрх зүйт төр, Үндсэн хууль дээдлэх ёс зарчим байна. БНМАУ-ын Засгийн газарт чиглэх тухай хуулийг Улсын Бага Хурлын өмнөөс Улсын Их Хурал хэрэглэх нь Үндсэн хууль дээдлэх ёс зарчим, эрх зүйт төр ёсны зарчимд бас хэр зэрэг нь нийцэх вэ гэдгийг. Энэ бол яах вэ 1, 2 практикийн юм гээд л хэрэглээд яваад байхаар энэ бид нар далайн орны эрх зүйтэй, жишигийн эрх зүйтэй, прецедент проба хэрэглэдэг улс бас болсон биш. Тиймээ энэ жишиг гээд ингээд үргэлжлүүлээд яваад байвал энэ хожим ийм. Тэгэхээр энийг бол ингээд 1 нөхцөл байдалдаа тааруулаад л ингээд хэрэглээд байхаар бид нар буруу хэвшил тогтоох гээд байна л даа.

Ийм учраас энэ зарчим горимын саналаар санал хураалт явна. Эдийн засгийн байнгын хороо өнөө орой юм уу, маргааш өглөө хуралдаад, тэгээд энэ тогтоолын төсөл дээрээ ахиж ажиллая. Тэгээд энэ гадаад хөрөнгө оруулагчдад ч гэсэн буруу сигнал өгөхгүй байхыг бодоод, тэгээд энэ 9 хуулиа бас хүчингүй болгох асуудлыг дурдаад, ингээд Тамгын газар хууль зүйн лавлагаа гаргасан Агар-Эрдэнэ дарга энэ тэр ажиллаад, тэгээд өглөө өнөө орой хуралдах уу, өглөө хуралдах уу харин Эдийн засгийн байнгын хороо? Ингээд өнөө оройдоо энэний дараа хуралдаад ингээд шийдчих гэж байна. Тийм. Тэгээд бид нар ингээд 1 цаг тулчихсан гээд л яарч сандраад л тухайн үед ч гэсэн тэгээд яваад байсан. Энэ их

буруу жишиг байгаа юм бас эрх зүйт төрийн хувьд.

Төрийн эрх барих байгууллага гэдэг маань хуулийг хуулиар төрийг жолоодно гэж байгаа шүү дээ. Ер нь бас ингээд БЭТ-үүд ч гэсэн 2 ажилтай, 2 эзний 1 зарсан гэдэг шиг 2 ажил ингээд л хийгээд яваад байдаг. Энийг ингээд бас Засгийн газар дээрээ ч гэсэн нэлээн ярих хэрэгтэй, цэгцлэх хэрэгтэй байх. Асуулт хариулт дуусчихсан. Тэгээд санал хураалт явуулъя. Горимын саналаар асуулт байхгүй. Чинзориг сайд тэгж Засгийн газрын гишүүн тэгж үзэж байна.

Хуульд 93.3-д хууль зүйн хувьд энэ 93.1-ээр шууд хэлэлцэж байгаа учраас 93.3-д нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно. Энд 93.3-аар санал хураалт явуулна. Байнгын хорооны тогтоолоор хүчингүй болгохгүй. Энийг Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуультай хамт энэ БНМАУ-ын Засгийн газарт чиглэх тухай хуулийг хүчингүй болгох хууль орж ирээд хэлэлцэгдээд дэмжигдчихсэн явж байгаа байхгүй юу. Энэ 9 хуультайгаа энийг ер нь нэг мөр болгоё, энэ харилцаагаа нэг мөр зохицуулах. Ганбат дарга энэ тэр суугаад өнөөдөр энүүгээр бас хууль зүйн хувьд бас зөрчилгүй байх, Цэц дээр болон элдэв маргаан дээрээ. Өмнөх Цэц дээр үүссэн гарсан шийдвэр бол бас яг энэ тухайн кэйс дээр гараагүй юм байна лээ. Тухайн үедээ энийг энэ тэр гээд. Арай өөр тайлбаруудтай. Энийгээ нэг үзэж байгаад нэг цэгц болгоё. Ингээд Байнгын хороо санаачилсан юм чинь энэ тогтоолын төслийг.

Энэ агуулгаар бол БНМАУ-ын Засгийн газарт Улсын Бага Хурлын нэрийн өмнөөс Улсын Их Хурал чиглэл өгсөн тогтоол батлах гэж байгаа юм бид нар. Засаг өргөн бариагүй, саналаа ирүүлснийг Байнгын хороо санаачилсан болоод ингээд өөрчлөгдсөн байхгүй юу. Энэ тогтоол нь өөрчлөгдсөн болчихоод

байгаа байхгүй юу. Хууль орж ирчихсэн, хэлэлцэгдээд явж байгаа юм. Тэр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиа хэзээ хэлэлцэж батлах юм, тэр энэ тэртэйгээ энэ дээр тогтоолын төсөл дээр шинээр тусгаад, эрх зүйн зөрчилгүй болгоод баталчхаж болно гэж Тамгын газар үзэж байгаа юм. Ингээд энэ горимын саналаар санал хураалт эхлээд явуулъя. Санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.3-д заасны дагуу нэгдсэн хуралдаанд шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно гэсэн энэ дэгийн заалтын дагуу Байнгын хороонд хэлэлцүүлэгт буцаахаар санал хураалт явуулъя. Тэгээд өнөөдөр хэлэлцээд маргааш шийдчихнэ гэсэн үг. Энэ асуудлыг ийм амархан, түргэн шуурхай шийдэж болохгүй гээд байгаа шүү дээ бид нар. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Олонхын саналаар энэ санал горимын санал дэмжигдсэн учраас Эдийн засгийн байнгын хороонд дахин хэлэлцүүлэг хийж эцсийн найруулга хийхээр. Эдийн засгийн байнгын хороо одоо хуралдах уу? 18 цагаас.

17.57 цаг

Дөрөв.Монгол Улсын хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах

Дараа нь горимын саналаар санал хураалт явуулна. Энэ асуудлын дараа Эдийн засгийн байнгын хороо хуралдъя. Одоо горимын саналаар Хөгжлийн банкны Монгол Улсын Хөгжлийн банкаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг Түр хорооны тайлан, санал дүгнэлтийг танилцуулах ажлаа сонсчих

уу? Сонсож байна шүү дээ. Энэ Хөгжлийн банкны Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг. Өнөөдөр хугацаа нь дуусаж байгаа юм. Хугацаатай асуудал учраас шууд хэлэлцэж болж байна уу? Тийм. Үгүй ээ, өнөөдөр томилогдож байсан юм. Тэгээд өнөөдөр эхлүүлчихье тэгэх үү, сонсчихъё, тэгээд санал хураалт байхгүй юм чинь дараа нь гарч байгаа тогтоолыг нь маргааш санал хураалтыг нь явуулчхаж болно.

Энэ юунууд чинь аягүй олон санал хураалттай учраас одоо хэлэлцэхээр энэ Үндэсний зөвлөл энэ тэр чинь хэлэлцэхээр аягүй бол уначих эрсдэлтэй учраас өглөө хэлэлцсэн нь дээр байх. Тийм. 1 жилийн ажлын тайлангаа л тавина. Тэгээд л асуулт, хариулт болоод л санал хураалтгүй дуусгачихна. Тэгээд шууд явчих уу, санал хураах уу? Ингэвэл тэгээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий Түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулна. Тайланг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц байдлыг шалгах чиг үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн Хянан шалгах түр хороо 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаж, Хянан шалгах түр хорооны тайлан гаргасныг та бүхэнд танилцуулж байна.

Хянан шалгах түр хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк байгуулагдсанаас хойших хугацааны зээл олголт, эргэн төлөлттэй холбоотой баримт материалууд болон зээлдэгч аж ахуйн нэгж байгууллага арилжааны банкнудаар дамжуулан олгосон зээлийн ашиглалт, зарцуулалттай холбоотой материал, дансны гүйлгээ, төсөл, хөтөлбөрийн үр өгөөж, Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр ашигт байдал, түүнд тавигдах дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцооны үйлчлэлтэй холбоотой баримт материалыг хамруулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хянан шалгах түр хорооноос баталсан нотлох баримт гаргуулах тухай 2022 оны 2 дугаар тогтоолын хүрээнд нотлох баримтууд цуглуулах, хяналт шинжилгээ хийлгэхээр хянан шалгалт шалгагчаар Л.Эрдэнэчулуун, И.Уянга, шинжээчээр О.Оргилмаа, О.Лхагвадорж, Б.Хишигтогтох, Б.Эрдэнэбат, Ч.Амарбаясгалан, О.Мөнхбат, Г.Лхагвадорж нарыг томилон ажиллуулсан. Хянан шалгагч шинжээч нар нь Хөгжлийн банк, Монголбанк, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний аудитын газар, АТГ, УЕП, ШШГЕГ, УБЕГ, АМГТГ-аас нийт сая гаруй хуудас цаасан болон цахим материалыг гаргуулан авч тайлан дүгнэлтээ гаргасан.

Хянан шалгах түр хороонд хянан шалгагч шинжээч нарын гаргасан тайлан дүгнэлтэд үндэслэн Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн 77 зээлдэгчийн 3.2 их наяд төгрөг, арилжааны банкаар дамжуулан олгосон 2542 зээлдэгчийн 1.6 их наяд төгрөг, Засгийн газарт шилжүүлсэн 355 зээлдэгчийн 2.5 их наяд төгрөг, тус банкны охин компаниудаас

санхүүжүүлсэн 35 зээлдэгчийн 161.6 тэрбум төгрөгийн багцын хамаарал болон зарцуулалтыг данс хөөх зарчмаар шалгаж, төсөл хөтөлбөрийн олголт хэрэгжилттэй холбоотой асуудлаар 3 удаагийн нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг нээлттэй зохион байгуулж, олон нийтэд шууд дамжуулан хүргэсэн.

Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан сонсгол нийт 13 өдрийн турш үргэлжилж, 672 иргэнийг гэрчээр дуудсанаас 356 иргэн сонсголд биечлэн оролцсон байна. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь холбогдох хуулийн хүрээнд арилжааны 12 банканд газар дээрх хянан шалгалтын удирдамжийг батлан зээлдэгч бүрийн санхүүжилтэд данс хөөх аргаар зарцуулалтыг нэг бүрчлэн шарга шалгаж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1.Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хувьд 18.3 хувь нь зориулалтын дагуу буюу зээлийн гэрээнд заасны дагуу зарцуулалтыг хийсэн, 74.2 хувь нь зориулалт бүрэн бус буюу зээлийн тодорхой хэсгийг зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, 7.4 хувь нь зээлийг 100 хувь зориулалт бусаар ашигласан, 0.3 хувь нь нягтлан нягтлах боломжгүй буюу зээлийг бэлэн зарлагын гүйлгээгээр зарцуулалтыг хийсэн байна.

2.Монгол Улсын Хөгжлийн банкны шууд зээлдэгч 77, арилжааны банкаар дамжуулан зээлдэгч 2542, Засгийн газарт шилжүүлсэн багцын 355 нь төсөл хөтөлбөрийг гүйцэтгэгч 279 компани, Хөгжлийн банкны охин компаниудаас санхүүжүүлсэн 42 зээлдэгч, нийт 3000 гаруй зээлдэгчийн идэвхтэй, идэвхгүй хувьцаа эзэмшигч, өмнөх ба одоогийн гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нар дээр бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн мэдээллийг улс төрийн хамаарлын хүрээлэлтэй тулгаж нягтлахад 125 хуулийн этгээд, 8 иргэн, нийт 133 зээлдэгч улс төрийн хамааралтай байна.

Улс төрийн хамааралтай зээлдэгчид нь Хөгжлийн банкнаас нийтдээ 1.5 их наяд төгрөгийн дүн бүхий зээл авсан байгаа нь тус банкны нийт олгосон 7.5 их наяд төгрөгийн зээлийн 20 хувийг эзэлж байна.

3.Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг олгохдоо хууль, бодлого, журмыг хангасан эсэх нийцлийг шалгахад хуулийн зорилттой нийцсэн төсөл 3 хувь, бүрэн бус нийцэлтэй төсөл 49.5 хувь, нийцээгүй төсөл 17.5 хувийг тус тус эзэлж байна.

4.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулагдаж ажилласнаас хойш зээлдэгчид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зээлийн эргэн төлөлтөө идэвхжүүлсэн нь 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийтдээ 1.08 их наяд төгрөгийн эргэн төлөлт хийгдсэнээс харагдаж байна.

5.Хөгжлийн банканд 2011 оноос хойш ажиллаж байсан гүйцэтгэх удирдлагын баг нь мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тухайн үеийн зах зээлийн хүүгийн хэмжээгээр харьцуулан тооцоолоход 120 гаруй тэрбум төгрөгийн алдагдсан боломжийн зардал үүсгэж, банкны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна гэж дүгнэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэн Хянан шалгах түр хорооны 135 хуудас дэлгэрэнгүй тайланг та бүхэнд тараасан байгаа болно. Анхааралд авсанд баярлалаа. Одоо санал, дүгнэлт.

Г.Занданшатар: Санал, дүгнэлтээ хамт танилцуулчих уу? Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна уу.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасны дагуу Хянан шалгах түр хорооны сонсголоор цуглуулж, шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан тайланг Хянан шалгах түр хороо 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Хянан шалгах түр хорооноос 3 үе шаттайгаар зохион байгуулсан нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын үр дүнгээс үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банк нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчин засаглалын хэлбэрээр цаашид үйл ажиллагаагаа явуулсан тохиолдолд Хөгжлийн банканд үүссэн хүндрэл бэрхшээл арилахгүй, нөхцөл байдал дахин давтагдах эрсдэлтэй байна. Хөгжлийн банк манай улсад байх хэрэгтэй юу гэх асуудлыг ч хөндөхөөр байна.

Иймд Хянан шалгах түр хорооноос Хөгжлийн банкиг татан буулгах, Хөгжлийн банкны үйл ажиллагааг нь өнөөдрийн хэлбэрээр үргэлжлүүлэхэд ямар эрсдэл үүсэх талаар холбогдох тооцоо судалгаа хийж дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1.Хөгжлийн банкны нийт хөрөнгө 2023 оны эхний улирлын байдлаар 3.9 их наяд төгрөг, чанаргүй зээл болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.5 их наяд төгрөг, хуримтлагдсан алдагдал 455 тэрбум төгрөг байна. Банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээрх

мөнгөн урсгалын зөрөө 2023 оны 10 дугаар сарын байдлаар 1.03 их наяд төгрөгт хүрэх, 2025 оны 12 дугаар сар хүртэл дунджаар 950 тэрбум төгрөг байхаар хүлээлттэй байна. Гадаад бондын эх үүсвэрийн батлан даагч нь Засгийн газар бөгөөд Хөгжлийн банкнийг татан буулгасан тохиолдолд дээрх алдагдал улсын төсөвт дарамт учруулах, гадаад валютын улсын нөөцөөс төлөгдөх эрсдэлтэй байна. Ийм нөхцөлд Хөгжлийн банкнийг татан буулгах нь хамгийн амархан боловч санхүүгийн хувьд өндөр зардалтай, эдийн засгийн хувьд үр ашиггүй, ирээдүйд дахин хөгжлийн хөтөлбөрүүд санхүүжүүлэх институт байгуулах шаардлага үүссэн нөхцөлд бүгдийг шинээр эхлэх шаардлага тулгарахаар байна.

2. Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдалд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд: Сүүлийн хорь гаруй жилд хэт ойртсон, зааг ялгаагүй, хаалттай, авлигажсан улс төр, бизнес, банк санхүүгийн санхүүжилтийн тогтолцоо Монгол Улсад нутагшиж, тэр нь Хөгжлийн хөгжлийн банкны засаглал, хүний нөөц, шийдвэр гаргалт, гаргалтад гүнзгий нэвтэрсэн, засаглалын хувьд зохистой зарчим хэрэгжээгүй, улс төрийн хууль бус нөлөөллөөс ангид тогтвортой мэргэжлийн шийдвэр гаргаж чадаагүй. Банкны үндсэн бизнесийн загвар нь тооцоолол судалгаа шинжилгээнд бүрэн суурилаагүй, орлого олох эх үүсвэрийн болон үйл ажиллагааны зардлыг нөхөх үйл ажиллагааны чиглэл байхгүй. Нийт зээлийн санхүүжилтийн дийлэнх нь үндсэн зорилгодоо нийцээгүй, зээлийн зарцуулалт үр дүнд хийх хяналт сул, хариуцлагын тогтолцоо байхгүй байна гэж үзлээ.

Өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банканд Хянан шалгах түр хорооноос болон төрийн бүх шатын байгууллагуудаас хийгдсэн хяналт шалгалтуудын дүгнэлтээс үзэхэд Хөгжлийн банк нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчны

хүрээнд одоогийн санхүүгийн үзүүлэлт, засаглалын хэлбэрээр цаашид үйл ажиллагаагаа хэвийн гүйцэтгэх боломжгүй гэж дүгнэж байна.

Харин Хөгжлийн банкнийг олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаатай улсын томоохон стратегийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжилтээр ханган эдийн засагт дэмжлэг үзүүлэх бодлогын банк байх үндсэн зорилго, зорилтыг биелүүлэхэд анхаарч, бодлогын шийдлүүдийг авч хэрэгжүүлж, банкны засаглалтай холбоотойгоор цаашид дараах өөрчлөлтийг Хөгжлийн банканд хийх нь зүйтэй гэж үзлээ.

1. Хөгжлийн банкны засаглал удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, банкны хяналтын Базелын хорооноос 2015 онд баталсан банканд зориулсан компанийн засаглал зарчмууд, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан компанийн засаглалын зарчмууд, төрийн өмчит компанийн засаглалын баримт бичгүүдэд засаглал удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй тайлбарыг тусгасан байгаа тул эдгээр баримт бичгүүдэд үндэслэн банкны засаглалын бодлого, эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

2. Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох, ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах.

3. Гүйцэтгэх удирдлагын багийг багаар нь сонгон шалгаруулж, гэрээ хийн үнэлэлт дүгнэлт хийн ажилладаг байх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн олон улсын жишигээр Хөгжлийн банкуудын 72 хувь нь Төв банкны, 28 хувь нь Засгийн газрын хяналтад байгааг харгалзан үр ашигтай зохистой хяналтын тогтолцоог бий болгох, банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк санхүүгийн стандартад нийцүүлж, энэ хүрээнд холбогдох эрх зүйн орчин дүрэм журмуудыг тогтоох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хорооноос дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Хөгжлийн банкныг цогцоор нь иж бүрэн өөрчлөх өөрчлөн байгуулах асуудлаар холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Хянан шалгах түр хорооноос гаргасан тайлангаар илэрсэн зөрчил дутагдал гаргасан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлаар Монгол Улсын Засгийн газарт үүрэг чиглэл өгөх шаардлагатай гэж үзлээ.

Мөн Хянан шалгах хорооны үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар сонсголд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа болно.

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаарх Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг

та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Идэрийн Уянга Түр хорооны хянан шалгагч, Лувсандашийн Эрдэнэчулуун Түр хорооны хянан шалгагч, Одсүрэнгийн Оргилмаа Түр хорооны шинжээч, Очирбатын Лхагвадорж Түр хорооны шинжээч, Баттулгын Эрдэнэбат Түр хорооны шинжээч, Батмөнхийн Хишигтогтох Түр хорооны шинжээч, Очирхуягийн Мөнхбат Түр хорооны шинжээч, Чулууны Амарбаясгалант Түр хорооны шинжээч, Жасрайн Батаа Хөгжлийн банкны тэргүүн дэд захирлын үүргийг гүйцэтгэж. Яасан орой ирдэг юм бэ чи.

Түр хорооны тайлан болон санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн бүртгүүлчихье. Баагаагийн Баттөмөр гишүүн горимын санал гэсэн, үг хэлнэ.

Б.Баттөмөр: Их Хурлын даргаа энэ таны захирамж гарч энэ оны 1 дүгээр сард ажлын хэсэг байгуулж, тэр ажлын хэсгийг би ахалж ажиллаж, нийтийн сонсгол хийж, Засгийн газарт 20 гаруй чиглэлээр үүрэг даалгавар өгчихсөн, чиглэл өгсөн байгаа. Тэгээд би өөрийнхөө бланк дээр энэ Түр хороог санаачилж, 28 гишүүн гарын үсэг зурж, энэ түр Хянан шалгах түр хороо байгуулагдаж манай Энхбаяр ахалж ингээд ажлаа танилцуулж байгаа юм байна.

Энэ материалыг энэ өглөө өгсөн, унших боломж ерөөсөө олдоогүй. Өнөөдөржингөө хуралдсан. Мааш их чухал, чухал асуудлууд энэ дотор явж байгаа. Тийм учраас би энэ хурлыг бүр үгүй ядахдаа маргааш хүртэл хойшлуулах. Болж өгвөл ирэх долоо хоног хүртэл хойшлуулъя. Энэ чинь мааш сайн унших, судлах шаардлага байна шүү дээ. Тийм учраас энд хугацааг нь хойшлуулж өгөөч гэсэн ийм горимын санал гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Баттөмөр гишүүн маргааш хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулна. Үгүй ээ үгүй энэ асуулт асуух гээд асуулт асууж, үг хэлэх хэлэлцсэн хүмүүс яачихсан юм чинь энэ асуулт, үгээ дуусгачхаад маргааш санал хураалт бусад юмаа үргэлжлүүлж болно л доо. Тэгэхдээ энэ уншигдсан хүмүүс асуулт асууж, үг хэлье гээд нэрээ өгчихсөн байна шүү дээ. Энэ хүмүүсийн эрхийг бас хүндэтгэх хэрэгтэй байна.

Зарчмын хувьд ийм нэгэнт хэлэлцээд эхэлчихсэн асуудлыг цаг дууссан байлаа ч гэсэн хойшлуулах бол санал хураалтаар шийднэ. Горимын санал гаргасан учраас. Горимын саналаар санал хураалт явуулъя. Баттөмөр Баагаагийн тийм, Баагаагийн Баттөмөр гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцүүлгийг маргааш үргэлжлүүлж гэсэн, өнөөдөр хойшлуулж, маргааш үргэлжлүүлж гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдсэнгүй. Санал дэмжигдээгүй учраас асуулт хариултаа явуулъя.

Ер нь зүгээр санал, дүгнэлтээ танилцуулснаар Түр хороо татан буугдана л гэж байгаа юм. Тэгээд өмнөх санал, дүгнэлтүүд бол хэлэлцээд л энэ. Ингээд нэрийг сэргээе. Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг явж байгаа.

Ш.Адьяа: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлаас байгуулагдсан Хөгжлийн банкны түр хороо гэдэг энэ түр хороо тодорхой хугацаанд жил гаруй шахуу хугацаанд Хөгжлийн банктэй холбоотой асуудлыг Хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд шалгаж, өнөөдөр Улсын Их Хуралд тайлангаа тавьж байгаа гэж ойлгож байна. Энэ түр хорооны үйл ажиллагаа бас олон сорилтуудыг олон шинэ зүйлүүдийг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд авч ирэхийн төлөө бас зорьж ажилласан гэсэн ийм бодолтой явдаг.

Нөгөө талаасаа хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд энэ мөрдөн шалгах ажиллагаа Хяналт шалгалтын хуулийн хэрэглээ гэдэг чинь ямар байдал руу орж байгааг ямар зүйл дээр бодит байдал бодит үнэлэлт дүгнэлт өгөх, нотлох баримтын хэмжээнд явах энэ шинэлэг зүйл чинь өнөөдөр хууль тогтоох эрх мэдлийг шүүхийн танхим болгосон. Шүүхийн танхим болгосон их сонирхолтой юм шиг. Өнөөдөр нийгэм хараар будагдсан, хар мэдээлэл дарагдсан ийм цаг үед энд бас содон, содон үйл явдлууд болж байсныг бид бас мартаж өссгүй.

Тэгэхээр би энд 1 ганцхан зүйлийг асууя. Энэ нотлох баримт шинжлэн судлах үйл ажиллагаанд оролцож байгаа энэ шинжээч нар шинжээчийн эрх, үүргийн хүрээнд үүрэг хариуцлагаа хийж ажилласан уу? Энэ Түр хорооны журмаар шинжээчийн шинэ үүрэг хариуцлага гэж байсан юм уу гэдэг нэг ийм асуултыг асууя. Өнөөдөр шинжлэн судлах шинжээчийн үүрэг хариуцлага гэдэг бол өнөөдөр нотлох баримтыг шинжлэхдээ бүх авагдсан нотлох баримт түүнчлэн архивд байгаа нотлох баримт, шинээр илэрсэн нотлох баримт, тухайн байгууллага, ААН, харилцагч банкин дээр байгаа нотлох баримт бүгдийг нь тулгаж шалгах ийм үндсэн үүрэг шинжээчийн үүрэгт Монгол Улсын хуулиар байдаг.

Гэтэл зөвхөн гүйлгээ банкны гүйлгээ дээр үнэлэлт дүгнэлт хийж, өнөөдөр зээл авсан ААН банкны зээлийн нотлох баримтаар үнэлэлт дүгнэлт өгсөн гэдэг ийм бодолтой байна. Энэ дээр 1 хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр.

Б.Энхбаяр: Адьяа гишүүнийг ойлгож байгаа. Бас Түр хорооны сонсголд гэрчээр дуудагдсан байгаа. Ингэж шалгана ч гэж бодоогүй байх л

даа. Зээлийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулагдсан уу, үгүй юу гэдгийг ер нь яаж шалгах байсан бэ? Жишээлбэл манай Адьшаа гишүүн өөрөө байсан бол яаж шалгах байсан бэ? Өөрөөс нь асуух байсан уу. Та энийгээ юунд зарцуулсан бэ, тэгээд тэр ам мэдүүлгээр дүгнэж болох байсан уу гэдэг асуудал байгаа юм.

Зээлийг энэ бол Монгол Улсын түүхэнд хийгдэж байгаагүй өргөн хүрээтэй шалгалт болсон гэдэг дээр би ам бардам хэлнэ. Сая танилцуулагдаа дүгнэлтдээ хэллээ. Сая гаруй хуудас цаасан материал цуглуулж цуглуулсан гэсэн үг. Ийм хэмжээний өргөн цар хүрээтэй шалгалт хийгдсэн. Түр хорооны сонсгол 3 удаа зохион байгуулагдсан. 1 сард хамгийн анхны сонсгол явагдсан. Энэ 1 сард хийгдсэн сонсгол хийгдэхээс өмнө би хэлж байсан. 3 сая гүйлгээ шалгачхаад байгаа гээд хэлээд байсан. 3 сая гүйлгээ. Зарим гүйлгээ зориулалт бусаар зарцуулагдсан нь 10 дахь шилжүүлгээрээ илэрч байсан. Дамжаад л байсан, дамжаад л байсан, дамжсаар л байсан, дамжсаар байгаад л өөр рүүгээ буцаад л ороод ирж байсан. Тэгэхээр энэ зээл зориулалтын дагуу зарцуулагдсан уу, үгүй юу, үнэхээр тэр яриад байгаа үйлдвэр барих, экспортыг орлох, бүтээгдэхүүнийг авсан уу, үгүй юу эсвэл хувьдаа зарцуулагдчихсан уу үгүй юу гэдгийг чинь данс хөөж л үзнэ шүү дээ.

Тийм учраас энд их олон хүн цочирдсон. Тэгэхдээ 1 зүйлд итгэлтэй байгаа. Хувь хүний өөрийн үйл ажиллагааны ашигт үйл ажиллагааны орлого, түүнийгээ хэрхэн зарцуулсантай холбоотой ямар ч эх сурвалж нотлох баримтыг ил болгоогүй. Шинжээчид гагцхүү Хөгжлийн банкны эх үүсвэртэй буюу Хөгжлийн банкнаас гарсан 1 төгрөг болгон хаашаа хаашаа орж, юу руу оров гэдгээс рүү хөөгдөж шалгасан. Түр хороо анх байгуулагдаад удирдамжаа гаргасан. Ингэхдээ данс хөөх аргаар шалгана гэдэг удирдамжаа баталчихсан.

Тийм учраас шинжээчид Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн

дагуу, Монгол Улсын түр хорооноос баталсан удирдамжийн дагуу ажилласан. Одоо энэ ажлыг хийсний ард дээр сүүлдээ энэ ажлыг хийсэн Монгол Улсын парламентаас анх удаа томилогдсон энэ хүмүүс буруутан болж таарахгүй. Хэрэв буруутгах гэж байгаа бол би энэ дээр харин өмнөөс нь харин бат зогсоно гэдгийг харин хэлчихмээр байна.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн 1 минут. Уул нь энэ асуулт, үг учраас нэмэлт минутгүй.

Ш.Адьшаа: Зүгээр улс төрийн зорилгоор авч очоод 1 гэрчээр асуусны төлөө би 1 асуугаагүй шүү Энхбаяраа. Монгол Улсын Их Хурал гэдэг бол хууль дээдлэх зарчим хуулийн хүрээнд л явагдах ёстой. Түр хорооны дарга шинжээчийн дүгнэлт гэдэг юм батлаад өнөөдөр явах нь хэр зохимжтой вэ л гэдгийг би ярьсан. Тэрнээс биш би энд 1 айж бачимдаад, цочроод зүгээр энийг асууж байгаа юм биш. Миний ярьж байгаа асуудлыг бас авах гээхийн ухаанаар авч үзээрэй л гэж хэлэх байгаа юм. Тэрнээс биш би энийг нэг цаашилаад энэ түр хорооны үйл ажиллагаа түр хороо гэдэг энэ байгууллага хуулийнхаа хүрээнд хууль дээдлэх зарчмынхаа хүрээнд л яваасай гэж бодоод л энийг хэлсэн шүү.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулна. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр энэ сонсгол бол Монгол Улсын парламентын түүхэнд бол маш зөв жишиг тогтоосон ийм сонсгол болсон. Тэгээд бас түүхээ бас бодитоор нь ярья. Баттөмөр гишүүн түрүүн би бол би санаачлаад ингээд явсан гээд, 28 гишүүн. Үнэн, үнэн санаачлаад явсан. Тэрнээс өмнө энэ асуудлыг сөхөж гаргаж ирээд гарын үсэг цуглуулаад явсан гишүүн байна. Тэгээд сөрөг хүчний зүгээс саналуудаа цуглуулсан, гарын үсгээ цуглуулсан 19 гарын үсэг хүрээгүй л дээ. Бодитоор л ярья. Тэгэхдээ ямар ч байсан

энэ ингээд сонсгол хийгдсэн нь бол сайн. Энэ дээр бол гарын үсэг зурсан. Тэгээд сонсголыг зохион байгуулсан гишүүддээ бол талархал илэрхийлмээр байгаа юм. Яагаад вэ гэхээр үр дүн гарсан.

Харин өнөөдөр бид нар ингээд цаашид юун дээр анхаарах юм бэ гэдэг тайлангаа хэлэлцэж байгаа юм шүү. Тэгээд яг энэ асуудал дээр бас өдөр болгон тэр сууж асуудлуудтай нь бас ингэж тулж ярьж байсан гишүүний хувьд бас нотлох баримтын хүрээнд бол өөрийнхөө үзэл баримтлалыг бодлыг илэрхийлэх боломжгүй байсан юм. Тийм болохоор харин хэлмээр санагдаж байгаа юм. Тэгээд 3 зүйлийг хэлмээр байна.

Нэгдүгээрт, Монгол Улс түүхэндээ анх удаагаа хөгжиж байгаа буюу бага орлоготойгоос дунд орлоготой орон руу шилжсэн байдаг юм 2011 онд. 2012 онд гадаад зах зээл дээр боломж гарч ирсэн байдаг юм. Тэгээд үр дүнд нь бид нар бондоо зарсан байдаг юм. Бондоор эх үүсвэр татсан байдаг юм. Анх удаа арилжааны нөхцөлтэй амжилттай зээл авсан. Харамсалтай нь авсан мөнгөө бид нар бүгдийг нь буцаагаад өмнөд хөрш рүү гаргачихсан. Зовлон нь бол тэр шүү. Макро эдийн засгийн ямар ч ойлголт байхгүй, мэдлэг байхгүй, мэдээлэл байхгүй. Зөвхөн ажил хийнэ, үйлдвэр хийнэ, бүтээн байгуулалтуудад нь хийнэ гэдэг ийм улс төрчид гарч ирээд энэ улсын эдийн засгийг самарсан шүү.

Тухайн үед нь хэлж байсан, анхааруулж байсан, хүлээж аваагүй ажлаас халж байсан, халагдаж байсан маш олон мэргэжилтнүүд байдаг юм. Тэрний 1 нь би. Тэгээд өнөөдөр энэ улс төрчид орж ирээд би үйлдвэрлэл барих гэж байсан шүү дээ, өөр юу ч биш шүү дээ гээд. Цаад барьсан үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг хэнд зарах юм, яаж зарах юм, ямар ч ойлголт байхгүй. Тэгээд судалгаа шинжилгээ нь болохоороо бид нар ашигт ажиллагаанд чинь баталгаа гарахгүй шүү гэдэг цагаан дээр үг, үсэг байж байхад тэрийгээ ч уншиж

чадаагүй ийм л хүмүүс байсан шүү. Энийгээ хэлчихье.

Тэгэхээр сургамж хэрэгтэй. Нэгдүгээрт гаднаас эх үүсвэр өндөр үнэтэй татаж авч ирчхээд тэрүүгээрээ төсвийн шинж чанартай зардал санхүүжүүлж болдоггүй юм байна. Талаар 1 тарааж болдоггүй юм байна, урсгал зардлыг санхүүжүүлж болдоггүй юм байна. Бизнесүүд рүү өгөөд тэр нь буцаагаад экспортыг дэмжиж, импортыг орлох биш харин импортыг дэмждэг ийм төслүүд болчихсон энэ зүйлийг дахиж давтаж болохгүй юм байна гэдэг энэ бол хав хатуу зүйл шүү. Монгол Улсын түүхэнд энэ хараар үлдэнэ. Эдийн засагчдын түүхэнд энэ бол маш сайн хичээл болно. Улс төрчдийн хувьд бол энэ сургамж болох ёстой юм шүү.

2.Ханишийн эрсдэл. Бид нар гаднаас мөнгө орж ирсэн. Харамсалтай нь 2, 3 жилийн дотор тэр ханшаа 2 дахин алдчихсан. Мөнгө хэвлэж тараадаг, дээрээс нь нөгөө оруулж ирсэн мөнгөөрөө буцаад валют олох биш зүгээр төгрөг болгоод байсан нь бид нарын алдаа байсан. Үр дүнд нь Хөгжлийн банк ханишийн эрсдэлд орсон, 120 тэрбум чинь бага тоо. Босгож ирсэн мөнгөөрөө бид нар ханишийн эрсдэлд орчихсон байхгүй юу. Хэн орсон бэ гэхээр татвар төлөгчид орчихсон байхгүй юу, төсөв орчихсон юм. Төсвөөс энэ санхүүжилтийг чинь 2.3 их наядыг хийж байгаа. Төсөв авчихсан байгаа шүү ханишийн эрсдэлийг. Хэн энэ алдаа гарсан юм гэхээр тухайн үеийн Монголбанкны удирдлага, тухайн үеийн Засгийн газрын гишүүд шүү. Одоо юм бодитой байх ёстой. Макро эдийн засгийн буруу бодлого. Тэгээд хэтэрхий их нөгөө инфляцыг хөөрөгдсөн мөнгө хэвлэж тараасан. Энэ их буруу нөгөө төслүүдийг санхүүжүүлсэн байдал чинь эргээд бизнесүүд дээр, төр дээр дарамт учруулчихсан. Ханшаа алдчихсан. Ингээд Монгол Улсын бизнесүүд үнэ цэнгүй болчихсон.

Тэгээд цаашаа бол бид нар энэ банкнийг хөгжлийг санхүүжүүлдэг банк байлгах ёстой юм. Түүнээс биш цемент санхүүжүүлдэг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Байр сууриа илэрхийлж үг хэллээ. Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Асуулт байхгүй. Би бас энэ түр хорооны гишүүн. Тэгэхдээ яах вэ зүгээр түр хороо энэ сонсголын талаар бас 1 өөрийнхөө саналыг бас хэлье. Ер нь түрүүн манай гишүүд хэлж байна. Үнэхээр энэ сонсгол бол Монголын парламентын энэ цаг хугацаанд бол шинэ, Монгол Улсын нийгэм, эдийн засагт бол томоохон бас санамжийг өгсөн, зөв голдиролд нь оруулах гэсэн ийм том алхам байлаа. Энэ бол бодитой.

Тэгэхдээ түр хорооны үйл ажиллагаа, сонсголын үйл ажиллагаанд хэд хэдэн анхаарах асуудлууд гарч ирж байгаа юм. Жишээлбэл энэ Хөгжлийн банкны асуудал гэвэл 10 гаруй жилийн асуудлыг мөрдөн мөшигөж нийтийн сонсгол болгосон. Энд 4 жилийн асуудлыг л голчилж ярьсан байхгүй юу. 10 жилээс бол 4-ийг нь. Энэ нь өөрөө түр хороо маань юу гэдэг юм эрх баригч нар түр хороогоо ахлахаар өөдөөс нь хараад сууж байгаа намынх нь нөхдүүдийн асуудлыг ярих гэх нь бас нүүр халуун, асуудалд хандахад бас хүндрэлтэй байсан байх. Яах вэ, сөрөг өмнө нь эрх барьж байсан намын асуудлыг ярихад бол илүү нүүр бардам асуудлыг ярих нь бол амар байсан байх. Ийм асуудлууд бол гарч байсан.

Хоёрт нь түр хорооны гишүүдэд мэдээлэл өгөх энэ боломж нь хомс байсан. Тухайн хурал дээр орж ирээд шинжээчийн дүгнэлтийг сонсдог. Бусад гишүүд нь давуу байдал бас байсан. Энийг бол нуугаад яах вэ хэдүүлээ ярьж ярих нь зөв байх. Ийм асуудлууд гарч байгаа. Тэгээд энийг цаашид энийгээ улам төгөлдөр болгохын тулд бол мэдээж энэ асуудлуудыг бас энэ хууль дээр, журам дээр өөрчлөлт оруулах

зайлишгүй шаардлага бол харагдаад байгаа юм.

Хэрэв нөлөө бүхий улс төрч нь нэг намынх байх юм бол тухайн түр хорооны тэр өдрийн хурлыг магадгүй сөрөг хүчнийх нь намын гишүүнээр энэ асуудлыг удирдуулан явуулах ийм боломжийг бас нээж өгөх ёстой юм байна лээ. Ийм байдлаар асуудалд хандах нь зөв байх л даа. Зүгээр жишээ болгож ярихад данс хөөх аргаар асуудлыг олон нийтэд ил болгож, мэдээллийг ил тод болгоход бол сөрөг хүчний асуудлууд бол ил тод гарч байгаа юм. Зүгээр жирийн бизнесменүүдийн асуудлууд бол бас ил тод гарсан.

Манай Их Хуралд сууж байгаа Бямбацогт гишүүн гэхэд 86 тэрбум төгрөгийг бол зээл авсан байдаг. Энэ асуудал нь өөрөө ямар нэгэн барьцаа байхгүй, төслөө барьцаалаад авчихсан зээл байгаа байхгүй юу. Энэ дээр болохоороо асуудлыг яаж хандаж байна вэ гэхээрээ түүний хамаарал бүхий компанийн захирал, дүү нь гадаадад томилолттой байгаа учраас энэ асуудал тухайн асуудал бол бусад асуудалтай адилхан ил тод явж чадахгүй л байгаа юм. Жишээлбэл ийм асуудлууд гарсан.

Тэгэхээр түр хорооны дараагийн зөвхөн Хөгжлийн банкны дараагийн асуудалд дүгнэлт өгөхөөс гадна бас түр хорооны хурал дээр бол энэ түр хороо сонсголын асуудлыг улам төгөлдөр болгох асуудлыг бол бас ярьсан байгаа юм. Тэгэхээр энэ бол цаашид Монгол Улсад жишиг болохуйц сонсгол болсон. Энийгээ улам ямар нэгэн улс төрийн ашиг хонжоо олдоггүй, ижил тэгш байлгах тал дээр бол бид бүхэн бас Их Хурал ажиллах ёстой юм байна гэдгийг бас та бүхэндээ хэлчихье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Яах юм хариулах юм уу түр хороо? Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулья түр хорооны дарга.

Б.Энхбаяр: Ганибал гишүүн маань бол манай түр хорооны гишүүн байгаа.

Энэ парламентын Хяналтын түр хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зааснаар олонх ба цөөнхийн төлөөллийн оролцоог тухайлан хуульчилчихсан. 1/3-ээс доошгүй нь цөөнхөөс байна гэдэг маань бас энэ хяналт шалгалт улс төрийн зорилгоор явагдах вий гэдгийг балансыг их жигд хангасан ийм хэлбэрээр зохион байгуулагдах зохицуулалт болсон юм байна лээ.

Мэдээж энэ бүх юм анхных учраас алдаа оноо бүгд цуг байгаа. Хамгийн бага алдаж ийм зарчим бол баримталж бас баримталсан. Хууль зүйн хуульч хүний хувьд энэ анхных учраас хууль шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа руу халтирчих вий гэдэг дээр нэлээн бас зарчим баримталж байсан. Улс төржилт хардалт байнга л явагдаж байсан. Тэгээд энийг яаж давах вэ гэдэг дээр ерөөсөө л ганцхан зарчим баримталсан. Тэр нь хамгийн дэлгэрэнгүй, нээлттэй, ил тод байх гэдэг л зарчим барьсан. МҮОНТ-ээр шууд дамжуулсан, 3 сая Монголчууд шууд зэрэг энэ нотлох баримтын шинжээчийн дүгнэлттэй танилцаж байсан. Аль 1 намын гишүүдэд нь арай жоохон мэдээллийг нь хаагаад л байгаад л, арай жоохон 1 нь илүү мэдээлэлтэй байгаад байсан зүйл огт байхгүй.

Би сая хэллээ. Шинжээчдийн дүгнэлт яг тухайн тухай тухайн үедээ түр хорооны гишүүд танилцагдаад л, тэгээд л явж байсан. 1 өдөр бүр ийм явдал болсон. Манай Ганибал гишүүн урьд өдөр нь шинжээчийн дүгнэлттэйгээ өг гэдэг л, өгөөгүй гэдэг л асуудал яриад байх шиг байгаа юм. Бид үнэхээр нойр хоолгүй ажиллаж байсан. Өглөө 7 цагт унтаагүй ажилласаар байгаад шинжээчийн дүгнэлтээ гаргаад, тэрийгээ хувилаад яг хурлын өмнө амжиж байсан ийм тохиолдлууд байгаа байхгүй юу. Түр хорооны дарга би өөрөө ч танилцаагүй, энэ хүмүүс тэгж ажиллаж байсан байхгүй юу. Түр хорооны сонсголын үеэр бие нь муудаж байсан, урьдчилж танилцуулсангүй,

ингэсэнгүй гэж яриад байгаа юм. Би сая хэлээд байна шүү дээ. 1 сая цаасан материал энэ нотлох баримтуудыг чинь үзэж байсан.

Тийм учраас энэ дээр Ганибал гишүүн маань бас юу яах хэрэггүй. Харин хэрэв өөрийн намынхаа хүнийг дутуу ярьсан барьсан, ярьсангүй эд нар гэж ярьж байгаа бол та өөрөө хуралдаа орж ирж ярихгүй яасан юм бэ? Манай намын хүнийг. Одоо хуралдаа суухгүй байж өнгөрсөн хойно нь ярьсангүй асуусангүй гээд яриад байх юм. Өөрөө асуух эрхтэй гишүүн нь байсан шүү дээ. Яагаад хуралдаа суугаагүй юм бэ харин. Монголын ард түмний итгэлийг хүлээсэн үндэсний хэмжээний том намыг төлөөлж энэ парламентын түр хорооны гишүүн болчихоод танд маш том эрх олгочихсон байна шүү дээ хяналт тавих. Тэгээд өөрөө суухгүй. Тэгээд одоо ийм юм бол ярих шаардлагагүй гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

Н.Ганибал: Өнөөдөр ч яах вэ тэрийг маргалдаад суух нь ч бас буруу л даа. Гэхдээ зүгээр зарчмын асуудлыг хэдүүлээ үнэн мөнөөр ярих нь зөв л дөө. Албан ёсны илтгэл бэлдчихдэг, тэрийг ганцхан түр хорооны дарга нь мэддэг, тэрийг тавьчих, энийг тавьчих, одоо энийг өгчих гээд л явдаг биз дээ. Бүх нийт мэдэж байгаа шүү дээ. Тэгээд бид нар болохоороо зүгээр хөндлөнгийн яг л хүмүүстэй адилхан тэр түр хороонд байсны хувьд ямар нэгэн мэдээлэл байхгүйгээр асуудалд ороод бид нар чинь юугаа асуух вэ дээ. Ийм л асуудал байгаа юм. Энийг л засъя л гэж байгаа байхгүй юу даа. Дараа дараа энэ асуудлууд давтагдахгүй явбал илүү үр дүнтэй болох байх л гэдэг саналаа хэлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр 2019 онд энэ Монгол Улсын

Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурал энэ хянан шалгах чиг үүргийг илүү тодорхой хэрэгжүүлэх үүднээс Хянан шалгалтын тухай хуулийг гаргаад, энэ хуулийн дагуу магадгүй анхных нь болох тийм нотлох баримтын сонсголыг манай Хянан шалгах энэ Хөгжлийн банкны асуудлаарх Хянан шалгах түр хороо хийсэн.

Мэдээж анхны юм болсон учраас туршилага багатай, алдаа оноо байсныг үгүйсгэхгүй. Том агуулгаар нь авч үзэх нь бол би харьцангуй тийм сайн зохион байгуулалттай тийм сонсгол болсон гэж ингэж бодож байгаа. Ямар ч байсан иргэдэд үнэн зөв мэдээллийг өгөхөд бол их томоохон амжилттай ийм сонсгол болсон. Улсын Их Хурал бол сонсголыг бас яаж зохион байгуулах шаардлагатай байна вэ гэдэг талаар бас тодорхой хэмжээний жишиг болсон гэж ингэж бодож байгаа юм.

Би ингээд Энхбаяр гишүүнээс 3 зүйлийг асууя гэж бодож байгаа юм. Хамгийн чухал асуудал бол энд маш олон нотлох баримт цугласан гэж сая Энхбаяр гишүүн тайландаа ч дурдсан байна. Өөрөө ч ярилаа. 1 сая орчим цаас энд цугларсан. Энэ бол маш олон шинэ нотлох баримтууд шинээр илэрсэн гэж. Юу сонсголын явцад ч гэсэн харахаар их олон шинэ мэдээлэл, шинэ нөхцөл байдлууд байсан. Тэгэхээр хуульд бол бид нар зааж өгсөн байгаа. Шинэ нөхцөл байдлууд илэрсэн, шинэ баримтууд гаргах гээд. Тэгэхээр хамгийн чухал асуудал энэ шинээр илэрсэн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг үнэлэхтэй холбоотой асуудал байгаа юм.

Өнөөдөр Монголд энэ Хөгжлийн банкны шүүх хурал явж байна. Тэгэхээр энэ манай энэ Хянан шалгах түр хорооны хийсэн нотлох баримтын сонсголын үр дүнд гарсан шинээр илэрсэн нөхцөл байдлуудыг шүүх яаж авч үзэв гэдэг асуудал байгаа юм 1 дэх асуулт.

Хоёрдугаарт нь энэ бид энэ хуулийг батлах явцад 1 гарч байсан

асуудал бол энэ нотлох баримтын сонсголын асуудал байгаа юм. Энэ үед өнөөдөр энэ асуудал 1 талаараа Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороо гараад, шалгаад, үзээд, хараад явж байгаа. Нөгөө талд нь хэрэг бүртгэдэг, мөрддөг шалгадаг байгууллага шалгаад явж байгаа. Энэ 2 үндсэндээ зэрэгцэж явсан болов уу гэж бодож байна. Тэгэхээр бол бид нарыг нөгөө хууль хэлэлцэх үед гарч байсан 1 гол маргаан бол мөрдөн байцаалтын шатад эсвэл шүүхийн шатад явж байгаа хэрэг маргааныг сонсгол хийх үү, үгүй юу гэдэгтэй холбоотой асуудал байсан юм. Тэгэхээр одоо та бүхний хувьд ингээд сая туулаад ирэхээр цаашидаа ер нь яг ямар жишиг баймаар юм бэ гэдэг асуудал байгаа юм. Энэ талаар бодвол энэ түр хорооныхон, түр хороог ахалж ажилласан Энхбаяр гишүүн эд нар тодорхой хэмжээний ийм санал бодол төрсөн болов уу гэж би бодож байна.

Гуравд энэтэй холбогдуулаад бид энэ цаашидаа энэ Хяналт шалгалтынхаа тухай хуулийн асуудлыг авч үзэх ёстой болов уу гэж бодож байгаа юм. Энэ өмнө нь ийм жишиг байгаагүй учраас бид нар ерөнхий хууль хийсэн байхгүй юу. Ерөнхий хууль хийсэн. Одоо яг ингээд ажиглаад үзэхэд эрх зүйн орчны хувьд сайжруулах шаардлага байна уу, үгүй юу гэдэг асуудал байгаа юм.

Гурав дахь асуудал нь банкны асуудал байгаа юм. Банкны асуудал. Сая илтгэлд дурдаж байна. Ер нь бол Хөгжлийн банк цаашидаа байх ёстой юм байна гэж. Тэгэхээр цаашидаа энэ нөхрийг байлгахын тулд эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна уу, үгүй юу? Манай өнөөдрийн эрх зүйн орчны нөхцөл нь ер нь ямар байна вэ гэдэг асуудал байгаа юм. Энэ талаар бодвол энэ эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр түр хороо тодорхой санал бэлтгэж гаргасан болов уу гэж би бодож байна. Ийм 3 зүйлийг би асууя. Анхны ийм учраас бодвол энэ үнэлэлт дүгнэлт өгсөн, шинэ жишигийг тогтоосон ийм түр хороо байсан гэж

ингээж бодож байгаа юм. Цаашидаа бол мэдээж түр хороод бол энэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Үнэхээр бүх юм шинэ байсан учраас сая хэлсэнчлэн бага алдах, жишиг болгох их хариуцлага ирсэн. Алдаа гаргахгүй байх. Энэ дээр ямар асуудал үүссэн гэхээр яг энэтэй зэрэгцээд биднийг шалгаж байх үед Хөгжлийн банктэй холбоотой АТГ-аас, прокуророос эрүүгийн хэрэг үүсгэгдээд шалгагдчихсан байсан. Тэгээд түр хороо анх байгуулагдаад АТГ, прокурор луу маш олон удаагийн бичиг явуулсан. Яагаад гэхээр очоод шалгах гээд материалуудаа үзэх гэсэн чинь бүх материалуудыг нь хуулийн байгууллага чинь татаад аваад явчихсан байсан. Шалгуулах нөгөө шалгая гэх бичиг баримтуудыг нь. Ингээд шинжээч нар маань яах вэ гээд, тэгээд сүүлдээ АТГ, прокурорын удирдлагуудад хэлсэн. Би бичиг явуулсан, тогтоол гаргасан. Ер нь хамтраад шалгачихвал яасан юм. Манай шинжээчдийг энэ нотлох баримтад өгөх бололцоог хангаач гэсэн үгүй гэсэн. Хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын нууц бид өгөхгүй гэсэн.

Ингээд нүцгэрсэн. Тэгвэл яах вэ гэж. Тэгэнгүүт нь царай алдах алдахгүй, хуулийн байгууллагынхан ингээж царай алдахгүй гэж үзсэн шууд. Ерөөсөө бүх нотлох баримтуудыг ёстой байж болох бүх хэмжээнд нь шалгасан. Сая хэлсэнчлэн тэр данс хөөх арга гэж яриад байгаа чинь тэр байхгүй юу. Тэдний ороогүй, үзээгүй бүхий л зүйлүүдийг бид үзсэн. Аюулгүйн зөвлөлийн протокол, Бондын зөвлөлийн протоколоос нь эхлээд. Ингээд саяын хэлсэн чинь тэр сая цаас цугларсан. Хэрэв хуулийн байгууллагын шалгаж байгаа асуудлаар парламентын мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй гэж хэрэв баталсан байсан бол ер нь цаашидаа ийм парламентын хяналт байж чадахгүй юм байна лээ. Цаашиа

ийм түр хороо ажиллах боломжгүй юм байна лээ.

Би хэлж байсан. Энэ нотлох баримтын шинжлэх, судлах сонсголын хүүрэнд хууль хяналтын байгууллагад дээр өнөөдөр шүүх хурлууд нь үргэлжилж байгаа асуудлууд гэж харьцуулж авч үзэх юм бол 90 хувь нь бид шинэ нотлох баримтууд ирсэн. Цоо шинэ асуудлуудыг. Энийг яах вэ гэдэг асуудал бол хууль хяналтын байгууллагын асуудал. Тогтоолын төсөл дээр энийг ингэ гэж Улсын Их Хурал шүүхэд үүрэг өгч болохгүй байгаад байгаа юм. Энэ чинь Үндсэн хуулиа зөрччихнө эргээд. Улсын Их Хурал шүүх эрх мэдэлд үүрэг өгч болохгүй тогтоол гаргаж. Энэ асуудлын парламентын чинь хамгийн гол юм бол ард түмэндээ ард түмний төлөөллийн хамгийн дээд байгууллагын хувьд мэдээлэлжүүлэх, нээлттэй болох энэ асуудал байгаа юм. Үнэнийг илчлэх.

Яагаад гэхээр энэ Хөгжлийн банкны асуудал 10 жил яригдчихсан байсан. Хууль хяналтын байгууллагын өмнө шалгасан гэдэг, цагаадсан гэдэг, буцсан гэдэг юу болсон юм энэ нь хэнд ч ингээд ойлгомжгүй болчихсон. Цааши цаашидаа Хяналтын түр хороо байгуулагдвал зүгээр бас Их Хурлын тогтоолын төслийн энэ хуульдаа бас өөрчлөлт оруулах шаардлага байгаа юм байна гэж үзсэн. Энийг байгуулах босго, зүгээр ингээд 1 үйл ажиллагаа болгоныг бол түр юу парламент шалгах ёсгүй юм байна лээ. Урьд нь энэ олон түмний дунд ингээд хууль хяналтын байгууллагаар ороод, буцаад яачихсан бүр ингээд ойлгохоо больчихсон, эргэлзээ рүү орчихсон, д... болчихсон ийм асуудлаар бол байгуулж байх шаардлагатай юм байна лээ. Энэ түр хорооны гишүүд дээр тавих босгыг бас өндөрсгөмөөр юм байна лээ.

Л.Мөнхбаатар: Түр хорооны гишүүн Тогмидын Доржханд нэмж хариулъя.

Т.Доржханд: Энэ Тогтохсүрэн гишүүний хамгийн сүүлийн асуулт их чухал юм. Ер нь энэ эрх зүйн орчин нь яах юм, цаашидаа энэ Хөгжлийн банк байх юм уу, байхгүй юм уу, байвал ямар байлгах юм. Зөвлөмждөө бол яах вэ байлгаад явах нь зүйтэй гэсэн ийм зөвлөмж бол байгаа. Гэхдээ 1 зүйлийг маш сайн ойлгох хэрэгтэй. Энэ чинь анх 2000 онд байгуулагдахдаа ямар нэгэн банкны статусгүй байсан байгаа юм 2000 онд. Тэгээд 2017 онд болохоор зөвшөөрөл авсан байгаа тусгай зөвшөөрөл. Тэгэхээр 2010-аас 17 оны хооронд энэ бол ямар нэгэн банк биш нөгөө ЖДҮ сан гэдэг шиг Засгийн газрын сан байсан байгаа байхгүй юу. Зүгээр л энэ.

Тэгээд 2017 оноос нөгөө үзэл баримтлалыг нь өөрчлөөд, одоо болохоороо 1 арилжааны банкны ийм жишиг рүү оруулчихсан байхгүй юу. Хөгжлийн банк нь тусдаа хуультай мөртөө. Тэгээд ингээд цаашаа яах юм бэ гээд тэгэхээр бодит байдлыг ярья. Өнөөдөр ингээд алдагдалтай дефолт зарлахад бол бэлэн. Тэгээд энэ банкны үндсэн зарчим нь яаж явж байсан бэ гээд тэгэхээр гаднаас их хямд эх үүсвэр олж аваад, тэр эх үүсвэрийгээ төсвөө санхүүжүүлж чаддаггүй, экспортыг дэмждэг, импортыг орлодог томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх ийм санхүүгийн платформ хэрэгтэй юм байна гэж хийж байсан. Би өөрөө Сангийн яаманд техникийн ажлын хэсгийг нь ахалж байсан. Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын даргын хувьд. Энэ төслийг Япончуудтай анх хийж байсан юм. Японы хөгжлийн банкны экспертүүдтэй цуг хийгээд, тэгээд яаж явуулах юм бэ гээд тэгэхээр Монголд бүтээн байгуулалт хийх санхүүжилтийн эх үүсвэр байхгүй байгаа болохоор Хөгжлийн банкны энэ схемийг оруулж ирье гээд хийж байсан юм.

Тэгээд гаднаас эх үүсвэр олоод, тэрийгээ доллар олдог буюу экспортыг дэмждэг, долларыг хэмнэдэг буюу импортыг орлодог ийм бүтээгдэхүүн рүү оруулаад дамжуулаад явъя. Үр дүнд нь

Хөгжлийн банкны зээлжих зэрэглэл сайжирна. Зээлжих зэрэглэл сайжраад ирэх юм бол тэрэн дээр үндэслээд дахиад ингээд гаднаас эх үүсвэр татаад ийм байдлаар явъя. Олон улсын хөгжлийн банкнууд бүгд ингэж явдаг. Энэ зарчмаар явъя гэсэн. Тэгээд харамсалтай нь энэ зарчмаар явж чадаагүй. Анхны оруулж ирсэн эх үүсвэрээ бүгдийг нь талаар нэг тараачихсан. Түрүүн би хэлсэн. Тэгээд нөгөө 1 валют олдог тэр урсгалаа бид нар алдчихсан, эсрэгээрээ импортыг дэмждэг ийм л санхүүжилтүүдийг хийчихсэн.

Хувийн хэвшилд өгсөн зээлүүд нь ч гэсэн дандаа импортыг дэмждэг, төрийнхөн ч гэсэн импортыг дэмждэг. Ингээд шууд дампуурчихсан байхгүй юу. Одоо энийг ингээд дахиад босгож ирье гээд тэгэх юм бол ийшээгээ хөрөнгө оруулах, хувьцааг нь бондыг нь авах тийм хөрөнгө оруулагч байхгүй дэлхий дээр байхгүй шүү. Тэгээд Засгийн газраас бол Эксим банкны хувилбараар явъя гээд, шинэчлээд явах юм бол яах вэ гэж байна. Яг адилхан болно. Ганцхан тохиолдолд энэ маань зөв ажиллах юм. Тэр маань юу вэ гээд тэгэхээр энэ менежментийн баг нь буюу энэ зээлийн шинжилгээ хийдэг, хяналтаа хийдэг, үнэлгээ хийдэг, энэ баг нь ямар нэгэн эрх мэдэлтэй эсвэл Засгийн газрын томилгоо байх л юм бол хэзээ ч авахгүй. Дэлхийн түүх ийм.

Дэлхий дээр 40-өөд Хөгжлийн банк үүссэн. 70, 80-аад хувь нь бол дампуурсан. Амжилттай явсан нь бол дандаа мэргэжлийн банк ингэж гарч ирээд авч явдаг. Дараа нь хувьцаагаа зардаг үнэлгээ гаргасны дараа. Өөрөөр хэлэх юм бол төрийнхөөс хувийн сектор луу нар шингэх зарчмаар ингэж явдаг. Ийм байдлаар ярих юм бол Хөгжлийн банкнууд нь бүгдээрээ амжилттай яваад байгаа. Ийм байдлаар төрийн хямд эх үүсвэрийг хувийн секторын мөнгөтэй хольж байгаад төрийн бүтцийг санхүүжүүлдэг нь бол энэ Хөгжлийн банкны үндсэн загвар юм. Тэгээд ийм байдлаар явахын тулд өнөөдөр бид нар бол Хөгжлийн банкаараа явуулж болно,

Эксим банкаараа явуулж болно. Хамгийн түрүүнд бол энэ менежментийн багийг нь ерөөсөө төр томилдоггүй байх л зүйлийг хамгийн түрүүнд хийх ёстой. Ингэсэн тохиолдолд итгэлцэл бий болно.

Хоёрдугаарт төр шийдвэр гаргаад, энэ төслийг санхүүжүүлээ гэдэг юмыг шийдэх ёсгүй юм. Их Хурлаас шийдвэр гарчихдаг, Засгаас шийдвэр гарчихдаг. Ингээд л холион бантан болчихсон. Энийг харин нөгөө *ban...* буюу банк өөрөө үзээд ашигтай гэдэг юмаа ингээд гаргаж санхүүжүүлсэн тохиолдолд энэ.../минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ Хөгжлийн банкны түүхийг мэдэх улсуудын 1 юм л даа. Энэ анх бол Монгол Улсад хөгжлийн баг байгуулах нь зөв зүйтэй юм. Хямд эх үүсвэртэй, эх үүсвэр татаж төвлөрүүлээд, үүгээрээ бол энэ хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх ёстой гэсэн ийм зорилготой байгуулсан. Бидний хувьд бол юу гэж ойлгож байсан гэхээр зэрэг энэ тухайн үед батлагдсан Их Хурлаар батлагдсан хууль нь энэ гадаадын мэргэжлийн ийм менежментийн багийг ажиллуулна гэсэн ийм шийдвэртэй байсан. Тэгээд энэний дагуу ажиллаж байгаа юм болов уу гэж бодсон чинь энийг нь тэгээд тухайн үед эрх барьж байсан нөхдүүд маань бол төд удалгүй хөөгөөд гаргачихсан юм байна лээ л дээ.

Тэгээд эндээс үүссэн олон асуудлууд хуримтлагдсан ийм зүйл байна лээ. Тэгээд энэ Хөгжлийн банкны асуудлыг сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагаас анх гаргаж тавихад Их Хурал дээр яг энэ асуудлаас энэ асуудлыг шүгэл, шүгэл үлээнэ гэж ярьдаг энэ зарчмаар шүгэл үлээсэн гишүүдийн 1 нь бол би байгаа юм. Ингээд Их Хурал дээр чуулган хуралдсан өдөр болгон энэ асуудлыг тавьж байж Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг

байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Баттөмөр гишүүн ажилласан. Бидний хэдэн гишүүд Даваасүрэн, Пүрэвдорж, Чинзориг бидний хэдэн гишүүд ороод ингээд 56 хоног ажилласан. Энэ ажил бол нүсэр ажил юм байна лээ.

Гэхдээ бол бид нарын ажилласан хүрээ хязгаар бол их тодорхой. Тухайн үед ямар байсан гэхээр зэрэг 3.2 их наяд төгрөг гаргачихсан. Энэнээс 1.7 их наяд нь бол чанаргүй зээлийн ангилалд орчихсон. Үүнтэй холбоотой 53 төсөл ААН-тэй холбоотой асуудлыг л бид шалгасан. Улаанбаатар хот, аймаг, бүх байгаа газруудад нь очиж яг төслийн хэрэгжилт дээр нь газар дээр нь үзсэн. Энэ төслүүдийг барьцаа хөрөнгө, баталгаа, зориулалтын дагуу ашигласан уу, үгүй юу тэгээд энэ асуудлыг нь бид бол 1 бүрчлэн ингэж үзсэн юм. Ажлын хэсгийн ажиллаж байх явцад бол бас зарим нэгэн асуудал гарч байсан. Тухай бүр нь хэлж танилцуулж байсан.

Түрүүн Ганибал гишүүний хэлдэг шиг энэ ажлын хэсгийн, дэд ажлын хэсгийн гаргасан материалтай танилцаж чадахгүй юм уу эсвэл зөвхөн ажлын хэсгийн ахлагч танилцдаг ийм зүйл бол байгаагүй. Тэгээд бид нар нээлттэй сонсгол явуулаад, ингээд энэ асуудлыг ер нь 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, тэгээд Хяналт шалгалтын тухай хууль батлагдсан. Энэ хүрээндээ түр хороо байгуулж ажиллах нь зүйтэй юм байна гээд. Ингээд Улсын Их Хурлын өмнөө барьж байгаа энэ хуульчид болох Сүхбаатар эхэлж ахалсан. Ингээд дараа нь Баттөмөрийн Энхбаяр гишүүн ахлаад ингээд түр хорооны ажил бол үндсэндээ бүтэн 1 жилийн хугацаанд үр дүнтэй ажиллалаа. Тайлан дүгнэлтээ Их Хуралд танилцуулж байна гэж би ингэж үзэж байгаа юм.

Энэ түр хорооны саяын 3 удаагийн тэр нээлттэй сонсголоор ч гэсэн ер нь бол тэр ямар нэгэн улс төрийн өнгө аясаар асуудалд хандаагүй гэж би бол үздэг. Харин ч сөрөг гэх юм уу, тухайн үед эрх барьж байсан улс

төрийн хүчнээс энэ гэрчээр оролцож байгаа хэлэлцүүлэгт оролцож байгаа хүмүүс бол туйлын хүндэтгэлтэйгээр тэгш ийм байдлаар бол хандсан гэж би бол ингэж харсан. Миний бас ажлын шаардлагын үүднээс тэр болгон оролцож чадаагүй ийм зүйл бий. Гэхдээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нөгөө нэмэлт юу байхгүй юм байна. Дэгээрээ тийм юм байна. Одоо хэн яах юм бэ, Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Үг хэлье.

О.Цогтгэрэл: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Хөгжлийн банкны асуудал бас нийгэмд нэг том асуудал болж энэний цаана ер нь энэ засаглалын тогтолцооны асуудал ч, төрийн өмч, шийдвэр гаргалтын асуудал. Тэрэн дээр бодлогын асуудлууд, тэрэн дээр хэрэгжилтийн асуудлууд зээл олголт зээлийн зориулалтын дагуу зарцуулалт, дахиад тэрний үр дүнгийн гээд ер нь энэ нийгэмд төрөөр ард түмний өмнөөс хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр энэ бодлого чиглэл ер нь яаж явдаг дээр иж бүрэн тийм том нийгмийн хэлэлцүүлэг болсон нь их тийм үр дүнтэй л гэж би үзэж байгаа юм.

Тэр тусмаа миний хувьд төрийн өмч, төртэй холбоотой энэ мөнгө төгрөгийн шийдвэр гаргалт аль болох бага байгаасай гэж боддог хүний хувьд. Тэгээд тэр Хөгжлийн банкны сонсгол дээр би бас оролцсон. Тэгээд энэ бүгдээс ингээд харахад бас надад бас ингээд тодруулах болоод нэг ингээд эмзэглэх зарим зүйлүүд үлдсэн. Миний хамаарал бүхий компаниуд тухайн үед арилжааны банкаар дамжсан, арилжааны банктэй гэрээ хийж зээл авсан ийм үйл явдал тэрэнд байсан. Тэгэхдээ энэ арилжааны банканд бүрэн зээлээ бол төлөөд, зээл аваад гэрээгээ байгуулаад, эргээд буцаан төлөлт хийсэн. Жишээ нь яг ийм магадгүй зуу зуун ч юм уу мянган компани байх шиг байгаа юм тэрэн дотор. Ямарваа нэгэн Хөгжлийн банктэй гэрээ хийгээгүй, тамга дарж

гарын үсэг зурж Хөгжлийн банктэй ямарваа нэгэн хэлцэлд ороогүй тэнд барьцаагаа тавиад авсан.

Гэтэл эд нар ингээд бүхэл бүтэн ингээд нийгмийн 1 том бүлэг, баялаг бүтээгчдийн гэж байгаа, бизнес эрхлэгчдийн төлөөлөл энэний цаана магадгүй тэнд төлөөгүй болоод хүндрэл учруулсан олон ААН-үүд байгаа байх. Энэ бүгдэд тэр асар их тийм гомдолтой хэсэг нийгэмд тэр үндсэндээ бизнес эрхлэгчдийн дотор үлдэж байгаа юм. Эндээс би юу гэж харьцуулж хэлэх гэж байна вэ гэвэл энэний дараа, энэний дараа Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед Арван их наядын хөтөлбөр гэж гараад бас хэдэн их наяд нь ч байна уу бас арилжааны банкаар дамжаад зээл олгогдсон байх. Энэ хүмүүс үнэхээр энэ Хөгжлийн банкны энэ төсөл хөтөлбөрүүд тэр тусмаа тэр арилжааны банкаар явсан нь буруу гэж байсан бол яагаад энэ Арван их наядын хөтөлбөр гэдэг хөтөлбөр гарч ирээд, дахиад баахан бизнес эрхлэгчид энд хамрагдаад явж байна вэ? Эдгээр нь дахиад 1 хэдэн жилийн дараа бүгдээрээ буруутан болох уу? Энийг олгосон Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ хэдэн жилийн дараа буруутан болох уу?

Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Хүнсний хувьсгал гээд 1.8 их наядын хөтөлбөр бараг өнөө маргаашгүй зарлаад, яам нь судалгаа хийгээд явж байна гэх юм. Дахиад л ингээд олгох юм байна. Тэгэхдээ энэ харьцангуй зөв нь, эдгээрийн зөв нь бас арилжааны банкаар олгох гэж байгаа юм шиг байна лээ. Дахиад эд нар бас яг саяын тэр жишигээр бол бас ингээд буруутнууд болоод энэ бизнес эрхлэгчид ингээд хохирох уу? Аль эсвэл ерөөсөө үнэхээр буруу бол буруу. Нөгөө талаасаа энэ буруу бол энийг ерөөсөө төрөөс ийм төсөл хөтөлбөр гаргахаа больчихвол яадаг юм бэ?

Яг адилхан 2 бизнес эрхлэгчид нэгэнд нь давуу тал олгохоор нөгөө бизнес чинь тэсэж үлдэхэд хэцүү. Хэцүү, ялгаатай өрсөлдөх чадварт нь

нөлөөлчихнө. Авчихаар нөгөө нөхдүүд чинь ингээд 1 ийм буруутан, эрүүгийн хэрэгтэн ялтан шиг сүүлд нь ийм нөхцөл байдлууд үүсээд, тэгээд одоо энэ дээр зүгээр асуулт маягаар асуух нь энэ Арван их наядын Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын олгосон нь, Ерөнхийлөгчийн олгох гэж байгаа санаачлаад явж байгаа Хүнсний хувьсгалын хүрээний энэ бас хэдэн их наядаар тоологдож байгаа энэ мөнгө төгрөгүүд чинь тэгээд бодлогын хувьд зөв юм уу? Та нар энэ дээр нэг харьцуулалт дүгнэлт хэлж өгөөч. Хэдэн жилийн дараа энэ нөхдүүд яг өнөөдөр Алтанхуяг гээд Ерөнхий сайд тухайн үеийнхээ улс төрийн шийдвэрийн төлөө Хөгжлийн банкны хэргээр тэнд шүүхийн танхимд шүүгдээд сууж байна. Нэг ийм жишиг, ийм зүйл рүү цаашид орох юм уу? Энэ дээр 1 тодруулга өгөөч.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад хэн хариулах вэ? Түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Тэгэхээр Цогтгэрэл гишүүн бол энэ төр ялангуяа энэ чөлөөт эдийн засгийн харилцаанд оролцдогийг их буруушаадаг. Яг энэ байр суурь дээр бол би Цогтгэрэл гишүүний энэ зарчим, үнэт зүйлийг их үнэлж дэмжиж ингэж явдаг бас гишүүн л дээ. Нэг зүйлтэй бол санал нэг байгаад байгаа юм. Төр оролцсон хаалт дотор нэг төр хайрлах гэсэн юм болгон цаанаа хулгай болж дуусаад байна. Авлига болж дуусаж байна. Бизнесийн чөлөөт өрсөлдөөнийг нухчхаж байна. 3 хувийн хөнгөлөлттэй зээл авчихсан бизнестэй 30 хувийн арилжааны зээл авч байгаа бизнес яаж өрсөлдөх юм бэ. Төр ингээд нэг бодлын тийм ч хөнгөлөлттэй, ийм ч хайрлах гэж байна, ингэж ч хөгжүүлж дэмжих гэж байгаа гэдэг болгон чөлөөт бизнесээ нухчин дарж байгаа үр дүн гаргаж байгаа гэдэг нь энэ сонсголоор нэн тодорхой болсон.

Энэ олон хөтөлбөрүүдийг ер нь хэн хүртчихсэн байсан бэ. Сая хэлсэнчлэн нийт Хөгжлийн банкнаас гарсан

мөнгөний 20 хувийг улс төрчид, тэдний хамаарал бүхий компаниуд авчихсан байна гэдэг дүгнэлт гарч ирж байна шүү дээ. 5 зээл тутмын 1 нь гэсэн үг шүү дээ. Тэгээд чөлөөт эдийн засаг, бизнес, либералчлал ярих боломжгүй юм байна лээ. Тийм учраас би таны нэг бодлоготой ерөөсөө их санал нэг байгаа юм. Ер нь ийм төр төрийн ийм хөтөлбөр юмнуудыг заавал үзүүлэх алба байна уу. Зах зээл гэдэг бол чөлөөт эдийн засаг гэдэг бол нөгөө талаар харгис шүү дээ. Хэн ухаантай нь, хэн чадвартай нь, хэн бага үнэ санал болгож байгаа, хэн илүү шинэ технологи гаргаж байгаа, зардлаа бууруулж байгаа тэр нь зах зээлдээ тэсэж үлддэг тэр жинхэнэ капитализм руугаа орох ёстой юм байна лээ.

Тийм учраас энэ асуудал дээр санал нэг байгаа. Мэдээж арилжааны банкнуудаар дамжуулан зээлдүүлсэн асуудал дээр Хөгжлийн банкны тухайд бол эрсдэл үүсээгүй. Арилжааны банкнуудаар дамжуулан олгосон 2500 зээл бүгд 100 хувь эргэн төлөгдсөн байгаа. Тийм учраас урьд нь энэ 2500 зээлийн асуудлыг огт хэн ч шалгаж байгаагүй. Сая бол анхнаасаа түр хороо байгуулахдаа Хөгжлийн банкнаас гарсан мөнгө шууд болон арилжааны банкнуудаар дамжуулж гаргасан бүх зээл ер нь зориулалтын дагуу байна уу, үгүй юу гэдгийг үзсэн. Ингэж үзэхэд бол бас нэлээн олон асуудлууд гарсан. Тухайлбал Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан Баттулга гэдэг ганцхан хүний тушаал л олдсон бидэнд, өөр юу ч олдоогүй. 200 гаруй тэрбум төгрөг 1 банкныг санхүүжүүлээд л явчихсан байсан. Тэр нөгөө арилжааны банкнуудаар дамжуулсан дотор шүү дээ. Тэрэнтэй холбоотой ямар ч шийдвэр, юу хуралдсан юм, яагаад тэр дамжуулж олгосон компаниудыг судалсан юм тийм ерөөсөө нотлох баримт юу ч олдоогүй. Тэр дотор чинь 10 жил зээлээ төлөөгүй Монголын улс төрч, намын дарга хүртэл гарч ирлээ шүү дээ.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад нэмж хариулъя. Түр

хорооны гишүүн Доржханд гишүүн хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Зөв, зөв нэг зүйл дээр санал нийлж байгаа нь үнэн. Нөгөө төр ингээд хувийн сектортой өрсөлдөж болохгүй. Болохгүй, болохгүй. Тэгээд чөлөөт зах зээлээр ингээд явах нь зүйтэй. Гэхдээ бид нар бас туйлиширч болохгүй шүү. Юу вэ гээд тэгэхээр нөгөө санхүүгийн зах зээл чинь жаахан өөр байдаг юм шүү. Юу юугаараа гээд тэгэхээр нөгөө мөнгө босгож ирээд, тэгээд санхүүжилт хийх нэг зовлон байдаг юм. Тэгээд мөнгө яаж босгох вэ гэдэг нь өөрөө хамгийн их зовлонтой байдаг юм. Тэгээд хямдхан эх үүсвэр аваад, тэрийгээ босгоод үр ашгийг нь гаргаад, буцаагаад ингээд, 1 урсгалд оруулаад л revolving fund гэдэг юм даа. Нөгөө ингээд явдаг энэ байдал чинь бол нэг хөгжиж байгаа эдийн засагт маш чухал байхгүй юу.

Яагаад вэ гээд тэгэхээр тухайн улсын зээлжих зэрэглэл гэж байдаг. Тэр зээлжих зэрэглэл нь суурь нь болдог байхгүй юу. Тэгээд тэрэн дээр үндэслээд нөгөө хувийн секторууд нь мөнгөө босгодог. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ сайн байж бид нар хямдхан мөнгө босдог байхгүй юу. Тэгээд зээлжих зэрэглэл нь хэзээ ч хувийн компаниуд нь тухайн улсаасаа өндөр байдаггүй юм. Тийм болохоороо Засгийн газрынхаа үнэлгээг нь сайжруулж байж хямдхан эх үүсвэр татаж байж хувийн сектороо дэмждэг. Энийг чинь бол энэ Хөгжлийн банк, Эксим банк эд нар чинь ийм ажил хийж байж хөгжлийнхөө үе шатад шаардлагатай дэд бүтцийн санхүүжилт хэрэгтэй санхүүжилтээ санхүүжүүлж байж босгож ирсэн энэ дэлхийн түүх шүү. Дэлхийн бүх улсууд мөнгөгүй байсан. Солонгосчууд хүртэл Германаас, Японоос мөнгөө авч байгаад санхүүжүүлж байсан босгож ирсэн. Америкууд ч гэсэн, Европ ч гэсэн бүгд ингээж явдаг юм.

Харин хамгийн чухал нь тэр санхүүжүүлж байгаа мөнгөө бид нар үр

ашигтай зарцуулдаг уу, үгүй юу л гэдэг байх. Монголд бол юун үр ашиг. Зүгээр талаар нэг тараагаад хаячихсан. Улс төрчид нь өөрийнхөө компанид май гээд ингээд өгчихсөн. Ерөнхийлөгч байсан нөхөр нь өөрийнхөө ингээд мөрөөдөлдөө би үйлдвэр барина гээд мөрөөдөл дээрээ бас баахан ингээд санхүүжилт хийнэ гээд ингээд явчихсан. Үгүй ээ тэгээд тэрийг нь дараа нь ингээд хэн тэр гоё мөрөөдлийг нь ингээд төлөх юм бэ гэхээр ард нийтээрээ төлж байгаа байхгүй юу. Яагаад вэ гэхээр эдийн засгийн тооцоо байхгүй, гарч ирсэн бүтээгдэхүүнээ хаашаа хэдэн километрийн цаана аль, аль усыг давуулаад хэнд зарах юм бэ гэдэг ямар ч тооцоо байхгүй. Нөгөө нэг авна гэсэн хүмүүс нь бид нар юу гэж та нараас энэ юмыг чинь авах юм бэ гээд.

Энгийн жишээ Австрали яаж хөгжсөн юм. Ядуу орон байсан юм шүү дээ. Шотланд, Ирландуудын цөллөгийн газар байсан юм. Японы зах зээлд гарч ирээд, Хятадын зах зээлд гарч ирээд хөгжсөн байдаг юм. Хөгжихдөө үйлдвэрлэж хөгжөөгүй байдаг байхгүй юу. Эхлээд юмнуудаа зарсан байдаг юм. Австрали манайхтай адилхан төмрийнхөө хүдрийг зардаг юм шүү дээ. Яагаад вэ гэхээр үйлдвэрүүд нь Япон, Хятад, Солонгост байгаад байгаа байхгүй юу. Тэр хүмүүс түүхий эд биш түүхий эд болохоос биш үйлдвэрлэсэн Австралид үйлдвэрлэсэн юм биш байхгүй юу. Энэ агуулгаараа бид нар нөгөө хаана зарах вэ гэдгээсээ эхэлж байж төслөө санхүүжүүлдэг болохоос биш, би нэг гоё үйлдвэрлэл барьчих юм бол тэр чухал шүү дээ. Доржхандаа би үйлдвэр барих гээд байхад чинь чи юу яриад байгаа юм бэ гэдэг ийм популист улс төрчдийн зовлонг тэр нэг хүсэл мөрөөдлийг нь улсаараа ингээд төлж байгаа байхгүй юу.

Өндөр үнэтэй зээл авчхаад л хашаа барьчихдаг. Юу вэ энэ чинь. Тойрогтоо хашаа барьдаг, хашаа буддаг, парк янзалдаг, наадмын талбай хийдэг юу вэ энэ чинь. Дахин сонгогдохын төлөө гээд. Өндөр үнэтэй зээл авчхаад том

бүтээн байгуулалтыг хийхийн оронд чинь банкнудаар жижиглэж зардаг, ширхэглэж зардаг. Зарахдаа бүр 1 зээлдэгчийн 79000 төгрөгийг Хөгжлийн банк санхүүжүүлж байгаа байхгүй юу. Ийм эмгэнэлтэй. Зүгээр л мөнгө гээд тарчихсан. Тэгээд энэ төлбөрийг хэн төлөх юм бэ гэхээр үр хүүхдүүд маань төлчихнө гээд, төсвөөс төлчихнө гээд. Төсвөөс 2.3 их наядыг нь төлүүлж байгаа шүү дээ. Тэр төсөв гэдэг чинь татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Зүгээр л зээл гэж хараад л мөнгө гэж хардаг юм байна. Миний мөнгө юм байна би энийг санхүүжүүлнэ гэдэг ийм нэг хөгийн ядуу ийм сэтгэхүйгээр хандсан болохоороо Хөгжлийн банк дампуурчхаад байгаа юм. Энийг харин цаашаа засаж залруулах шаардлага бол байгаа. Ингэхийн тулд ерөөсөө л менежментийг л бид нар тусдаа хийж байж, энэ бол өөрчлөгдөнө. Өөр ямар ч боломж байхгүй. Хэрэв менежмент тусдаа хувийн сектор байхгүй бол энийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Ямар ч байсан Улсын Их Хурлаас энэ хяналт шалгалтын тогтолцоог бий болгоод анхны хяналт шалгалтын энэ түр хороо Энхбаяр гишүүнээр ахлуулж, маш амжилттай ажилласан. Би энэ хяналт шалгалтын энэ нотлох баримт дээр суурилсан энэ хэлэлцүүлэг юмнууд явагдаж байхад яг орон нутагт тойрогтоо ажиллаж таарсан. Сум болгонд очоод уулзахад энэ Хөгжлийн банкны энэ зүйлийг үзэж байгаа харж байгаа ийм талаараа иргэд бол байнга сум болгонд л хэлж байсан. Харамсалтай нь үзээд үнэхээр бас гутарч байна.

Монгол улс ер нь цаашид хөгжих юм уу, энэ арай хэтэрчихсэн юм гэдэг ийм зүйлүүд бас яригдаж байна лээ. Магадгүй энэ нь цаашид Монгол Улсын ирээдүйд бас тустай дэмтэй байх. Энд оролцсон байж болзошгүй энэ төрийн албан хаагч нарт ч гэсэн цаашид нэлээн бодолтой хандахгүй бол тухайн үедээ

болж байгаа юм шиг боловчиг тодорхой хугацааны дараа энэ асуудлууд чинь бас мартагдахгүй гарч ирдэг юм байна шүү гэдгийг бас хойшдоо ийм сургамжтай зүйл боллоо гэж ингэж бодож байгаа. Тэгээд магадгүй энэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжээд ингээд явсан бол өнөөдөр долларын хани 3500 гарахгүй байсан байх л даа. Монгол Улс бүх зүйлээ дотроо хийдэг ийм бололцоо бүрэн дүүрэн гарах байсан юм байна даа. Одоо бидний гаднаас хэрүүлтэй уруултай өндөр үнээр авч байгаа энэ бүтээгдэхүүнүүдийг хийхийн тулд л анх хийсэн юм байна. Зорилго нь бол зөв байж, гүйцэтгэхдээ замбараагүй юм болжээ гэдгийг л бас харж байгаа юм.

Ер нь Монгол Улсын төсвөөс татвар төлөгчдийн ч бай, энэ төр түмний нэр байж босгосон бондууд ч бай, хаана хаана л бас хяналтгүй л явж байна л даа. Ер нь төр өөрөө ингээд нэг банк ч юм уу эсвэл төр хажуудаа нэг зээлийн нэгж байгуулаад олгоод эхлэхээр үнэндээ дампуу байдаг юм байна. Үүний хажуугаар бас Сум хөгжүүлэх сан гээд л олон жилийн өмнө бас бий болсон. Сумын Засаг даргын Тамгын газрууд хажуудаа 1 зээлийн мэргэжилтэнтэй. Үгүй ээ тэр улсын дүнгээрээ тэр чинь 340, 50 тэрбум төгрөг л юм байна лээ шүү дээ бас. Тэгээд л жил болгон жижиг, дунд бизнесийг дэмжих зээл мөнгө тавиач л гээд байдаг. Уул нь тэр мөнгөө авбал маш их юм эргэлтэд орох юм байна лээ. Гэх мэтчилнээр ингээд Хөгжлийн банкин дээрээ ч тэр, Сум хөгжүүлэх сан дээрээ ч тэр маш замбараагүй болгож иржээ. Энэ ингээд нэг хумигдаад явах юм бол Монгол Улсын эдийн засагт энэ импортыг орлох ч бай, хэрэглээг нэмэгдүүлэхэд ч бай, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд бол нэлээн тустай гэж ингэж харж байгаа.

Би 2, 3 асуулт байгаа юм. Ер нь бол яах вэ ингээд зориулалтын бусаар ашигласан маш их кэйсүүд гарч байна гэж байгаа. Ялангуяа ББСБ руу аваачаад хийчихсэн юмнууд маш их байна гээд. Яг энийг яригдаж байх үед энэ Хөгжлийн

банкны асуудал энэ төр засгаасаа ч тэр, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр энэ сайтууд чинь бас сайн, муу хэлэгдээд энийг маш хүчтэй гаргаж ирсэн шүү дээ. Ингэсний үр дүнд нөгөө арилжааны банкнууд нь зээлийн зээл олгохгүй бүр тэр битгий хэл хамгийн найдвартай цалингийн зээл олгохгүй байхад банк бус санхүүгийн байгууллагууд манайхаас зээл аваач гэж уриалж байсан юм байна лээ шүү дээ. Төлөгдөөд ирэнгүүт тэр татагдчихсан гэж байгаа юм. Тэгээд ийм зүйлүүд ер нь яг хэдий хэмжээний мөнгө ББСБ руу ороод явчихсан гэж ингэж бас харж байгаа юм бэ?

Хоёрдугаарт та бүхнийг би бол зөвхөн Хөгжлийн банкны асуудлаар юм бэ гэж бодсон. Гэтэл Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн бүх төсөл хөтөлбөрүүд арилжааны банкаар дамжаад тэндээс авсан зүйлүүдийг бас судлаад эхэлсэн. Эндээс би 2 зүйл хараад байгаа юм. Төр яг өөрөө гардаад ингээд мөнгө өгөхөөрөө бүр 1.2 их наядараа эд нар ингэж эрсдэлтэй болдог. Арилжааны банкнуудаар ингээд явуулчихаар энэ чинь их хамаагүй эрсдэлгүй болчихдог юм байна. Ер нь тэгээд энэ түүр хорооныхон эдийн засгийн мэргэжилтнүүд ч байгаа. Цаашидаа Монгол Улсад энэ Хөгжлийн банк энэ загвараар явах уу эсвэл Доржханд гишүүний хэлж байгаа шиг өөр загвараар явах уу? Ер нь арилжааны банкнуудаараа явах уу гэдэг энэ үедээ ер нь яг аль зааг дээр нь бас байх ёстой юм бол? Энэ дээр ер нь яг энэ ний нуугүй бүгдийг нь сая гаруй материал уншсан, судалсан та бүхний хувьд бас ямар итгэл үнэмшил төрсөн бэ л гэж би бас 2 дахь асуулт асуух гээд байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулъя 85 дугаар микрофоныг өгье. Албан тушаал, нэрээ хэлээд асуултдаа хариулаарай.

И.Уянга: Гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн хянан шалгагч Уянга. Бид хэд дүгнэлтдээ ерөнхийдөө та бүхэнд тарааж өгсөн тайландаа

дурдсан байгаа. Нийт зориулалт бүрэн бусаар зарцуулагдсан нийт зээлийн жагсаалт бол 74.2 хувийг бол эзэлж байгаа. Таны асуусан ББСБ руу хэд нь орсон бэ гэдэг хэсэг дээр бол ер нь бол 2 төрлөөр байгаа. Нэг нь бол ББСБ-аас авсан зээлээ хаасан. 2 дахь нь бол яг өөрийн эзэмшлийн ББСБ руу хөрөнгө оруулалт хийсэн. Энэ 74.2 хувьдаа бол ер нь тодорхой хувийг бол эдгээр зориулалтаар ашигласан зээлүүд бол ороод явж байгаа.

2 дахь асуудал арилжааны банкаар дамжуулаад олгох нь эрсдэл арай багатай юу гэж та асуусан. Энэ дээр бол бид хэд удирдамжийн хүрээнд шалгалтын удирдамжийн хүрээнд бол ажиллахад бол арилжааны банкаар бол нийтдээ Хөгжлийн банкны 1.6 их наяд төгрөгийн 2542 зээлдэгчийн бол зээл бол олгогдсон байгаа. Тэгээд Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн Засгийн газарт шилжүүлсэн энэ багцуудтай харьцуулахад арилжааны банкнууд дээр байгаа үлдэгдэл бол тэр зориулалтынхаа хувьд бол эрсдэлийнхээ хувьд бол хэр байсан бэ гэхээр ерөнхийдөө бол 50-60 хувьтай байсан. Тэгэхээр бас энэ дээр яг арилжааны банкаараа дамжих нь илүү эрсдэл багатай гэж энэ ажлын хэсгээс бол дүгнэхэд бол өнөөдөр бол юу гарахад бол жоохон хүндрэлтэй байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу? Түүр хорооны гишүүн Доржханд нэмж хариулъя.

Т.Доржханд: Зөв, зөв. Тэгэхээр энэ асуулттай бол санал нэг байна. Тухайлбал тэр анхны ярьсан тэр нөгөө Засгийн газар дээр ингээд сангууд цуглуулаад л ЖДҮ сан ч гэдэг юм уу, янз янзын сангууд ингээд цуглуулаад тэрийгээ нөгөө шинжээчид биш, эдийн засагчид биш, мэргэжилтнүүд нь биш эсрэгээрээ 1 дарга ингээд шийдээд яваад байдаг ийм байх юм бол энэ авлига бүтэхгүй. Тэгээд энэ мөнгө хэзээ ч төлөгдөхгүй. Тийм болохоороо энэ сангуудыг дандаа нөгөө яг мэргэжлийн

хүмүүс нь үнэлгээ хийдэг хүмүүс нь санхүүгийнх нь ингээд суугаад, тэгээд болж өгвөл нөгөө баг нь менежментийн баг нь, өөр хоёрдугаарт хувийн банкнудаар дамжуулаад үнэлгээг нь өгөөд эрсдэлийг нь өөрсдөөр нь үүрүүлээд явдаг энэ систем бол зөв систем.

Гэхдээ энэ хэзээ зөв систем байдаг вэ гээд тэгэхлээр ЖДҮ-ийн бизнесүүд дээр зөв байдаг байхгүй юу. Ингээд 2 шатлалтай Японы зээл гэхэд маш амжилттай хэрэгжсэн. Ази тивдээ хамгийн сайн хэрэгжсэн Японы зээл Монголд байдаг юм. Тэр нь яаж явсан бэ гээд тэгэхээр бид нар Японы эх үүсвэрийг аваад хөнгөлөлттэй эх үүсвэрийг арилжааны банкнудаар ингэж тараагаад, эрсдэлээ та нар хариуцна шүү. Харин аль байгууллагад зээл өгөхөө та нар өөрсдөө шийд гээд л ингээд л өгчихсөн. Тэгэхэд бол ердөө 25 сая доллароор чинь 10000 ажлын байр бий болгочихсон юм шүү дээ. Маш сайн 10 жилийн хугацаатай, бага хүүтэй. Тэгээд л зээлийн эргэн төлөлт нь 100 хувь байхгүй юу.

Яг ижилхэн санг бид нар ингээд ЖДҮ сан дээр ингээд төсвийн хөрөнгөөр ингээд байгуулсан байхгүй юу. Харамсалтай нь тухайн Хөдөө аж ахуйн яам дээр ингээд байгуулагдчихсан. Тэгээд нөгөө нэг банкнудаар дамждаг юмыг нь Засгийн газрын шийдвэрээр байхгүй болгоод, сүүлдээ ингээд яамных нь сайд, тэгээд даргын үзэмжээр ингээд шийддэг болоод л ЖДҮ сан чинь ингээд дампуурчихсан байхгүй юу. Хөгжлийн банк яг адилхан. Анхны менежментийг нь бас бид нар ингээд гаднын Японы баг оруулж ирэхээр тохирчихсон байсан юм. Харамсалтай нь Солонгосын баг ороод ирчихсэн юм. Яах вэ дээ гээд явсан. Солонгосын багийг хөөгөөд явуулчихсан юм. Тэгээд дараа нь шийдвэрийг Их Хурал гаргадаг болсноо Бондын зөвлөл гээд бүр ингээд сайхан цаашаа ингээд халиад явчихсан. Тэгээд үр дүнд нь өнөөдрийн Хөгжлийн банк дампуурчхаад байгаа нь ердөө л энэ юм.

2 дахь зүйл нь. Одоо ингээд цаашаа яах юм бэ, яаж явах юм бэ гэдэг юм бол байна. Энэ Хөгжлийн банк гэдэг бол олон улсаа бол томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлдэг болохоос банкаар дамжуулаад жижиг хувиараа бизнес эрхлэгч түрүүчийн ярьдаг 70, 80 мянган төгрөг ингээд дамжуулж өгдөг ийм бүтэц биш байхгүй юу. Анхны зорилго нь бол биш юм. Анхны зорилго нь юу байдаг вэ гэхээр цахилгаан станцуудыг санхүүжүүлбэ. Яагаад вэ гэхээр экспортод гаргах боломжтой юм байна, мөнгөө олох боломжтой юм байна ч гэдэг юм уу. Төмөр замыг санхүүжүүлбэ, мөнгөө олох боломжтой юм байна урд зах зээл чинь байна ч гэдэг юм уу. Ийм нөгөө төслүүдийг том төсөв дээр бид нар ингээд мөнгө хайхаар байхгүй. Төсөв чинь хөрөнгө оруулалт чинь 1.3-хан их наяд шүү дээ хөөрхий. Тэгээд нэг ингээд 76 тойрог руугаа явчихдаг.

Тэгэхээр энэ мөнгийг гаднаас ингэж оруулж ирээд, том бүтээн байгуулалт руугаа ялангуяа экспортыг дэмждэг, доллар орж ирдэг энийгээ санхүүжүүлбэ. Импортыг хэмнэдэг, тухайлбал Монполиментын цементийн үйлдвэр, МАК-ийн үйлдвэр ч гэдэг юм уу ийм үйлдвэрүүдийг санхүүжүүлэхэд яг энэ Хөгжлийн банк хэрэгтэй. Энэ бол том санхүүжилт шүү. Том санхүүжилт, дэд бүтцийн том төслүүд. Монгол Улс маш давуу талтай. Бид нар байгалийн баялагтайдаа давуу талтай биш шүү. Манай урд талд дэлхийн 2 дахь том зах зээлд үүссэнээрээ том давуу талтай. Иийшээ чиглэсэн, экспортлоод мөнгөө олоод явдаг маш олон төрлийн бизнесүүд байж болно. Энийг санхүүжүүлэх энэ эх үүсвэр нь бол Хөгжлийн банк байх бүрэн боломжтой.

Тэгэхээр цаашид бол энэ том бүтээн байгуулалт руугаа анхаарах хэрэгтэй. Тэгээд дахин хэлье. Самурай бонд, Евро бонд, Кредит Свисс гээд маш их хэмжээний бид нар нийтдээ 1.5 тэрбум долларыг ингээд гаднаас эх

үүсвэрийг нь ингээд авчихсан, зээл авчхаж байна шүү дээ хүүтэй, доллароор. Валютаа ингээд төлөхийн тулд тэр чинь валют хэрэгтэй шүү дээ. Гэтэл манайх тэр валют олдог төслүүдийг санхүүжүүлэхгүй байгаагийн үр дүнд бид нар ингээд дампуурчхад байгаа байхгүй юу. Одоо энийг засах юм бол цаашаа явах боломжтой юм. Өөрөөр хэлбэл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Байгаагийн Баттөмөр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Баттөмөр: Бид нар энэ Хөгжлийн банкныг шалгахад 3.2 их наяд төгрөгийн асуудал. Тэрнээс чанаргүй болчихсон 1.7 их наяд төгрөгийн л асуудлыг 53 зээлдэгчид холбогдох ингэсэн юм л даа. Тэгээд яах вэ Хянан шалгах түр хороо нарийвчилж, охин компаниуд, банкаар дамжуулсан гээд бүгдийг нь ингээд үзээд нэлээн нарийвчилж ажилласан. Тэгээд ерөөсөө ингээд л харахаар Монголчууд бол янз бүрийн ажилд, янз бүрийн юманд бэлтгэгдээгүй байна, төрд бэлтгэгдээгүй. Бэлтгэгдсэн ч гэсэн хулгай хийдэг ийм хүмүүсийг л энд тэнд аваачиж тавьж хулгай хийлгэж байгаа байхгүй юу. Одоо сая тэр сонсгол дээр очоод тэр мэргэшсэн хулгайч нарыг ярьж байхгүй юу. Том, том юм яриад. Тэдний хувьд бол насаараа хулгай хийсэн учраас одоо ерөөсөө байдаг тийм амьдардаг арга нь тэр ерөөсөө бүр бүх юм нь яг тийм болчихсон. Ийм л харамсалтай байгаа байхгүй юу.

Солонгосчууд өөрийнхөө менежмент, өөрснийхөө зардлаар менежментийг нь хийгээд, ингээд явж байсан юмыг хөөж явуулж байгаад л хойд талд нь тонож байгаа байхгүй юу. Солонгосчуудын өгсөн зээлийг гэхээр чанаргүй зээл гэсэн Хөтөл гэж байгаа юм. Хөтөл нь байж байна. Өнөөдөр ашигтай ажиллаж байна, буцаад төлөгдөнө. Тэгээд ийм л юм байгаа байхгүй юу. Энэ ганц Хөгжлийн банк ч биш, энэ нүүрс тойрсон асуудал бүх

юман дээр ийм хүмүүс зорилго бүхий хүмүүс тавьж байгаа байхгүй юу.

Манай ерөөсөө хөгжил бол ийм байхгүй. 2 хөрш бол бидэнтэй сайхан хамтарч яаж байна. 3 дахь ертөнц бидэнтэй сайхан хамтарч ажиллаж байна. Яагаад байна гэхээр ерөөсөө Монголчууд өөрсдөө Монгол Улсаа хөгжүүлэхгүй байгаад байгаа байхгүй юу. Энэний нэг тод жишээ нь энэ Хөгжлийн банк. Энүүгээр маш их олон төслүүдийг хэрэгжүүлж, санхүүжүүлж үр ашгийг нь авах ийм боломж энэ арваад жилийн хугацаанд байлаа. Харамсалтай нь байхгүй. Тэр нэг банкнаас 12 тийм юу билээ энэ чинь 1 банкнаас 12 хувийн хүүтэй хадгаламж авангуутаа нөгөө банкдаа 10 хувийн хүүтэй аваачаад өгчихдөг. Нэг банкнаас 10.5 хувийн хүүтэй зээл авангуутаа, нэг банканд нь аваад буцаад аваачаад 9 хувийн хүүтэй зээл өгчихдөг. Монголбанкны хүүгээс 2, 3 хувь бууруулаад ингээд зээл өгчихдөг. Энэ чинь ерөөсөө цэвэр луйвар шүү дээ. Тэгээд төрийн хяналт гэдэг юм энд байхгүй. Сахилга хариуцлага гэдэг юм бол байхгүй. Ийм л юмны жишээ энд харагдаад байгаа байхгүй юу.

Тэгээд бид ерөөсөө энэ алдаанаасаа сургамж авахгүй байгаа. Яах вэ ингээд энэ манай Энхбаяр энэ тэр ингээд энэ тайлангаа ингээд Их Хуралд өгсөн байна л даа тэгээд. Тэгтэл энэ жил, энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байхгүй байхад нь өнөө өглөө бидэнд өгөөд, өнөөдөржингөө хурал хийгээд унших боломж байхгүй. Одоо ингээд хэлэлцүүлчхэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дотор нэг хэд юм 5, 6 хүн байна. Энэ хүмүүс нь энэ дээр нэг ойлголт байхгүй. Энэнээс маш их сургамж авах ёстой байсан, байхгүй. Ийм юм яасан байхгүй юу. Сая тэр манай Энхбаяр энэ тэрийн ярьж байгаа нь тэр яг үнэн шүү дээ. Барьцаагүй зээл өгчихсөн. Энд тэнд аваачаад банканд аваачаад хадгаламж хэлбэрээр байршуулсан. Тэр нь өнөөдөр төлөгдөөгүй. Удирдлагууд нь мөнгөн

хөрөнгийн удирдлагын зохистой, зохистой тийм юуг хэрэгжүүлээгүй. Арилжааны банкнуудад байрлуулсан нь бол тэр чигээрээ луйвар гээд л. Одоо ингээд аймшигтай юм байгаа байхгүй юу даа.

Тэгээд энд яах вэ дээ ингээд л зах зээлд ийм байдаг, ийм байдаг, ингээд, ингээд явах ёстой л гэж байгаа юм. Тэр зах зээлд одоо яахад бэлтгэл юун дээр хангагдаагүй байна шүү дээ. Төр зохицуулж оновчтой зохицуулалтуудыг хийх ёстой шүү дээ. Тэгээд тийм юм алга байна.

Хоёрдугаарт 2 асуулт байна. Нэгдүгээрт нь бол юу гэхээр энэ Хөгжлийн банкны ирээдүйг юу гэж харж байна вэ? Би Энхбаяраас асууж байгаа юм. Сая энэ дотор цаашидаа ингээд ажиллах боломжгүй байна гээд ингээд хэлчхэж байгаа юм.

Хоёрдугаарт би Доржхандаас асууж байгаа юм. Энэ дээр хийгдсэн нэг луйвар, луйвар 2-3 банкин дээр энэ ханшийн зөрөө гэдэг юм байгаа юм. Энийг ер нь яах юм бэ, цаашидаа ингээд хаячих юм уу, дахиад энийг үргэлжлүүл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Хянан шалгах түр хорооны дарга Энхбаяр асуултад хариулъя. Дараа нь Доржханд гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Энэ түр хорооны хяналт шалгалтын дүгнэлт бол их олон удаагийн шалгалтуудын бас нийлбэр шүү. Тэр дотроо Баттөмөр гишүүний ажлын хэсэг ахалж ажилласан өнгөрсөн оны 2 сард энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар бас байгуулагдсан энэ ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн шалгалтууд ч гэсэн энэ дотор багтаж танилцагдаж байгаа, тайлан дотор байгаа.

Тийм учраас энэ асуудлыг бас нэлээн цогцоор нь Баттөмөр гишүүн

угаасаа мэдэж байгаа. Тийм ч учраасаа их том зургаар нь асууж байгаа юм. Тэгээд энд санал, дүгнэлтэд бол 2, 3 хуудас хамгийн хураангуй маягтай хэлж байгаа энд 1 өгүүлбэрийг би дахиад уншаад өгчихье. Санал, дүгнэлтэд би сая уншсан. Сүүлийн 20 гаруй жилд хэт ойртсон, зааг ялгаагүй, хаалттай, авлигажсан, улс төр, бизнес, банк санхүүгийн санхүүжилтийн тогтолцоо Монгол Улсад нутагшиж тэр нь Хөгжлийн банкны засаглал, хүний нөөц, шийдвэр гаргалтад гүнзгий нэвтэрсэн гэдэг дүгнэлтийг өгсөн. Бид ганцхан Хөгжлийн банкиг шалгаагүй юм байна лээ.

Сая энэ илчлэгдсэн асуудал бол ганцхан Хөгжлийн банкны асуудал илчлэгдээгүй. Сүүлийн 20, 30 жилийн хугацаанд Монгол Улсад тогтсон улс төрийн санхүүжилт, улс төр, нам, бизнес, банк, санхүү дамжсан бүлэглэлүүд илчлэгдсэн байхгүй юу сая. Тэр бүлэглэлүүд энэ ард түмний мөнгийг яаж цэвэрхэн ухаалгаар идэж уудаг схем нь илчлэгдсэн байхгүй юу. Схем нь бүтнээрээ. Тийм учраас энэ зүгээр нэг Хөгжлийн банкны 2, 3 захирлуудыг шалгасан асуудал биш байсан. Энэ Монголын улс төрд өгч байгаа Улс төрийн намын өнөөдөр бид нар хууль ярьсан. Энэ намууд чинь юу болчихсон юм, санхүүжилтийг нь юу болчихсон юм, энэ намуудаар дамжиж төрийг хэн удирдаж байна, ард түмэн удирдаад байна уу, банкны эзэд удирдаад байна уу гэдэг дээр хариулт өгчихсөн бид нар.

Үр дүн нь хаана байгаа юм бэ гээд байгаа юм. Одоо яах вэ гээд байгаа юм. Үр дүнгээ өгөөд эхэлчихсэн энэ сая нээлттэй түр хорооны. Ард түмнийхээ нүдийг нээчихсэн шүү дээ. Ард түмнийхээ ард түмнээ сэрээчихсэн байхгүй юу. Ер нь л идэж уугаад байна, авлигажаад байна, шударга ёс алдагдаад байна, хариуцлага тооцохгүй байна, нийгмийн тэгш бус байдал улам л зааглагдаад байна гэж мэдээд байсан боловч яг яаж идээд уугаад байгаа юм бэ гэдгийг нь ойлгохгүй байсан байхгүй юу.

Энэ тэд яаж, ямар хүмүүсээр дамжуулж, яаж улс төр, бизнес, энэ банк санхүү хэрсэн мафи Монголд нүүрлэчихсэн байсан бэ. Тэрэнд нь хуулийнхан хүртэл яаж оролцсон байсан байсан бэ. Хэн, хэн шүү бүр. Тэр Хурц гэж нөхөр чинь бүгдэнгээс нь хуссан байсан шүү дээ. Өөрөө АТГ-ын дэд дарга байсан хүн байхгүй юу. Энэ зүйлийг бүгдийг нь илчилсэн байхгүй юу.

Тийм учраас энэ бол би шинжээч дээр тусгайлан баярлалаа гэж хэлж байгаа юм. Энэ бол зориг шаардсан ажил байсан шүү. Ганцхан ур чадвараас илүү зориг.

Л.Мөнхбаатар: Нэг зүйл хэлээд орхиё. Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу Эдийн засгийн байнгын хороо маргааш өглөө 9 цагт хуралдаж онцгой дэглэмийг сунгахтай холбоотой асуудлыг хэлэлцэнэ. Гишүүд өглөө 9 цагт хуралдах нь байна. Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя. Түр хорооны гишүүн Доржханд асуултад хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Баттөмөр гишүүн бол маш зөв асуултыг асууж байна. Энэ асуултыг бүр асуугаасай гэж их хүсээж байгаа юм. Юу вэ гээд тэгэхээр бид нар нөгөө авсан зээлийнхээ асуудлыг яриад байдаг, зориулалт уу, зориулалт бус уу, эргэн төлсөн үү, үгүй юу гээд. Тэрнээс том алдагдал үүсчхээд байгаа юм эрхэм гишүүдээ. Тэр бол ханишийн алдагдал юм. Нийтдээ бид нар 1.5 тэрбум орчим долларыг Хөгжлийн банкнаас зээлж авсан. Буцаад валютаараа зээлнэ, төлнө. Гэтэл үүн дээрээ хамгийн багадаа бид нар мянган төгрөгийн алдагдал үүсчхээд байгаа юм. Энгийнээр бол 1.5 их наядын. Үүнээс Хөгжлийн банканд оногдож байгаа нь болохоороо 216 тэрбум төгрөг, нэмэх нь 120 тэрбум төгрөг бол хуулийн шатад явж байгаа юм. Ингээд нийтдээ 340 орчим тэрбум төгрөг ханишийн алдагдал Хөгжлийн банк. Хөгжлийн банк чинь 100 хувь төрийн өмч, татвар төлөгчдийн мөнгө гэсэн үг шүү дээ.

Хоёрдугаарт төсөв рүү бид нар 2012-оос 16 онд ингээд зээлээ төсөв рүү шилжүүлчихсэн буюу татвар төлөгч рүү, иргэд рүү ингээд шилжүүлчихсэн. Энэ ханишийн алдагдал бол 589 тэрбум төгрөг. Үлдэж байгаа 600 орчим тэрбум төгрөгийг хэн үүрч байна вэ гэхээр алдагдлыг нь болохоор жирийн бизнесүүд үүрч байгаа. Тэр Монполиметын Гарамжав гэдэг бизнес эрхлэгч эмэгтэй үүрч байгаа. Тухайн үед 69 сая доллар зээлж авсан байдаг юм байна лээ. 130, 40 орчим тэрбум төгрөг төлнө гэсэн бол одоо 300 гаруй тэрбум төгрөг төлөхөөр болчихоод байгаа юм. Энэ бол бодитой факт юм. Ийм болохоороо энэ ханишийн алдагдал хаанаас үүсчхэв, хэн үүсгэчхэв, хэний алдаанаас болж үүссэн юм бэ гэдгийг бид нар гаргаж ирж ярих ёстой юм.

Тухайлбал тухайн үеийн Монголбанкны удирдлага, тухайн үеийн Засгийн газрууд буруутай бодлого, сонгуульд зориулаад мөнгө хэвлэдэг, гоё нэртэй хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг, 3, 4 төсөвтэй байдаг. Тэгээд маш их нууцаар ингээд бондуудын санхүүжилтийг хийдэг. Тэрнийхээ ханишийн алдагдлыг төр лүү ингээж оруулдаг 1.6 их наяд байдаг юм шүү. Тэгээд тэр бүх ингээд гэрээ хэлцлүүдээ бүгдийг нь нууцалчихдаг. Тэгээд хэн ч мэддэггүй. Яг нөгөө оффтейк гэрээ шиг ийм нөхцөл байдал байгаа юм. Ийм болохоороо уучлаарай бодитой юмыг бодитойгоор л хэлье.

Хөгжлийн банкны энэ 2 их наяд бол тэр миний яриад байгаа хаништай холбоотой саяын элдэв хөтөлбөрийг санхүүжүүлэхтэй холбоотой, элдэв цаад тал нь нууцад оруулчихсан энэ алдагдлын хажууд бол карманы мөнгө шүү. Ийм болохоороо Улсын Их Хурлын гишүүний хувьд, бас энэ Хөгжлийн банкны түр хорооны гишүүний хувьд бол дараагийн энэ түр хороог санаачлаад хяналтын сонсгол хийнэ, нотлох баримтын сонсгол хийнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Баттөмөр гишүүнээ та заавал ороорой

энэ дотор. Тэгээд жинхэнэ хулгай юу байдаг юм, ямар луйврын систем байдаг юм, ямар санхүүгийн схемээр эд нар ингэж төрөөс хулгай хийж авсан юм, хэн ч ойлгодоггүй, мэддэггүй энэ юмыг нь задална, ил болгоно.

Хөгжлийн банкны энэ асуудал бол ил болсон юм. Бид нарын хайрлаж хүндэтгэж байдаг маш олон бизнесүүдийн арьсыг нь хуулсан юм. Мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд байсан эрх мэдэлтэй нөхдүүдийн бас асуудлыг нь гаргаж ирж ярьсан юм. Иргэддээ мэдээллийг нь өгсөн. Иргэд бүгд маш их ундууцаж байна, дургүйцэж байна, ард нь гараарай гэж байна. Харин дараагийн асуудлуудыг бол бид нар орно, орно, дэлгэнэ, иргэддээ ил болгоно. Үр дүнд нь дахиж ийм хулгай хийж болдоггүй юм, ядарсан улсынхаа жижиг жосохон мөнгөнөөс хулгай хийдэг ийм хэгийн том бизнесүүд байснаас өөрсдөө татвараа төлөөд банкнаасаа зээл аваад явдаг тэр жирийн бизнесүүд чинь эх орончид шүү. Тэр хүмүүсийгээ харин яаж дэмжих юм. Харилцан ялгаатай бодлого өгөхгүйгээр, үзүүлэхгүйгээр харин яаж тэр хүмүүсийг ажлын байраар жинхэнэ зөв бодлогоор дэмжих юм бэ гэдэг зүйл дээр Их Хурал нь ярих юм бол энэ дэвшил болно. Тэгэхээр таны хэлээд байгаа бид нар ийм их муу сургамжийг цаашаа авч явахгүйн тулд өнөөдөр энийг ярих ёстой гэдэгтэй бол би 100 хувь санал нэг байгаа. Үр дүн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Энэ тодруулга байхгүй дэгээрээ. Баттөмөр гишүүнд баярлалаа. Гишүүд асуулт асууж, харилцан авч, үг хэлж дууслаа. Хөгжлийн банкны асуудлаар байгуулагдсан Хянан шалгах түр хороо, түр хороо. Юу яая түр хорооны анхны даргаар ажиллаж байсан Сүхбаатар гишүүн үг хэлье.

Ж.Сүхбаатар: Хурал даргалагчид баярлалаа. Би бас өнөөдөр нөгөө Улаанбаатар форум гээд тэнд илтгэл тавиад оролцсон учраас бас бусад асуудлууд дээр нь оролцож чадсангүй. Уучлаарай. Тэгэхээр энэ Улсын Их

Хурлын хяналт шалгалтын тухай хууль өнгөрсөн жил батлагдаад ингээд Улсын Их Хурлын дарга Занданшатар дарга бол намайг энэ хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан учраас зөв жишиг тогтоох, цаашидаа бас Монголд энэ хяналт шалгалтын механизмыг боловсронгуй болгох хүрээнд ажлыг зохион байгуулах ийм үүрэг өгөөд, тэгээд энэ манай нөхдүүд итгэл хүлээлгээд ингээд түр хороо байгуулагдсан.

Тэгээд энэ түр хороо маань ингээд татан буугдаж байгаа хуулийн дагуу. Тайлан, дүгнэлтээ танилцуулж байна. Авах арга хэмжээгээ танилцууллаа. Монгол орон даяар ард түмний төлөөлөгчдийн байгууллага болох тэр мөн чанараа өөрөө илэрхийлж, олон түмэндээ бүх л талаас нь бол олон талын мэдээллүүдийг гаргаж танилцуулсан, хэлэлцүүлсэн. Энэ бол зөвхөн Улсын Их Хурлын танхим, түр хорооны зааланд бол энэ бол энэ ажил бол яваагүй. Энэ ажилд маш олон хүн оролцлоо.

Хөгжлийн банкин дээр миний анх ажилд томилж байсан, миний сайн танихгүй байсан хянан шалгагч, шинжээч, мөн манай Их Хурлын хяналт шалгалтын хэлтсийн хамт олон, цаана нь ажилласан олон зуун төрийн ажилтнууд таньж мэдэхгүй хүмүүс бол байгаа. Тэрэнд би бас энэ түр хороог ахалж ажиллаж байсан хүний хувьд бол бас өөрийн хувийн бас зүгээс талархлаа илэрхийлье.

Энэ Хянан шалгах хорооны ажлын үр дүн гэдэг бол тэр олон арван мянган хуудас гэж байгаа боловч тэрэн дээр цаана нь энэ дээр ажилласан энд харагдахгүй, бидний мэдэхгүй байгаа маш олон хүмүүс байгаа. Гэхдээ энэ бол Монголын түүхэнд сургамж бас гарын авлага болно. Бидний хийж байгаа энэ хяналт шалгалтын тайлан бол энэ ард түмэндээ бол бидний үлдээж байгаа дахин энэ буруу зүйлүүд давтагдахгүй байх энэ гол үндсийг бол бид энд бол оруулж өгсөн байгаа шүү. Тэгээд энд

байгаа олон юм хэлэх байх. Энд тайлан, дүгнэлт нь тодорхой юм байгаа. Тэгээд үе үеийн парламент, бусад иргэд маань ч гэсэн Улсын Их Хурлын мэдээллийн санд энэ бол байршина. Тэгээд ингээд явах учраас бол энэ ажлын үр дүн гаргасан хамт олондоо бас талархал илэрхийлж байна. Их Хурлын гишүүддээ ч гэсэн бас талархал илэрхийлж байна. Энд оролцсон, идэвхтэй оролцсон гишүүддээ.

Л.Мөнхбаатар: Хөгжлийн банкны асуудлаар байгуулагдсан Хянан шалгах түр хороо бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу байгуулагдсан анхны түр хороо. Энэ түр хороо хуулиар хүлээсэн үүрэг болон байгуулагдсан зорилгоо бол бүрэн биелүүллээ. Энэ түр хорооны гишүүн, түр хорооны дарга, гишүүдээр ажилласан, түр хорооны дарга Энхбаяр, анхны даргаар ажилласан Сүхбаатар, гишүүн Батлут, Батсуурь, Батицугар, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Жадамбын Бат-Эрдэнэ, Ганибал, Ганбат, Доржханд, Мөнхбаатар, Мөнхцэцэг нарын гишүүд болон түр хорооны ажлын алба, түр хорооны хянан шалгагч, шинжээчээр ажилласан хүмүүс, түүнчлэн Хөгжлийн банкны өнөөгийн удирдлагууд та бүгдэд бас талархаж байгаагаа илэрхийлье.

Ингээд Хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэн тайлантай Улсын Их Хурал танилцлаа. Түр хорооны зүгээс Улсын Их Хурлын тогтоолын төсөл гаргах шаардлагатай гэж үзсэн байгаа. Ингээд тогтоолын төслийг бол боловсруулсан. Энэ тогтоолын төслийг маргааш өглөөний чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Ажлын хэсэг, гишүүдэд та бүгдэд баярлалаа.

Өнөөдрийн чуулганаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдэж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

